



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

ГҮН ӨРӨМДӨЖ ҮЗЭХҮЙ

Олборлох үйлдвэрлэлийн орлого, Олборлох
үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга
(ОҮИТБС)-ын тухай иргэний нийгмийн гарын авлага

Орчуулсан: Г.Батбаяр
Хянан тохиолдуулсан: Э.Сумьяа

Улаанбаатар, 2009

DDC
622.338 1
Б-332



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

ГҮН ӨРӨМДӨЖ ҮЗЭХҮЙ

© Нээлттэй Нийгэм Форум

Энэхүү номын орчуулгын эрхийг ННФ эзэмших ба номыг хэсэгчлэн болон бүтнээр нь хэвлэхийг хүсвэл доорхи хаягаар хандаж зохих зөвшөөрөл авна уу.

Хаяг: Жамъян гүний гудамж
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар -48,

Утас: 976-11-318207

Факс: 976-11-324857

Вэб: <http://www.forum.mn>

Вэб: <http://www.revenuewatch.org>

И-мэйл: osf@forum.mn

ISBN 978-99929-54-79-5

DRILLING DOWN

The Civil Society Guide to Extractive
Industry Revenues and the EITI

Edited by David L. Goldwyn

Copyright © 2008 by the Revenue Watch Institute. All rights reserved.

ISBN: 978-0-9817665-0-8

Library of Congress Cataloging-in-Publication Data
A CIP catalog record for this book is available upon request.

Published by the Revenue Watch Institute
400 West 59th street, New York, NY 10019, USA
+ 1 212 548 0600
www.revenuewatch.org

Design by Jeanne Criscola | Criscola Design
Cover photo by JuniperImages
Layout by Judit Kovács | Createch Ltd
Printed in Hungary

Аа Õ ÷ è ã

Хүснэгт, зураг, шигтгээ сэдвүүдийн жагсаалт	7
Өмнөтгөл	11
Талархал	15
Оршил	19
Хэсэг I: ОУИТБС-ын үйл явцын дөрвөн үе шат	28
Бүлэг 1: Элсэн орох шат	29
Бүлэг 2: Бэлтгэл шат	39
Бүлэг 3: Тайлагнах шат	67
Бүлэг 4: Түгээн дэлгэрүүлэх шат	79
Хэсэг II: Олборлох үйлдвэрлэлийн бизнесийн үйл ажиллагааг ойлгох нь	96
Бүлэг 5: Эрх зүйн болон эдийн засгийн хүрээ	97
Бүлэг 6: Гэрээний үндсэн төрлүүд	101
Бүлэг 7: Засгийн газрын орлогын үндсэн төрлүүд	107
Бүлэг 8: Засгийн газрын ямар байгууллагууд орлогыг удирддаг вэ?	125
Бүлэг 9: Олборлох үйлдвэрлэлийн бүртгэл тооцооны гол эмзэг талууд	135
Хэсэг III: ОУИТБС-ын үндсэн хүрээг гүнзгийрүүлэх нь	144
Бүлэг 10: ОУИТБС-ын хувьсан хөгжих шаардлага	145
Бүлэг 11: ОУИТБС-ын Нэмэлт хүрээ	153
Хавсралтууд	158
Хавсралт А ОУИТБС-ын баталгаажуулалтын хүснэгт	159
Хавсралт Б Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгсэлүүд	163
Хавсралт В Гана Улсын Үйл ажиллагааны төлөвлөгөө	175
Хавсралт Г Казахстан Улсын Үйл ажиллагааны төлөвлөгөө	181
Хавсралт Д Бүтээгдэхүүн хуваах гэрээ (БХГ)-ний дагуу зардал ба газрын тосон зардлыг тооцоолох нь	193
Хавсралт Е БХГ-ний дагуу газрын тосон ашгийг тооцоолох нь	195
Хавсралт Ё БХГ-ний дагуу газрын тосон эзэмшил хувийг тооцоолох нь	197
Хавсралт Ж Засгийн газар ба хувийн компанийн түншлэл	199
Хавсралт З Засгийн газарт орох бэлэн мөнгөний урсгалын бусад төрлүүд	203
Хавсралт И Монгол Улсын бүртгэл тооцооны маягтын загварууд	205
Хавсралт Й Лавлах эх сурвалжууд	223
Нэр томъёоны тайлбар	227
Төгсгөлийн тэмдэглэлүүд	235
Индекс	000



Огноо, үнэмлэхүй, өөрчлөлт нээх, үнэмлэхүй хөгжлийн төлөв

Хүснэгтүүд

1.1	ОУИТБС-д тайлагнагч орнууд тоо баримтаа хэрхэн задалдаг вэ	24
2.1	Олон оролцогч талт бүлгүүдэд үзүүлэх дэмжлэг, улс орноор	41
2.2	Шаардагдах аудитын тайланг гаргах Ажлын даалгавар (АД)	48
2.3	Одоо байгаа ОУИТБС-ын тайлангууд хамрагдсан хугацаа	51
3.1	Хараат бус шинжээч нарт тохиолдсон зөрүүтэй байдлууд	70
4.1	ОУИТБС-ын тайлангуудын түгээн дэлгэрүүлэлт	80
4.2	Азербайжаны нэгдсэн тайлан	83
4.3	Нигерийн нэгдсэн тайлан	85
7.1	Газрын тос, байгалийн хийн үйл ажиллагаанаас засгийн газрын хүртэж байгаа хувь, улсаар	108
7.2	Нөөц ашигласны төлбөрийн төрлүүд	115
10.1	Нигерийн Засгийн газраас мужуудад хуваарилж буй орлого	150

Зургууд

1.1	ОУИТБС-ын шалгуурууд	20
1.2	ОУИТБС-ын зарчмууд	20
1.3	ОУИТБС-ын баталгаажуулалтын арга зүй	22
1.4	ОУИТБС-ын үндсэн ба нэмэлт хүрээ	25
2.1	Перу Улсад уул уурхайн татварын орлогоос төрийн байгууллагуудад хуваарилсан байдал	49
2.2	ОУИТБС-ын тендер шалгаруулах ажиллагаа	55
5.1	Тогтвортой шагнал ба эрсдэл	99
7.1	Гана Улсын уул уурхайн салбар дахь хууль ёсны төлбөрүүдийн ангилал	121
8.1	Нигерийн газрын тос ба орлогын урсгалуудын бүдүүвч зураг	126
8.2	Нигерийн газрын тос ба орлогын урсгалуудын бүдүүвч зураг-тайлбар	127
8.3	Төв Банкны дансанд хийгддэг үндсэн гүйлгээнүүд	130
8.4	Перу Улсын 2004 онд төлбөрийн хуваарилалт, яам, газруудаар	132
8.5	Перу Улс уул уурхайн татварын орлогыг төрийн байгууллагуудад хуваарласан байдал	132

Шигтгээ сэдвүүд

1.0	ОУИТБС-ын жишээ- Нигери дахь орлогын боломжит алдагдал	23
1.1	Мавританий Кибер форум	30
1.2	Зорилтуудаа тодорхойлох	31
1.3	Гадны тусламж	32
1.4	Иргэний нийгмийн өөрийн сонголт	34
2.1	Маягтын загварууд бий болгох	46
2.2	Бусдыгаа сургах сургалт	46
2.3	Мөнгөн ба аккруэль нягтлан бодох бүртгэл	52
2.4	Аудитын тайлангаас юу олж мэдэж авах вэ	62
3.1	Зөрүүтэй байдлыг тогтоох нь	73
3.2	Газрын тосны нөөц ашигласны төлбөрүүд: зөрүүтэй байдлыг шийдвэрлэх нь- ОУИТБС-ын жишээ	75

3.3	Газрын тосны нөөц ашигласны төлбөрийн зөрөөтэй байдал- ОҮИТБС-ын жишээ	75
4.1	Шинэтгэлийн зөвлөмжүүд: Байгууллагын чадавхи	91
4.2	Шинэтгэлийн зөвлөмжүүд: Байгууллагын чадавхи- хэмжилтийн системүүдийг сайжруулах нь	92
5.1	Газрын тосны үндэсний компаниуд	98
6.1	Засгийн газрын БХГ-ний төслүүдийн удирдлага	102
6.2	Газрын тосон ашгийн тооцоо	103
6.3	Газрын тосон зардлын тооцоо	103
6.4	Нөөц ашигласны төлбөрийн тооцоог шалгах нь	104
7.1	Татварын өрийн тооцоо	108
7.2	Татварын хөнгөлөлт	110
7.3	Татварын дэглэмүүд	110
7.4	Төслийн үргэлжлэх хугацаан дахь татвар ногдуулалт	112
7.5	Газрын тосны жишиг үнэ тогтоох нь	112
7.6	Газрын тосны нөөц ашигласны төлбөр- ОҮИТБС-ын жишээ	114
7.7	Газрын тосны нөөц ашигласны төлбөрийг тооцоолох нь	114
7.8	Ногдол ашиг төлөлт	118
7.9	Засгийн газар ба арилжааны харилцааны хэлбэрүүд	121
7.10	Байгалийн хийн үйлдвэрлэл дэх төсөв, санхүүгийн зохицуулалтууд	122
7.11	Шингэрүүлсэн байгалийн хийн төслүүдийг үнэлэх нь	123
8.1	Хөнгөлөлтийн гэрээний дагуу татварыг тооцох нь- Аргачлал	128
9.1	Нэг улс гэрээний олон янзын тогтолцоо, нөөц ашигласны төлбөрийн өөр өөр хувьтай байж болно	137
10.1	Сонгон шалгаруулалтыг ил тод явуулах нь үр өгөөжийг дээд зэргээр нэмэгдүүлдэг	149
11.1	ОҮИТБС-ын дагуу хүлээн авч байгаа ашиг орлогын урсгалаа тайлагнах үүрэг: хүлээн авсан орлогынхоо зарцуулалтад үнэлэлт өгөх бүс	154
Ж.1	Газрын тосны үндэсний компаниуд хамтарсан үйлдвэрийн түншлэгч болох нь	200



а ì í ° ò ã ° ө

Газрын тос, байгалийн хий, ашигт малтмалаар баян олон орны хувьд хөгжилд хүрэхэд хэцүү хэвээр, эдийн засаг нь ороо бусгаа байж, авлига цэцэглэн, зөрчил гүнзгийрч баян нь улам баяжиж, ядуу нь ядуугаараа үлдэж байна. Дэлхийн дахинд байгаа 50 гаруй орны олборлох үйлдвэрлэлүүд асар их баялаг бий болгож байгаа боловч олон үндэстэн энэхүү гэнэтийн их ашгаа урт хугацааны өсөлт, иргэдийн сайн сайхан байдлын сайжралт болгон хувиргаж чадаагүй л байна.

Өнгөрсөн арван жилийн хугацаанд энэхүү “нөөцийн хяслан”-тай тэмцэх зорилготой нэгэн олон улсын хөдөлгөөн төрөн гарсан билээ. Үйлдвэрлэгч, хэрэглэгч орнуудын иргэд хамтран байгалийн нөөц баялгийн олборлолт, ашиглалт дахь засаглалыг сайжруулж, бодитой хариуцлага тооцох үйлсэд нэгдээд байна. Улс төрийн элитүүд, томоохон корпорациуд зонхилон удирдаж нууц байдалд байлгаж ирсэн уламжлалтай энэ салбар үүд хаалгаа нээж эхлэн олон нийтийн хяналтад улам бүр орох боллоо. Үүнийг нөөц баялгаар баян орон бүрийн ирээдүйг шийдвэрлэх үүрэгтэй болгон хувиргах арга замыг иргэний нийгмийн бүлгүүд эрж олсоор байна. Нээлттэй байдлыг нэмэгдүүлэх нь тэдний урт хугацааны ашиг сонирхолд нийцэж болохыг засгийн газрууд ч, компаниуд ч хүлээн зөвшөөрч эхлээд байна.

Энэхүү яриа хэлэлцээр дэх иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС) чухал үүрэг гүйцэтгэж байна. ОУИТБС бол олборлох үйлдвэрлэлийн ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх замаар үйлдвэрлэгч орнуудын засаглал, хөгжлийг бэхжүүлэхийн төлөө ажиллаж буй засгийн газрууд, компаниуд, иргэний нийгмийн хамтарсан олон оролцогч тал бүхий олон улсын санаачилга юм. ОУИТБС-ын үйл явцын Ядуурлыг бууруулах стратегийн баримт бичгүүд (ЯБСББ-үүд) юмуу Байгаль орчинд үзүүлэх нөлөөний үнэлгээнүүдээс ялгаатай тал нь иргэний нийгэмтэй дан ганц зөвлөлдөөд зогсохгүй, тэдэнд суудал олгож, шийдвэрлэх ач холбогдолтой шийдвэрүүдийн үед санал өгөх эрхтэй оролцуулахыг шаарддаг явдал юм.

ОУИТБС-д үр нөлөөтэй оролцож, аливаа улсын олборлох үйлдвэрлэлд хяналт тавина гэдэг бол иргэний нийгмийн хувьд томоохон сорилт юм. Олборлох үйлдвэрлэл бол техникийн, эрх зүйн, санхүүгийн хувьд ч нарийн төвөгтэй салбар байдаг. Бараа, түүхий эдийн зах зээл, нягтлан бодох бүртгэлийн практикууд, институтууд ч өөрсдөө байнга хувьсан өөрчлөгдөж байна. Үүнд олон улсын болон дотоодын улс төрийн бодлого ч ихээхэн үүрэг гүйцэтгэдэг. Мөн ОУИТБС-д оролцдог улс байсан ч гэсэн энэ салбарын нилээд мэдээлэл олон нийтийн хяналтаас гадуур хэвээр үлдсэн байна. Товчоор хэлвэл, иргэний нийгмийн идэвхтнүүдийн хувьд газрын тос, байгалийн хий, уул уурхайн бизнес, улс төрийн бодлогын талбарт хурдацтайгаар түрэн орж ирнэ гэдэг амаргүй ажил билээ.

Эдгээр бэрхшээлээс гадна дайны хөлд зовж зүдэрсэн, урьд өмнө нь төрийн бодлогын ажиллагаандаа иргэдийг оролцуулж байсан тохиолдол байхгүй буюу тийм туршлага багатай орнуудад ОУИТБС-ын олон идэвхтэн амьдарч байна. Олон оролцогч талын засаглал нь нөхцөл байдал хамгийн сайн үед илүү хүчтэй байдаг бөгөөд олборлох үйлдвэрлэлийн асуудалд оролцож байгаа иргэний нийгмийнхэн төрийн ба хувийн хэвшлийнхнийг бодвол мэдээлэл, техникийн боловсрол, нөлөө багатай сул байдлаас гараагаа эхэлж байна.

Эдгээр томоохон саад бэрхшээлийг эс тооцвол, дэлхийн эргэн тойронд байгаа идэвхтнүүдийн ажил зургаахан жилийн өмнө эхэлсэн ОУИТБС-аас хойш эрчимтэй урагшилж байна. Хүмүүст олборлох үйлдвэрлэлийн талаар илүү их мэдээлэл, илүү их ойлголт авах, илүү их оролцох эрмэлзэл их байгаа нь илэрхий байна.

Орлогын ажиглагч хүрээлэн өөр бусад салбарынхан, ОУИТБС-ын мэргэжилтнүүдийн тусламжтайгаар энэхүү *Гүн өрөмдөж үзэхүй* номыг ОУИТБС-д иргэний нийгэм үр нөлөөтэй оролцоход туслах эх сурвалж болгон гаргасан юм. Энэхүү гарын авлагад ОУИТБС-ын үйл явцын үе шат бүрийн дэлгэрэнгүй тоймыг харуулсан байгаа. Энд иргэний нийгмийн гүйцэтгэх үүрэг, мэтгэлцээн ба шийдвэрийн үе шат бүрд гарч болзошгүй гол асуудлууд, янз бүрийн үе шатанд нөлөөлөх боломжууд зэргээс гадна бусад орны иргэний нийгмийн оролцогчид ижил төстэй асуудлуудыг хэрхэн шийдвэрлэж ирсэн, ямар үр дүн гарсан тухай дүрслэн харуулсан байна. Гарын авлагад Харилцан ойлголцлын санамж бичиг, улсын ажлын төлөвлөгөө, аудиторыг сонгох ажиллагаа гэх мэт төрөл бүрийн загвар, үйл явцуудын жишээг оруулжээ. Эдгээр хэрэгсэл бүрийн давуу ба сул талыг харьцуулан шинжлэх нь иргэний нийгмийн цаашдын үйл ажиллагааны хэтийн төлвийг бий болгож өгдөг бөгөөд улмаар ОУИТБС-ын хэрэгжилтийн ил тод, шударга, хариуцлагатай байдлыг дээд цэгт нь хүргэхэд чиглэгдэж байна.

Нөөц баялаг ихтэй орнуудын иргэдийг шаардлагатай дэмжлэг туслалцаа, мэдлэг туршлагаар хангасан тохиолдолд засгийн газар болон үйлдвэрлэлийн салбартайгаа түншлэн ажиллаж нөөцийн хясланг буцаан эргүүлж, улмаар дэлхий дахины олборлох үйлдвэрлэлийн засаглалд ардчилсан хариуцлагатай байдлыг нэвтрүүлж чадна гэсэн итгэл үнэмшилд Орлогын ажиглагч хүрээлэн тулгуурлаж ажилладаг.

Үйлдвэрлэлийн салбар, засгийн газруудад байгаатай ижил хэмжээний өндөр чанартай мэдлэг туршлага, зөвлөгөөгөөр иргэний нийгмийнхнийг хангах гэсэн хүчин чармайлт маань биднийг энэхүү гарын авлагыг зохиогч Дэвид Голдвин, түүний бүтээлч багт хандахад хүргэсэн билээ. Голдвин Интернэйшнл Стратэжиес (ГИС) болон Хартын бүлгийн Крис Ньюрс хоёр Нигерийн ОУИТБС-д шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн бөгөөд энэ туршлагаас олж авсан үнэ цэнэтэй сургамжуудаа харамгүй хуваалцсанд Орлогын ажиглагч хүрээлэнгийн зүгээс талархаж байна.

Гүн өрөмдөж үзэхүй номыг ОУИТБС-ын Нарийн бичгийн газраас гаргасан *ОУИТБС-ыг хэрэгжүүлэх гарын авлага, ОУИТБС-ын баталгаажуулалтын заавар* хоёрын нэмэлт, хавсарга болгон ашиглах зорилготой бүтээсэн юм. Энэхүү сургалтын хэрэгсэл нь иргэний нийгмийн идэвхтнүүд ба бусад сонирхогч талууд ОУИТБС-ын талаар болон тус санаачилгад үр дүнтэй оролцохын тулд авч болох тодорхой алхмуудын талаар ойлгоход нь туслах болно.

Орлогын ажиглагчийн Ванесса Херрингшоу, Хуан Карлос Квироз, Мичелл Сийфф нар удаа дараагийн эх нооргуудад иж бүрэн санал шүүмжлэл гаргаж өгсөн. Энэхүү гарын авлагыг хэвлэгдэн гарах хүртэлх төслийн ажиллагааг Орлогын ажиглагч хүлээлэнгийн мэдээлэл харилцааны менежер Жид Миллер удирдаж, Брендэн Шпийгел, Рэчел Харт, Пэйж Дикстра нар туслалцаа үзүүлсэн юм. Номын эх бэлтгэл, загварыг чадварлаг хийж гүйцэтгэн хувь нэмрээ оруулсан Жюдит Ковач, Жиан Крискола, Эри Корпиваара нарт Орлогын ажиглагч хүрээлэнгийн зүгээс талархал илэрхийлмээр байна.

Орлогын ажиглагч хүрээлэнгийн тухай

Орлогын ажиглагч хүрээлэн (ОАХ) бол ашгийн бус бодлогын институт төдийгүй газрын тос, байгалийн хий, ашигт малтмалын нөөцийг нийтийн сайн сайхны төлөө хариуцлагатайгаар удирдахыг хөхиүлэн дэмждэг тусламж олгогч байгууллага юм. Орлогын үр нөлөөтэй удирдлага, иргэдийн оролцоо, засгийн газрын бодит хариуцлагатай байдалтай тохиолдолд байгалийн нөөц баялаг улс орныг хөгжил цэцэглэлт, үндэсний өсөлтөд хүргэж чаддаг. ОАХ улс орнуудад эдгээр үр ашгийг хүртэхэд нь туслах мэдлэг туршлага, санхүүжилт, техникийн туслалцаагаар хангаж байна.

Орлогын ажиглагч нь улс орнуудыг “нөөцийн хяслан”-гаас сэргийлэхэд нь туслах үүднээс байгалийн нөөц баялгийг ил тод, хариуцлагатай, үр нөлөөтэй удирдахыг хөхиүлэн дэмждэг. Бид нөөц баялаг ихтэй орнуудын олборлох үйлдвэрлэл, орлого бүрдүүлэлт, орлогын удирдлагаас эхлээд зарлагын ажиллагаа, хөгжлийн үр дүнгүүд хүртэл үнэ цэнэт бүхий л гинжин урсгалын хэмжээнд засаглал, хөгжлийн сайжруулах өргөн хүрээтэй арга барил хэрэглэж байна.

Орлогын ажиглагч хүрээлэнг одоогоор Ангол, Азербайжан, Бразил, Камерун, Камбож, Зааны ясан эрэг, БНАКУ, Эквадор, Гүрж, Гана, Гвиней, Индонез, Казахстан, БН Кыргыз Улс, Либери, Мавритани, Мексик, Монгол, Нигр, Нигери, Перу, Сао Томе Принцип, Сьерра Леоне, Танзани, Тринадад Тобаго, Уганда, Йемен зэрэг улсын түнш болон харьяа байгууллагууд дэмжин ажиллаж байна. ОАХ нь Нью-Йоркод төвтэй, Лондонд дагуул оффистой бөгөөд Азербайжан, Гана, Индонез, Малайз, Перу улсуудад тус хүрээлэнгийн бүс нутгийн зохицуулагч нар ажилладаг.

Карин Лиссакерс
Орлогын ажиглагч
хүрээлэнгийн захирал



Òàèàõõàè

Энэхүү гарын авлагыг Голдвин Интернэйшнл Стратэжис (ГИС) баг бэлтгэн боловсруулсан болно. Ингэхдээ Нигерийн үндэсний оролцогч талуудын ажлын хэсэг болон Нигерийн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (НОУИТБС)-д зөвлөгөө өгсөн практик туршлагадаа тулгуурласан юм. ГИС баг 1999-2004 онд НОУИТБС-аас газрын тос, байгалийн хийн үйлдвэрлэлд хийгдсэн санхүүгийн, үйл явцын, биет аудитын түүхэн ажиллагаанд оролцож зөвлөгөө өгсөн бөгөөд 2005 онд дахин зөвлөхөөр ажилласан. Бид мөн шинээр илүү эрчимтэй түрэн гарч байгаа Мөнгөний үнэ цэнийн аудитаас гадна 2006 оны аудитын бүтэц, нөхцлүүд ямар байх талаар Нигери Улсад зөвлөгөө өгсөн. Энэ ажиллагааны үе шат бүрт, түүний дотор ОУИТБС-ыг эхлүүлэх, менежерүүдээр хангахад оролцох, ОУИТБС-ын тайлангуудыг ойлгох, уг тайлангийн талаар сурталчилж түгээн дэлгэрүүлэх, хэлэлцэх холбогдох асуудлыг боловсруулах шатуудад бидэнд ихээхэн сорилт бэрхшээл тулгарч байлаа. Оролцогч талуудад тулгарсан сорилтуудыг шийдвэрлэх талаар бидний гаргасан ололт амжилт, олж авсан гүнзгий туршлага нь бусад орнууд гол шийдвэрүүдээ хэрхэн гаргаж, оролцооныхоо үр нөлөөг хэрхэн дээд зэргээр нэмэгдүүлэх талаар зөвлөхөд маань тусалж байна. Түүнчлэн бид ОУИТБС-ыг даган мөрдөж байгаа компаниудад зөвлөгөө өгч байсан туршлага, орлогын ил тод байдал, засаглалын чиглэлд ухамсартайгаар манлайлах талаар хийсэн ажлууд, мөн нээлттэй эх сурвалжуудыг судлах, ярилцлага хийх замаар ОУИТБС-ын одоогийн практикуудад хийсэн өргөн хүрээтэй шинжилгээндээ тулгуурладаг.

Гарын авлага боловсруулах ажлыг ГИС-н ерөнхийлөгч Дэвид Голдвин удирдан явуулсан юм. ГИС-н ахлах судлаач Шэйла Мойнихан ОУИТБС-ын өнөөгийн практикуудыг судлах ажлыг өргөн хүрээтэй явуулж, хүснэгт, шигтгээ сэдвүүдийг бэлтгэсний зэрэгцээ сургалтын гарын авлага боловсруулж, эхийг гаргасан болно. Энэ төслийг амжилттай дуусгахад түүний тавьсан анхаарал, нягт нямбай байдал, дийлдэшгүй хөгжилтэй зан туйлаас чухал байлаа. Түүнчлэн

ГИС-н Семийл Хэсибиёглу, Жэмий О'Мийлия, Фаарназ Чэвоуши нар судалгааны болон редакторын ажлын дэмжлэг үзүүлсэн.

Христофер Ньюрс болон түүнтэй хамтран ажиллагч Хартын бүлгийн гишүүд, Харт Ньюрсийн мэргэжсэн нягтлан бодогч нар, тухайлбал Сэм Афемихе, Энди Аллингтон, Крис Морган нар 1999-2005 он, 2005 онд Нигерид аудиторoor, Камерунд ОУИТБС-ын тоо баримт тулгагчаар болон уул уурхайн асуудлаарх олон улсын зөвлөхөөр ажилласан туршлагаа ашиглаж нягтлан бодох бүртгэл, аудит, уул уурхай, төсөв санхүүгийн асуудлын тухай хэсгүүдийн агуулгыг хянан засварлахад хувь нэмрээ оруулахын зэрэгцээ гарын авлагыг хянан үзэж аудиторын ба тоо баримт нэгтгэн дүгнэгчийн байр сууринаас төрөн гарч буй практик асуудлуудыг тусган гаргасан болно.

НОУИТБС-ыг тодорхойлох, хэрэгжилтийн хянах хүчин чармайлтын бүр эхнээс ГИС-н багт ажиллаж байсан Мэйлэндер & Компани-гийн удирдах захирал Христофер Мэйлэндер редакцийн засвар хийх ажилд ихээхэн дэмжлэг үзүүлсэн. Крисийн хувьд чадварлаг аудитор, менежментийн зөвлөхүүд сонгон шалгаруулахаар НОУИТБС-аас зарласан олон улсын тендерүүдийг боловсруулж, удирдахад туслах талаар ГИС-д ажилласан практик туршлагадаа болон НОУИТБС-ын тайлангийн үр дүнг нийтэд түгээн дэлгэрүүлэх мэдээлэл харилцааны стратеги боловсруулсан туршлагадаа тулгуурласан болно. Аудитор, нэгтгэн дүгнэгч нарын сонголт, мэдээлэл харилцаатай холбоотой хэсгүүдэд түүний зөвлөгөө, туршлагыг ихээр ашигласан болно.

Гарын авлагын эхний нооргуудыг Их Британий Олон Улсын Хөгжлийн Департаментийн голлох гишүүн, одоо Дэлхийн Банкинд ажиллаж байгаа Сифтон Дарби уншиж хянасан. Сиф болон түүний багийнхан ОУИТБС-ын одоогийн практикийн тухай олон жишээг бидэнтэй хуваалцаж, уг гарын авлагын хэв маяг, гол утга агуулгын талаар үнэтэй саналууд гаргаж өгсөн билээ.

Мөн *Газрын тос, ашиг, энх тайван* (АНУ-ын Энх тайвны хүрээлэнгийн хэвлэл, 2006 он) номын зохиогч Жилл Шэнклман эхний нооргийг хянаж, номын хэв маяг, бүтцийн тухай санал гаргасныг энэхүү гарын авлагыг эцэслэн гаргахад ашигласан болно.

Энэхүү төслийг надад итгэн хариуцуулж, гарын авлагын хэв маяг, бүтэц, утга агуулгын талаар сайхан саналууд гаргаж, эхнээс нь эцсийг хүртэл удирдан зохицуулсан Орлогын ажиглагч хүрээлэнгийн Жюлийн МакКарти, Мичелл Сийфф нарт миний бие гүн талархал илэрхийлж байна.

Хувь нэмрээ оруулсан энэ бүх хүмүүс зохих гавьяаг хүртэх ёстой бөгөөд харин гарын авлагад орсон аливаа алдаа, дутагдлыг хариуцлагыг миний бие дангаар хүлээх болно.



ᠠ ᠳᠥᠭᠡᠢ

ОУИТБС гэж юу вэ?

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС) гэдэг бол олборлох үйлдвэрлэлд ил тод байдлыг бий болгоход чиглэсэн хараат бус, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, сайн дурын стандарт юм. ОУИТБС-ын үндсэн санаа бол аливаа улс үндэстний газар доорх нөөц баялгийг олборлон гаргахтай холбоотойгоор компаниудаас улсад төлж байгаа төлбөрүүд, засгийн газруудын хүлээн авч байгаа орлогуудыг ил тод байлгахыг шаардах явдал юм. Энэхүү ил тод байдал нь тэдгээр нөөц баялгийн удирдлагын төлөө засгийн газартайгаа хариуцлага тооцох эрх мэдлийг иргэний нийгэмд олгоход тус дөхөм болдог.

ОУИТБС-ыг анх 2002 онд эхлүүлснээс хойш энэхүү стандартыг тогтоох ажилд иргэний нийгэм, засгийн газрууд, компаниуд, хөрөнгө оруулагчид бүгд идэвхтэй үүрэг гүйцэтгэж ирсэн юм. Одоогоор 40 гаруй улс ОУИТБС-ыг хэрэгжүүлэхээр амлаад байна. 2006 оны 10 дугаар сард болсон ОУИТБС-ын бага хурлаар ОУИТБС-ын хэрэгжилтийг удирдан зохицуулах олон оролцогч тал бүхий олон улсын удирдах зөвлөл бий болгож, орон тооны Нарийн бичгийн газар байгуулсан. Мөн уг бага хурлаар ОУИТБС-д оролцох үүрэг амлалт авсан улс орон, компаниуд үйл ажиллагааныхаа тайланг хараат бус гуравдагч талд илгээн үнэлүүлэх замаар олон улсын стандартыг хангахад гарч буй ахиц дэвшилээ тогтмол баталгаажуулж байхыг шаардсан юм. Энэхүү баталгаажуулалт нь улс орнууд ба компаниудын зүгээс хийж хэрэгжүүлэхээр амласан зүйлээ хийж байгаа эсэх, хэрэгжүүлэлтийн хөтөлбөр нь ОУИТБС-ын Шалгуурууд (Зураг 1.1-с үзнэ үү) ба Зарчмуудад¹ (Зураг 1.2-с үзнэ үү) бүрэн нийцэж байгаа эсэхийг шалгаж тогтоох зорилготой байдаг. Энэхүү номыг бичиж байх мөчид баталгаажуулалтын үнэлгээнд орсон улс орон хараахан байхгүй байлаа.

Зураг 1.1: ОУИТБС-ын Шалгуурууд

1. Компаниудаас засгийн газарт төлж байгаа газрын тос, байгалийн хий, уул уурхайн холбогдолтой бүх материаллаг төлбөр ("төлбөрүүд"), ба газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниудаас засгийн газарт хүлээн авсан бүх материаллаг орлого ("орлогууд")-ын талаар өргөн олон нийтэд зориулж хүртээмжтэй, ойлгомжтой, цогц байдлаар тогтмол хэвлэн нийтэлж байх.
2. Хэрэв хөндлөнгийн хяналт байхгүй бол дээрх төлбөр болон орлогуудыг итгэмжлэгдсэн, хараат бус аудитаар олон улсын аудитын стандартын дагуу шалгуулдаг байх.
3. Төлбөр болон орлогыг итгэмжлэгдсэн, хараат бус захирагчаар олон улсын аудитын стандартууд хэрэглэн нэгтгэн дүгнүүлж, хэрэв ямар нэг зөрүү, зөрчилтэй байдал илэрсэн бол энэ талаарх тухайн захирагчын дүгнэлтийг хэвлэн нийтэлдэг байх.
4. Энэ аргыг бүх компаниуд, түүний дотор төрийн өмчит үйлдвэрийн газруудад хамааруулан хэрэглэдэг байх.
5. Дээрх үйл явцыг зохион байгуулах, түүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд иргэний нийгэм идэвхтэй оролцох бөгөөд олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэхэд хувь нэмрээ оруулдаг байх.
6. Санаачилгыг хэрэгжүүлж буй хүлээн авагч засгийн газар, шаардлагатай тохиолдолд олон улсын санхүүгийн байгууллагуудын тусламжтайгаар, дээрх бүх үйл явцад зориулан санхүүгийн хувьд тогтвортой үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах бөгөөд энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөөнд хэмжиж болохуйц зорилтууд, хэрэгжүүлэх хугацаа, гарч болзошгүй хүндрэл бэрхшээлийн үнэлгээ зэргийг багтаасан байх.

Зураг 1.2: ОУИТБС-ын Зарчмууд

1. Бид, байгалийн нөөц баялгийг ухаалаг ашиглах нь тогтвортой хөгжил, ядуурлыг бууруулахад чухал хувь нэмэр оруулдаг эдийн засгийн тогтвортой өсөлтийн нэг чухал хөшүүрэг бөгөөд хэрэв үүнийг зөв зохистой удирдахгүй бол нийгэм эдийн засгийн сөрөг үр дагаварт хүрч мэднэ гэдэг итгэл үнэмшлийг хуваалцдаг.
2. Бид, аливаа улс орон байгалийн нөөц баялгаа ард иргэдийнхээ тусын тулд ашиглах нь үндэсний хөгжлийнхөө ашиг сонирхлыг гүйцэлдүүлэх гэсэн тусгаар улсын засгийн газруудын анхаарлын төвд байдаг гэдгийг баталж байна.
3. Бид, нөөц баялгийг олборлосны ашиг тус нь олон жилийн турш хуримтлагдах орлогын урсгалаар бий болох бөгөөд энэ нь үнээс өндөр хамааралтай байх болно гэдгийг хүлээн зөвшөөрч байна.
4. Бид, засгийн газрын орлого, зарцуулалтын талаар ард иргэд ямар нэг ойлголттой байх нь цаашдаа тогтвортой хөгжлийн зохистой, бодитой хувилбаруудын сонголтын талаар олон нийтийн хэлэлцүүлэг явуулах, мэдээлэл өгөхөд тустай байж болохыг хүлээн зөвшөөрч байна.
5. Бид, олборлох салбарт ажиллаж буй засгийн газар ба компаниудын ил тод байхын чухлыг болон төрийн санхүүгийн удирдлага, хариуцлагатай байдлыг сайжруулах шаардлагыг онцлон тэмдэглэж байна.
6. Бид, ил тод байдлыг илүү ихээр хангах явдлыг гэрээ хэлэлцээр, хууль тогтоомжуудыг хүндэтгэн үзэх хүрээнд явагдах ёстой гэдгийг хүлээн зөвшөөрч байна.

7. Бид, гадаад, дотоодын шууд хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах нь санхүүгийн ил тод байдлыг авчрах болно гэж үзэж байна.
8. Бид, улсын төсвийн орлого, зардлын урсгалыг зохицуулах талаар засгийн газрын бүх ард түмнийхээ өмнө хүлээсэн хариуцлагын зарчмууд болон практик үйл явцад итгэж байна.
9. Бид, нийгмийн амьдрал, бизнесийн болон засгийн газрын үйл ажиллагаанд ил тод байдал, хариуцлагын дээд зэргийн стандартуудыг дэмжин нэвтрүүлэхийн төлөө байна.
10. Бид, төлбөр болон орлогыг ил тод болгоход чиглэсэн өргөн хүрээтэй уялдаа холбоо бүхий, хэрэгжихүйц бөгөөд хэрэгжүүлэх, ашиглахад энгийн хялбар арга барил хэрэглэх шаардлагатай гэдэгт итгэлтэй байна.
11. Бид, аливаа улс орон дахь төлбөр тооцоог ил тод болгоход тухайн оронд үйл ажиллагаагаа явуулж байгаа олборлох үйлдвэрлэлийн бүх компаниудыг хамруулах ёстой гэж үздэг.
12. Бид, аливаа шийдвэр гаргахад бүх оролцогчид, түүний дотор засгийн газар, түүний агентлагууд, олборлох үйлдвэрлэлийн компаниуд, үйлчилгээний компаниуд, олон талт байгууллагууд, санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулагчид, төрийн бус байгууллагууд дор бүрнээ тус тусын чухал хувь нэмрийг оруулдаг гэдэгт итгэдэг.

ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд ямар алхмууд шаардагддаг вэ?

ОУИТБС-ын үйл ажиллагаа нь Элсэн орох, Бэлтгэх, Тайлагнах, Түгээн дэлгэрүүлэх гэсэн дөрвөн үе шаттай байна. Үе шат бүрт улс орнуудын дагаж мөрдөх ёстой алхмуудыг Баталгаажуулалтын хүснэгтэд (Хавсралт А-г үзнэ үү) дэлгэрэнгүй харуулсан байгаа. Эдгээр алхмуудыг хэрхэн хэрэгжүүлэх тухай илүү дэлгэрэнгүй тайлбарыг уг хүснэгтэд дурдсан Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгсэл (ҮҮХ)-д (Хавсралт Б-г үзнэ үү) оруулсан байгаа. Улс орнууд өөрсдийгөө нэг бол “нэр дэвшигч” орон (Элсэн орох шатыг дуусгаснаар ОУИТБС-ыг хэрэгжүүлэхээр нухацтайгаар бэлтгэж буй орнууд), аль эсхүл “дагаж мөрдөгч” орон (дөрвөн шатыг бүгдийг нь дагаж мөрдөж байгаа орнууд) байхаар мэдүүлэх ёстой. ОУИТБС-ыг “дагаж мөрдөгч”-д тооцогдохыг хүсч буй орнууд 2008 оны 11 дүгээр сард багтаж баталгаажуулалт хийлгэсэн байх ёстой. Харин нэр дэвшигчид тооцогдох хүсэлтэй байгаа орнууд Элсэн орох үе шатны алхмуудыг хийж дууссанаа харуулан 2007 оны намар “урьдчилсан баталгаажуулалт”-д орохыг ОУИТБС-ын Удирдах зөвлөлөөс шаардаж байгаа.

ОУИТБС-ыг дагаж мөрдөгчөөр баталгаажих орнуудын хувьд хийж дуусгах ёстой 18 алхам байдаг. (Зураг 1.3-г үзнэ үү)

Элсэн орох (1-4 дүгээр алхам)

Тухайн улсын засгийн газар ОУИТБС-ыг хэрэгжүүлэхийг дэмжсэн тууштай мэдэгдэл гаргах; иргэний нийгэм ба компаниудтай хамтарч ажиллах үүрэг амлалт авах; уг ажлыг удирдаж ахлах хүнээ томилох; *хэмжиж болохуйц зорилтууд, хэрэгжүүлэх ажлын хуваарь бүхий зардлыг бүрэн тусгасан ажлын төлөвлөгөө* боловсруулж, оролцогч талуудын *чадавхид тулгарч болзошгүй хүндрэл бэрхшээлд үнэлэлт* өгөх ёстой.

Бэлтгэх (5-13 дугаар алхам)

Энэ үе шатанд олон оролцогч талын бүлэг байгуулах (ООТБ); компаниуд, иргэний нийгмийнхнийг татан оролцуулах; иргэний нийгмийн оролцоонд тулгарч буй саад тотгоруудыг арилгах; компаниуд ба засгийн газрууд төлсөн төлбөр, хүлээн авсан орлогоо тайлагнах маягтын загварын талаар хэлэлцэн тохиролцох; компаниудын төлсөн төлбөр ба засгийн газруудын хүлээн авч буй орлогын дүнг тулгах байгууллагыг ООТБ-ээс батлах; бүх компаниуд төлж буй төлбөрөө тайлагнадаг байх нөхцлийг бүрдүүлэх арга хэмжээ авах; компаниуд ба засгийн газрын гаргасан тайлангууд олон улсын стандартын дагуу аудитлагдсан бүртгэл тооцоонд тулгуурласан байх баталгааг засгийн газраас гаргаж өгөх зэрэг ажиллагаа орно.


Ил тод тайлагнах (14-17 дугаар алхам)

Компаниудаас тухайн засгийн газарт төлж байгаа бүх материаллаг төлбөрүүд, тухайн засгийн газрын компаниудаас хүлээж авсан бүх материаллаг орлогуудыг тэдгээр тоо баримтыг нэгтгэн тулгах, ОУИТБС-ын тайлан гаргах үүрэг бүхий гэрээт байгууллагад гаргаж өгсөн байх ёстой. Энэхүү гэрээт байгууллага нь тоо баримтыг зөв зохистой нэгтгэж тулгасан, тайландаа зөрүүтэй байдлыг тогтоож, авбал зохих арга хэмжээг зөвлөмж болгосон гэдэгт олон оролцогч талын бүлэг сэтгэл ханамжтай байх ёстой.

Түгээн дэлгэрүүлэх (18 дугаар алхам)

ОУИТБС-ын тайланг нийтэд хүртээмжтэй, дэлгэрэнгүй, ойлгомжтой байдлаар олон нийтийн хүртээл болгосон байх ёстой.

Зураг 1.3: ОУИТБС-ын баталгаажуулалтын арга зүй



Хэрэгжүүлэлтийн заавартай байх шаардлага

ОУИТБС бол ил тод байдлыг дээшлүүлэхэд иргэний нийгэмд туслах хэрэгсэл юм. Иргэний нийгмийн байгууллагууд (ИНБ) ОУИТБС-ыг хэрхэн учир утгатайгаар ашиглахаа ойлгох шаардлагатай байна. Өнөөдөр ОУИТБС-ыг хэрэгжүүлж буй практикууд маш олон янз байна:

- ОУИТБС-ыг хэрэгжүүлэх сонирхолоо дөчин улс илэрхийлээд байгаа боловч үүнийг бичиж байх мөчид дөнгөж наймхан орон ОУИТБС-ын тайлангаа гаргаад байна (Азербайжан, Камерун, Габон, Гана, Гвиней, Кыргызстан, Мавритани, Нигери). Эдгээр найман орны долоо нь засгийн газар ба компаниудын тоо баримтыг нэгтгэн тулгаж нийтлээд байна. Үүнд хамрагдсан талууд олон улсын стандартуудын дагуу аудитлагдсан тоо баримтаа ирүүлэх шаардлагатай байдаг. ОУИТБС-ын дагуу тоо баримтыг нэгтгэж тулгах ажиллагаа нь төлсөн төлбөрүүд ба хүлээн авсан орлогуудын тайлан тохирч байгаа эсэхийг шалгадаг боловч эдгээр тайлагнасан дүнгүүд үнэн хэрэгтээ үнэн зөв эсэхийг бодитойгоор харуулдаггүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.
- Баталгаажуулалтын шалгуурууд гараад удаагүй байгаа учир одоохондоо ОУИТБС-ын баталгаажуулалт хийлгэх хүсэлт гаргасан буюу хийлгэсэн улс орон байхгүй байна.
- ОУИТБС-ыг дагаж мөрдөх хүсэл сонирхолоо нийтэд зарласан орнуудын дотроос ганцхан Нигери Улс л олборлох үйлдвэрлэлд оролцож байгаа компаниуд болон холбогдох төрийн байгууллагуудын данс бүртгэлд иж бүрэн аудит хийлгээд байна. Нигерид хийсэн аудитаар татвар, нөөц ашигласны төлбөр ба бусад мөнгөн дүнгүүдийн цаад тооцоог буруу хийсэн нь тогтоогдсон. Эдгээр алдааг засч залруулснаар улсын төсвийн орлого бүрдүүлэлтийг нэмэгдүүлээд зогсохгүй татварын хяналт шалгалт хийх, нөөц ашигласны төлбөр тогтоох ажиллагааг сайжруулах зөвлөмж гаргахад хүргээд байна. (Шигтгээ 1.1-г үзнэ үү).

Шигтгээ 1.0: ОУИТБС-ын жишээ-Нигери дэх орлогын боломжит алдагдал

- Компаниудад Газрын тосны бүтээгдэхүүний ашгийн татвар ногдуулах, хураах тал дээр Холбооны дотоод орлогын алба (ХДОА) идэвхи санаачилгагүй ажиллаж байна. Энэ нь татвараа эмх замбараагүй тодорхойлоход хүргэсэн байна.
- Түүхий нефтийн үйлдвэрлэлийн хэмжээний тухай ХДОА-ны тоо баримт нь нүүрсөрөгчийн нийт хэмжээний тэнцлээс гарсан аливаа мэдээлэлтэй тулгагдаагүй байв.
- ХДОА-ны албаны бүртгэл хөтлөх системүүд хангалтгүй байв. ХДОА давхар бичилтийн системээр бүртгэл хөтлөөгүй төдийгүй зохих ёсны бэлэн мөнгөний анхан шатны бүртгэл, журнал хөтлөөгүй байна.
- Газрын тосны нөөцийн газар (ГТНГ) нь нөөц ашигласны төлбөр ногдуулах, хураах бүрэн эрхээ энэхүү үнэлгээний хугацаанд нотлон харуулсангүй.

НОУИТБС-ын Аудитын тайлангийн Гүйцэтгэлийн хураангуй, хуудас 11

- Тоон мэдээллээ тайлагнаад байгаа найман орны хоёр нь тоо баримтаа “задалсан” байдлаар тайлагнаж байгаа нь компани бүрийн төлсөн татвар, нөөц ашигласны төлбөр, төлбөрийн төрөл, ангилал бүрээр (татвар, нөөц ашигласны төлбөр гэх мэт) дүрслэн харуулсан гэсэн үг. Үлдэж байгаа тайлагнагч орнуудын хувьд санхүүгийн тоо баримтаа “нэгтгэсэн” байдлаар тайлагнаж байгаа нь санхүүгийн мэдээллийг компани бүрээр, эсхүл төрөл ангилал бүрээр гэхээсээ илүү нэгдмэл байдлаар тайлагнасан гэсэн үг. Түүнчлэн зарим орнууд олборлох үйлдвэрлэлд хамрагдаж байгаа бүх компани төлсөн төлбөрөө тайлагнахыг шаардаж байхад бусад орнууд зөвхөн томоохон компаниуд ингэж тайлагнахыг шаардаж байна. (Хүснэгт 1.1-г үзнэ үү)

Хүснэгт 1.1: ОУИТБС-ын тайлагнагч орнууд тоо баримтаа хэрхэн задалдаг вэ

Улс	Компаниар задалсан?	Төлбөрийн төрлөөр задалсан?	Аудит, эсхүл тулгалт хийсэн?
Азербайжан	Үгүй	Тийм	Тулгалт
Камерун	Үгүй	Тийм	Тулгалт
Габон	Үгүй	Тийм	Тулгалт
Гана	Тийм	Тийм	Тулгалт зарим нэмэлт сорилын хамт
Гвиней	Үгүй	Тийм	Тулгалт
БН Кыргыз Улс	Үгүй	Тийм	Тулгалт
Мавритани	Үгүй	Тийм	Тулгалт
Нигери	Тийм	Тийм	Аудит

Эх сурвалж: Азербайжан, Камерун, Габон, Гана, Гвиней, БН Кыргыз Улс, Мавритани, Нигери улсуудын тайланг үзэх холбоосыг www.eitransparency.org/section/countries хаягаар болон Хүснэгт 3.1-ээс үзэж болно.

Аливаа улсын ОУИТБС-д оролцогч талуудтай холбоотой хамгийн чухал олон шийдвэрийг хэрэгжүүлэлтийн нэн тэргүүний шатуудад гаргадаг бөгөөд энэ үед иргэний нийгмийн бүлгүүдийн ОУИТБС-ын тухай ойлголт хамгийн сул, ОУИТБС-ын үйл явцын ашиг тустай байдлыг тодорхойлох гол шийдвэрүүдэд оролцох бэлтгэл хамгийн бага байдаг. Жишээлбэл, Азербайжан улсад өөрөө сонгогдоогүй байсан нэгэн төрийн бус байгууллага (ТББ)-ын эвсэл Харилцан ойлголцлын санамж бичгээр ОУИТБС-ын шаардлагын хүрээг хүлээн зөвшөөрч тус санаачилгад нэгдсэн бөгөөд уг санамж бичиг нь ОУИТБС-ын ажиллагааны эхний тайлагнах хэлбэр (нэгтгэсэн байдлаар) гэх мэт асуудлуудыг тодорхойлсон байв. Түүнээс хойш уг эвсэл хувьсан хөгжиж 90 гаруй гишүүнийг эгнээндээ нэгтгэдэг болоод байна.

Энэхүү үйл явцын үе шат бүрт гаргах шаардлагатай шийдвэрүүд, тэдгээрийн цаана мэдээллээр хангах асуудлуудыг ИНБ-ууд, компаниуд, засгийн газрууд зөвөөр ойлгоход туслахад энэхүү гарын авлага зайлшгүй шаардлагатай юм. Мөн яагаад ОУИТБС-ын наад захын шаардлагуудаас цааш явах шаардлагатай, түүгээр ч зогсохгүй яваандаа тайлагнасан мэдээллийг илүү нарийн шалгаж судлах шаардлагатай тухай шалтгааныг оролцогч талуудад тайлбарлан ойлгуулахад энэхүү гарын авлага чухал шаардлагатай байх болно.

Зураг 1.4: ОУИТБС-ын Үндсэн ба Нэмэлт хүрээ

ОУИТБС-ын Үндсэн хүрээ

- Газрын тос, байгалийн хий, уул уурхайн салбарт оролцогчид бүх төлбөрөө ил тод тайлагнах
- Хараат бус, гуравдагч тал нэгтгэн тулгах
- Тайлагнасан төлбөрүүдийг тулгаж, илэрсэн зөрүүтэй байдлыг нийтэд тайлагнах
- ОУИТБС-ын тулгалтаас олж мэдсэн зүйлсийг тогтмол нийтлэх

ОУИТБС-ын 'Нэмэлт' хүрээ

- *Нэгтгэн тулгалтаас аудитад шилжих*
Олж тогтоосон зөрүүтэй байдлыг шалгаж баталгаажуулах
- *Мөнгөний үнэ цэнийн аудит хийх:*
Томоохон төслүүдийн зардлын бүтцэд аудит хийх
- *Зэрэгцүүлэлт:*
Төслүүдийн гүйцэтгэлийг дотоодын бусад төслүүд болон олон улсын төслүүдийн жишигтэй харьцуулах
- *Биет аудитуд:*
Олборлосон биет бараа, түүхий эд, холбогдох ажиллагааг хэмжих
- *Үйлдвэрлэлийн үйл явцыг шалгах:*
Тусгай зөвшөөрөл олголт, портфелийн менежмент, улсын хөрөнгө оруулалтууд, орон нутгийн агуулга
- *Орлогын хүрээнээс хальж түгээлтэд анхаарах:*
Бүсийн болон орон нутгийн түвшинд хийгдэх хуваарилалт, түгээлт, хүлээн авалт, ашиглалт

ОУИТБС-ын Үндсэн ба Нэмэлт хүрээ

ОУИТБС-д зөвхөн олборлох үйлдвэрлэлийн компаниудын төлсөн материаллаг төлбөрүүд, тухайн засгийн газрын хүлээн авсан орлогуудыг нэгтгэн тулгаж, үр дүнг нийтлэхийг шаарддаг. Компаниуд, эсхүл засгийн газраас өгсөн тоо баримт нь оролцогч талууд тоон мэдээллийг өөр хэлбэрээр (ихэвчлэн тоо баримтын байгаа аль ч хэлбэрээр) хүлээн авахаар тохирсноос бусад тохиолдолд олон улсын аудитын стандартын дагуу аудитлагдсан санхүүгийн тайлангуудаас авсан байх ёстой. Өнөөдөр ОУИТБС-ыг хэрэгжүүлж буй нэгээс бусад орны хэрэглэж байгаа энэхүү нэгтгэн тулгалтын үйл ажиллагааг бид ОУИТБС-ын үндсэн хүрээ гэж нэрлэж байна. Аливаа сайн дурын зөвшилцөлд чиглэсэн системд байдаг хамгийн чухал эхний алхам бол ийм нэгтгэн тулгалт хийхээр хуульчлан батлахыг зөвшөөрөх явдал байх нь олонтаа. Гэвч ийм нэгтгэн тулгалт нь зөвхөн тайлагнасан дүнгүүд таарч байгаа эсэхийг харуулахаас биш тэдгээр дүн үнэн зөв эсэхийг харуулдаггүй. Олборлох үйлдвэрлэлийн орлогыг удирдахад тулгардаг нилээд асуудлууд өнгөн давхаргын дор, далд үлдэх нь олонтаа: Нөөц ашигласны төлбөрийг үйлдвэрлэлийг үнэн зөв хэмжээнд тулгуурлаж төлсөн үү? Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний төр эзэмших хувийг бодитой үнээр борлуулсан уу? Компаниуд гаргасан зардлаа суутгаж хасалт хийхийг гэрээгээр зөвшөөрсөн байсан уу? Үндэсний газрын тосны компани татвар, эсхүл нөөц ашигласны

төлбөрт ногдох хувиа төв банкинд цаг хугацаанд нь, үнэн зөв дүнгээр тушаасан уу?

Нэгтгэн тулгаж байгаа тоо баримтуудын цаана хийгдэж байгаа гүйлгээг шалгадаггүй тохиолдолд болон түүнийг шалгах хүртэл эдгээр орлого, төлбөрүүд ямар нэг тооцооны алдаа, заль мэх, авлигад өртөмтгий байдаг. Ийм учраас оролцогч талууд ОУИТБС-ын Үндсэн хүрээнээс Нэмэлт хүрээнд шилжих асуудлыг авч үзэх хэрэгтэй. ОУИТБС-ын Нэмэлт хүрээ нь тоо баримтын нэгтгэн тулгалтаас илүү гүн гүнзгий шалгалт хийдэг. Энэ нь цаад төлбөр тооцоонд хяналт шалгалт хийх, биет үйлдвэрлэлийн хэмжээг нягтлан шалгах, тухайн салбарын үйл ажиллагаа хэрхэн явагдаж байгааг үнэлж дүгнэх ажиллагаа байж болно.

Гарын авлагын бүтэц

Энэхүү гарын авлага гурван хэсэгтэй. I хэсэгт ОУИТБС-ын хэрэгжилтийн дөрвөн үе шатыг дэс дараатайгаар авч үзнэ. Энэ нь уншигч тухайн шат бүрт гаргадаг гол шийдвэрүүдийг мэдэж авахад туслахаас гадна эхний шатуудад асуух асуулт, хөндөгдөх асуудлуудыг танилцуулах зорилготой.

II хэсэгт олборлох үйлдвэрлэлийн ил тод байдалтай холбоотой дээд түвшний асуудлуудыг хамруулж байна. Энд олборлох үйлдвэрлэлийн эрх зүйн болон эдийн засгийн хүрээг гэрээний хэлбэрүүдээс эхлээд засгийн газруудын хүлээн авч буй төлбөрийн төрлүүдийг хүртэл тайлбарлана. Энэ хэсэг нь ямар төрлийн төлбөрүүд хамрагдах ёстой, яагаад чухал байдаг талаар уншигчид ойлгоход тустай байх болно. Мөн гарын авлагын энэ хэсэгт засгийн газарт төлөх өрийн тооцоог хийхэд алдаа гардаг гол чиглэлүүд болон оролцогч талууд яагаад тоо баримтын цаана хийгдэж буй гүйлгээг тодорхой хэмжээнд шалгахыг шаардах ёстой талаар буюу ОУИТБС-ын Нэмэлт хүрээний талаар авч үзнэ.

III хэсгийг “ОУИТБС-ын үндсэн хүрээг гүнзгийрүүлэх нь” гэж нэрлэсэн. Гарын авлагын энэ хэсэгт яагаад бүх оролцогч талууд ОУИТБС-ын үйл явцыг өөрчлөн хөгжүүлэх сонирхолтой байдаг талаар болон энэхүү үйлсийн чадамжийг бүрэн ойлгохын тулд ОУИТБС-ын шаардлагын хүрээг өргөтгөхөд анхаарвал зохих гол чиглэлүүдийн талаар тайлбарласан байна.



| ХЭСЭГ

ОҮИТБС-ын үйл
явцын дөрвөн
үе шат

ГҮН ӨРӨМДӨЖ ҮЗЭХҮЙ

БҮЛЭГ 1

Үеңүгí î ðî õ ¿à øàò

Элсэн орох үе шат бол ОҮИТБС-ыг хэрэгжүүлэхэд чиглэсэн анхны алхам юм. Энэ үед аливаа засгийн газар ОҮИТБС-ыг нухацтайгаар авч үзэж байгаагаа илэрхийлэх ёстой. Ингэхдээ:

- ОҮИТБС-ын хэрэгжилтийг дэмжих хүсэл сонирхолоо илэрхийлсэн тууштай мэдэгдэл гаргах
- ОҮИТБС-ыг хэрэгжүүлэх ажилд иргэний нийгэм ба компаниудтай хамтран ажиллах үүрэг амлалт авах
- ОҮИТБС-ын хүчин чармайлтыг удирдаж ажиллах хүнийг томилох
- хэмжиж болохуйц зорилтууд, хэрэгжүүлэх ажлын хуваарь бүхий зардлыг бүрэн тусгасан үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, оролцогч талуудын чадавхид тулгарч болзошгүй хүндрэл бэрхшээлд үнэлэлт өгөн, тэдгээрийг нийтлэх² ёстой.

ОҮИТБС-ын хүчин чармайлтыг анхлан боловсруулж буй энэ үед иргэний нийгмийн байгууллагууд (1) зохион байгуулалтад орох, (2) зорилго зорилтуудаа тодорхойлох, (3) зорилтуудаа биелүүлэхэд нь туслаж чадах хараат бус мэргэжилтнүүдээс мэргэжлийн дэмжлэг туслалцаа авах, (4) төр засгийн өндөр албан тушаалтнуудыг татан оролцуулах, (5) тухайн улсын Үйл ажиллагааны төлөвлөгөөг үнэлж эхлэх, (6) ООТБ-т орох ИНБ-дын төлөөлөгчдийг сонгоход оролцох, (7) ИНБ-уудаар албан ёсоор зөвшөөрүүлэхээр санал болгосон харилцан ойлголцлын санамж бичгийн төслийг нарийвчлан шалгах ёстой.

1.1 Зохион байгуулалтад орох

Улс орон бүр өөр өөр төрлийн иргэний нийгэмтэй байдаг бөгөөд хүмүүс ихэвчлэн өөр өөр асуудлыг тойрч зохион байгуулалтад ордог билээ. Зарим улс хүчтэй ТББ-уудтай эсхүл бүр иргэний нийгмийн эвслүүдтэй байдаг нь илүү том эвсэл байгуулах үндэс болдог.

Гана Улсад нийгмийн шударга ёс, хүний үндсэн эрхийг хөхиүлэн дэмжих эрхэм зорилго бүхий ISODEC буюу Нийгмийн хөгжлийн нэгдсэн төв нэртэй нөлөөллийн ТББ байсан нь ОУИТБС-ын иргэний нийгмийн хөдөлгөөний үндэс суурь болжээ³.

Гвиней Улсын Иргэний нийгмийн байгууллагуудын үндэсний зөвлөлийн ерөнхийлөгч нь үндэсний оролцогч талуудын хороог байгуулсан бүлэгт суудалтай болсон байна.

ОУИТБС-ын эвсэл байгуулах нь маш их ашиг тустай байж болно. Энд төрөл бүрийн ИНБ-ууд өөр өөрийн давуу талтайгаар хувь нэмрээ оруулж болно. Тэдний зарим нь олборлох үйлдвэрлэлийн талаар сайн мэддэг байхад, зарим нь төсвийн хариуцлагатай байдлыг дагнасан, зарим нь хүний эрх, эсхүл байгаль орчны асуудалд анхаарлаа хандуулдаг байж болно. Тэд хамтарч нэгдсэнээр ИНБ-уудын үзүүлэх нөлөө дээшилж, засгийн газрууд тэдэнтэй нэг нэгээр нь тоглохоос эмээдэг болохоос гадна газар зүйн хувьд илүү өргөн хүрээг хамруулах боломж ихтэй байх юм.

Нигери Улсын ИНБ-уудын нэгэн бүлэг Төлснөө Нийтэл эвслийн удирдлаган дор нэгдэж бүр том эвсэл байгуулсан нь хожим Нигерийн ОУИТБС-тай иргэний нийгмийн оролцоог дэмжих Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан байна.

Зарим улсад иргэний нийгмийн бүлгүүд эвлэлдэн нэгдэхийг төрийн засгийн зүгээс хориглодог, эсхүл бүр айлган сүрдүүлдэг байж болно. Ийм тохиолдолд төр засгаас ОУИТБС-ын хэрэгжилтийг дэмжих үүрэг амлалт авахуулж, ОУИТБС-ын нэрээр үйл ажиллагаа явуулах эрх авах нь иргэний нийгмийн үг хэлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөнд тулгарч буй саад бэрхшээлийг арилгах шахалтыг засгийн газарт үзүүлэх бас нэг хөшүүрэг байж болох юм.

Ямар ч нөхцөлд байсан иргэний нийгмийн гишүүд:

- Ил тод байдлын төлөө шахалт үзүүлэх хүсэлтэй, өөртэйгээ ижил бодол санаатай хүмүүсийг олж аван өөрсдөө ямар нэг бүлэг, эсхүл эвсэл байгуулахаар санал нэгдэх
- Тогтмол цуглаж уулзан ажлын явцын талаар мэдээлэлтэй байхаар тохиролцох
- Уулзалтын тэмдэглэл хөтөлж шинэ гишүүдэд мэдээлэл авах боломжтой болгох, мөн вэб сайт ажиллуулан бусад иргэд уг эвсэлтэй харилцах боломжтой болгох хэрэгтэй.

Шигтгээ 1.1: Мавританий кибер форум

Мавритани Улс ОУИТБС-ын тухай шинэ мэдээ түгээн дэлгэрүүлэх хэрэгсэл болгож кибер форум бий болгосон байна. Энэ талаар www.cyberforum.mr/presentation/index.html хаягаар танилцаж болно.

Зохион байгуулалтад орох тухай илүү өргөн хүрээтэй багц санаануудыг *ОУИТБС-ыг ажиглацгаая*⁴ хэмээх Орлогын ажиглагч хүрээлэнгээс⁵ хэвлэн гаргасан тайлангаас үзнэ үү. Түүнчлэн Төлснөө Нийтэл эвслийг хэрхэн байгуулах тухай алхам алхмаар харуулсан зааврыг *Монгийг төшиг*⁶ хэмээх гарын авлагаас үзнэ үү.

1.2 Зорилго зорилтуудаа мэдэх

ИНБ-ууд төр засгийн албан тушаалтнуудыг татан оролцуулахын өмнө ОУИТБС-ын хөтөлбөрөөс юу хүсч байгаа, юуг тэргүүлэх чиглэл болгохоо мэддэг байх хэрэгтэй. Эдгээр тэргүүлэх чиглэлд дараахи зорилтын заримыг, эсхүл бүгдийг оруулж болно:

- Компаниудын төлж байгаа төлбөр, засгийн газарт хүлээн авч байгаа орлогыг нийтлэх (өөрөөр хэлбэл, ОУИТБС үүсч хөгжихөд хүргэсэн Төлснөө нийтэл гэдэг үзэл баримтлал)
- Олборлох үйлдвэрлэлийг удирдан зохицуулж буй төрийн байгууллагуудад итгэх олон нийтийн итгэлийг сэргээх
- Компаниудын олборлосон газрын тос, байгалийн хий, эрдэс баялгийн биет тоо хэмжээг нягтлан шалгах
- Орон нутгийн ба бүсийн засгийн газруудын авч буй орлогын хувь хэмжээг тодорхой болгох
- Компаниудаас орон нутгийн иргэдийг дэмжихэд зарцуулсан мөнгөний хэмжээг нийтлэх
- Тухайн улсын олборлох үйлдвэрлэлийн орлого хаашаа орж байгаа талаархи мэдлэг боловсролыг хүмүүст олгох
- Төр засгаас олборлох үйлдвэрлэлийн тухай мэдээлэл цуглуулах, удирдах системийг сайжруулах
- Дотоод агуулгын дүрмүүдийг сайжруулах
- Төр засгаас олборлох үйлдвэрлэлд зарцуулж байгаа хөрөнгө оруулалтыг удирдах арга барилыг сайжруулах

Шигтгээ 1.2 Зорилтуудаа тогтоох

Либерийн ОУИТБС-ын хөтөлбөр газрын тос, байгалийн хий, ашигт малтмал, ойн нөөцийг ашиглах эрх олгох ажиллагааг ил тод болгох явдлыг тус хөтөлбөрийн гол зорилтуудын нэг болгож тодорхойлсон байна.

Эдгээр тэргүүлэх чиглэлүүд нь тухайн улсын Үйл ажиллагааны төлөвлөгөөнд юу орох ёстой, ОУИТБС юуг нэгтгэн тулгах буюу аудит хийх ёстой, ОУИТБС-ын үйл явцад хэн хамрагдах ёстой талаархи ИНБ-уудын байр суурийг тодорхойлж өгөх болно. ОУИТБС бол сайн дурын үйл явц гэдгийг санагтун. Иймээс ОУИТБС ямар хэлбэртэй явагдах талаар олон янзын үзэл бодолтой байгаа оролцогч талуудын хооронд яриа хэлэлцээрүүд хийгдэх нь дамжиггүй. ИНБ-уудын хэлэлцэн тохиролцох байр суурийг аль болох дээшлүүлэхийн тулд юу хамгийн чухал вэ гэдгийг тодорхойлох нь зүйтэй. Одоогоор тэдний дэвшүүлж буй тэргүүлэх чиглэл улс орон бүрт ихээхэн харилцан адилгүй байна.

Нигерийн Засгийн газраар удирдуулсан тус улсын ОУИТБС-д оролцогч талууд газрын тос, байгалийн хийн системд итгэх итгэлийг бүхэлд нь сэргээхийг эрмэлзсэн байна. Тэд энэ системийн таван жилийн үйл ажиллагаанд аудит хийж, санхүүгийн ба биет хөрөнгийн урсгалд аудит хийснээс гадна засгийн газар түүхий нефтийн бүтээгдэхүүнээ хэрхэн худалдан борлуулж, нефть боловсруулах үйлдвэрүүдэд хэрхэн нийлүүлж, мэдээллийн технологийн систем, үйл ажиллагаагаа хэрхэн удирдаж байгааг судалсан байна. Нигерийн уул уурхайн салбар ОУИТБС-д хамрагдаагүй боловч тус улс уул уурхайн салбарынхаа эрх зүйн бүтцийг шинэчлэх хууль тогтоомж боловсруулжээ.

Гана Улсад ОУИТБС-ын хэрэгжилт уул уурхайн салбарт гол анхаарлаа хандуулж байв. ОУИТБС-ын эхний хөтөлбөр нь тус салбараас засгийн газарт төлж байгаа нийт төлбөрийн 99 хувийг бүрдүүлдэг цөөн тооны компаниудын төлбөрийг нэгтгэн тулгах ажлыг хийж гүйцэтгэжээ. Газрын тос, байгалийн хийн салбар дөнгөж хөгжиж байсан учраас гарын үсэг зуралтын шагнал, түрээс гэх мэт төлбөрүүд ОУИТБС-д хамрагдаагүй байв.

Перуд компаниудын төлбөрийн аудитлагдсан тоо баримтыг нийтлэхийг хуулиар аль хэдийн шаардаж эхлээд байв. Иймээс шинээр бий болсон ОУИТБС-ын хөтөлбөр нь орлогыг орон нутгийн түвшний засгийн газруудад хуваарилах томъёонд голлон анхаарч байсны дотор олборлох үйлдвэрлэлийн орлогын зарцуулалтад хариуцлага тооцож болох засгийн газрын түвшинүүдийг оруулсан байна.

Либерид уул уурхай, газрын тосны компаниудын нэг адил ой модны аж ахуйн салбарыг ОУИТБС-д хамруулдаг байна. Либерийн ОУИТБС-д ой модны бүх томоохон компани болон Ойн аж ахуйг хөгжүүлэх газар орох юм. Иймээс Либерийн ОУИТБС-ын тавьсан зорилтуудад ой мод ашиглах эрх олгох болон ой модны нөөц ашиглах ажиллагааг ил тод байдлаар явуулах, ой модны компаниудаас засгийн газрын бүхий л түвшинд болон төрийн өмчийн байгууллагуудад төлж буй бүх төлбөрийг тогтмол нийтэлдэг болгох явдал байв⁷.

1.3 Гадны тусламж авах

Иргэний нийгмийн гишүүд дэлхийн дахинд ОУИТБС-ын чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг олон улсын бүлгүүд болох Төлснөө нийтэл эвсэл⁸, Орлогын ажиглагч хүрээлэн⁹, Глобал Витнес¹⁰, Транспэрэнси Интернэйшнл¹¹ гэх мэт байгууллагатай холбоо тогтоох хэрэгтэй. Эдгээр байгууллагууд дор бүрнээ ОУИТБС-д нөлөөлөх ажилд цогц байдлаар оролцдог бөгөөд тухайн асуудлуудын талаархи тэдний ойлголт иргэний нийгмийн гишүүд нэгдсэн зохион байгуулалтад ороход тустай байж болно. Түүнчлэн, ийм байгууллагуудын харъяалалд орох нь дотоодын иргэний нийгмийнхний харагдах байдал, итгэл хүлээх чадвар, нөлөөлөх чадамжийг дээшлүүлэхэд тустай байж болно. Түүнчлэн олон оролцогч талын бүлэг нэгэнт байгуулагдсны дараа засгийн газар түүнийг гадны дэмжлэг тусалцаагаар хангана гэж үзэх хэрэгтэй. Гадны зөвлөх тухайн оролцогч талын бүлэгт хараат бус зөвлөгөө өгч чадахаас гадна ООТБ-ын үйл ажиллагаа олон улсын стандартад нийцсэн байдлаар явагдах нөхцлийг бүрдүүлж чадна.

Шигтгээ 1.3. Гадны тусламж

ОУИТБС-ын ихэнх төслийн гарааг эхлэхэд тусламж хэрэгтэй байдаг. Улс орнуудын чадавхи маш хязгаарлагдмал байж болох бөгөөд үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв, аудитын ажлын хүрээгээ боловсруулах, эсхүл тендер шалгаруулалт зарлах, аудитор эсхүл тоо баримт тулган нэгтгэгчтэй гэрээ хэлэлцээр байгуулах зэрэг ажилд тусламж хэрэгтэй байж болох юм. Олон оролцогч талт бүлэгт хараат бус техникийн зөвлөгөө өгөх гадны зөвлөхтэй байх нь хэрэгжилтийг түргэтгэж, зөрчлийг багасгаж болно. Ийм тусламж үзүүлэх санхүүжилтийн нэг эх үүсвэр нь Дэлхийн банкны Итгэлцлийн сан байж болно, эсхүл тухайн улсын ОУИТБС-ын төсөвт энэ зориулалтын санхүүжилтийг тусгасан байж болно. Иймээс оролцогч талуудын анхны уулзалтын нэг сэдэв бол ОУИТБС-ын хэрэгжилтийг эхлүүлэхэд ийм тусламж авах шаардлагатай эсэх, авбал хаанаас авах вэ гэдэг асуудал байх ёстой.

1.4 Өндөр албан тушаалтнуудыг татан оролцуулах

ОУИТБС-ын нэр дэвшигч болоход шаардлагатай нэг алхам болох ОУИТБС-ын үйл явцыг хариуцан ахлаж ажиллах өндөр албан тушаалтныг засгийн газраас томилж нийтэд зарласны дараа тухайн ИНБ энэ албан тушаалтантай нэн даруй уулзах ёстой. Энэ нь түүнтэй харилцаа тогтоох, ОУИТБС-ыг хэрэгжүүлэх үйл явцын талаар хэлэлцэх, ОУИТБС-ын хэрэгжилтийн нэг хэсэг болгож ИНБ-аас дэвшүүлж буй тэргүүлэх чиглэлийг танилцуулах, оролцоонд тулгарч буй саад тотгоруудыг тодорхойлох, үйл ажиллагааны төлөвлөгөөнд санал оруулах зорилготой юм. 2006 оны 10 дугаар сард баталгаажуулалтын шалгуурууд нийтлэгдэн гарахаас өмнө олон орны засгийн газрууд ОУИТБС-ын үзэл баримтлалаа олон нийтийн хараа хяналтаас гадуур боловсруулж, ИНБ-ууд сүүлд нь саналаа оруулсан байв. Үүнээс хойш ИНБ-ууд цаашид ашиглагдах ОУИТБС-ын хэрэгжилтийн загварыг бий болгоход идэвх санаачилгатай оролцож, түүнд үзүүлэх нөлөөгөө аль болох нэмэгдүүлэхийн тулд уг ажиллагаанд аль болох эртнээс оролцох хэрэгтэй.

1.5 Тухайн улсын Үйл ажиллагааны төлөвлөгөөг үнэлэх

Одоогоор ОУИТБС-аас аливаа засгийн газар Элсэн орох үе шатныхаа дөрөв дэх алхам болгож тухайн улсын Үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан нийтэлж, гол оролцогч талуудтай хэлэлцэн тохирох хэрэгтэй байна. Энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөөний эхний төслийг засгийн газраас Дэлхийн Банкны зөвлөгөөгөөр боловсруулах явдал элбэг байна. Тухайн засгийн газар энэ байдлаар уг үйл явцад юу хамрагдах, хэдий хэр хугацаа шаардах, ямар хэмжээний зардал гарах талаар болон ОУИТБС-ын нэр дэвшигч, эсхүл дагаж мөрдөгч орноор баталгаажихын тулд юу хийх шаардлагатайг мэдэж авах болно.¹²

Үйл ажиллагааны төлөвлөгөөнд зардлыг бүрэн тооцож оруулсан байх, чадавхийн үнэлгээ хийсэн байх, төлөвлөгөөг нийтийн хүртээл болгосон байх зэрэг нь цоо шинэ шаардлагууд юм. Энэ бүх шалгуурыг хангасан үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж нийтэлсэн улс орон хараахан байхгүй байна. Үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн тохирсон байх шаардлага нь түүнийг ООТБ-ээр хэлэлцэн батлахаас өмнө иргэний нийгмийн зүгээс санал шүүмжлэл гаргах, өөрчлөлт оруулах боломжтой байна гэсэн үг. ИНБ-ууд баталгаажуулалтын энэхүү шинэ шаардлагыг ашиглан зардалжуулсан үйл ажиллагааны төлөвлөгөөг аль болох эртнээс шаардаж аван танилцах хэрэгтэйгээс гадна уг төлөвлөгөөг хэлэлцэх, батлах зорилгоор явуулж буй аливаа хурал цуглаанд оролцож байх ёстой.

ОУИТБС-ыг хэрэгжүүлэх явцын үе шат бүрт буюу Бэлтгэх, Тайлагнах, Түгээн дэлгэрүүлэх үе шатад зориулсан төсвийн хуваарилалтыг тухайн улсын Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан эсэх талаар ямагт бодож байх нь чухал. Та бүхэн үүнтэй холбоотой хэд хэдэн асуулт хөндөж болно:

- Тухайн үйл ажиллагааны төлөвлөгөөнд чадавхийн хязгаарлагдмал байдлыг хөндсөн үү (тухайлбал, засгийн газар, иргэний нийгэм, компаниудад тулгарч буй эрх зүйн, эсхүл боловсролын саад бэрхшээл)
- ООТБ-ийн чадавхийг бэхжүүлэх төсөв хэрэгжилтийн аль нэг шатанд хуваарилагдсан уу?
- Нарийн бичгийн газрыг санхүүжүүлэх үү, хэн санхүүжүүлэх вэ?
- ООТБ-т байгаа ИНБ-ын гишүүдийг хурал цуглаанд оролцоход туслах мөнгө байгаа юу?

- Шаардлагатай бол эцсийн тайланг олон хэлээр орчуулах төсөв байгаа юу?
- ОУИТБС-ыг хэрэгжүүлэх явцад ОУИТБС гэж юу болох талаар иргэдэд тайлбарлан таниулах сургалт семинарын санхүүжилт байгаа юу?

Үйл ажиллагааны төлөвлөгөөг гол төлөв хэрэгжүүлэгч засгийн газар ба олон улсын хандивлагч нарын дэмжлэгийг хослуулах замаар санхүүжүүлдэг. ОУИТБС-ын үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдийг санхүүжүүлэх гол гадаад эх үүсвэр нь Дэлхийн Банкнаас захиран зарцуулдаг ОУИТБС-д зориулсан олон хандивлагчдын итгэлцлийн сан байдаг. Түүнчлэн аливаа улсын ОУИТБС-ын үйл ажиллагааны төлөвлөгөөний зардлыг бусад хандивлагчид хоёр талт харилцааны шугамаар санхүүжүүлэх тохиолдол заримдаа гардаг.

1.6 ООТБ-т орох ИНБ-ын төлөөлөгчдийг сонгоход оролцох

Иргэний идэвхтнүүд ОУИТБС-ын ажиллагаанд үр нөлөөтэй оролцох гол механизм бол оролцогч талуудын бүлэг юм. ОУИТБС-д иргэний нийгмийн төлөөлөл байх, төлөөлөл нь тэгш шударга, хараат бус байх, оролцох урилга нь нээлттэй бөгөөд ил тод байхыг шаарддаг. Элсэн орох үе шат бол засгийн газар эдгээр шаардлагыг хэрхэн хэрэгжүүлэхээр, төлөөлөгчид нь хэн байх талаар ИНБ-ын саналыг хэрхэн авахаар төлөвлөж байгаа талаар тухайн төр засгийн өндөр албан тушаалтанд асуулт тавих цаг юм. Зарим оронд (тухайлбал, Нигери, Азербайжанд) ООТБ-т оруулах иргэний нийгмийн төлөөлөгчдийг засгийн газар нь сонгодог буюу Азербайжаны хувьд Удирдах зөвлөл нь сонгодог байна. Мавритани гэх мэт бусад оронд бол гишүүд нь өөрсдийгөө сонгодог байна. ОУИТБС-д оролцогчоор урих ажиллагаа нээлттэй, ил тод байх, сонгогдсон хүн үнэхээр хараат бус байх, иргэний нийгмийн олон янзын оролцогч талуудын төлөөллийг хангалттай оруулсан байхыг шаарддаг¹³.

Шигтгээ 1.4: Иргэний нийгмийн өөрийн сонголт

Иргэний нийгэм дөнгөж үүсэн хөгжиж байгаа орнуудад өөрийгөө сонгох ажиллагаа арай удаан явагддаг боловч яваандаа энэ нь цаг хугацаа илүүтэй хэмнэдэг. Мавритани Улсын Засгийн газар иргэний нийгмийнхэн өөрсдөө ОУИТБС-ын хороонд оруулах гурван төлөөлөгчөө сонгохыг хүссэн байна. Мавританид иргэний нийгэм дөнгөж шинээр үүсч хөгжиж байсан учраас маш олон шинэ бүлгүүдтэй, тэдгээрийн уялдаа зохицуулалт удаан байлаа. Ингээд иргэний нийгмийнхэн өөрсдийгөө зохион байгуулж төлөөлөгчдөө сонгоход гурван сар зарцуулсан боловч тухайн төлөөлөгчдийн хууль ёсны байдлыг олон нийтээр хүлээн зөвшөөрөх байдал нь зүгээр Засгийн газар нь шууд томилсноос хамаагүй илүү байлаа.

Перу бол цөөнгүй тооны боловсронгуй байгууллага бүхий иргэний нийгэм сайн хөгжсөн улс юм. Перугийн ОУИТБС-ын Үйл ажиллагааны төлөвлөгөө ёсоор иргэний нийгмийн гурван төлөөлөгчийг ООТБ-т оролцуулахаар урьсан байна. Уг ажлыг хариуцсан сайд нэгэн вэбсайт нээж, иргэний нийгмийн төлөөлөх хүмүүсээ нэр дэвшүүлэхийг холбогдох байгууллагуудаас хүсчээ. Ингээд 11 хүн нэр дэвшигдсэн байна. Улмаар эдгээр 11 хүнийг цуглуулж тэдний дотроос гурван хүнийг ООТБ-т суух иргэний нийгмийн төлөөлөгчөөр сонгосны нэг нь эрдэм шинжилгээний байгууллага, нөгөө нь дотоодын ТББ, гурав дахь нь олон улсын ТББ-ын төлөөлөгч байв.

ОУИТБС-ын ИНБ-ын эвслийн гишүүд олон оролцогч талуудын бүлэгт оруулах төлөөлөгчөө өөрсдөө сонгодог тохиолдолд, уг бүлэгт сонгогдоогүй хүмүүс сонгогдсон төлөөлөгчөө шүүмжлэх буюу басамжлан доромжилж эвгүй байдалд орохгүй байхад ихээхэн анхаарах нь чухал. Ингэх нь зөвхөн иргэний нийгмийн хүчин чармайлтыг сулруулах үр дагавартай. Илүү дээр нэг практик бол хэн

нэгнийг сонгохоос өмнө (1) байнга холбоотой байх арга зам бий болгох, (2) хамтарч ажиллахаар тохиролцох, (3) олон оролцогч талын бүлэгт ажиллуулахаар Засгийн газарт санал болгож болох төлөөлөгчдийнхөө жагсаалтыг өөр хоорондоо хэлэлцэн тохирохоор санал нэгдэх явдал юм. Бас нэг санаа авах чухал зүйл бол Азербайжаны ТББ-ын эвсэл иргэний нийгмийн засаглалын бүтэц, дүрмүүдээ маш тодорхой боловсруулан гаргасан байсан¹⁴.

1.7 ООТБ-т орох иргэний нийгмийн төлөөлөгчид ямар шаардлагууд тавигдах вэ?

Энд албан ёсоор тавигдах ямар нэг шаардлага байхгүй боловч анхаарвал зохих хэд хэдэн практик асуудал бий. Жишээлбэл, ООТБ-т орох иргэний нийгмийн төлөөлөгч нь бүлгийн хуралдаан үр нөлөөтэй явуулж чадах хүмүүс байх хэрэгтэй. Тэд бусдыг сонсох, ярих чадвартай байх, асуудлыг шийдэж чаддаг байх, хуралд суух цаг завтай байх, мөн олборлох үйлдвэрлэлийн талаар багагүй мэдлэгтэй байх нь зүйтэй. Тэд ажлыг урагшлуулахын тулд хэзээ буулт хийхээ мэддэг байх ёстойгоос гадна хэзээ зарчмаа хатуу баримталж үр дүнгийн чанарыг алдагдуулахгүй байхаа мэддэг байх ёстой. ООТБ-ын төлөөлөгчид хурлынхаа өмнө болон дараагаар, тогтсон зарим механизмийн дагуу иргэний нийгмийн бусад гишүүдтэй холбоотой байх үүрэг амлалт авах ёстой.

1.8 Харилцан ойлголцлын санамж бичгийг хянан үзэх

ОУИТБС-ын эхний үе шатуудад төрөн гарсан нэг практик бол компаниуд, засгийн газрууд, иргэний нийгмийн дунд ОУИТБС-д оролцох хүрээний талаар харилцан ойлголцлын санамж бичгүүд (ХОСБ-үүд) боловсруулж, гарын үсэг зурах явдал юм. Эдгээр ХОСБ-үүдийн төслийг гол төлөв компаниуд боловсруулж засгийн газарт ОУИТБС-д оролцох шахалт үзүүлэхийн зэрэгцээ оролцох хүрээг нь хязгаарлах арга зам болгон ашигладаг. Ингэснээрээ засгийн газар нь уг санаачилгад нэгдэх дургүй байгаа орнуудад ОУИТБС-ын нөлөөлөл явуулах арга замыг компаниудад олгодог ач холбогдолтой. Компаниуд ОУИТБС-д оролцох хүсэл эрмэлзэлтэй байгааг мэдэх нь засгийн газрууд нэгдэн орох итгэлийг бий болгож өгдөг. Түүнчлэн компаниудын зүгээс өөрсдийн гаргаж өгсөн мэдээллийг компаниар нь нэгтгэн гаргах үүрэг амлалтыг засгийн газраар авахуулахыг хүсч болно. ХОСБ-үүдэд нэмэлт өөрчлөлт оруулах нь дөнгөж гараагаа эхлэж байгаа сайн дурын санаачилгын хувьд практик асуудал байж болохын зэрэгцээ оролцогч талуудын анхны хуралдаанаар ХОСБ-ын нөхцөл болзлуудыг өөрчлөхөд хэцүү байж болно.

Азербайжанд компаниудаар нэгтгэн тайлагнах заалтыг ХОСБ-тээ оруулсан байдаг¹⁵. Харин Нигерид компаниудаар задлан гаргах шаардлагыг засгийн газар нь санаачилан хэрэгжүүлсэн байна.

ИНБ-уудын хувьд баримталдаг тэргүүн туршлага бол ямар нэг эвсэл байгуулах, гаднаас зарим туслалцаа авах, асуудлыг бүрэн ойлгодог болтлоо ямар нэг ХОСБ-т гарын үсэг зурахгүй байх явдал юм. Ямар ч тохиолдолд нэгэнт байгуулсан ООТБ бүрэн бүрэлдэхүүнээр хэлэлцэх ёстой гол шийдвэрүүд дээр ХОСБ-гээ баригдаж хязгаарлагдахыг ИНБ-ууд зөвшөөрөх ёсгүй. Эдгээр гол шийдвэрүүдийн дотор тайлагнах хэлбэр (нэгтгэсэн, эсхүл задалсан байдлаар), тайлангийн маягтын загварын бүтэц, агуулга, материаллаг байдлын түвшин, аудиторыг сонгох ажиллагаа, аудиторын ажлын даалгавар гэх мэт асуудлууд орно.

Бүлэг 1: Элсэн орох үе шат	Тийм/Үгүй
I. Засгийн газар ОУИТБС-д нухацтай хандаж байгаагаа илэрхийлсэн үү?	
<i>Засгийн газар...</i>	
1. ОУИТБС-ын хэрэгжилтийг дэмжих эрмэлзэлээ илэрхийлсэн тууштай мэдэгдэл гаргасан уу?	
2. ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд иргэний нийгэм, компаниудтай хамтран ажиллах амлалт авсан уу?	
3. ОУИТБС-ын хүчин чармайлтыг ахалж удирдах хүнээ томилсон уу?	
4. Хэмжиж болохуйц зорилтууд, хэрэгжүүлэх ажлын хуваарь, чадавхийн үнэлгээ бүхий зардлыг бүрэн тусгаж, оролцогч талуудаар батлуулсан үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, нийтэлсэн үү?	
II. ИНБ-ын төлөөлөгчид зохион байгуулалтад орсон уу?	
<i>ИНБ-ын төлөөлөгчид...</i>	
1. Танай орны иргэний нийгмийн эвслүүд илүү том эвсэл байгуулах үндэс суурь болж чадах эсэхэд үнэлэлт өгсөн үү?	
2. Ил тод байдлын төлөө шахалт үзүүлэх талаар ижил үзэл бодолтой хүмүүсийг эрж хайж, бүлэг байгуулахаар тохирсон уу?	
3. Уг ажиллагааны талаар мэдээлэлтэй байхын тулд тогтмол уулзахаар тохирсон уу?	
4. Хурал цуглааны тэмдэглэл хөтөлж, шинэ гишүүдэд мэдээлж байхаар тохирсон уу?	
5. Вэб сайттай болж бусад иргэд уг эвсэлтэй харилцах боломж бүрдүүлсэн үү?	
III. Зорилтуудаа тогтоосон уу?	
<i>ИНБ-ын төлөөлөгчид...</i>	
1. ОУИТБС-ын хөтөлбөрөөс юу хүсэн хүлээж байгаагаа шийдсэн үү?	
2. Тэргүүлэх чиглэлүүдийнхээ дарааллыг тогтоосон уу?	
3. Үйл ажиллагааны төлөвлөгөөнд юу оруулах тухай байр сууриа тогтсон уу?	
4. ОУИТБС-ын хамрах хүрээний талаарх (юуг/хэнийг шалгаж нэгтгэн тулгах, эсхүл аудит хийх) байр сууриа тогтсон уу?	
IV. Гадны тусламж авсан уу?	
<i>ИНБ-ын төлөөлөгчид...</i>	
1. ОУИТБС-ын чиглэлээр дэлхийн дахинд идэвхтэй ажилладаг олон улсын бүлгүүдтэй холбоо тогтоосон уу?	
<i>Засгийн газар...</i>	
2. ОУИТБС-ын Нарийн бичгийн газар, Дэлхийн Банк, бусад хандивлагчид, мэргэжилтнүүдэд хандаж гадны тусламж авсан уу?	

V. Өндөр албан тушаалтнуудыг татан оролцуулсан уу?	
<i>ИНБ-ын төлөөлөгчид...</i>	
1. ОУИТБС-ыг удирдаж буй төр засгийн өндөр албан тушаалтантай уулзаж холбоо тогтоосон уу?	
VI. Тухайн улсын Ажлын төлөвлөгөөг үнэлж дүгнэсэн үү?	
<i>Засгийн газар...</i>	
1. Зардлыг бүрэн тусгаж, чадавхийн хомсдлыг хөндсөн ажлын төлөвлөгөө боловсруулан хэвлэж, өргөн олны хүртээл болгосон уу?	
<i>ИНБ-ын төлөөлөгчид...</i>	
2. Зардалжуулсан ажлын төлөвлөгөөнүүдийг аль болох эрт үзэж танилцсан уу?	
3. Дараахь зүйлийг: (а) үйл ажиллагааны төлөвлөгөөнд чадавхийн (эрх зүйн, эсхүл боловсролын) хязгаарлагдмал байдлыг хөндсөн; (б) ООТБ-ийн чадавхийг бэхжүүлэх төсвийг аль нэг шатанд хуваарилсан; (в) Нарийн бичгийн газрыг санхүүжүүлсэн; (г) ООТБ-т байгаа ИНБ-ын гишүүдийг хурал цуглаанд оролцоход туслах мөнгө байгаа; (д) ОУИТБС-ыг хэрэгжүүлэх явцад ОУИТБС-ын талаар иргэдэд тайлбарлан таниулах сургалт, семинарын санхүүжилт байгаа эсэх зэргийг шалгаж магадласан уу?	
VII. Та бүхэн ООТБ-т орох ИНБ-ын төлөөлөгчдийг сонгоход оролцсон уу?	
1. ООТБ-т ИНБ-үүд адил тэгш төлөөлөлтэй орсон уу?	
2. ИНБ-н төлөөлөл хараат бус уу? Оролцох урилга нь нээлттэй, ил тод байсан уу?	
VIII. ООТБ-т орсон ИНБ-ын төлөөлөгчид бүлгийн хуралдаанд үр нөлөөтэй оролцож чадах хүмүүс үү?	
1. ИНБ-ын төлөөлөгчид нь: (а) сайн сонсох, ярих чадвартай, (б) асуудал шийдэх чадвартай, (в) хуралд оролцох цаг завтай, (г) олборлох үйлдвэрлэлийн тухай зарим мэдлэгтэй, (д) хэзээ буулт хийхээ мэдэх чадвартай юу?	
2. Сонгогдсон төлөөлөгчид нь бүлгийн хуралдааны өмнө, эсхүл дараа ИНБ-уудтай холбоотой ажиллах үүрэг амлалт авсан уу?	
IX. ОУИТБС-ын хүрээг тодорхойлсон ямар нэг Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан уу?	
X. Та бүхэн Элсэн орох үе шатаа амжилттай дуусгав уу?	



БҮЛЭГ 2

ÁÿëÒäÿõ ¿à ØàÒ

ОУИТБС-ын Бэлтгэх үе шат буюу Баталгаажуулалтын хүснэгтийн 5-13 дугаар алхамыг хэрэгжүүлэх явдал бол ОУИТБС-ын үйл явцын хамгийн чухал үе байдаг. Энэ үеэр олон оролцогч талын бүлгийн өөрийнх нь тухай, иргэний нийгэм ба компаниудыг татан оролцуулах тухай, ОУИТБС-ын хүрээнд ямар төлбөр, орлогуудыг (мөн ямар нарийвчлалын түвшинд) шалгах тухай, тоо баримтын нэгтгэн тулгалт, эсхүл аудитыг хэнээр хийлгэх тухай, нийтэлсэн тайлангууд ямар байх тухай, ОУИТБС-ын үйл явцад хамрагдах бүх талууд зохих ёсоор оролцож байгаа эсэхийг тогтоохын тулд засгийн газар юу хийх тухай бүхий л чухал шийдвэрүүд гардаг. ОУИТБС-ын баталгаажуулалтад шаардагдах алхмуудын нэг хэсэг нь энэ үе шатанд хийгддэг. Мөн Тайлагналтын ба Түгээн дэлгэрүүлэлтийн үе шатанд оролцогч талуудад шаардагдах санхүүгийн, мэдээлэл харилцааны болон бусад хэрэгцээг энэ шатанд шийдвэрлэх нь онцгой чухал бөгөөд ингэснээр тэдгээрийг төсөвт тусгах, нэгтгэн тулгалт хийх байгууллагын ажлын даалгаврыг боловсруулах, эсхүл аудиторуд тайлангаа шаардлагатай хэлбэрээр гаргах боломжтой болох юм.

Энэхүү гарын авлагад Бэлтгэх үе шатны дараахь элементүүдийг авч үзнэ:

1. Олон оролцогч талын бүлэг байгуулах (Алхам 5)
2. Тухайн улсын Үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах (Алхам 5)
3. Иргэний нийгэм, компаниудыг татан оролцуулах (Алхам 6-7)
4. Оролцоонд тулгарч буй саад тотгорыг арилгах (Алхам 8)
5. Тайлангийн маягтын загварууд гаргах буюу ОУИТБС-ын шаардлагын хамрах хүрээг тодорхойлох (Алхам 9)
6. Хараат бус захирагчийг томилох (Алхам 10)
7. ООТБ-ээс ажил гүйцэтгүүлэхээр хөлсөлсөн байгууллагад сэтгэл ханамжтай байдал (Алхам 10)
8. Компаниудыг тайлагнадаг болгох талаар засгийн газраас авах арга хэмжээ (Алхам 11)

9. Засгийн газар ба компаниудын тайлан олон улсын стандартын дагуу аудитлагдсан бүртгэл тооцоонд тулгуурласан тухай засгийн газрын баталгаа (Алхам 12-13)

2.1 Олон оролцогч талын бүлэг байгуулах

Улс бүрийн ОУИТБС-ын хүчин чармайлтыг хувийн хэвшил ба хараат бус иргэний нийгмийн төлөөлөгчид, холбогдох төр засгийн удирдагч нараас бүрдсэн бүлэг удирдан зохицуулахыг ОУИТБС-д шаарддаг. Энэхүү бүлэг нь өөрийн үйл ажиллагааны Ажлын даалгавар (АД), түүний дотор тухайн улсын Үйл ажиллагааны төлөвлөгөөг хянаж батлах ёстой¹⁶.

ООТБ-т хэн орж ажиллах вэ? ОУИТБС-д оролцогч талуудын төлөөллийг хангалттай (гэхдээ адил тэгш бус) оруулахыг шаарддаг. Үүнд үнэлэлт өгөхөд хэцүүгээс гадна ООТБ-т орох иргэний нийгмийн суудлын тооноос хамаарч (Алхам 5) хуваарилахад хэцүү байж болно. Мөн энд олборлох аль үйлдвэрлэлийг оруулах вэ гэдгийг шийдэх асуудал гардаг. Нигери, Гана улсууд хоёулаа газрын тос, байгалийн хий, уул уурхайн салбартай. Гэхдээ Нигерид зөвхөн газрын тос, байгалийн хийн салбарыг НОУИТБС-д хамруулан авч үзэж байна. НОУИТБС-ыг анх байгуулах үед компаниудын төлөөлөлд газрын тосны олон улсын компаниуд, газрын тосны дотоодын нэг компани, Nigeria LNG буюу Нигерийн Шингэрүүлсэн байгалийн хийн компани орж байв. Дөнгөж саяхнаас газрын тосны орд илрүүлээд байгаа Гана Улсын ОУИТБС одоогоор зөвхөн уул уурхайн үйлдвэрлэлийг хамарч байгаа бөгөөд ООТБ-т газрын тос, байгалийн хийн ямар нэг компаний төлөөлөл байхгүй байна.

ООТБ-т төр засгийн янз бүрийн албан тушаалтныг оруулж болдог. Ихэнх орнуудын хувьд газрын тос, байгалийн хий, эсхүл уул уурхайн улсын үйлдвэрийн газрууд, хууль сахиулах байгууллагууд, сангийн яам, төв банкууд орсон байдаг. Мөн зарим оронд парламентийн буюу хууль тогтоох байнгын хорооны дарга нар төдийгүй орон нутгийн засгийн газрын тэргүүнүүдийн төлөөлөл орсон байдаг. ООТБ-ийн хувьд хамгийн гол нь бүх шатны засгийн газрын төлөөлөгчдийг нэг ширээнд суулгаж, улмаар хариуцлага тооцох, хамтарч ажиллах нөхцөл бүрдүүлэх явдал байдаг.

Өөр нэг асуудал бол иргэний нийгмийг хэн төлөөлөхийг тодорхойлох явдал юм. Энд гол нь янз бүрийн эвлэл, эвслүүд, төв ба орон нутгийн засгийн газрын төлөөлөгчид, хэвлэл мэдээллийн хэрэгсэлийн төлөөллийг хэрхэн тэнцвэржүүлэх вэ гэдгийг ойлгож авах явдал нэг чухал сорилт байдаг. ИНБ-ын байр суурийг илэрхийлэх тогтсон дүрэмтэй, сайн зохион байгуулалттай эвсэл бол (Бүлэг 1-ээс үзнэ үү) тухайн ИНБ-д олон янзын ашиг сонирхол, үзэл бодлын төлөөллийг үр нөлөөтэй хангахад тусалж чадна. (Бүлэг 1-ийн Шигтгээ 1.4-с иргэний нийгмийн гишүүд өөрсдийн төлөөлөгчдийг хэрхэн сонгож болох тухай жишээнүүдийг үзнэ үү). Олон оронд төлөөлөгчдөө сэлгэн ажиллуулах хууль, эсхүл журам гаргасан байдаг. Нигерид гэхэд НОУИТБС-ын тухай хуулиар таван жилийн хугацаа заасан байдаг. Азербайжанд ТББ-ууд хамтран “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг сайжруулах эвсэл” нэртэй хараат бус эвсэл байгуулсан байдаг нь бүх ТББ-уудад нээлттэй байдаг¹⁷. Казахстанд иргэний нийгмийн байгууллагууд хамтран “Газрын тосны орлогууд-Олон нийтийн хяналтад!” нэртэй ТББ-ын эвсэл байгуулсан нь мөн л бүх ТББ-уудад нээлттэй байдаг байна¹⁸.

Нарийн бичгийн газар буюу хэрэгжүүлэлтийн нэгж. Дээрхтэй холбоотой боловч шийдвэрлэх ач холбогдолтой нэг асуудал бол тухайн ООТБ үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх Нарийн бичгийн газар буюу ямар нэг төрлийн хэрэгжүүлэлтийн нэгжтэй байх эсэх тухай асуудал юм. Хөтөлбөр бүр Нарийн бичгийн газартай байхыг ОУИТБС шаарддаггүй. Үнэн хэрэгтээ, тайлангаа гаргасан орнуудын дотроос зөвхөн БН Кыргыз Улс, Мавритани, Нигери улсууд орон тооны Нарийн бичгийн газартай байна. Бусад газруудад аль нэг яам, эсхүл яамдын ажилтнууд дэмжлэг үзүүлж байна (Хүснэгт 2.1-г үзнэ үү). ОУИТБС-ын хүчин чармайлтын үр нөлөөтэй байдлыг хангахад чиглэсэн практик асуудал гэдэг үүднээс уг ажлыг төр засгийн өндөр албан тушаалтнууд удирдах нь чухал байхын зэрэгцээ ОУИТБС-ын олон оролцогч талт бүлгүүдийн хувьд орон тооны нарийн бичгийн дарга, эсхүл захиргааны асуудлыг удирдан зохицуулах ахлах ажилтан бүхий орон тооны Нарийн бичгийн газартай байх нь ихээхэн хүсүүштэй юм.

Хүснэгт 2.1: Олон оролцогч талт бүлгүүдэд үзүүлэх дэмжлэг, улс орноор

Улс	Яамны харьяа, эсхүл хараат бус Нарийн бичгийн газар?	ОУИТБС-ын орон тооны захирал, эсхүл ажилтан?
Азербайжан	Газрын тосны улсын сан	Байхгүй
Камерун	Эдийн засаг, санхүүгийн яам	Байхгүй
Габон	Габоны Эдийн засаг, санхүү, төсөв, хувьчлалын яамны санхүү хариуцсан зөвлөх ОУИТБС-ын Ажлын хэсгийн байнгын нарийн бичгийн даргаар ажиллаж байна	Байхгүй
Гана	Санхүү, эдийн засгийн төлөвлөлтийн яам	Мэдээлэл байхгүй
Гвиней	Уул уурхай, геологийн яамнаас ОУИТБС-ыг хэрэгжүүлэх байнгын хороо байгуулах тушаал гаргажээ	Байхгүй
Казахстан	Сангийн яам болон Эрчим хүч, инженерчлэл, эрдэс баялгийн яамны хамтарсан тушаалаар байгуулсан	Мэдээлэл байхгүй
БН Кыргыз Улс	Хэрэгжүүлэлтийн хорооны бүрэлдэхүүнд янз бүрийн яам, газрын төлөөлөгчид ордог	Байхгүй
Мавритани	Хараат бус	Мэдээлэл байхгүй
Монгол	ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийг Ерөнхий сайдаар ахлуулж, бүрэлдэхүүнд нь засгийн газар, уул уурхайн компаниуд, иргэний нийгмийн төлөөлөгчид ордог, бага хэмжээний нарийн бичгийн газрын дэмжлэгтэй ажилладаг.	Мэдээлэл байхгүй
Нигери	Хараат бус	Байхгүй
Перу	Эрчим хүч, уул уурхайн яам	Мэдээлэл байхгүй

Эх сурвалж: Азербайжан www.eitransparency.org/section/countries/_azerbaijan,
 Камерун www.eitransparency.org/UserFiles/File/cameroon/cameroon_minutes_feb_01_07.pdf,
 Габон www.eitransparency.org/section/countries/_gabon,
 Гвиней www.eitransparen.org/section/countries/_guinea
 Гана www.geiti.gov.gh/news/newsarticle.asp?id=3,
 Казахстан www.eiti.kz/secretary/,
 БН Кыргыз Улс www.eitransparency.org/section/countries/_kyrgyz,
 Мавритани www.eitransparency.org/section/countries/_mauritania,
 Монгол www.eitransparency.org/section/countries/_mongolia,
 Нигери www.neiti.org/about.htm,
 Перу www.minem.gob.pe/eiti/archivos/ds027-2006-ingles.pdf.

Нарийн бичгийн газар ажиллуулах нь хэд хэдэн шалтгаанаар чухал ач холбогдолтой байдаг. Нэгдүгээрт, оролцогч талуудын төлөөлөгчид ихэвчлэн бүтэн цагийн ажилтай байдаг учраас тэднийг мэдээллээр хангаж хуралд оролцох бэлтгэлтэй байлгах ёстой. Хоёрдугаарт, ахлах албан тушаалтан нь төрийн албан хаагч байх болно. Тэд хэдийчинээ өндөр албан тушаалтай байна, төдийчинээ их нөлөөтэй байх магадлалтай. Энэ нь олборлох үйлдвэрлэлд оролцож байгаа төрийн байгууллагууд, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хийсэн аудиттай холбоотой асуудлуудаар ОУИТБС-ын зүгээс шахалт үзүүлэх үед үүсч болох хүнд суртлын саад тотгорыг даван туулахад чухал байдаг. Гэхдээ ахалж байгаа хүн нь хэдийчинээ өндөр албан тушаалтай байна, төдийчинээ завгүй байдгийг мэдэх учраас ОУИТБС-ын хөтөлбөрийг хэн нэг нь хариуцан удирдах ёстой. Гуравдугаарт, оролцогч талуудын хийх ихэнх ажил нь баримт бичгүүдийг (тухайлбал, аудитын ажлын даалгавар, аудит хийх гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт, гадны зөвлөхүүдийн ажлын даалгавар, аудитын ажлын гэрээ гэх мэт) хянан үзэх, шүүмжлэх, багтах ажил байдаг. Хэрвээ эдгээрийг сайн бэлтгэж, урьдчилж тараан танилцуулахгүй бол иргэний нийгмийнхэн ОУИТБС-ын үйл явцын талаар мэдээлэлтэй байж үр нөлөөтэй оролцож чадахгүй. Нарийн бичгийн газрын дэмжлэг хангалтгүй буюу хүлээн авч байгаа их хэмжээний мэдээллээ удирдах чадваргүй, түүн дээрээ бага ажиллаж байгаа учраас ил тод байдлын олон хүчин чармайлт доголдсон байдаг.

Камеруны ОУИТБС-ын Үнэлгээний хорооны тайланд ИНБ-уудыг мэдээ материалаар хангах ажил дутагдалтай байгаагаас ИНБ-ын оролцоо доголдож байгаа тухай дурджээ. Түүнчлэн тоног төхөөрөмж, боловсон хүчин дутагдалтай байгаа нь үр нөлөөтэй байдалд саад учруулж байна гэдгийг тус хороо цохон тэмдэглэжээ.¹⁹

Нарийн бичгийн газрын үүрэг бол хурал зохион байгуулж, бүрэлдэхүүнийг оролцуулах; хэлэлцэх асуудлыг хэвлэн нийтлэх; ОУИТБС-ын хэрэгжилтэд оролцож байгаа төрөл бүрийн төрийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хурлын мэдээлэл материалыг оролцогчдод талуудад урьдчилж тараах; аудит, мэдээлэл харилцаа, эрх зүйн чиглэлээр мэргэжилтний зөвлөгөөгөөр хангах; ОУИТБС-ын төсвийг бүрдүүлж захиран зарцуулах; гадаадын хандивлагчидтай харилцах; вэбсайт нээж ажиллуулах; олон оролцогч талын бүлгээс өгсөн заавар чиглэлийн мөрөөр арга хэмжээ авах; ОУИТБС-ын үйл явцад юу болж байгаа талаар хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд тайлбарлах; хэвлэл мэдээллийнхний тавьсан асуултад хариулах; аудиторчуудын үйл ажиллагааг удирдах; засгийн газар, эсхүл аж ахуйн нэгжүүд аудиттай иж бүрэн, эсхүл тэгш шударга хамтран ажиллахгүй байгаа тохиолдолд зохицуулалтаар хангах явдал юм.

Олон оролцогч талын бүлгийн анхны хуралд санал болгох хэлэлцэх асуудлууд: Оролцогч талын бүлгийн анхны хурлаар Нарийн бичгийн газрын хэмжээ, орон тоо, чиг үүргийг хэлэлцэн тохирох хэрэгтэй. Ажилтнуудын тоо хэмжээ хэд байх нь төсвөөс хамаарна. Гэхдээ дараахи тэргүүн туршлагыг анхаарч үзэх хэрэгтэй:

- Тус бүлгээс томилж, төлөөлдөг орон тооны гүйцэтгэх захиралтай байх хэрэгтэй бөгөөд уг ажлыг урагшлуулж чадах хангалттай ахмад, туршлагатай хүн байх нь зүйтэй.
- Нарийн бичгийн газар хурлын хэлэлцэх асуудал ба дагалдах материалыг хангалттай бэлтгэн эртнээс тарааж, төлөөлөгчдөд хуралдаа бэлтгэлтэй

оролцох боломж, хуралд болох газар хүрэлцэн ирж амжихуйц хугацаа олгох хэрэгтэй.

- Оролцогч талуудад зориулсан вэбсайт нээж ажиллуулан оролцогчид томоохон материалыг электрон шуудангаар биш (хөгжиж буй олон оронд аудитын тайлангууд гэх мэт томоохон баримт бичгүүд и-мэйлийн системийг бөглөн гацааж болдог) вэбсайтаас татаж авах боломж олгох хэрэгтэй.
- Нарийн бичгийн газар бүх хурлын тэмдэглэлийг яаралтай гаргаж, бүх гишүүдэд тараах хэрэгтэй.
- Нарийн бичгийн газар нь төсвөө боловсруулан, бүлгийн гишүүдэд тараах (буюу уг төсвөө Ажлын төлөвлөгөөний төсөлд оруулж тайлбарлах) ёстой. Ингэснээр ОУИТБС-ын хөтөлбөр нь аудитын ажил, ажилтны хувьд хэр их зүйл хийж чадах, гадаад эх үүсвэрээс хэдий хэмжээний санхүүжилт авах шаардлагатай байж болох талаар оролцогч талууд мэддэг болох юм.

Нарийн бичгийн газар боломжтой бол гарын дор ажиллах хэд хэдэн ажилтантай байх хэрэгтэй. Үүнд:

- ОУИТБС-ын үйл явц, үйл ажиллагаануудын талаар сайн мэддэг, байнга бэлэн байж олон нийттэй харилцах ажиллагаа, сургалт семинар, бага хурал зохион явуулах, дотоодын ОУИТБС-ын вэбсайт удирдан ажиллуулах чадвартай, хэвлэл мэдээллийн хэрэгсэлүүдийг тогтмол мэдээллээр хангаж чадах мэдээлэл харилцааны ажилтан.
- Үйл ажиллагааны төсвийг удирдаж, мэргэжлийн туслалцаа үзүүлэх, албаны үйл ажиллагааг удирдан ажиллуулах үүрэгтэй захиргааны ажилтан.
- Аудиторуудыг удирдахад тусалж, аудитын ажиллагааны тухай мэдээллээр оролцогч талуудыг хангах аудитын мэргэжилтэн.

2.2 Тухайн улсын Үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах

ООТБ тухайн улсын Үйл ажиллагааны төлөвлөгөөг хянаж үзэн шаардлагатай үед засвар өөрчлөлт оруулах, улмаар бүлгээрээ хэлэлцэн батлахыг ОУИТБС шаарддаг. Тухайн улсын Үйл ажиллагааны төлөвлөгөө нь тавьсан зорилттой, цаг хугацааны хуваарьтай, төсвийг зүйлчлэн заасан, чадавхид тулгарах хүндрэл бэрхшээлийн үнэлгээтэй байх ёстой. (Хавсралт В-гээс Гана Улсын Үйл ажиллагааны төлөвлөгөө, Хавсралт Г-гээс Казахстан Улсын Үйл ажиллагааны төлөвлөгөөний жишээг үзнэ үү). ИНБ-ууд уг үйл ажиллагааны төлөвлөгөөний зүйл анги бүрийг шалгах хэрэгтэй. Тавьсан зорилтуудад тухайн хөтөлбөрт шаардагдаж болох бүх үйл ажиллагааг оруулах ёстой. Жишээлбэл, ОУИТБС-ын тухай олон нийтийн боловсролыг тэргүүлэх чиглэл болгосон, эсхүл ООТБ-т аудитын үйл ажиллагааны журмуудын талаар товч мэдээлэл өгөх шаардлагатай тохиолдолд сургалт, семинарууд явуулж вэбсайт ажиллуулах зорилт тавигдана. Цагийн хуваарь нь бодитой хэрэгжихүйц, зөв дараалалтай (өөрөөр хэлбэл, гол шийдвэрүүдийг гаргахаас өмнө чадавхийг бэхжүүлэх ажил хийгдэх ёстой) байх ёстой. Төсвүүд нь хийх ажилтайгаа уялдсан байх хэрэгтэй. Хамгийн нийтлэг асуудлуудын нэг бол аудит, эсхүл нэгтгэн тулгалт хийх чадавхийг бэхжүүлэх, тайланг түгээн дэлгэрүүлэхэд зориулсан мөнгө хэр их байгаа вэ гэдэг асуудал байдаг. Угтаа бол ОУИТБС-ын үнэлэлт дүгнэлтийн ажлын цар хүрээ төсвөө удирдан чиглүүлэхээс биш, төсөвтөө баригдах ёсгүй юм.

Ганагийн жишээ

Хавсралт В-д үзүүлсэн Гана Улсын Үйл ажиллагааны төлөвлөгөөний хувилбар бол зорилтоо сайн тодорхойлсон төлөвлөгөөний үлгэр загвар юм. Энд тоо баримт тулгагчид өгөгдөл цуглуулах явцаа юу хийхийг заасан байна. Үйл ажиллагаанууд буюу зорилтуудын багана нь маш дэлгэрэнгүй, олон жилийн хугацааны хуваарьтай байна. Гэхдээ энэ үйл ажиллагааны төлөвлөгөөнд төсвийн тухай ямар нэг мэдээлэл байхгүй байна.

Казахстаны жишээ

Хавсралт Г-д үзүүлсэн Казахстан Үйл ажиллагааны төлөвлөгөө бол зорилтот үйл ажиллагаа, цагийн хуваарь, зардлыг харуулсан загварын сайн жишээ юм. Нарийн бичгийн газар байгуулах гэсэн эхний зүйлийг авч үзье. Энд тухайн зорилт, авсан арга хэмжээ (Дэд сайдаар ахлуулсан гурван хүнтэй Нарийн бичгийн газар), гарах зардлыг (ямар нэг санхүүжилт шаардлагагүй) харуулжээ. Энэ тохиолдолд оролцогч талууд зарим нэг асуулт тавьж болох юм: Гурван хүн ажиллуулахад хангалттай юу? Дэд сайдын хувьд өөрийн албан тушаалын хажуугаар энэ ажлыг хийх цаг завтай юу? Томлолт, бичиг баримт хувилах гэх мэт Нарийн бичгийн газрын үйл ажиллагаанд санхүүжилт хэрэгтэй болох уу?

2.3 Иргэний нийгэм ба компаниудыг татан оролцуулах

ОУИТБС нь уг үйл явцад иргэний нийгэм ба компаниудын аль алиныг татан оролцуулахыг шаарддаг²⁰. Энэ нь засгийн газар ба ООТБ-ийн зүгээс төр засаг ОУИТБС-ыг хэрэгжүүлэх үүрэг амлалт авсан талаар олон нийтэд мэдээлэх хүчин чармайлт гаргаж, ОУИТБС-тай харилцахад тулгарч буй аливаа саад тотгорыг даван туулахад туслах ёстой гэсэн үг.

Олон нийтэд хүрч ажиллах олон хэлбэр байж болно. Нигерид НОУИТБС-аас сурталчилгааны аян зохион байгуулсан байна. Аудиторууд болон үндэсний ба орон нутгийн ИНБ-ууд тус улсын томоохон бүс нутгуудад очиж нээлттэй уулзалтууд зохион байгуулан НОУИТБС юу хийхийг зорьж байгааг тайлбарлан, хүмүүсийн санаа бодлыг сонссон байна. Азербайжанд вэбсайт нээж ажиллуулан компаниуд, хувь хүмүүст мэдээлэл авахад нь тусалж байна. Иргэний нийгмийн байгууллага, компаниудын аль аль нь чадавхийн хувьд хязгаарлагдмал байж болно. Магадгүй бүх талуудын хувьд ОУИТБС шинэ зүйл байж болно. Сургалт, семинар явуулах, товч мэдээлэл өгөх нь ОУИТБС-д яг юу хамрагдах талаар хүмүүст мэдлэг олгоход туслах болно.

Оролцоог тогтвортой байлгах хамгийн шилдэг арга бол байнга холбоотой байх явдал юм. Иргэний нийгмийн төлөөлөгчдийг нэгэнт томилсны дараа байнга харилцаатай байх зарим механизмийг бий болгох хэрэгтэй. Төлөөлөгчид ихэвчлэн цалин хөлсгүй ажилладаг бөгөөд тэд их, дээд сургуульд багшлах, сонин эрхлэн гаргах, ТББ ажиллуулах гэх мэт бусад бүтэн цагийн ажил хийдэг хүмүүс байдаг. Мэдээлэл харилцааны арга, давтамж нь бүх талуудын хувьд боломжийн байх ёстой. Нигерийн жишээнд гэхэд иргэний нийгмийн гишүүдийн эвсэл болох Үндэсний оролцогч талуудын ажлын хэсгээс албан ёсны Харилцан ойлголцлын санамж бичиг²¹ боловсруулж гаргасан байдаг. Арай жижиг улсуудын хувьд харьцангуй албан ёсны бус механизмтай байхад хангалттай байж болно.

Байнга холбоотой байхад зориулж санал болгож байгаа тэргүүн туршлагауудын жишээ гэвэл:

- Иргэний нийгмийн төлөөлөгчид аливаа хуралдааны өмнө иргэний нийгмийн бусад гишүүдтэй уулзаж ажлын хэсгийн хэлэлцэх асуудлуудын талаар ярилцан тэдний саналыг авдаг байж болно.
- Иргэний нийгмийн төлөөлөгчид е-мэйл хаягийн жагсаалт гаргаж түүгээрээ дамжуулан бүх сонирхогч талуудыг мэдээллээр хангадаг, ОУИТБС ба түүнтэй холбоотой асуудлуудаар тогтмол холбоо барьдаг байж болно.
- Компаниуд салбарын ажлын хэсгүүд байгуулж, аливаа хуралдааны өмнө бусад компаний төлөөлөгчидтэй уулзаж ажлын хэсгийн хэлэлцэх асуудлуудын талаар ярилцан, тэдний саналыг авч болно.
- Оролцогч талуудын төлөөлөгчид е-мэйлээр мэдээлэх, эсхүл оролцогч талуудын бүлгийн хурлын тэмдэглэлийг ямар нэг нээлттэй вэбсайтад тавих нөхцөл бүрдүүлэх замаар хуралдааны үр дүнг нийтэд танилцуулж болно.
- Оролцогч талуудын төлөөлөгчид иргэний нийгмийн (эсхүл салбарын) бүлгүүдийн тусламжтайгаар мэдээлэл түгээж болно.

Иргэний нийгмийн бүлгүүд хэд хэдэн үүрэг хариуцлага хүлээдэг. Үүнд:

- Өөрсдийн сүлжээг ашиглан ОУИТБС-ын тухай мэдээг түгээн дэлгэрүүлэх
- Олон нийтээс тавьж буй асуулт, ойлголтуудын тухай мэдээллээр төлөөлөгчдийг хангах
- Судалгаа хийх, эсхүл мэдлэг туршлагаа хуваалцах замаар төлөөлөгчдөд туслах
- Хэвлэл мэдээллийн хэрэгсэлүүдээр ОУИТБС-ын хуралдаан, тайлангуудын талаар мэдээлэхийг дэмжих.

2.4 Оролцоонд тулгарч буй саад тотгорыг арилгах

ОУИТБС-д иргэний нийгмийн бүлгүүд засгийн газраас хараат бус байж, зохисгүй дарамт шахалт, албадлагагүйгээр өөрсдийгөө илэрхийлж чаддаг байхыг шаарддаг²². Иргэний нийгмийн оролцоонд тулгарч буй зарим саад бэрхшээлүүд эрх зүйн, эсхүл зохицуулалтын шинжтэй байж болно. Ийм тохиолдолд иргэний нийгмийн бүлгүүд тухайн саад тотгорын мөн чанарын талаар гадны байгууллагуудад хандаж (тухайлбал, ОУИТБС-ын Нарийн бичгийн газар, эсхүл Төлснөө нийтэл эвслийн дотоодын салбарт), улмаар ООТБ-ийн зүгээс тэдгээрийг шийдвэрлэхэд тусалж болно.

Компаниуд засгийн газрын зөвшөөрөлгүйгээр санхүүгийн мэдээллээ өгөхийг гэрээний дагуу хориглосон байж болно. Ийм тохиолдолд Засгийн газраас шийдвэр гаргаж компаниудыг энэ мэдээллийг нууцлах үүргээс нь чөлөөлж болно. Нигерийн жишээнд гэхэд тус улсын ерөнхийлөгчөөс компани бүрт хандаж мэдээллээ ирүүлэхийг шаардсан хүсэлт тавьсан байна.

Үүнээс ч илүү практик шинжтэй бусад саад тотгорууд байж болно. Хэрэв ООТБ-ын хурал тухайн улсын нийслэлд болдог бол тухайн бүсээс гадна байгаа иргэний нийгмийн гишүүдэд ирж оролцох цаг хугацаа, зардал мөнгө шаардагдаж болно.

Иймээс хурлын товыг төлөөлөгчдөд эртнээс урьдчилан мэдэгдэж ирж оролцох хугацаа олгох шаардлагатай. Эдгээр асуудлыг шийдэхийн тулд ОУИТБС-ын ООТБ-дээс авч болох нэг практик алхам бол хуралд ирж оролцох төлөөлөгчдөд, ялангуяа нийслэл хотоос өөр газар амьдардаг хүмүүст санхүүгийн туслалцаа үзүүлэх явдал байдаг. Нигерид гэхэд замын зардал, буудлын хөлсний туслалцаа үзүүлдэг болоод байна.

2.5 Тайлангийн маягтын загварууд гаргах, ОУИТБС-аас тавих шаардлагын хүрээг тодорхойлох

ОУИТБС нь тайлангийн маягтыг олон оролцогч талын бүлгээр хэлэлцэн батлахыг шаарддаг²³. Энэ нь маягтуудыг зүгээр нэг хүлээн зөвшөөрөх төдий хэрэг биш юм.

Шигтгээ 2.1: Маягтын загварууд бий болгох

Баталгаажуулалтын хүснэгтийн үзүүлэлт ба Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгсэл 9-д олон оролцогч талын бүлгийг маягтын загвар гаргаж батлахад оролцох, иргэний нийгмийнхэнд санал шүүмжлэл гаргах боломж олгохыг заасан. Мөн аудитор авч ажиллуулахаас өмнө орлогын аль урсгалыг авч үзэхээ шийдэх ёстой. Ерөнхийдөө бол аудиторууд эцсийн загварыг гаргаж мэдээлэл олж авахад ашиг тустай загвар бий болгохыг хүсэх болно.

Маягтын загвар нь дараахи зүйлсийг тодорхойлох ёстой:

- Компаниуд ба засгийн газрын тайлагнавал зохих орлогын урсгалууд
- Тайлан мэдээ гаргавал зохих компаниуд
- Тайлан мэдээ гаргавал зохих төрийн байгууллагууд
- ОУИТБС-ын тайланд хамрагдвал зохих хугацаа
- Мэдээллийг тайлагнах хэлбэр (задалсан, эсхүл нэгтгэсэн байдлаар)

Эдгээр загварууд нь ил тод байдлын бүхий л ажиллагааны үндсийг тавих буюу аливаа улсад ОУИТБС-ыг хэрэгжүүлснээр ямар мэдээлэл ил тод болохыг тодорхойлох юм. *ОУИТБС-ын сурвалж бичиг*-т маягтын загварын хэлбэрийг гаргаж өгсөн байдаг боловч улс орнууд уг загварыг өөрсдийн хэрэгцээндээ тохируулан засч хэрэглэж байна. Тухайлбал Монголын маягтын загварын жишээг Хавсралт И-д үзүүлэв. Ер нь эдгээр маягтыг ойлгож бөглөхөд компаниуд ба төрийн байгууллагуудын аль алинд туслалцаа хэрэгтэй байдаг.

Мөн эдгээр шийдвэрийг гаргахтай холбоотой асуудлуудыг ойлгоход оролцогч талуудад туслах, оролцогч талын бүлгээр хэлэлцүүлэх, олон нийтээр өргөн хэлэлцүүлж саналыг нь авах боломж олгох, эцсийн загварыг олон оролцогч талын бүлгээр батлуулахыг ОУИТБС шаарддаг.

Шигтгээ 2.2: Бусдыгаа сургах сургалт

Гвинея Улсад санхүүгийн мэргэжилтэй иргэний нийгмийн гишүүд аудитын үйл ажиллагааны талаар иргэний нийгмийн бусад гишүүддээ тайлбарлаж өгөхийг хүссэн байна. Энэ үйл явцад Гвинейн Үндэсний Аудиторуудын Байгууллага оролцсон нь түүний хууль ёсны байдлыг нэмэгдүүлж өгсөн байна.

Компаниуд ба засгийн газруудын тайлагнавал зохих орлого, ашгийн урсгалууд. ОУИТБС-ын Сурвалж бичигт заахдаа:

Аливаа олборлох үйлдвэрлэлээс хүлээн авагч засгийн газарт орж байгаа эдийн засгийн ашиг шимийн боломжит эх сурвалжийг Ашиг орлогын урсгал гэж тодорхойлно. Бүх материаллаг ашиг орлогын урсгалыг тайлагнах ёстой²⁴ гэжээ.

Компаниудаас төлж буй ашиг орлогын хэд хэдэн нийтлэг хэлбэр байдаг. Үүнд:

- Татвар
- Нөөц ашигласны төлбөр
- Бүтээгдэхүүний хувь
- Тусгай зөвшөөрөлтэй газруудын төлбөр, хураамж
- Бонусууд
- Ногдол ашиг ба ашгийн шилжүүлэг
- Хөрөнгийн борлуулалт

Эдгээр урсгалууд дотроос хамгийн их нь ихэвчлэн нөөц ашигласны төлбөр, ашгийн татвар, засгийн газарт ногдох бүтээгдэхүүний хувь гурав байдаг. Эдгээр төлбөрийг эрдэс баялгийн олборлолт, үйлдвэрлэл, тээвэрлэлт буюу бусад үйлдвэрлэлийн дараахи үйл ажиллагаанд оролцож буй хувийн компаниуд, газрын тосны үндэсний компаниуд, эсхүл уул уурхайн улсын компаниуд төлдөг. Засгийн газарт төлвөл зохих ашиг орлогын тодорхой урсгалуудыг хууль тогтоомж, зохицуулалтууд, засгийн газраас компаниудтай байгуулсан гэрээгээр тодорхойлдог. Улс орнууд нэг салбар дотроо ч өөр өөр санхүүгийн зохицуулалттай байж болдог (тухайлбал гүний ба гадаргуугийн усан доорх олборлолтод ялгавартай, эсхүл алт, зэс хоёрт өөр өөр нөхцөлтэй гэх мэт) төдийгүй уул уурхайн болон байгалийн хийн олборлолтод өөр өөр зохицуулалттай байж болно. (Эдгээр ашиг орлогын урсгалын нэг бүрчилсэн дэлгэрэнгүй тайлбар, тус бүртэй нь холбоотой эрх зүйн төрөл бүрийн зохицуулалтууд, ашиг орлогын урсгалуудыг зөв тооцоход тулгардаг бэрхшээлүүд зэргийн талаар уг гарын авлагын II хэсэгт авч үзнэ).

Мэдээлэлтэй байх. Оролцогч талуудын хувьд мэдээлэлтэй байх, ялангуяа чухал шийдвэрүүд гаргахын өмнө мэдээллээр хангагдсан байх нь маш чухал. Харамсалтай нь, ингэж чадахгүй байх явдал хэтэрхий элбэг тохиолддог. Харин баталгаажуулалтын шинэ шалгууруудын ачаар ашиг орлогын ямар урсгал засгийн газарт орох ёстой, хамгийн сүүлийн үеийн мэдээгээр засгийн газар эдгээр урсгалаас хэр их орлого олсон гэж үзэж байгаа, тэдгээрийг ямар төрийн байгууллагууд хүлээн авсан талаар оролцогч талууд засгийн газраас юмуу гадны мэргэжилтнээс товч мэдээлэл шаардах боломжтой болсон билээ. Энэ нь ашиг орлогын урсгалууд ямар байгаа талаар ООТБ-г мэдээлэл өгч, улмаар энэ бүх урсгалыг тайлагнах ёстой, эсхүл зөвхөн томоохон урсгалуудыг нь голлон сонирхож байгаа эсэхээ шийдэх боломжтой болно. Жишээлбэл, ашгийн татварын төлөлт их, харин компаниудаас төлж байгаа цалин хөлсний татвар, эсхүл нэмэгдсэн өртгийн татварын хэмжээ их биш байж болно. Иймээс оролцогч талууд ОУИТБС-ын шаардлагад хамаарал багатай (цалин хөлсний суутгал татвар гэх мэт) төлбөрүүдийг шалгахасаа илүү ашиг орлогын томоохон урсгалууд зөв зохистой төлөгдсөн эсэхийг шалгахад цаг хугацаа, хөрөнгө мөнгөө илүүтэй зарцуулахыг эрхэмлэж болно.

Ямар компаниуд тайлагнах ёстой вэ? ОУИТБС-ын Шалгууруудад “засгийн газарт төлж буй газрын тос, байгалийн хий, уул уурхайн бүх материаллаг

төлбөр”, “газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниудаас засгийн газарт хүлээн авч байгаа бүх материаллаг орлого”-ыг тайлагнахыг шаардсан байдаг²⁵. Дараахи хэсэгт тайлбарласанчлан, энэ нь компаниудаас төлж байгаа, нэгтгэн тулгах, эсхүл аудит хийхэд хангалттай хэмжээний бүх төрлийн мөнгөн төлбөр (тухайлбал, бонус, татвар, нөөц ашиглалтын төлбөрийн мөнгө)-ийг тайлагнах ёстой гэсэн үг. Энэ төлбөр хэр их (буюу материаллаг) байх ёстойг ОУИТБС-ын оролцогч талын бүлэг бүр шийдэх ёстой. ОУИТБС-ын Шалгууруудын 4 дүгээрт тусгайлан заасанчлан, ОУИТБС-ын хамрах хүрээнд улсын үйлдвэрийн газруудыг оруулах ёстой²⁶. Бүх төлбөрийг, эсхүл зөвхөн материаллаг гэж үзсэн төлбөрийг тайлагнах ёстойг оролцогч талууд шийдэх ёстой. Түүнчлэн зөвхөн томоохон урсгалуудыг материаллаг гэж үзэн нэгтгэдэг байсан ч бүх аж ахуйн нэгж тайлагнахыг шаардах боломжтой байдаг. (Жишээлбэл, энэ аргыг Нигерийн газрын тосны салбарт хэрэглэсэн байна). Тэр ч байтугай жижиг компаниуд, хувиараа олборлолт эрхлэгчид хүртэл маягтын дагуу тайлагнах үүрэг хүлээлгэдэг. Эдгээр маягтуудыг бөглүүлж авах нь нэгтгэн тулгалт хийж байгаа газарт хүнд ачаа үүрүүлж болох юм. Өөр нэг арай хялбар арга бол зөвхөн тодорхой хэмжээтэй, эсхүл тодорхой орлогын түвшинтэй компаниудаас тайлагнахыг шаардаж болно. (Хүснэгт 2.2-с үзнэ үү).


Хүснэгт 2.2: Шаардагдах аудитын тайланг гаргах Ажлын даалгавар (АД)

Гаргасан дүгнэлт	Ажлын даалгаварт санал болгох үг хэллэг
Хийсэн ажлын дэлгэрэнгүй тайлбар, “тогтсон журмын дугуу” уг ажлаас олж мэдсэн зүйлс	Нягтлан бодогч нар дараахи журмыг баримталж үр дүнг тайлагнана...
Өгөгдсөн тоо баримтын үндэслэлтэй байдлын тухай дүгнэлт (Баталгааны тайлан)	Нягтлан бодогч нар шаардлагатай гэж үзсэн журмыг баримталж ажиллан, дүгнэлтэндээ тэдэнд өгөгдсөн тоо баримтууд материаллаг байдлын хувьд тохирч байгаа эсэх талаар тайлагнана. Материаллаг зөрүү тогтоогдсон тохиолдолд тэр талаар тайлагнах ёстой.
Аудитын олон улсын стандартуудын дагуу хийгдэх аудит	Нягтлан бодогч нар [хуулийн этгээдийн нэр], [огноо] өдрөөр дуусгавар болгосон санхүүгийн тайлангуудад Аудитын олон улсын стандартуудын дагуу аудит хийж, дүгнэлтэндээ уг санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналтын олон улсын стандартуудын дагуу гаргасан эсэх талаар тайлагнана.

Төрийн ямар байгууллагууд орлогоо тайлагнах ёстой вэ? Оролцогч талуудад төлбөр хүлээн авч байгаа бүх төрийн байгууллага, улсын үйлдвэрийн газрын талаар танилцуулсан байх ёстой. Хэд хэдэн ийм байгууллага байх нь олонтаа. Орлого хүлээн авдаг байх боломжтой төрийн байгууллагуудын тухай дэлгэрэнгүй тайлбар, тэдний хүлээн авсан орлогыг шалгахад тулгардаг онцлог асуудлуудын талаар энэхүү гарын авлагын II хэсэгт дэлгэрэнгүй авч үзнэ. Ихэнх орнуудад байдаг голлох байгууллагуудын дотор төв банк, татварын газар, зохицуулагч байгууллагууд, газрын тосны үндэсний, эсхүл уул уурхайн компани, орон нутгийн ба муж улсын засгийн газрууд, мөн хагас төрийн байгууллагууд ордог.

Перугийн хуулиар уул уурхайн зарим орлогыг шууд орон нутгийн засгийн газруудад төдийгүй төрийн яам, газруудад хуваарилдаг байна. Эдгээр хуваарилалтыг Зураг 2.1-д дүрслэн харуулав.

Зураг 2.1: Перу Улсад уул уурхайн татварын орлогоос төрийн байгууллагуудад хуваарилсан байдал



Ашиг орлогын ямар урсгалыг материаллагт тооцох вэ? ОУИТБС-д ашиг орлогын бүх материаллаг урсгалыг нийтлэхийг шаарддаг. Цаашилбал аливаа орлогын урсгалын материаллаг байдлыг хэрвээ “орхигдуулсан, эсхүл буруу тогтоосон нь ОУИТБС-ын эцсийн тайланд материаллаг байдлаар нөлөөлж болзошгүй бол” гэж тодорхойлдог²⁷. “Материаллаг” гэдэг нэр томъёог тоо хэмжээгээр илэрхийлэх нь голдуу оролцогч талын үүрэг байдаг бөгөөд тухайн улсын ОУИТБС-ын хөтөлбөрт ямар зорилтууд тавьснаас хамаардаг. Тухайлбал, 1 сая доллараас дээш гэх мэт тодорхой долларын босгоос дээш гарсан бүх ашиг орлогын урсгалыг “материаллаг” гэж үзэхээр маягтын загвар боловсруулсан байж болно. Хоёр дахь босго нь аливаа компанийн үйлдвэрлэлийн буюу төлбөрийн хэмжээ байж болно. Өөр нэг босго нь төлбөрийн хувь байж болно. Энэ нь тухайн улсын түрүү жил олсон нийт орлогын 5 хувиас доошгүй хувьтай тэнцэх аливаа орлогын урсгал, эсхүл нийт олсон орлогын 95, эсхүл 99 хувийг оруулсан компаниудын төлж буй төлбөр гэх мэт байж болно. Түүнчлэн олборлох үйлдвэрлэлийн компаниудаас орон нутгийн түвшинд үзүүлж байгаа нөлөөг ойлгох нь чухал байгаа, мөн оролцогч талууд бүс нутгийн болон орон нутгийн засгийн газруудад орж байгаа санхүүжилтийн иж бүрэн дүр зургийг гаргахыг хүсч байгаа тохиолдолд хэдийгээр их биш байсан ч гэсэн ОУИТБС-ын ажлын хувьд бүх төлбөр буюу бэлэн мөнгөн орлогууд материаллаг байж болно. Өнөөдөр ОУИТБС-ыг хэрэгжүүлж байгаа улс орнууд материаллаг байдлыг олон янзаар тодорхойлж байгаа бөгөөд материаллаг байдлыг тодорхойлох ямар нэг стандартчилсан арга хараахан бий болоогүй байна.

Камеруны ООТБ-ээс ямар аж ахуйн нэгж, байгууллагууд хамрагдахыг шийдсэн боловч эндээс гаргасан нэгтгэсэн тайландаа материаллаг байдлын ямар стандарт хэрэглэсэнэ харуулаагүй байна.

Ганад тухайн аудитлагдсан жилд нөөц ашигласны төлбөрийн 99 хувийг 8 компани төлсөн байв. Иймээс нийт төлбөрийг нь нэмээд үзэхэд засгийн

газарт оруулсан орлогын нэг хувьд ч хүрэхгүй хэмжээний төлбөр төлсөн бусад олон жижиг компанид аудит хийх нь өртөг зардал өндөртэй гэж үзээд бусад компанийг тайлагнуулахгүй байхаар шийдсэн байна. Ийм ч учраас тус улсын нийт орлогын бутархай хувьтай тэнцэх хамгийн жижиг уул уурхай эрхлэгчдийн төлбөрийг “материаллаг”-т үл тооцон, тайлан ирүүлэхийг шаардаагүй байна. Эдгээр хувь хүмүүсийг олж авахад хэцүү, өртөг ихтэй байх байсан бөгөөд тэд ямар нэг бүртгэл тооцоо хөтөлдөг байлаа гэхэд олон улсын стандартаар аудитлагддаг компаниудаас хамаагүй бага байх байлаа.

Нигери Улс бүх компани татвар, нөөц ашигласны төлбөр, бүтээгдэхүүнээс хүртэх хувиа тайлагнахыг шаардсан боловч зөвхөн нийт орлогын урсгалын тав буюу түүнээс дээш хувийн зөрүүтэй байдлыг шалгаж шийдвэрлэхийг аудиторуудаас шаардсан байна.

Гвиней Улс 2005 оны тайландаа уул уурхайн хамгийн том зургаан компанийн төлсөн төлбөрийг оруулах байдлаар материаллаг байдлыг тодорхойлжээ.

Габон Улс ОУИТБС-ын анхны тайландаа засгийн газрын хүлээн авсан газрын тосны ашгийн орлогыг оруулж чадаагүй нь аль ч тодорхойлолтоор авч үзсэн материаллаг урсгалыг орхигдуулсан нь тодорхой байна.

Гана, Нигери хоёроос бусад ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч орнууд “материаллаг байдал”-ыг тодорхойлох үйл явцын хувьд ч, ашиг орлогын материаллаг урсгалын шинжилгээний хувьд ч ил тод байсангүй. Компаниудын оролцоо сайн дурын шинжтэй, эсхүл компаниуд тайлангаа ирүүлдэггүй тохиолдолд ашиг орлогын материаллаг урсгалаа тайлагнасан эсэхийг мэдэх боломжгүй юм. Баталгаажуулалтын шаардлага нь цаашид эдгээр сул талуудыг арилгахад туслах ёстой.

Гана Улс хэмнэлттэй арга хэрэглэсэн байна. Тус улс томоохон урсгалуудыг хамруулж, тэдгээрийг илүү нарийвчлан авч үзэхийг оролджээ. Нигери Улс илүү өргөн хүрээтэй арга хэрэглэсэн нь аудит хийхэд илүү өндөр өртөгтэй, цаг хугацаа их шаардсан ажил болсон байна. Иймээс оролцогч талуудаас тодорхойлсон “материаллаг байдал”-ын тодорхойлолт нь ОУИТБС-д хамрагдсан салбарын компаниудад аудит хийх хугацаа, төсөв, тоо хэмжээнд төдийгүй тухайн улсад үйлчилж байгаа ОУИТБС-ын зорилтуудын биелэлтэд ихээхэн нөлөө үзүүлдэг нь тодорхой юм.

ОУИТБС-д цаг хугацааны ямар үеийг хамруулах ёстой вэ? ОУИТБС нь ООТБ тайлагнах хугацааг тодорхойлохыг шаарддаг боловч энэ хугацаа хэр урт байх ёстойг зааж өгөөгүй байна. Хүснэгт 2.3-т үзүүлсэнчлэн бодит байдал дээр хэрэглэгдэж байгаа практикууд харилцан адилгүй байна. Гана Улсын ОУИТБС-ын анхны тайлан 2004 оны 1 дүгээр сараас 6 дугаар сар хүртэл 6 сарын хугацааг хамарчээ. Нигерийн анхны аудит 1999-2004 он хүртэл таван жилийн хугацааг хамарсан байна. Оролцогч талууд өмнөх жилүүдийн үнэлэлт дүгнэлтийн зардлыг ирэх жилүүдийн төлөв байдалтай харьцуулж үзэхийг хүсэх нь мэдээж. Түүнчлэн, үнэлэлт дүгнэлтэд өнгөрсөн үеийг хэдийчинээ их хамруулах тусам бүртгэл тооцоо хөтлөлт муутай байсан, бичиг баримт алдагдаж үрэгдсэн зэргээс болж тоо баримтын чанар муудаж болно (нилээд буурах боломжтой) гэдгийг хүлээн зөвшөөрч байна.

Хүснэгт 2.3: Одоо байгаа ОУИТБС-ын тайлангууд хамрагдсан хугацаа

Улс	Тайлангийн тоо	Хамрагдсан хугацаа
Азербайжан	5	2003.01-2006.6
Камерун	2	2001-2005
Габон	2	2004-2005
Гана	2	2004
Гвиней	1	2005
БН Кыргыз Улс	1	2004
Мавритани	1	2005
Нигери	1	1999-2004

Эх сурвалж: Азербайжан, Камерун, Габон, Гана, Гвиней, Кыргыз, Мавритани, Нигери улсуудын тайлангуудыг www.eitransparency.org/section/countries хаягаар, эсхүл Хүснэгт 3.1-ээс үзнэ үү.

ОУИТБС-ын тайлагнах хэлбэр (нэгтгэсэн, эсхүл задалсан). Оршил хэсгийн Хүснэгт i.1-д үзүүлсэнчлэн, тайлагнасан тоо баримтыг нэгтгэсэн, эсхүл задалсан аль нэг хэлбэрээр нийтлэх ёстой гэсэн шаардлага ОУИТБС-д байдаггүй.

ОУИТБС-ын тайлан гаргасан бүх компаниуд тайлангаа төлбөрийн төрлөөр (татвар, нөөц ашигласны төлбөр, бүтээгдэхүүн, эсхүл хувьцаа гэх мэт) задалж харуулах аргыг ашигласан бол, зөвхөн Гана, Гвиней, Нигери улсууд тайланг тодорхой компаниудаар задалж харуулах нэмэлт шаардлага тавьсан байна.

Компаниуд ОУИТБС-ын тайлангийн маягт бөглөж ирүүлэхийг зөвшөөрөхөөсөө өмнө ирүүлсэн тоо баримтыг гуравдагч талд гаргаж өгөхийг зөвшөөрсөн баталгаа авахыг хүсэх болно гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. (Засгийн газартай холбоотой үүргийн талаар Хэсэг 2.7-с үзнэ үү). Мөн компаниуд ихэвчлэн тоо баримт хэвлэх хэлбэрээ тохирохыг хүсдэг. ИНБ-ууд, Орлогын ажиглагч хүрээлэн болон бусад олон газрын хувьд өргөн хүрээтэй задалж харуулсан тайланг илүүд үзэх нь тодорхой. Гэхдээ аливаа сайн дурын санаачилгын хувьд зөвшилцөлд хүрэх ёстой. Компаниудын хувьд ерөнхийдөө хийж байгаа гүйлгээнийх нь нөхцлүүдийг өрсөлдөгч нар нь мэдчихвэл өрсөлдөх чадварт нь хор хохиролтой гэсэн байр суурьтай байдаг. Компаниуд Засгийн газартай эдийн засгийн нөхцлүүдээ (бүтээгдэхүүн хуваах гэрээ, хамтарсан үйлдвэр, мөн техникийн, санхүүгийн, үйл ажиллагааны болон эрх зүйн талаасаа нилээд нарийн төвөгтэй холбогдох гэрээ хэлэлцээрүүд гэх мэт) хэлэлцэн тохироход хүргэсэн давтагдашгүй нөхцөл байдлынх нь талаар олон нийтэд мэдээлэгдэхгүй, эсхүл олон нийт ойлгохгүй гэдгээс тэд эмээж байдаг. Харин, энэ бол олон нийтэд хэрэгцээтэй байгаа мэдээлэл мөн, олон нийтэд мэдлэг боловсрол олгох нэг үндэс суурь бол ОУИТБС гэж ИНБ-ууд үздэг байна.

Нигери Улсад төлж буй төлбөрүүдээ бүрэн задалсан байдлаар тайлагнахыг зөвшөөрсөн олон компани бусад орнуудад ч үйл ажиллагаа явуулдаг гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Хүлээн авагч орны засгийн газрууд юу хүсч байгаа нь компаниудад ихээхэн нөлөөлдөг. Нигерид гэхэд тайланг бүрэн задалсан байдлаар нийтлэх гэсэн засгийн газрын хүсэл эрмэлзэлийг компаниуд албадлага гэж үзсэн байна. ИНБ-уудын хувьд ОУИТБС-д компаниудыг татан оролцуулахын өмнө засгийн газрыг ятган үнэмшиүүлэхэд гол анхаарлаа хандуулж болох юм.

Шигтгээ 2.3: Мөнгөн ба аккруэль нягтлан бодох бүртгэл

Компаниуд Санхүүгийн тайлагналтын олон улсын стандартын дагуу аккруэль суурьт нягтлан бодох бүртгэл ашиглан санхүүгийнхаа тайланг гаргадаг бөгөөд холбогдох санхүүгийн бичилтүүд нь ингэж хийхээр зохион байгуулагдсан байдаг. Харин засгийн газрууд санхүүгийн бүртгэлээ бэлэн мөнгөнд суурилсан байдлаар хийж ирсэн уламжлалтай. Нягтлан бодох бүртгэлийн энэ хоёр аргын ялгааг ойлгохын тулд дараахи жишээг авч үзье: та 12 дугаар сарын 1-нээс эхлэн сарын 1,000 \$-н түрээстэйгээр байр хөлслөхөөр шийдтэл 3 сарын төлбөрөө урьдчилан төлөх шаардлагатай болсон байна. Хэрэв та 12 дугаар сарын сүүлээр санхүүгийн тайлангаа гаргах боллоо гэхэд:

- Мөнгөн суурьт бүртгэлээр бол та 12 дугаар сард 3,000\$ бодитойгоор төлсөн гэдэг нь харагдана.
- Аккруэль суурьт бүртгэлээр бол 12 дугаар сард та бодитойгоор 1,000\$-н түрээсийн зардал гаргасан, мөн 2000\$-н ашгийг дараагийн жилд шилжүүлсэн тооцсон нь харагдана.

ОУИТБС-ын санхүүгийн гүйлгээний загвараар бол ямагт мөнгөн суурьт бүртгэлийг ашиглах шаардлагатай. Эс тэгвэл компаниудын хийсэн гүйлгээ засгийн газрын хийсэн гүйлгээтэй яв цав тохирч чадахгүй. Ийм учраас компаниудын гаргасан санхүүгийн тайланг загварын дагуу тайлагнахад хэрэгтэй тоо баримтын эх сурвалж гэж үзэж болохгүй.

Цаашилбал санхүүгийн жилийн төгсгөл орчимд хийгдэж байгаа гүйлгээг тойрсон төлбөрийн асуудал үүсдэг. Хэрэв компани татвараа 12 дугаар сарын 31-нд төлөх ёстой байсан бөгөөд тэр өдрөө төлбөрийн даалгавар бичиж банкинд өглөө гэж үзэхэд уг төлбөр засгийн газрын дансанд 1 дүгээр сарын эхээр орж ирэх магадлал ихтэй. Энэ нь төлсөн ба хүлээн авсан мөнгөн дүнгийн хооронд зөрүү үүсгэж болно. ООТБ тухайн томилогдсон аудитор, эсхүл нэгтгэн тулгагчтай зөвлөлдсөний үндсэн дээр энэ асуудлыг шийдэх ёстой. Хэрэв та бүхний гол зорилго засгийн газрын хүлээн авсан мөнгөн дүнг тогтооход чиглэгдэж байгаа бол төлбөр хүлээн авсан өдөр нь тайлагнавал зохих өдрөөс илүү чухал гэсэн шийдвэр гаргаж болох юм. Ямартай ч байсан, аудитор, эсхүл нэгтгэн тулгагч нь тайлангийн загвар боловсруулахдаа цаг хугацааны энэ ялгааг анхаарч үзэх шаардлагатай.

2.6 Хараат бус захирагч томилох

Оролцогч талын бүлэг нь ОУИТБС-ын үйл явцын хүрээг буюу нэгтгэн тулгалт хийх, эсхүл өргөн хүрээтэй аудит хийх эсэхээ нэгэнт тодорхойлсны дараа энэ ажлыг хийж гүйцэтгэх хараат бус мэргэжилтнүүдийг авч ажиллуулах хэрэгтэй болно. ОУИТБС-д ООТБ нь тухайн ажлыг хийлгэхээр хөлсөлсөн байгууллагадаа сэтгэл ханамжтай байхыг шаарддаг²⁸. Энэ нь, ООТБ нь сонгосон байгууллагынхаа төлөө санал өгөөд зогсохгүй уг сонголтыг хийхэд тодорхой үүрэг гүйцэтгэнэ, тэр дундаа тухайн байгууллагын ажлын даалгаврыг тодорхойлно гэсэн үг. Үүний нэг адилаар, ООТБ цаг нь болоход баталгаажуулагчаа ч бас үнэлж дүгнэх, батлах эрхтэй. Ингэхдээ ООТБ нь ОУИТБС-ын Нарийн бичгийн газраас гаргаж өгсөн баталгаажуулагч байгууллагуудын жагсаалтаас сонголт хийх юм.

Оролцогч талуудын хувьд авч ажиллуулж байгаа фирм (мөн бусад холбогдох чиглэлийн мэргэжилтнүүд) нь зохих чиглэлээр мэргэжсэн, ямар нэг ашиг сонирхлын зөрчилгүй байх, тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах төсөв хөрөнгөд тохирсон үнийн санал авах сонирхол ихтэй байдаг. Энэ зорилгоо биелүүлэхийн тулд ООТБ нь, ерөнхийдөө Нарийн бичгийн газраараа дамжуулж,

худалдан авалтын үйл ажиллагааны эхнээс эхлээд яг юу шаардлагатай байгаагаа маш тодорхой болгож, энэ бүх шаардлагаа сонгон шалгаруулалтад оролцох сонирхлын бичиг, эсхүл тендерийн зарлах баримт бичигтээ оруулж өгөх ёстой.

Нэн ялангуяа, хараат бус мэргэжилтнүүд авч ажиллуулахаасаа *өмнө* танай улсад ОУИТБС-ын хамрах хүрээ ямар байхыг тодорхойлох нь чухал бөгөөд улмаар тэд үнэн зөв, зардлыг бүрэн тусгасан, иж бүрэн тендерийн санал ирүүлж чадах болно. Урьдаас шийдвэрлэх шаардлагатай дараахи гол асуудлууд байна:

- Шалгалт хийх жилийн тоо
- Материаллаг байдлын түвшин
- Хамрагдах аж ахуйн нэгж, байгууллагууд
- Хараат бус мэргэжилтэн нь бэлэн гаргаж өгсөн аудитад найдах, эсхүл түүний цаана байгаа орлогын тоо баримтыг шалгах эсэх
- Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний (өөрөөр хэлбэл, газрын тос, байгалийн хий, ашигт малтмал гэх мэт) биет тоо хэмжээг шалгах эсэх
- Үйлдвэрлэлийн аль нэг үйл ажиллагааг (тусгай зөвшөөрөл олголт, үйлдвэрлэлийн хэмжилт гэх мэт) шалгах эсэх
- Дотоодын түнштэй байх шаардлагатай эсэх.

Аудиторууд буюу нэгтгэн дүгнэгч нарт тавигдах шаардлага. ОУИТБС-ын Шалгуур 2-г хэрэв хөндлөнгийн хяналт байхгүй бол аудиторууд буюу нэгтгэн дүгнэгч нар нь итгэмжлэгдсэн, хараат бус байж аудитын олон улсын стандартууд хэрэглэхийг шаардсан байдаг. Эдгээр стандартууд хангагдаж байгаа эсэхийг шалгах тал дээр иргэний нийгмийн оролцогч талууд сонор сэрэмжтэй байх хэрэгтэй.

Итгэмжлэгдсэн байхын тулд аудиторууд, эсхүл нэгтгэн дүгнэгчдийн ажлын даалгаварт дараахи шаардлагыг тавих хэрэгтэй:

- Мэргэжсэн нягтлан бодогчид байх
- Ялангуяа танай оронд, болж өгвөл олон улсын хэмжээнд олборлох үйлдвэрлэлийн компаниудад аудит хийж байсан туршлагатай байх (хараат бус байдал-тай холбоотой шаардлагыг энэ талаар дор дурдсан хэсгээс үзнэ үү)
- Тухайн ажлыг хийж чадах хангалттай хэмжээ, ажилтнуудтай байх
- Тайланд аль нэг мэргэжсэн нягтлан бодогч гарын үсэг зурна гэдэгтэй санал нэг байх

Бүр тодорхой авч үзвэл, одоогийн аудитын тайлангуудад ООТБ-ийн итгэх илтгэлийн түвшин, үндэсний нягтлан бодох бүртгэлийн салбарын боловсронгуй байдлын түвшин, ОУИТБС нь иж бүрэн аудит, эсхүл нэгтгэн тулгалт байх эсэх зэргээс хамаарч олон улсын, эсхүл ОУИТБС-ын стандартын дагуу аудит хийж гүйцэтгэх чадвартай, хараат бус шинжээчээр ажиллаж чадах, өөрийн улсынхаас өөр орны аудитын фирмтэй байхыг хүсч болно. Санхүүгийн урсгалд зөвхөн тулгалт биш, аудит хийдэг Нигери Улсын ОУИТБС-ын Үндэсний оролцогч талуудын ажлын хэсгийн хувьд одоогийн байдлаар дотоодын туршлагатай аудитын компаний туслалцаатайгаар аудитыг удирдан явуулж, тайланд гарын үсэг зурах аудитын олон улсын фирм шаардлагатай байна. Дотоодын нягтлан бодох бүртгэлийн салбарын мэргэжлийн түвшин, аудитын болон олон улсын стандартуудын зонхилох байдал, фирмүүдийн чадавхи, хараат бус байдлаас хамаарч аудитын дотоодын компаниуд чухал үүрэг гүйцэтгэж болно.

Аудиторууд буюу нэгтгэн дүгнэгчид *хараат бус* байхын тулд одоогоор дараахи зүйлсэд оролцоогүй байх ёстой:

- танай улсын засгийн газрын бүртгэл, эсхүл тухайн салбарын үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд оролцогчдын аудитад
- танай орны засгийн газарт, эсхүл олборлох үйлдвэрлэлийн компаниудад зөвлөх үйлчилгээ үзүүлэхэд
- ашиг сонирхлын томоохон зөрчил байж болзошгүй бусад үйл ажиллагаанд.

Ашиг сонирхлын зөрчлийг удирдах нь. Болдогсон бол ОУИТБС-ын аудиторууд, эсхүл нэгтгэн дүгнэгчид олон улсын хэмжээнд газрын тос, байгалийн хий, уул уурхайн аудит хийж байсан туршлагатай, танай улсад үйл ажиллагаа явуулж буй аль нэг компаний төлөө ажиллахааргүй, тухайн улсын онцлогын талаар зарим дотоод мэдлэгтэй, ОУИТБС-ын ажлыг хийх сонирхолтой байвал зохино. Гэвч дэлхий даяар үйл ажиллагаа явуулдаг нягтлан бодох бүртгэлийн дөрөвхөн компани байдаг учраас газрын тос, байгалийн хий, уул уурхайн томоохон компаниудтай ажиллаж байгаагүй компани олоход хэцүү байдаг. Нэг аудитын фирм ямар нэг компаний бүртгэл тооцооны аудит, тоо баримт нэгтгэн тулгалт хоёрыг аль алийг нь хийх нь өмнө хийсэн ажлаа өөрөө шалгаж байна гэсэн үг учраас ашиг сонирхлын зөрчил болох талтай.

Энэ асуудлыг шийдэх гурван арга зам байдаг:

- Харьцангуй жижиг боловч чадвар сайтай фирм сонгож авах
- Дэлхийн хэмжээнд ажилладаг компаниас хараат бус баг байгуулж ажиллахыг шаардах
- Туршлагатай, ямар нэг зөрчилгүй, итгэлтэй үндэсний фирм сонгож авах

Олон фирм дэлхийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаггүй, гэхдээ Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (ЭЗХАХБ) орнуудад үндэсний газрын тос, байгалийн хийн компаниуддаа аудит хийж байсан туршлагатай (эсхүл өмнө нь газрын тос, байгалийн хийн компаниудад аудит хийж байсан) боловч одоогоор тэр ажлаа хийхгүй байгаа чадварлаг аудиторууд олон байдаг. Хэрэв тэд энэ ажлын шаардлагыг хангаж байвал ийм фирмүүд ямар нэг ашиг сонирхлын зөрчилгүй байх болно.


Мөн дэлхийн хэмжээний фирмүүдийн хувьд тухайн улсын үндэсний газрын тосны компанид, эсхүл тус улсад ажиллаж байгаа өөр нэг компанид аудит хийж байгаагүй аудиторууд буюу мэргэжилтнүүдийн баг байгуулж ажиллах замаар ашиг сонирхлын зөрчлөө багасгахыг хичээж болох талтай. Үүний тулд тэд танай оронд ажиллаж буй тус фирмийн салбараас Газрын тосны үндэсний компанид (ГТҮК) ажиллаж байгаагүй хэсэг аудитор сонгон авч ашиглах, эсхүл өөр нэг орны салбараас аудиторуудын баг авчирч ажиллуулах боломжтой.

Эдгээр тохиолдолд яг ямар хүмүүс аудит хийх, ажлыг удирдах, дүгнэлтэд гарын үсэг зурахыг тогтоох, танай оронд ажиллаж байгаа бусад компаниудад уг аудиторуудын хэн нь ч ажилладаггүй байх нөхцлийг ООТБ-ээс бүрдүүлж өгөх нь чухал.

Дотоодын туслалцаа. Танайхаас өөр аль нэг улсад ажиллах тусгай зөвшөөрөлтэй буюу мэргэжсэн аудитын фирм авч ажиллуулан аудитын, эсхүл нэгтгэн тулгалтын ажлыг удирдуулж, дүгнэлтэд гарын үсэг зуруулах нь олон нийтийн итгэлийг хүлээх ихээхэн давуу талтай гэж бид үздэг. Тоо баримтын шинжилгээ хэдийчинээ нарийн байх тусам тухайн салбарын үйл ажиллагаа хэрхэн явагддагыг сайн мэддэг мэргэжилтнүүд сонгож авах нь чухал. Гэхдээ тухайн орны онцлогыг сайн мэддэг байх нь ямагт чухал. Тухайн орны хэл, ёс заншлыг мэддэг байх нь аудитыг үр дүнтэй явуулахад салшгүй ач холбогдолтой. Гадаадын аудиторунд буюу мэргэжилтнүүдийг удаан хугацаагаар авчирч ажиллуулан нисэх онгоц, зочид буудал болон бусад зардлыг даах нь маш өндөр өртөг зардалтай байж болно. Өөр нэг тэргүүн туршлага бол аудитын олон улсын баг нь дотоодын фирмтэй түншилж ажиллах явдал юм. Мөн тухайн дотоодын фирм итгэл хүлээх чадвар, хараат бус байдлын сорилтыг хангасан, дээр дурдсан ашиг сонирхлын зөрчилгүй байх ёстой.

Сонгон шалгаруулах ажиллагаа. Аудитор, эсхүл нэгтгэн дүгнэгчийг сонгон шалгаруулах тендерийг боловсруулж явуулах олон арга зам байдаг бөгөөд уг үйл явц ил тод, өрсөлдөөнтэй, тэгш шударга байж, олон улсын стандартууд болон дотоодын эрэлт хэрэгцээнд нийцсэн байх нөхцлийг бүрдүүлэхэд харгалзах олон хувьсагч байдаг. ООТБ-ээс энэ асуудлыг хариуцсан дэд хороо томилон энэхүү цаг хугацаа шаардсан ажиллагаанд оролцуулах хэрэгтэй. Энэ хороондоо бас ИНБ-ын төлөөллийг оруулах нь чухал. Эдгээр олон янзын, хүндрэл бэрхшээлтэй шалгууруудыг амжилттай хангаж байгаа нь нотлогдоод байгаа ОУИТБС-ын олон улсын тендерийн үйл ажиллагааны үндсэн бүтэц нь ерөнхийдөө дараахи дараалалтай урсгалаас бүрддэг:

Зураг 2.2: ОУИТБС-ын тендер шалгаруулах ажиллагаа



Олон нийтэд хандсан зар сурталчилгаа. Сонгон шалгаруулалтын ажиллагаа нь ихэвчлэн тендерт оролцох сонирхолоо илэрхийлэхийг урьсан зар гаргаж томоохон хэвлэл мэдээллийн хэрэгсэлүүд тавьснаар эхэлдэг. Уг зар буюу тендерийн урилгад тусгайлан санал болгож байгаа үйлчилгээнийхээ талаар (ОУИТБС-ын аудит буюу нэгтгэн тулгалт, тендерт оролцогчдод тавигдах шаардлага, тендерт оролцох сонирхолоо илэрхийлэх эцсийн хугацаа, ашиг сонирхлын зөрчлийн бодлого гэх мэт) хураангуй байдлаар дүрсэлдэг. Ингээд оролцох сонирхолоо илэрхийлж байгаа байдлаас уг өрсөлдөөнт тендерт санал болгосон ажлыг гүйцэтгэх сонирхолтой пүүс компани хангалттай байгаа эсэх нь харагдах болно. Мөн олон улсын сэтгүүлүүдэд (*Экономист, Файнаншиал Таймс, Европын Холбооны Сэтгүүл* гэх мэт) энэ тухай зарлал тавих нь тустай байдаг. Хэрэв Дэлхийн Банк юмуу өөр нэг хөгжлийн агентлаг ОУИТБС-ын ажлыг тодорхой нэг улсад хариуцан гүйцэтгүүлэхэд тусалж байгаа бол тухайн санхүүгийн байгууллага өөрийн дүрмийн дагуу хаана, хэзээ зарлан сурталчилж туслахаа шийдэх болно.

Ажлын даалгавар буюу тендерийн баримт бичиг. Зөв аудиторoo тохирох үнээр олж авах хамгийн шилдэг арга бол ямар ажил хийх шаардлагатай нь маш тодорхой байх явдал юм. Зарим тохиолдолд энэ нь маш хялбар байдаг: хийх ажил нь бүхий л холбогдох орлогын урсгалын дагуу төлж байгаа төлбөр ба хүлээн авч байгаа орлогыг нэгтгэн тулгаж, зөрүүг тайлагнах явдал юм. Бусад тохиолдолд хийх ажлын хамрах хүрээ илүү өргөн, тухайлбал холбогдох гүйлгээний үнэн зөв байдлыг болон газрын тос, байгалийн хийн биет үйлдвэрлэлийн хэмжээг нягтлан шалгах, эсхүл төлвөл зохих татвар, нөөц ашигласны төлбөрийг тооцоолох шаардлагатай байж болно.

ООТБ нь энэхүү баримт бичгийг боловсруулах чадвартай, эсхүл шаардагдах туслалцааг авч байгаа эсэхийг иргэний нийгмийн гишүүд шалгах хэрэгтэй. Энэ баримт бичгийн хариуд тендерт оролцогчдоос ирүүлж байгаа материал нь иргэний нийгмийн гишүүд тухайн аудитаар хийгдэх ажлын чанарыг үнэлэх буюу урьдчилан төсөөлөх боломж олгодог. Тендерийн баримт бичиг буюу тендерийн санал тавих хүсэлтэд ООТБ-т тогтмол тайлагнах, тайлагнах маягтын загварууд гаргах, эцсийн тайланг ойлгомжтой үг хэллэгээр бэлтгэж гаргах гэх мэт тусгай шалгуурууд тавигдах ёстой.

Ингээд урьдчилсан шаардлага хангасан тендерт оролцогчдод тендерийн баримт бичиг, гүйцэтгэх ажлын хүрээний нэг хувийг илгээж, улмаар уг баримт бичгийн дагуу техникийн болон санхүүгийн саналаа ирүүлэхийг хүсдэг.

Тендерт оролцогчдын богино жагсаалт гаргах. Тендерийн саналууд ирсний дараа хэрэв өрсөлдөөний талбар хэтэрхий том байна гэж үзвэл ООТБ-ээс хамгийн өрсөлдөх чадвартай фирмүүдийг сонгон нэр дэвшигчдийн тоог цөөлөх хэрэгтэй. Энэ тохиолдолд тендерийн саналуудыг үнэлэхээс өмнө оролцогчдод зэрэглэл тогтоож, үнэлгээний оноо өгөх техникийн шалгуур үзүүлэлтүүдийг тендерийн дэд хороо шийдэх ёстой. Эдгээр шалгуурт: холбогдох салбарт (газрын тос, байгалийн хий, эсхүл уул уурхай) аудит хийж байсан туршлага, ОУИТБС-ын туршлага, ОУИТБС-ын аудитын ямар нэг төрөлжсөн чиглэлээр (тухайлбал, очир алмаас олборлолт, шингэрүүлсэн байгалийн хийн борлуулалт гэх мэт) ажиллаж байсан туршлага, ажлын төлөвлөгөөний хангалттай байдал, ажилтнуудын чадавхи, хэлний мэдлэг чадвар, консорциумдаа нэр хүндтэй дотоодын түнштэй эсэх зэргийг оруулж болох юм. Мөн энэ цэг дээр ООТБ-үүд тендерт оролцогчидтой ярилцлага хийх буюу ООТБ-ийн хуралд танилцуулга хийх хүсэлт тавьж болно.

Тендерт оролцогчдын бага хурал. Тендерт оролцогчдод тухайн тендерийн баримт бичгийн талаар асуух асуулт гарах нь дамжиггүй. Бүх оролцогчид ижил гараанаас өрсөлдөх нөхцлөөр хангахын тулд бага хурлын үеэр тендерт оролцогч бүр асуулт асууж хариулт авах боломж олгох, өгч байгаа хариултыг нь бүх оролцогчдод зэрэг танилцуулах нь зүйтэй байдаг. Өөр нэг хувилбар бол тендерт оролцогчдод асуултаа ирүүлэх боломж олгож, хариултыг нь бүх оролцогчдод e-мэйлээр илгээх явдал байдаг.

Хэлэлцээр хийх урилга. ООТБ техникийн шаардлагын дагуу тендерт оролцогчдын богино жагсаалт гаргасны дараа (магадгүй 3-4 фирм сонгосон), ООТБ-ын тендерийн хороо санхүүгийн саналуудыг нээж, байр эзлүүлнэ. Хамгийн энгийн нэг арга бол хамгийн бага үнийн санал өгсөн газартай гэрээ байгуулах явдал боловч үнэн хэрэгтээ тендерийн саналууд ихээхэн ялгаатай байж болно. Нэг оролцогчынх нь ажлын төлөвлөгөө нарийн нямбай хийгдсэн боловч үнийн санал нь өндөр байж болно. Нөгөө оролцогчийн ажлын төлөвлөгөө өнгөцхөн, эсхүл цаад тоо баримтад хийх шалгалт нь хязгаарлагдмал боловч ямар нэгэн ашиг сонирхлын зөрчил огт байхгүй фирмээс ирүүлсэн байж болно. Иймээс хамгийн бага үнийн санал өгсөн оролцогчийг шалгаруулж яаруу, эсхүл албадмал шийдвэр гаргахын оронд оролцогч бүрт хэлэлцээрт оролцох урилга өгч, ООТБ-ийн зүгээс богино жагсаалтад орсон бүх оролцогчдод хандан саналаа өөрчлөн сайжруулах, тус бүлгээс хүсч буй ажлын шаардлагад тулгуурласан үнэ санал болгох, яг ямар ажилтан нь аудит хийх эсвэл удирдан явуулахыг тодорхой болгох, чанарын өндөр түвшинг хангах, ямар нэг ашиг сонирхлын зөрчил байхгүй гэдгээ батлахыг хүсч болно. Нэгэнт эдгээр шаардлагын хариултыг авсны дараа хорооноос зөвлөмж гаргаж ООТБ-ийнхэн болон иргэний нийгмийнхэнд тайлбарлаж болно.

Гэрээ. ООТБ ба аудиторын хооронд байгуулах гэрээнд хийх ажлын хүрээ, тайлагнах үүрэг, төлбөрийн хуваарь, нууцлалын үүрэг, маргаан гарсан үед авах арга хэмжээ зэргийг зааж өгөх ёстой. Хэрэв гэрээний маягтаа тендерийн баримт бичигтэйгээ хамтад нь өгчихсөн бол гэрээнд гарын үсэг зурах нь харьцангуй энгийн асуудал байх юм. Гэрээг бэлэн болгож гарын үсэг зурахаасаа өмнө ООТБ-ийн бүх гишүүдээр батлуулах ёстой.

2.7 Явцын хяналт тавих

Явцын тайлангийн ач холбогдол. Аудит буюу нэгтгэн тулгалтын ажиллагаа нь тухайн ажлын хамрах хүрээ, бүртгэлийн бичилтүүдийн чанараас (эсхүл бүр байгаа байхгүйгээс) хамаарч зургаан сараас нэг жил хүртэл үргэлжилж болно. ООТБ-ийн гишүүд, иргэний нийгмийн хувьд ажил эхлэх ба эцсийн тайлан гаргахын хоорондох хугацаанд юу болж байгааг мэдэх шаардлагатай байдаг.

Оролцогч талууд тухайн сонгогдсон байгууллагаас ажлын цар хүрээний явцын тайлан болон бусад цуврал “бүтээгдэхүүн” бэлтгэн гаргаж бичгээр болон биеэр танилцуулахыг шаардах хэрэгтэй. Ингэснээр ООТБ-т байгаа иргэний нийгмийн гишүүд салбарын практикуудын талаар суралцаж, аудитын ажиллагаа явагдаж байгаа эсэх талаар мэдээлэлтэй байх болно.

Аудиторууд буюу нэгтгэн тулгач нарт хүндрэл бэрхшээл тулгарах нь цөөнгүй. Жижиг компаниуд мэдээлэл авах шаардлагыг нь үл ойшоож болно. Маягтаа буруу бөглөж ирүүлсэн байж болно. Тэр ч бүү хэл төрийн байгууллагууд

хүртэл маягтаа зөв бөглөхөд хүндрэлтэй байж болно. Түүнчлэн зарим газрууд аудитын үйл ажиллагаанд санаатай, эсхүл санамсаргүйгээр саад учруулахыг оролдож болно. Хүндрэл бэрхшээлтэй асуудал гарсан үед тэдгээрийг шуурхай шийдвэрлэх шаардлагатай бөгөөд ООТБ-ээс тэдгээрийг шийдэгдсэн эсэхийг шалгаж арга хэмжээ авах хэрэгтэй. (Зөрүүтэй байдал яагаад гардаг, тэдгээрийг яаж шийдвэрлэх талаар Бүлэг 3-аас үзнэ үү.) Аудиторууд, нэгтгэн туллагчид, эсхүл захирагч нарын зүгээс хамтарч ажиллахгүй байгаа аливаа компани, эсхүл төрийн байгууллагын жагсаалтыг сар бүр ООТБ-т ирүүлж байх хэрэгтэй. Ямар нэг зохицуулалтын, эсхүл хууль ёсны арга хэмжээ авахын өмнө “нэрлэж ичээх” арга хэрэглэх нь эдгээр компаниудыг хамтран ажиллахад хүргэх үр нөлөөтэй арга байдаг. ООТБ-ээс бүх компаниудыг хамтран ажиллахад хүргэх алхам авч байгаа эсэхэд иргэний нийгмийн гишүүд анхаарал тавьж ажиллах хэрэгтэй. Нигерийн аудиторууд гэрээний дагуу сар бүр явцын тайлангаа биеэр болон бичгээр танилцуулах шаардлагатай байдаг бөгөөд бидний мэдэж байгаагаар ийм шаардлага тавьсан өөр орон байхгүй байна.

Хэрэв асуудал шийдэгдэхгүй бол иргэний нийгмийн гишүүд сонин хэвлэлд нийтлэл, шүүмжлэл бичих, ООТБ-т байгаа иргэний нийгмийн гишүүд төрийн байгууллагуудаас хамтын ажиллагаа шаардахыг дэмжих замаар төр засгаас арга хэмжээ авахуулахад чиглэсэн олон нийтийн шахалт үзүүлж болно.

ООТБ ямар тайлан хүсэн хүлээж болох вэ? ООТБ нь хараат бус шинжээчээс дараахи гол материалыг шаардах хэрэгтэй:

- Хамрагдах аж ахуйн нэгж байгууллагуудын бөглөх тайлангийн маягтын загвар
- Хамрагдах аж ахуйн нэгж, байгууллагуудын жагсаалтын төсөл
- Сар бүрийн явцын тайлангууд

Мөн эдгээр нь ажлын даалгаврын нэг хэсэг байх ёстой. ООТБ-ийн гишүүд Засгийн газраас дараахи баримт бичгийг шаардаж болно:

- Салбарт оролцож буй бүх аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт (түүний дотор, нөөц баялгын үйлдвэрлэл явуулж байгаа, тухайн аудитлагдах жилд төлбөр тооцоо хийхээр гэрээ байгуулсан этгээдүүд)
- Холбогдох төрийн байгууллага бүрээс хариуцаж ажиллах хүмүүсийн холбоо барих хаяг
- Улсын ба хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагууд аудиттай хамтран ажиллахыг төр засгаас үүрэг болгосон ямар нэг тушаал шийдвэр

Ажил эхлэн явагдсаны дараа иргэний нийгмийн гишүүд нэмэлт материалууд шаардаж болно. Үүнд:

- Аудитор буюу нэгтгэн туллагчийн ажлын сар бүрийн явцын тайлан
- Хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагууд хамтран ажиллаж байгаа эсэх тухай тэмдэглэл
- Засгийн газраас тулгарч буй саад бэрхшээлийг багасгаж, эсхүл үл ойшоож байгаа эсэх тухай тэмдэглэл

Тайланг хэзээ нийтийн хүртээл болгох ёстой вэ? Аливаа ил тод байдлын хөтөлбөрийн зорилго бол аль болох нээлттэй байх явдал юм. Харин ОУИТБС бол аудиторууд буюу нэгтгэн туллагчид бүх мэдээлэл, түүний дотор нууц мэдээллийг авах бүрэн эрх олгохын зэрэгцээ тогтоосон орлогуудыг төрлөөр нь, эсхүл компаниар нь нэгтгэх буюу задлах байдлаар олон нийтэд тайлагнахад чиглэгддэг. Бараг аль ч хувилбараар авч үзсэн, нийтлэгдэх мэдээллийн хэмжээ нь шинжээчдийн авч үзэх боломжтой мэдээллээс бага байх болно. Мөн хараат бус шинжээчдийн гаргасан явцын тайлангуудад хожим шийдэгдэх маш их зөрүүтэй байдал илэрч болно. Эдгээр үр дүнг эрт тайлагнаснаас болж олон нийтийн дунд асар их шүүмжлэл, буруу ойлголтууд төрж болно. Ийм учраас, шинжээчдийн зүгээс төлбөрийг нягтлан тодорхойлоход тулгарч буй бэрхшээлтэй асуудал гэх мэт тодорхой мэдээллийг олон нийтэд бус, ООТБ-т тайлагнах боломжийг үе үе олгож байх нь ухаалаг шийдэл байж магадгүй. Аудиторууд ба нэгтгэн туллагчид асуудлыг хөндөж тавих шаардлагатай ч, тухайн асуудлыг бүрэн шалгаж дуусах хүртлээ ямар нэг компани, эсхүл төрийн байгууллагад олон нийтийн эргэлзээ төрүүлэх, эсхүл шүүмжлэх зүйл хийх нь тусгүй. Иймээс ООТБ-ийн хувьд хүсвэл урьдчилсан тайлангуудыг нууц байлгах эрхтэй байх ёстой боловч эцсийн тайланг нууцлах эрхгүй байна.

Нууц мэдээллийг удирдах нь. Олон оролцогч талын бүлгийн ажилд гардаг нэг чухал асуудал бол мэдээлэлд хэрхэн хандах вэ гэдэг асуудал юм. Аливаа ил тод байдлын хүчин чармайлтад оролцогч талын бүлэгт хүлээн авч байгаа бүх мэдээлэл ил тод байх мэт санагдах боловч ингэх нь практик дээр тэр болгон сайн үр дүн авчирдаггүй. Жишээлбэл, хараат бус шинжээчийн ажлын даалгаврын төслийг бүх талуудад адил тэгш байдлаар өгөх хүртэл ил гаргах ёсгүй бөгөөд ингэснээр нэг ч өрсөлдөгч бусдаасаа давуу тал олж авахгүй байх нөхцөл бүрдэх юм. ОУИТБС-ын ажлын төсвийг нийтэд ил болгох ёсгүй. Учир нь, тендерт оролцогчид аудитын хөтөлбөр болон ажил үүргээ маш сайн төлөвлөн боловсруулж, тухайн ажлыг гүйцэтгэх өрсөлдөөнт үнийн саналаа дэвшүүлэхийн оронд уг төсвийг үнийн санал болгон ашиглах талтай.

2.8 Засгийн газар бүх компани тайлагнах нөхцлийг бүрдүүлсэн үү?

ОУИТБС (Баталгаажуулалтын хүснэгтийн үзүүлэлт 10)²⁹-д төрийн өмчийн ч бай, хувийн өмчийн ч бай бүх компаниуд төлбөрөө тайлагнахыг шаарддаг. Энэхүү үүргийг заавал биелүүлэх үүрэг болгохын тулд засгийн газрууд хууль батлуулах, зохицуулалт гаргах, бичгээр байгуулсан гэрээнд орох, эсхүл харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах замаар энэ шаардлагыг сахиулдаг. Энэ нь төлбөрийн тайлагналтад сайн дураар оролцдог Габон Улсад маш их хэрэгтэй шаардлага байв. Оролцогч талууд Баталгаажуулалтын алхам 9 (маягт бөглөх)-тэй холбоотой хоёр асуудлыг ООТБ-т гаргаж тавих хэрэгтэй. Эхний асуудал бол ямар төрлийн төлбөрүүдийг тайлагнах вэ гэдэг асуудал. Хоёрдугаарт, бүх компаниуд тайлагнах ёстой юу, эсхүл зөвхөн материаллаг төлбөртэй гэж үзсэн компаниуд тайлагнах уу гэдэг асуудал байна.

Хэдийгээр газрын тос, байгалийн хийн үйлдвэрлэлийн зарим компаниуд маш жижигхэн, орлого нь материаллаг биш байж болох боловч бүх оролцогч компаниудыг тайлагнуулах ёстой гэсэн нэг үзэл байдаг. Бүгд тайлагнахгүй бол нийт орлогын дүнг тогтоох аргагүй. Мөн бүх компани тайлагнахыг шаардах нь хэдийгээр төлбөрийн хэмжээ, эсхүл компаниуд нь материаллаг байдлын

босгод хүрэхгүй ч гэсэн засгийн газар татвар, нөөц ашигласны төлбөр болон бусад төлбөрөө хурааж авсан эсэхийг тодорхойлох боломжийг зохицуулагч нар олгодог. Зарим хэрэгжүүлэгч орнууд, бүх компаниас тайлан шаардах нь зардал ихтэй, эсхүл жижиг үйлдвэрлэгчдийн тайлангаас авах мэдээлэл бага байдаг гэдгийг тогтоочихсон учраас тэднээс тайлан шаарддаггүй байна.

Уул уурхайн салбар ч онцгой хүндрэлүүд үүсгэж болно. Уул уурхайн салбарын зарим оролцогчид нилээд жижиг байдаг. Иймээс бараг бүртгэл хөтөлдөггүй байж болох гар аргаар олборлогчид, хувиараа бизнес эрхлэгчдийг авч үзэх эсэх, авч үзвэл яаж авч үзэхээ ОУИТБС тогтоох шаардлагатай болно. Жижиг оролцогчдыг ОУИТБС-тай хамтран ажиллахад туслах үүднээс олон нийтэд хандсан тусгай арга хэмжээ авах шаардлагатай байж болно, эсхүл тэднийг бүхэлд нь тайлагнах шаардлагаас чөлөөлж болох юм.

Одоогоор тайлангаа гаргаад байгаа ихэнх орнууд материаллаг урсгалыг тогтоох эрмэлзэлдээ тулгуурлан зөвхөн одоо үйлдвэрлэл явуулж байгаа компаниуд, эсхүл томоохон компаниудыг тайлагнахыг шаардаж байна. Зөвхөн Нигери Улс л бүх компаниа тайлагнахыг шаарддаг боловч зарим нь дагаж мөрддөггүй байна. Тайлангийн энэ шаардлагыг одоо Нигерийн ОУИТБС-ын тухай хуулиар хуульчлан бататгаад байна. Гэхдээ дан ганц хуультай болох нь тэр бүр хангалтгүй, түүнийг ашиглаж, үйл явцыг удирдахад бэлэн хүмүүстэй байх хэрэгтэй.

2.9 Бүх компанийн тайлан олон улсын стандартын дагуу аудитлагдсан бүртгэл тооцоонд тулгуурласан байх нөхцлийг Засгийн газар бүрдүүлсэн үү?

ОУИТБС-д бүх компани, Засгийн газрын тайлангууд олон улсын стандартын дагуу аудитлагдсан данс бүртгэлээс авсан тоо баримтуудад тулгуурласан байхыг шаарддаг. (Баталгаажуулалтын гарын авлагын Хүснэгтийн үзүүлэлт 12, 13-г болон дагалдах Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгсэлийг үзнэ үү)³⁰. Засгийн газрууд тоо баримтыг стандартын дагуу бэлтгэхийг шаардах, нягтлан бодох бүртгэлийн үндэсний стандартыг шинэчлэн олон улсын стандартууд нэвтрүүлэх, тоо баримтаа олон улсын стандартуудын дагуу бэлтгэхээр тохирсон гэрээг компаниудтай байгуулах замаар энэ шаардлагыг хэрэгжүүлдэг. Мөн ОУИТБС-д компанийн мэдээлэл олон улсын стандартад нийцэхгүй байгаа тохиолдолд Засгийн газар тухайн компанитай тохиролцож тэдгээрийг стандартад нийцүүлэх хуваарь гаргахыг шаарддаг. Мэдээллийг олон улсын стандартын дагуу аудитлах энэхүү шаардлага нь дараахи гурван шалтгаанаар ОУИТБС-ын хамгийн чухал боловч хамгийн сул талуудын нэг байдаг.

Нэгдүгээрт, ОУИТБС-ын тулгалт тийм ч их мэдээлэл сайтай бус байдаг. *ОУИТБС-ын сурвалж бичиг*-т төлөгч байгууллагын мэдүүлсэн төлбөрүүдийг хүлээн авагч байгууллагын холбогдох мэдүүлэгтэй тулгах замаар баталгаажуулах асуудлыг онцолдог. Уг сурвалж бичиг ёсоор тухайн аудитор мэдүүлсэн хоёр тоо баримт тохирч байгаа эсэхийг шалгах шаардлагатай. Энэхүү маш хязгаарлагдмал шаардлагын цаана дараахи хоёр санаа агуулагддаг:

1. Аливаа гүйлгээг хоёр талын аль аль нь орхигдуулсан бол аудитор байгаа мэдээлэлдээ тулгуурлан илрүүлж чадахгүй.

2. Уг дүнгүүд зөв эсэхийг шалгах шаардлагагүй (тухайн төлсөн дүнгүүд нь төлөгдсөн байх ёстой дүнгүүд байсан эсэхийг шалгах үүрэг аудиторт байхгүй).

Хоёрдугаарт, Хүснэгтийн үзүүлэлт 12 ба 13 нь ОУИТБС-ын нэгдмэл байдалд материаллаг сул тал үүсгэдэг. Эдгээр үзүүлэлтэд заахдаа, “нэгтгэн тулгалтад ирүүлсэн тоо баримтууд аудитлагдсан стандартуудтай холбоогүй тохиолдолд олон оролцогч талын бүлэг энэ асуудлыг шийдвэрлэхээр тогтсон арга барилаа баримтална”³¹ гэсэн байдаг. Энэхүү онцгой тохиолдол нь, тоо бүртгэл нь олон улсын стандартыг хангахгүй байсан ч гэсэн тайлагнахыг зөвшөөрч болдог.

Гуравдугаарт, хэрвээ одоо аудитлагдсан бүртгэл тооцоо ашиглаж байгаа бол түүнийг нь олон улсын стандартын дагуу аудитлагдсныг нотлох нотолгоотой байх нь чухал гэдгийг ойлгох нь зүйтэй.

Бидний үзэж байгаагаар, оролцогч талууд компаниудын гаргасан тайлан, тоо бүртгэлийг тулгагдсан байхаас илүү аудитлагдсан байхын төлөө байж, үүнийг хийхийн тулд аль болох зөвшилцөлд хүрэх хэрэгтэй. Аудит нь нэгтгэн тулгалтыг бодвол хамаагүй илүү найдвартай мэдээлэл гаргаж өгдөг бөгөөд компани, Засгийн газрын практикууд дотроос засаглал, ил тод байдлыг дээшлүүлэх ажилд илүү их үнэ цэнэтэй мэдээллийг гаргаж өгөх болно.

Хэрвээ мэдээлэлд нэгтгэн тулгалт хийх болвол, тухайн компани, эсхүл Засгийн газраас ирүүлсэн тайланд хэн аудит хийсэн, олон улсын ямар стандартаар аудит хийсэн, тайлан ирүүлэх мөчид тухайн мэдээлэл үнэн зөв хэвээр байгаа эсэх талаар оролцогч талууд мэдээлэлтэй байх ёстой. Аливаа нэг компани, эсхүл төрийн байгууллагын тайланд тухайн компани юмуу байгууллагын гүйцэтгэх захирал, эсхүл санхүүгийн ахлах ажилтан гарын үсэг зурж баталгаажуулсан байх ёстой. Компани бүрийн аудиторуудаас энд мэдүүлсэн зүйлс өмнө нь аудит хийсэн тоо бүртгэлээс гажаагүй гэсэн баталгаа болгож тухайн компанийн ОУИТБС-ын тайланд гарын үсэг зурахыг шаардах хэрэгтэй.

Ямар ч байсан, аудиторууд, эсхүл нэгтгэн тулгагч нарын гаргах тайлангийн төрөл нь ООТБ тэднээс юу хийхийг шаардахаас хамаарах бөгөөд аудиторуудын гаргах шаардлагатай тайлангийн төрлүүд, тэдгээрт хэрэглэх олон улсын стандартуудын тухай Шигтгээ 2.4-т бичсэн байгаа.

Шигтгээ 2.4: Аудитын тайлангаас юу олж мэдэж авах вэ

Мэргэжсэн нягтлан бодогч нар өөрийн орны мэргэжлийн байгууллагын болон Нягтлан бодогч нарын олон улсын холбооны стандартуудын хүрээнд ажилладаг. Тэд бүхий л ажилдаа шударга, бодитойгоор хандаж (үүнийг ёс зүйн хэм хэмжээ гэдэг) ажиллах шаардлагатай. Төрөл бүрийн ажлын хувьд нягтлан бодогч нар юу хийх ёстой, тайландаа юу бичиж болохыг заасан тодорхой стандартууд ч байдаг. Хэрэв тэд муу ажиллаж, стандарт хэм хэмжээгээр зөрчсөн бол мэргэжлийн байгууллага нь шалгаж тогтоодог байж болно.

Нягтлан бодогч нар ОУИТБС-ын ажлын талаар албан ёсны тайлангууд гаргаж, түүндээ хэрэглэсэн стандартуудаа дурддаг. ОУИТБС-д тусгайлан зориулсан стандарт гэж байхгүй бөгөөд ажлын даалгаварт (АД буюу TOR) юу гэж зааснаас хамаарч ямар стандарт хэрэглэхээ тухайн нягтлан бодогч шийдэх юм. Энд үүсч болох нийтлэг нөхцөл байдлууд гэвэл:

1. АД нь ООТБ-ээс нягтлан бодогч нараар хийлгэхийг хүссэн ажил, олж мэдсэн зүйлийнхээ юуг нь тайлагнахыг зааж өгдөг.
 - Энэ тохиолдолд, тухайн тайлан Холбогдох асуудлуудын тухай олон улсын стандартыг баримтлах болно. Үүнд хийсэн ажлын тухай болон олж мэдсэн зүйлийнхээ талаар бичдэг. Үүнийг “тохиролцсон ажлуудын тухай тайлан” гэж нэрлэдэг. Энэ хэлбэрийн тайлангийн жишээг Габон Улс харуулдаг.
2. АД-т тухайн нягтлан бодогчийн хийх ёстой алхамуудыг нарийвчлан заалгүйгээр ООТБ-ээс гаргаж өгсөн өгөгдлийг хянаж үзэхийг шаарддаг.
 - Энд нягтлан бодогч нар өгөгдсөн тоо баримтад сэтгэл ханамжтай байхын тулд юу хийх шаардлагатайгаа шийддэг, тэд ихэвчлэн хийсэн ажлынхаа талаар тайлагнахгүй боловч тухайн тоо баримтын талаар дүгнэлт гаргана. ООТБ нь аудитын болон баталгаа гаргалтын хамгийн сүүлийн үеийн олон улсын стандартуудтай холбоотой санал зөвлөмж гаргахыг нягтлан бодогч нараас шаардах хэрэгтэй. Энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл <http://www.ifac.org/IIAASB/ProjectHistory.php?ProjID=0008> хаягаар хандана уу.
3. АД нь нягтлан бодогч нар санхүүгийн тайлангуудын багцад аудит хийхийг шаарддаг.
 - Нягтлан бодогч нар нь Аудитын олон улсын стандартын дагуу ажиллах бөгөөд санхүүгийн тайлангууд нь тогтсон тайлангийн хүрээнд нийцэж байна гэж үзэж байгаа эсэх талаар дүгнэлт гаргадаг. Энэ хүрээ нь ихэвчлэн нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартууд байдаг (нягтлан бодох бүртгэлийн стандартууд нь аудитын стандартуудаас ялгаатай гэдгийг анхаарна уу). Энэ төрлийн тайлан нь өртөг зардал ихтэй учраас ОУИТБС-ын зориулалтаар ашиглах магадлал багатай байдаг.

Нягтлан бодогч нар юу хийсэн, ямар стандарт баримтласныг ойлгохын тулд тайлангуудыг анхааралтай уншиж үзэх хэрэгтэй. Хэрэв ООТБ-ээс мэргэжсэн нягтлан бодогчоос өөр хэн нэгнийг аудит хийлгэхээр томилсон бол тухайн хүний хувьд эдгээр зарчмыг заавал баримтлах албагүй.

Ер нь, эдгээр мэргэжлийн стандартууд нь тухайн нөхцөл байдал бүрт нягтлан бодогчийн хийх ёстой ажлыг нарийвчлан заадаггүй. Учир нь, ажил үүрэг бүр өөр өөр байдаг. Харин, тухайн нягтлан бодогчоос шаардсан тайланг гаргахын тулд юу хийх хэрэгтэйгээ шийдэхэд баримтлах үйл явцыг нарийвчлан заасан байдаг. Дээр дурдсан жишээнүүдийн зөвхөн эхнийхэд л ООТБ тухайн тайлангаас яг юу хийснийг нь мэдэж авах боломжтой. Бусад хоёр жишээний хувьд нягтлан бодогчид өөрсөддөө дүгнэлт гаргах боломж олгоно гэж үзсэн янз бүрийн зүйлийг хийж болох боловч тайландаа юу хийсэн талаараа бичихгүй, үр дүнг нь ч харуулахгүй.

ООТБ-ын хувьд эндээс авах санаа бол: хэрэв та бүхэн нягтлан бодогч нар юу хийснийг дэлгэрэнгүй мэдэхийг хүсвэл дараахи зүйлсийн аль нэгийг хийх шаардлагатай: (а) тэдний АД-ыг “тохиролцсон ажлуудын тайлан”-гийн загварыг ашиглан бичих, эсхүл (б) дүгнэлтийн төрлийн тайлан шаардах, тэгэхдээ

энэ дүгнэлтэд хүрэхийн тулд юу хийснээ дурдсан нэмэлт тайлан гаргуулах (магадгүй нягтлан бодогч нар уг нэмэлт тайланг нийтлэхийг хүсэхгүй байх), (в) нягтлан бодогч нар ООТБ-т танилцуулга хийж, хийсэн ажлынхаа талаар болон олж мэдсэн зүйлсийнхээ талаар тодорхой асуултуудад хариулахыг шаардах.

Бүлэг 2: Бэлтгэх үе шат	Тийм/Үгүй
XI. ООТ-ын бүлэг байгуулагдсан уу?	
1. ООТБ-т хувийн хэвшил, ИНБ-ын төлөөлөгчид, төр засгийн (түүний дотор хууль тогтоох байгууллагын) өндөр албан тушаалтнуудын төлөөлөл хангалттай орсон уу?	
2. ООТБ нь дараахи зүйлсээ тогтоосон уу: (а) Ажлын даалгаврууд буюу TORs, (б) олборлох үйлдвэрлэлийн аль салбар хамрагдах, (в) иргэний нийгмийг хэн төлөөлөх, (г) ООТБ нь үйл ажиллагаандаа дэмжлэг үзүүлэх Нарийн бичгийн газар, эсхүл зарим төрлийн хэрэгжүүлэлтийн нэгжтэй байх эсэх?	
3. Хэрэв Нарийн бичгийн газартай бол тэр нь: (а) хурал зохион байгуулж, бүрэлдэхүүнийг оролцуулах; (б) хэлэлцэх асуудлыг хэвлэн нийтлэх; (в) ОУИТБС-ын хэрэгжилтэд оролцож байгаа төрөл бүрийн төрийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах; (г) хурлын мэдээлэл материалыг оролцогч талуудад урьдчилж тараах; (д) аудит, мэдээлэл харилцаа, эрх зүйн чиглэлээр мэргэжлийн зөвлөгөөгөөр хангах; (е) ОУИТБС-ын төсвийг бүрдүүлж захиран зарцуулах; (ё) гадаадын хандивлагчидтай харилцах; (ж) вэбсайт нээж ажиллуулах; (з) олон оролцогч талын бүлгээс өгсөн заавар чиглэлийн мөрөөр арга хэмжээ авах; (и) ОУИТБС-ын үйл явцад юу болж байгаа талаар хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд тайлбарлах; (к) хэвлэл мэдээллийнхний тавьсан асуултад хариулах; (л) аудиторуудын үйл ажиллагааг удирдах, түүний дотор аудиттай хамтран ажиллахгүй байгаа тохиолдолд зохицуулалтаар хангах ажлууд хийдэг үү?	
4. Оролцогч талын бүлгээс орон тооны гүйцэтгэх захирал томилсон уу, бүлэг тэр хүнийг огцруулах боломжтой юу? Мөн Нарийн бичгийн газарт мэдээлэл харилцааны ажилтан, захиргааны ажилтан, эсхүл аудитын мэргэжилтэн байгаа юу?	
XII. Тухайн улсын Үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан уу?	
1. ООТБ уг үйл ажиллагааны төлөвлөгөөг хянаж, шаардлагатай өөрчлөлтийг оруулсны дараа бүлгээрээ хэлэлцэн баталсан уу?	
2. Үйл ажиллагааны төлөвлөгөөнд хүрэх зорилтууд, цагийн хуваарь, төсөв, чадавхийн үнэлгээ орсон уу?	
XIII. ОУИТБС-ын үйл явцад ИНБ-ууд ба компаниудыг татан оролцуулсан уу?	
1. Төр засгаас ОУИТБС-ийг дэмжин хэрэгжүүлэх үүрэг амлалт авсныг засгийн газар болон ООТБ-ээс олон нийтэд мэдээлсэн үү?	
2. ИНБ-ын төлөөлөгчид ИНБ-уудтай байнга холбоотой байх механизм бий юу?	
3. ИНБ-ын төлөөлөгчид ООТБ-ийн хурлын өмнө ИНБ-дын гишүүдтэй уулздаг уу?	
4. Оролцогч талуудын төлөөлөгчид ООТБ-ийн хурлын үр дүнг мэдээлдэг үү?	
5. ИНБ-ууд: (а) өөрсдийн сүлжээг ашиглан ОУИТБС-ын тухай мэдээг түгээн дэлгэрүүлэх, (б) олон нийтээс тавьж буй асуулт, ойлголтуудын тухай мэдээллээр төлөөлөгчдийг хангах, (в) судалгаа хийх, эсхүл мэдлэг туршлагаа хуваалцах, (г) хэвлэл мэдээллийн хэрэгсэлүүдээр ОУИТБС-ын хуралдаан, тайлангуудын талаар мэдээлэхийг дэмжих ажил хийдэг үү?	
6. Оролцоонд тулгарч байгаа саад тотгоруудыг арилгасан уу? Иргэний нийгмийн бүлгүүд төр засгаас хараат бусаар ажиллаж зохисгүй дарамт шахалт, албадлагагүйгээр өөрсдийгөө илэрхийлж чадаж байна уу? Гэрээ ёсоор компаниуд Засгийн газрын зөвшөөрөлгүйгээр санхүүгийн мэдээллээ гаргах хориотой байдаг бол Засгийн газраас компаниудад албан захидал илгээж энэ мэдээллээ нууцлах үүргээс нь чөлөөлсөн үү?	
7. Хэрэв ООТБ-ын хурал тухайн улсын нийслэлд болдог бол хурлын товыг төлөөлөгчдөд эртнээс урьдчилан мэдэгдэж ирж оролцох хугацаа олгодог уу? Тэдэнд тээврийн болон буудлын зардлаа төлөхөд нь санхүүгийн туслалцаа үзүүлдэг үү?	

XIV. Тайлагнах маягтын загварууд боловсруулж ОУИТБС-аас тавигдах шаардлагын хүрээг тодорхойлсон уу?	
1. ООТБ маягтын загваруудыг авч хэлэлцсэн үү?	
2. Эдгээр маягтын талаар санал шүүмжлэл гаргах боломжийг олон нийтэд олгосон уу?	
3. Үндэсний газрын тосны компаниудыг ашиг орлогын урсгалын эх үүсвэрт тооцох эсэхийг ООТБ шийдсэн үү?	
4. Засгийн газар, эсхүл гадны мэргэжилтний зүгээс дараахи асуудлаар ООТБ-т товч мэдээлэл өгсөн үү: (а) ямар урсгалууд засгийн газарт орох эрхтэй вэ, (б) хамгийн сүүлийн үеийн байдлаар эдгээр урсгалаас засгийн газар хэдий хэр орлого олсон гэж үзэж байна вэ (в) тэдгээрийн төрийн ямар байгууллагууд хүлээж авсан бэ?	
5. Бүх төлбөрийн тайлагнах, эсхүл зөвхөн материаллаг гэж үзсэн төлбөрийг тайлагнах эсэхийг ООТБ шийдсэн үү?	
6. Компаниуд гуравдагч талд тоон мэдээлэл гаргаж өгөхийг зөвшөөрөх эсэхийг бататгасан уу?	
7. Маягтын загваруудад (а) компаниуд ба засгийн газрын тайлагнах орлогын урсгалууд, (б) хамрагдах компаниуд, (в) хамрагдах төрийн байгууллагууд, (г) ОУИТБС-ын тайланд хамрагдах хугацаа, (д) мэдээллийг тайлагнах хэлбэр зэргийг зааж өгсөн үү?	
XV. Аудитор, эсхүл нэгтгэн тулгагч авч ажиллуулсан уу?	
1. Аудитор, эсхүл нэгтгэн тулгагчийг авч ажиллуулахаас өмнө (а) шалгалт хийх жилийн тоо, (б) материаллаг байдлын түвшин, (в) хамрагдах аж ахуйн нэгж, байгууллагууд, (г) тайлангийнх нь цаана байгаа орлогын тоо баримтыг шалгах эсэх, (д) үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний биет тоо хэмжээг шалгах эсэх, (д) үйлдвэрлэлийн аль нэг үйл ажиллагааг тусгайлан шалгах эсэх, (е) дотоодын түнштэй байх шаардлагатай эсэх зэргийг ООТБ-ээс шийдсэн үү?	
2. Аудитор, эсхүл нэгтгэн тулгагчийн ажлын даалгаварт дараахи шаардлагыг тавьсан уу? Үүнд: (а) мэргэжсэн нягтлан бодогчид байх, (б) ялангуяа танай оронд, болж өгвөл олон улсын хэмжээнд олборлох үйлдвэрлэлийн компаниудад аудит хийж байсан туршлагатай байх, (в) тухайн ажлыг хийж чадах хэмжээний ажилтнуудтай байх, (г) тайланд аль нэг мэргэжсэн нягтлан бодогч гарын үсэг зурна гэдэгтэй санал нэг байх, (д) ашиг сонирхлын ямар нэг зөрчилгүй байх.	
3. ООТБ-ээс аудитор, эсхүл нэгтгэн тулгагчийг сонгон шалгаруулах дэд хороо томилж ажиллуулсан уу?	
4. ООТБ тендерийн зар гаргаж, (а) гүйцэтгүүлэхээр санал болгож байгаа үйлчилгээ, (б) тендерт оролцогчдод тавигдах шаардлага, (в) оролцох сонирхолоо илэрхийлэх сүүлийн хугацаа, (г) ашиг сонирхлын зөрчлийн бодлогоо танилцуулсан уу? Тендерийн зарыг олон улсын сэтгүүлүүдэд нийтлүүлсэн үү?	
5. Тендерийн баримт бичиг ямар ажил хийх шаардлагатай талаар маш тодорхой заасан байна уу?	
6. Тендерийн баримт бичигт ООТБ-т тогтмол тайлагнах, тайлангийн маягууд боловсруулах, эцсийн тайланг ойлгомжтой үг хэллэгээр бэлтгэж гаргах гэх мэт чухал шалгуурууд орсон уу?	
7. Тендерийн шаардлага хангасан оролцогчдод тендерийн баримт бичгийн ба ажлын цар хүрээний тодорхойлолтын хувийг илгээсэн үү?	
8. Тендерийн шаардлага хангасан оролцогчид тендерийн баримт бичигт тулгуурлан техникийн болон санхүүгийн саналаа бэлтгэж ирүүлсэн үү?	

9. Хороо оролцогчдод оноо өгөх, байр эзлүүлэх техникийн шалгуур үзүүлэлтүүдээ тендерийн саналыг үнэлэхээс өмнө тогтсон уу?	
10. Тендерт оролцогчдод зориулсан бага хурал зохион байгуулсан уу?	
11. ООТБ-ийн тендерийн хороо техникийн саналын дагуу богино жагсаалт гаргасны дараа санхүүгийн саналыг үнэлж, байр эзлүүлсэн үү?	
12. Богино жагсаалтад орсон оролцогчдод хэлэлцээр хийх урилга өгсөн үү?	
13. ООТБ ба аудиторын хооронд байгуулах гэрээнд хийх ажлын хүрээ, төлбөрийн хуваарь, нууцлалын үүрэг, маргаан шийдвэрлэх алхамуудыг зааж өгсөн үү?	
14. ООТБ авч ажиллуулсан аудитор буюу нэгтгэн тулгачдаа сэтгэл ханамжтай байна уу? ООТБ нь (а) тухайн мэргэжилтний талаар санал хураах , (б) сонголтод оролцох, (в) тухайн байгууллагын ажлын даалгаврыг боловсруулах зэрэг ажил гүйцэтгэсэн үү?	
XVI. Тухайн улсын Үйл ажиллагааны төлөвлөгөөг үнэлсэн үү?	
<i>ООТБ нь...</i>	
1. Тайланг хэзээ нийтэд ил болгохыг шийдсэн үү?	
2. ООТБ-ийн нууц мэдээллийг хэрхэн удирдахаа шийдсэн үү?	
3. Аудитор буюу нэгтгэн тулгачаас дараахи зүйлийг гаргаж өгөхийг шаардсан уу? Үүнд: (а) хамрагдах аж ахуйн нэгж, байгууллагуудын бөглөх тайлангийн маягтын загвар, (б) хамрагдах аж ахуйн нэгж, байгууллагуудын жагсаалтын төсөл, (в) сар бүрийн явцын тайлангууд, (г) хамрагдсан байгууллагууд хамтран ажиллаж байгаа эсэх тухай мэдэгдэл, (д) тулгарч буй саад бэрхшээлийг Засгийн газраас багасгаж, эсхүл үл ойшоож байгаа эсэх тухай мэдэгдэл.	
4. Дараахи зүйлийг гаргаж өгөхийг Засгийн газраас шаардсан уу? Үүнд: (а) тухайн салбарт оролцож байгаа бүх аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт, (б) холбогдох төрийн байгууллага бүрээс хариуцаж ажиллах хүмүүсийн холбоо барих хаяг, (в) улсын ба хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагууд аудиттай хамтран ажиллахыг төр засгаас үүрэг болгосон ямар нэг тушаал шийдвэр.	
5. Хэрэв асуудал шийдэгдээгүй бол зохих арга хэмжээ авахуулах талаар ИНБ-ууд Засгийн газарт шахалт үзүүлсэн үү?	
6. Засгийн газар хууль батлуулах, зохицуулалт гаргах, бичгээр гэрээ, эсхүл ойлголцлын санамж бичиг байгуулах замаар бүх компаниуд тайлагнах нөхцлийг бүрдүүлсэн үү?	
7. Засгийн газраас (а) тоо баримтыг стандартын дагуу бэлтгэхийг шаардах, (б) үндэсний нягтлан бодох бүртгэлийн стандартыг шинэчилж олон улсын стандарт нэвтрүүлэх, (в) тоо баримтаа олон улсын стандартуудад нийцүүлэхээр тохирсон гэрээг компаниудтай байгуулахад чиглэсэн хууль тогтоомж гаргасан уу?	



БҮЛЭГ 3

᠐ᠠᠶᠡᠭᠡᠨᠠᠶᠢᠨᠠᠳᠤ ᠵᠢᠨᠠᠳᠤ

3.1 ОУИТБС юу шаарддаг вэ?

Аудитор буюу нэгтгэн тулгагч ОУИТБС-ын тайлангаа бэлтгэж ООТБ-г гардуулснаар Тайлагнах үе шат эхэлдэг. Энэ шатанд аудиторүүд буюу нэгтгэн тулгагчид нь ООТБ-ээс тавьсан шаардлагын дагуу ажлаа гүйцэтгэж чадсан эсэхийг тодорхойлдог.

ОУИТБС-ын Тайлагнах үе шатанд дөрвөн шаардлага тавигддаг³²:

1. Компаниудаас төлж байгаа болон ОУИТБС-ын тайлан бэлтгэж байгаа байгууллагад гаргаж өгөх шаардлагатай газрын тос, байгалийн хий, уул уурхайн үйлдвэрлэлийн бүх төлбөрийг ил тод тайлагнасан байх ёстой.
2. Засгийн газарт хүлээн авч байгаа болон ОУИТБС-ын тайлан бэлтгэж байгаа байгууллагад гаргаж өгөх шаардлагатай газрын тос, байгалийн хий, уул уурхайн үйлдвэрлэлийн бүх төлбөрийг ил тод тайлагнасан байх ёстой.
3. Олон оролцогч талын бүлэг нь аудит, эсхүл нэгтгэн тулгалт хийлгэхээр ажиллуулж байгаа байгаа байгууллага нь үүргээ хангалттай биелүүлж байгаа эсэхэд сэтгэл ханамжтай байх ёстой.
4. ОУИТБС-ын тайланд зөрүүтэй байдлуудыг тогтоож, авах арга хэмжээний зөвлөмжүүд гаргах ёстой.

3.2 ОУИТБС-ын Тайланд юу агуулагдах ёстой вэ?

Оролцогч талуудын хувьд, ОУИТБС-ын тайланд эдгээр дөрвөн шаардлага тус бүр хэрхэн хангагдаж байгааг тайлбарлана гэсэн хүлээлттэй байх хэрэгтэй. Бүлэг 2-т дүрсэлсэнчлэн, ООТБ нь ОУИТБС-ын тайлан гаргах ажлын даалгавар боловсруулахдаа ямар компани, төрийн байгууллагууд тайлагнах ёстой, ямар төлбөр, орлогууд материаллаг байх, ОУИТБС-ын тайлан өөрөө ямар хэлбэртэй байх тухай асуултуудыг тодорхойлно. Оролцогч талууд ОУИТБС-ын тайланг уншихдаа дараахи зүйлийг ил тод тайлагнасан эсэхийг олж харах хэрэгтэй:

- Компаниуд төлсөн газрын тос, байгалийн хий, уул уурхайн бүх материаллаг төлбөрөө аудитор, эсхүл нэгтгэн туллагчид гаргаж өгсөн гэдгийг зааж өгөх ёстой:
 - Тайланд төлбөрүүдийн материаллаг түвшин ямар байсныг тодорхойлох ёстой бөгөөд энэ нь ООТБ-ээс ажлын төлөвлөгөөндөө заасантай адил байх ёстой.
 - Тайланд төлбөрүүдийг хэрхэн тодорхойлсноо зааж өгөх ёстой бөгөөд энэ нь ООТБ-ээс ажлын төлөвлөгөөндөө заасантай адил байх ёстой.
 - Тайланд түүнд хамрагдсан бүх компанийг танилцуулж, бүрэн дүүрэн хамтран ажиллаагүй компаниудын нэрсийг зарлах ёстой.
- Засгийн газар хүлээн авсан газрын тос, байгалийн хий, уул уурхайн бүх материаллаг орлогоо аудитор, эсхүл нэгтгэн туллагчид гаргаж өгсөн гэдгийг зааж өгөх ёстой:
 - Тайланд орлогуудын материаллаг түвшин ямар байсныг тодорхойлох ёстой бөгөөд энэ нь ООТБ-ээс ажлын төлөвлөгөөндөө заасантай адил байх ёстой.
 - Тайланд орлогуудыг хэрхэн тодорхойлсноо зааж өгөх ёстой бөгөөд энэ нь ООТБ-ээс ажлын төлөвлөгөөндөө заасантай адил байх ёстой.
 - Тайланд түүнд оролцсон бүх төрийн байгууллагыг танилцуулж, бүрэн дүүрэн хамтран ажиллаагүй байгууллагын нэрсийг зарлах ёстой.
- Тайланд сэтгэл ханамжтай байдлыг үнэлэхийн тулд нэгтгэн туллагч буюу аудитын мэргэжилтнүүд ажлаа хэрхэн хийсэн талаар танилцуулах ёстой.
 - Тэд санхүүгийн тайлангийн цаад гүйлгээнүүдийг шалгасан уу? (3.7 дугаар хэсэгт санал болгосончлон)
 - Тэд өмнө нь Засгийн газар болон компаниудад хийсэн аудитын тайлангуудад тулгуурласан уу? Хэрэв тийм бол, өмнөх тайлангууд аудитын олон улсын стандартад нийцсэн байсныг яаж тодорхойлсон бэ?
- Дагалдах тайлангууд нь олон улсын ямар стандартуудыг хангасан бэ?
 - Тайлангийн бүрэн дүүрэн, үнэн зөв байдлыг шалгахын тулд тайлагнагч компаниуд ба төрийн байгууллагуудад ямар шаардлага тавьсан бэ?
- Тайлангуудад тухайн тайлагнасан компанийн дээд удирдлагууд гарын үсэг зурсан байсан уу?

- Санхүүгийн тайлангууд нь бодитой, үнэн зөв гэдгийг тухайн компанийн аудиторуд өөрсдөө баталгаажуулсан уу?
- Аудиторууд нь бүх төлбөр, орлогуудыг бүрэн нэгтгэж чадсан эсэх, нарийвчлалын түвшин ямар байсныг тайланд тодорхой зааж өгөх ёстой.
 - Тайланд илэрсэн бүх зөрүүтэй байдлын дүнг тогтоож³³, тэдгээр нь материаллаг эсэхийг (ООТБ ажлын төлөвлөгөөндөө тодорхойлсон ёсоор) зарлах ёстой.
- Зөрүүтэй байдлыг арилгаж, тухайн улс ОУИТБС-ын баталгаажуулалтын шалгуурыг хангах чадварыг дээшлүүлэхийн тулд ямар нэг арга хэмжээ авбал зохино гэж үзэж байгаа эсэхээ тайланд дурдах хэрэгтэй.

ООТБ нь энэ бүх алхамуудад сэтгэл ханамжтай байгаа бол нэгтгэн тулгалт буюу аудит хийлгэхээр хөлсөлж авсан байгууллага нь хангалттай ажилласан гэдэгт сэтгэл хангалуун байгаа эсэх талаар шийдвэр гаргаж болох бөгөөд үүнийгээ болж өгвөл ООТБ-ийн санал хураалтаар шийдэх нь зүйтэй³⁴.

3.3 ОУИТБС-ын өнөөгийн практик

ОУИТБС-ыг хэрэгжүүлж байгаа орнуудад шинжээчдийн гаргаж өгсөн тайлан харилцан адилгүй байна. Нигери, Гана гэх мэт зарим оронд олон янзын зөрүүтэй байдлыг тайлагнажээ. Харин Азербайжан, Кыргыз гэх мэт бусад оронд зөрүүтэй байдал гарсан эсэх талаар тайлагнаагүй байна. Хүснэгт 3.1-д шинжээчдийн санаа зовоосон асуудал, тулгарсан бэрхшээл сорилтуудын талаар ОУИТБС-ын тайлангуудад бичиж, ООТБ-т тайлагнасан ишлэлүүдийг харуулж байна.

Хүснэгт 3.1: Хараат бус шинжээч нарт тохиолдсон зөрүүтэй байдлууд

Улс	Зөрүүтэй байдал	Шинжээч	Тайлангийн вэбсайт
Азербайжан	Ямар нэг материаллаг зөрүү байхгүй	Deloitte & Touche	2003 оны тайлан: www.eitransparency.org/ UserFiles/File/azerbaijanreports/ azerbaijanaccountreport2003.pdf
	Олборлох үйлдвэрлэлийн нэг компани ХОСБ байгуулаагүй учраас гэрээний биелэгдээгүй нөхцлийн нөхөн төлбөр 3,8 сая ам.доллараар зөрсөн Бусад татварт 264,3 тэрбум АЗМ-н зөрүү гарсан нь ОУ-н дотоод хоёр компани тайлагнахдаа алдаа гаргаснаас голлон шалтгаалжээ.	Deloitte & Touche	2004 оны тайлан: www.eitransparency.org/ UserFiles/ File/azerbaijanreports/ azerbaijanaccountreport2004a.pdf
	<i>Түүхий нефть:</i> <ul style="list-style-type: none"> ХОСБ байгуулаагүй Олборлох үйлдвэрлэлийн компанийн төлбөр <i>Байгалийн хий:</i> <ul style="list-style-type: none"> Олборлолтын нэг компаниас хүлээн авсан байгалийн хийн тоо хэмжээнд өөр хэмжилтийн нэгж ашигласан ХОСБ байгуулсан олборлолтын нэг компаниас Засгийн газарт шилжүүлсэн байгалийн хийг компанийн хуваарьт төлбөрт оруулаагүй ХОСБ байгуулаагүй олборлолтын нэг компаниас Засгийн газарт шилжүүлсэн байгалийн хийг компанийн хуваарьт төлбөрт оруулаагүй Засгийн газрын хуваарьт 6,430 мянган метр куб байгалийн хий орсон нь ХОСБ байгуулсан дотоодын нэг компанитай холбоотой байна <i>Транзитын хураамж</i> <ul style="list-style-type: none"> Арилжааны үйл ажиллагааны шугамаар төлбөр хийсэн нь ХОСБ-ийн нөхцлийн дагуу тайлагнах боломжгүй <i>Транзитын төлбөр</i> <ul style="list-style-type: none"> ХОСБ байгуулаагүй олборлолтын хоёр компанийн төлсөн транзитын төлбөр <i>Гэрээнд гарын үсэг зурсны болон бусад холбогдох бонусууд</i> <ul style="list-style-type: none"> ХОСБ байгуулаагүй олборлолтын нэг компанийн төлсөн дүн <i>Ашгийн татвар</i> <ul style="list-style-type: none"> Олборлолтын дотоодын нэг компани зөвхөн 2005 оны ашгийн татвараа тайлагнаад ХОСБ-т заасны дагуу 2005 онд төлсөн 2004 оны ашгийн татвараа тайлагнаагүй байна 	Deloitte & Touche	2005 оны тайлан: www.oilfund.az/download2/eiti_ report_31122005_en.pdf

Улс	Зөрүүтэй байдал	Шинжээч	Тайлангийн вэбсайт
	Зөрүүтэй байдал илэрсэн талаар тайлагнаагүй	Deloitte & Touche	www.oilfund.az/index_en.php?n=10012
Камерун	Ямар нэг материаллаг зөрүүтэй байдал тайлагнагдаагүй.	Hart Group & Mazars	www.eitransparency.org/UserFiles/File/cameroon/Cameroon_EITI%20Report_2005_Mar07.pdf
Габон	Ямар нэг материаллаг зөрүүтэй байдал тайлагнагдаагүй.	Ernst & Young	www.eitigabon.org/FRAN/PUBLICATIONS/rapport_2005/Rapport_EITI_Gabon_2005_version_definitive_050407.pdf
Гана	Дотоод орлогын албанаас Стүүл Лэндсийн захиргааны газарт шилжүүлэн зарцуулсан мөнгөн дүнгээс наян есөн сая дөчин мянган седис дутсан.	Boas & Associates	www.eitransparency.org/UserFiles/File/ghana/ghana_first_aggregated_report_to_June_2004.pdf
Гвиней	Ямар нэг материаллаг зөрүүтэй байдал тайлагнагдаагүй.	Richard Michel & Ismael Nabe	www.eitransparency.org/UserFiles/File/guinea/guineacommunique2005english.pdf
БН Кыргыз Улс	Зөрүүтэй байдлын талаар тайлагнаагүй	Кыргыз улс өөрсдөө аудит хийсэн	www.eitransparency.org/UserFiles/File/kyrgyz/kyrgyzgovreportenglish.pdf
Мавритани	Ямар нэг материаллаг зөрүүтэй байдал тайлагнагдаагүй.	Ernst & Young	www.cnitie.mr/documentspublic/RapportITIE.pdf
Нигери	Аудитлагдсан санхүүгийн тайланд болон Үл хөдлөх хөрөнгийн татварын тайланд заасан Тогтмол хөрөнгийн нэмэлтүүдийн хооронд мэдэгдэхүйц зөрүү гарсан Газрын тосны нөөцийн газраас тогтоосон нөөц ашигласны төлбөрийн үнэлгээ нь үйлдвэрлэгч компаниудын төлсөн бодит төлбөрөөс ихээхэн зөрсөн	Hart Group	

3.4 Зөрүүтэй байдлыг шийдвэрлэх нь

ОУИТБС-ын тайланд Засгийн газар ба компаниудын бүртгэл тооцооны хоорондох зөрүүтэй байдлыг харуулж болно. Яагаад ийм зөрүүнүүд гарав, тэдгээрийг яаж шийдвэрлэх вэ гэдгийг ойлгох нь чухал. Төрийн байгууллагууд болон хамрагдсан компаниуд хамтран ажиллахгүй, эсхүл тоо баримт нь өөр хоорондоо таарахгүй байгаа тохиолдолд томоохон асуудлууд үүсдэг.

3.5 Төрийн байгууллагууд хамтран ажиллахгүй бол яах вэ?

Орлого хүлээж авдаг бүх төрийн байгууллагын орлогыг тайлагнуулдаг байх үүргийг Засгийн газрууд хүлээдэг³⁵. Аудиторуудад нилээн их мэдээлэл гаргаж өгөх шаардлага төрийн байгууллагуудад тавигдаж болно. Төв банкнаас төлбөр хүлээн авсан баримтуудыг нь шаардаж болно. Зохицуулагч байгууллагуудаас нөөц ашигласны төлбөр ногдуулсан дүн ба бодитойгоор хүлээн авсан дүнг шаардаж болно. Татварын албадаас ногдуулсан ба төлсөн татварын тооцоог гаргуулж болно. Газрын тос, байгалийн хий, уул уурхайн үндэсний компаниудаас үйлдвэрлэж гаргасан бүтээгдэхүүнийхээ хэмжээг нотлохыг шаардаж, улмаар татвар, нөөц ашигласны төлбөрөө бүрэн төлсөн эсэхийг нь шалгаж болно. Сангийн яам нь хүлээн авсан болон зарцуулсан хөрөнгийнхөө дүнг тайлагнаж болно.

Засгийн газрууд хэд хэдэн шалтгаанаар хамтран ажиллаж чадахгүй байж болно:

- Бүртгэл тооцоо муутай, эсхүл огт байхгүй
- ОУИТБС-ын тухай ойлголт, мэдлэг дутагдалтай
- Төрийн бус байгууллагад тайлагнах соёл байхгүй
- Тоо баримт гаргаж өгөх чадвар хомс
- Бүртгэл тооцоог гараар хөтөлсөн
- Эсэргүүцэх

Иргэний нийгэм хэд хэдэн үүрэгтэй:

- Асуудлыг цаг тухайд нь мэдэх
- Асуудлын эх сурвалжийг ООТБ ойлгож байгаа эсэхийг магадлах
- Асуудлын шийдэх арга хэмжээ авах нөхцлийг бүрдүүлэх
- Шийдвэрлэвэл зохих бүтцийн асуудлууд байгаа эсэхийг тогтоох

Байнга тулгардаг нэг бэрхшээл бол бүртгэл тооцоо хөтлөлт муу байх явдал юм. Хэрэв өмнө нь огт аудит хийж байгаагүй бол холбогдох эрх бүхий байгууллагууд бүртгэл хөтөлдөггүй, бүртгэлээ муу хөтөлдөг, эсхүл тодорхой хугацааны дараа бүртгэлээ устгадаг байж болох юм.

Хэрэв бүртгэл муу хөтөлсөн, эсхүл үр нөлөөтэй бүртгэл хөтлөх систем дутагдалтай гэсэн тохиолдолд тэдгээрийг олон улсын стандартад хүргэж сайжруулахын тулд юу хийх шаардлагатай талаар зөвлөмж гаргаж өгөхийг иргэний нийгмийн зүгээс аудиторуудад хүсэлт болгох хэрэгтэй бөгөөд улмаар уг зөвлөмжийг шинэчлэлийн ажлын жагсаалтад нэмж оруулах хэрэгтэй.

Хэрэв аль нэг байгууллага цэвэр эсэргүүцэснээс асуудал үүсч байгаа бол ОУИТБС-ыг биелүүлэх хүсэл эрмэлзэл дутагдаж байгааг харуулах бөгөөд хамтран ажиллахыг эсэргүүцэж байгаа байгууллагад олон нийтийн дарамт шахалт үзүүлэхэд иргэний нийгмийнхэн чухал үүрэг гүйцэтгэж чадна. Хэрэв шаардлагатай бол олон нийтэд хандсан мэдэгдэл, хэвлэлийн бага хурал, үндэсний ба орон нутгийн сонины нийтлэл, радио нэвтрүүлэг гэх мэт аргуудаар үүнийг хийж болно. Мөн иргэний нийгмийн олон улсын байгууллагууд болон ОУИТБС-ын Удирдах зөвлөлд хандаж, тэд эргээд Засгийн газрын үйл ажиллагаанд гадныхны анхаарлыг хандуулж болно.

3.6 Компаниуд хамтран ажиллахгүй бол яах вэ?

ОУИТБС ёсоор бүх компани ОУИТБС-д хамрагдан төлбөрүүдээ тайлагнадаг болгох үүргийг Засгийн газар хүлээдэг³⁶. Аудитор, эсхүл нэгтгэн тулгагчийн хувьд компаниуд тайлангийн маягтуудаа бөглөж ирүүлсэн эсэх талаар тайлагнах ёстой.

Компаниуд энэ талаар хамтран ажиллах хүсэл зориг ихтэй байх ёстой. Засгийн газраас тавьсан шаардлагад хариулахгүй байх нь тухайн компанийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг хураахад хүргэж болох талтай. ОУИТБС-ын тухай хуультай улсуудад бол эрүүгийн хариуцлага хүлээлгэж ч болох юм³⁷.

Компаниуд төлбөрөө тайлагнахгүй байж болзошгүй хэд хэдэн шалтгаан байдаг. Үүнд:

- Мэдэгдэл авч чадаагүй байх
- Тайлагнах шаардлагагүй гэдэгт итгэх
- Маягтыг бөглөх чадавхи дутагдах
- Эсэргүүцэл үзүүлэх

3.7 Тоо баримтууд тохирохгүй үед

Санхүүгийн тоо баримтууд хоорондоо тохирохгүй үед зөрүүтэй байдал гардаг. Жишээлбэл, Азербайжанд тоог өөр өөрөөр тоймлосон, ХОСБ байгуулаагүй компаниудын төлбөр орсон, дутуу тайлагнасан зэргээс болж зөрүүтэй байдал гарсан байна³⁸. Нигерийн ОУИТБС-ын аудитын үеэр компаниуд Нигерийн Төв банкинд мөнгө төлснөө тайлагнасан боловч Төв банкинд хүлээн авсан баримт байхгүй байсныг аудиторуд тогтоосон байна³⁹. Үүний нэг адилаар, төв банк төлбөр хүлээн авснаа мэдэгдсэн боловч тухайн компаниудад төлсөн баримт байхгүй байсан байна⁴⁰. Азербайжанд, гүйлгээ хийсэн талуудын нэг нь ОУИТБС-тай хамтран ажиллаагүй учраас тодорхой гүйлгээнүүдийг нотолж чадаагүй болохоо аудиторуд тайлагнасан байна.

Зөрүүтэй байдал олж илрүүлсэн аудиторуд тоо баримт нь яагаад зөрж байгааг олж мэдэхийг тулд хоёр талтай хоёулантай нь хамтран ажиллах болно. Олон тохиолдолд аудиторуд оролцогч тал бүр (Засгийн газар ба компани хоёр хоёулаа) холбогдох гүйлгээгээ үнэн зөв бүртгэсэн эсэхийг шалгаж тогтоохыг хичээдэг. Нэг тал нь нөөц ашигласны төлбөрөө татвар төлөлтөд оруулж бүртгэсэн байх гэх мэт гэмгүй зөрүүтэй байдал гарч болно. Түүнчлэн цаана нь илүү том асуудал байгаа эсэхийг нягтлан шалгах шаардлагатайг харуулж “улаан туг”-аар тэмдэглэм зөрүүтэй байдал байж болно (тухайлбал, аль нэг тал нь Засгийн газарт төлсөн дүнгээ, эсхүл Засгийн газар хүлээн авсан дүнгээ бүртгэж аваагүй байж болно).

Шигтгээ 3.1: Зөрүүтэй байдлыг тогтоох нь

Нигерийн жишээнд, Нигерийн газрын тосны үндэсний компаниас Засгийн газарт төлөх ёстой 1,5 тэрбум найрагийн төлөгдөөгүй нэхэмжлэлийг аудиторуд илрүүлсэн байна.

Нигерийн жишээнд 365 зөрүүтэй байдал илэрсний 11-ээс бусдыг нь шийдвэрлэсэн байна. Төлбөрийг хэрхэн бүртгэсэн, хэн төлснөөр бүртгэгдсэн, ямар ангилалын төлбөрт бүртгэгдсэн (өөрөөр хэлбэл, заримдаа нөөц ашигласны төлбөрийг татвар гэж бүртгэсэн байв) зэрэгтэй нь холбоотой алдаа гарсан байв. Хүлээн авагч нь төлөгчөө үнэн зөв тодорхойлоогүйгээс олон зөрүү гарч байсан бол, компаниуд гүйлгээгээ мөнгөн суурьт биш, аккруэль суурьт бүртгэлээр бүртгэсний улмаас төлбөр тооцоо тохирохгүй байх явдал гарч байв.

Бүгдийг шалгаж дуусаад тохирохгүй үлдсэн гүйлгээ гарвал төлөгч байгууллагад хүсэлт тавьж гүйлгээгээ банкны системийн хэмжээгээр шалгаж үзэхийг хүсэх хэрэгтэй. Ингэж ул мөрийг нь шалгасны дараа тухайн төлбөр орж ирсэн дансны тухай тодорхой мэдээлэл гарах ёстой.

Аудиторууд аливаа шийдэгдээгүй зөрүүтэй байдлын талаар болон түүнийг шийдвэрлэхийн тулд юу хийсэн талаараа тайлагнах ёстой. Түүнчлэн цаашид иймэрхүү зөрүүтэй байдал гаргахгүйн тулд ямар өөрчлөлт хийх шаардлагатай талаар аудиторууд санал дүгнэлтээ гаргах ёстой.

3.8 Зөрүүтэй байдлыг хэн шийдвэрлэх ёстой вэ?

Ихэнх тохиолдолд, аудиторуудын тайлагнасан зөрүүг шийдвэрлэх нь зохицуулагч байгууллагуудын үүрэг байдаг. Аудиторууд, эсхүл нэгтгэн тулгагч нарын хувьд холбогдох талын тайлагнасан тоо баримт тухайн этгээдийн бүртгэл тооцоог үнэн зөв илэрхийлснийг нэгэнт шалгаж тогтоосон, зөрүүтэй байдлын шалтгааныг тодорхойлох талаар багагүй хүчин чармайлт гаргасан бол зөрүүг шийдвэрлэх нь тэдний үүрэг биш юм. Зарим тохиолдолд ООТБ-ийн зүгээс тогтоосон зөрүүтэй байдлыг нарийвчлан шалгахыг аудиторууд, эсхүл нэгтгэн тулгагчдаас хүсч болно. Ийм тохиолдолд аудитор, эсхүл нэгтгэн тулгагчийн гүйцэтгэх ажлын хүрээнд тухайн аудитор, эсхүл нэгтгэн тулгагч ямар үүрэг гүйцэтгэхийг нь тодорхой зааж хэрэгтэй, эсхүл ООТБ-ын хүсэлтээр гүнзгийрүүлэн судлах буюу ямар нэг үйл ажиллагаа хийх бол ажлын даалгаварт нь нэмэлт, өөрчлөлт оруулах ёстой.

3.9 Зөрүүтэй байдлыг шийдвэрлэхийн тулд тайлангийн хугацааг хойшлуулах ёстой юу?

Ямар нэг зөрүүтэй байдал гарахад Засгийн газрууд, компаниудын аль аль нь дургүй байдаг. Уг зөрүүнд гол анхаарал чиглэж, олон нийтийн зүгээс хүчтэй шүүмжлэл гарч болно. Гэхдээ ОУИТБС-ын тайланг цагт нь гаргах, зөрүүтэй байдлыг үргэлжүүлэн шалгах хоёрын аль нэгийг сонгох болдог.

Шигтгээ 3.2: Газрын тосны нөөц ашигласны төлбөрүүд-зөрүүтэй байдлыг шийдвэрлэх нь-ОУИТБС-ын жишээ

Нигерид хэрвээ тухайн үйл ажиллагаа эрхлэгч болон холбогдох агентлагын тоо баримтын хооронд ямар нэг шалтгаанаар зөрүү гарвал, тэдгээрийг ихэвчлэн хамтарсан тулгалтын аргаар шийдвэрлэдэг. Газрын тосны үйл ажиллагаа эрхлэгчийн тооцоолж гаргасан тоо болон Газрын тосны зохицуулалтын газрын хийсэн тооцоо ихэвчлэн таардаггүй. Ийм зөрүү нь дараахи шалтгааны улмаас гарч болох юм:

- Хэвлэлийн алдаа
- Үйлдвэрлэлийн өөр өөр тоо хэмжээ ашигласан
- API-н хүндийн хүчний өөр өөр үзүүлэлт ашигласан.

Нэгтгэн тулгалтын хороо нь тухайн үйл ажиллагаа эрхлэгчийн болон тус газрын дөрвөн хэлтсийн, тухайлбал Хяналт шалгалтын хэлтэс, Нөөцийн удирдлагын хэлтэс, Инженерчлэл, стандартын хэлтэс, Санхүү, бүртгэлийн хэлтсийн төлөөлөгчдөөс бүрддэг. Энэ нь нилээд хүч хөдөлмөр шаардсан ажил байдаг.

Хамгийн сайн туршлага бол тайлагнах эцсийн хугацааг маш хатуу баримтлах явдал юм. Эцсийн хугацааг хатуу баримтлах нь бүх талууд тайлангаа цагт нь ирүүлэхийг дэмжих, эсхүл хоцорч ирүүлсний үр дагаврыг хүлээлгэхэд хүргэдэг. Талууд ямар нэг маргааныг үргэлжлүүлэн шалгах хүсэлтэй боловч түүнийгээ хурдан түргэн хийдэггүйгээс тайланг удаан хугацаагаар хойшлуулж болох талтай. Аудиторууд аливаа зөрүүтэй байдлыг тайлагнах аудитаа хийж дуусгасны дараа тайлан гаргах асуудал үргэлж боломжтой байдаг.

Шигтгээ 3.3: Газрын тосны нөөц ашигласны төлбөрийн зөрүүтэй байдал-ОУИТБС-ын жишээ

ОУИТБС-ын нэгэн аудитын явцад татварын албанд хэд хэдэн бэрхшээл тулгарсан байна. Үүнд:

- Төрийн байгууллагуудын хоорондын мэдээлэл солилцоо муу байснаас дэлгэрэнгүй мэдээлэл авахад хэцүү байсан
- Хийгдсэн төлбөрүүдийн талаар Төв банктэй мэдээлэл солилцоход холболтын боломжийн хувьд саад бэрхшээл гарсан
- Татвар ногдуулалт болон татварын тооцоог шалгахад чухал ач холбогдолтой мэдээллийг өөр өөр байгууллага эзэмшиж байсан бөгөөд эдгээр байгууллага нь уг мэдээллийг татварын албанд гаргаж өгөх хууль ёсны үүрэг хүлээдэггүй байсан.

3.10 ОУИТБС-ын өнөөгийн практик

ОУИТБС-ын одоогийн тайлангуудын тухай судалгаанаас үзэхэд олон нийтэд мэдлэг боловсрол олгох ач холбогдлын хувьд харилцан адилгүй байна Жишээлбэл, Нигери, Гана улсуудын тайлан маш их мэдээлэл өгөхүйц болсон байна. Нигерийн ОУИТБС-ын тайлан гүйцэтгэлийн хураангуйтай, юуг, яаж шалгасан тухай мэдээлэл бүхий томоохон хавсралтуудтай, ямар шинэчлэл хийх шаардлагатай талаар дэлгэрэнгүй санал зөвлөмжүүдтэй байна. Гана Улсын тайланд санхүүгийн урсгалуудыг нарийвчлан харуулсан хүснэгтүүд оруулж, зөрүүтэй байдлууд ба засаглалын систем дэх сул талуудыг тогтоон, шинэчлэлийн зорилтот чиглэлүүдийг дэвшүүлсэн байна.

Бусад тайлангуудын хувьд мэдээлэл муутай хийгдсэн байна. Гвиней Улсын 2005 оны тайланд санхүүгийн урсгалууд, зөрүүтэй байдлууд, орон нутгийн иргэдэд очиж байгаа мөнгөн урсгал зэргийг харуулсан хүснэгтүүдтэй боловч засаглалын сул талын тухай мэдээлэл, ямар нэг санал зөвлөмж байхгүй байна. Кыргызийн тайланд санхүүгийн урсгалуудын хүснэгт орсон боловч хамрагдсан төрийн байгууллагууд, компаниудтай холбоотой ямар шийдвэр гарсан талаар олон нийтэд мэдээлэх дэлгэрэнгүй тайлбар, төр засгийн системүүдийн шударга байдалтай холбоотой ямар нэг дүгнэлт байсангүй. Азербайжаны тайлан хамгийн мэдээлэл багатайд орно. Тайлан үндсэндээ санхүүгийн нэгтгэсэн урсгалууд бүхий хүснэгттэй боловч юуг нэгтгэж тулгасан, эсхүл тайланг яаж бэлтгэсэн талаар ямар нэг тайлбар огт байхгүй байна. Энэ тайланд ямар нэг төрлийн санал зөвлөмж огт байсангүй.

3.11 Иргэний нийгмийн үүрэг

Иргэний нийгмийн бүлгүүд ОҮИТБС-ын аудитын тайлангаас зөрүүтэй байдлын тайлангуудыг олж харах хэрэгтэй. Тэд яагаад ийм байдал гарав, Засгийн газрын ба компаниудын бүртгэл тооцооны системүүд олон улсын стандартад хүрсэн эсэхийг асуух ёстой. Зарим тохиолдолд бүртгэл тооцоо нь үнэн зөв хийгддэггүй, ямар орлого хураан төвлөрүүлж байгааг зохицуулагч нар нь шалгадаггүй байдал илэрч болно.

Бүлэг 3: Тайлагнах үе шат		Тийм/Үгүй
XVII. ОУИТБС-ын тайланд төлбөр, орлого, зөрүүтэй байдлуудыг тогтоодог уу?		
<i>Тайланд...</i>		
1.	Төлбөрүүдийн материаллаг түвшин ямар байхыг тодорхойлсон уу? Энэ нь ажлын төлөвлөгөөнд заасантай адил байна уу?	
2.	Орлогуудын материаллаг түвшин ямар байхыг тодорхойлсон уу? Энэ нь ажлын төлөвлөгөөнд заасантай адил байна уу?	
3.	Төлбөрүүдийн тодорхойлолт ямар байхыг тодорхойлсон байна уу? Энэ нь ажлын төлөвлөгөөнд заасантай адил байна уу?	
4.	Орлогуудын тодорхойлолт ямар байхыг тодорхойлсон байна уу? Энэ нь ажлын төлөвлөгөөнд заасантай адил байна уу?	
5.	Оролцсон байгууллагууд болон бүрэн дүүрэн хамтран ажиллаагүй байгууллагуудыг заасан байна уу?	
6.	Оролцсон болон бүрэн дүүрэн хамтран ажиллаагүй компаниудыг заасан байна уу?	
7.	Аудиторууд буюу нэгтгэн тулгагчид тоо баримтын цаад гүйлгээнүүдийг шалгасан тухай дурдсан уу?	
8.	Аудиторууд буюу нэгтгэн тулгагчид өмнө нь Засгийн газарт, эсхүл компаниудад хийсэн аудитын тайлангуудад тулгуурласан эсэхээ мэдэгдсэн байна уу? Хэрэв тийм бол аудитын олон улсын стандарт (АОУС)-ыг хангасан эсэхийг хэрхэн тодорхойлсон бэ, цаана нь байгаа тайлангууд олон улсын ямар стандартуудыг хангасан бэ?	
9.	Компаниуд, төрийн байгууллагууд бүрэн дүүрэн, үнэн зөв тайлан гаргахад ямар шаардлагууд тавьсныг дурдсан байна уу?	
10.	Оролцсон бүх компаниуд болон бүрэн хамтран ажиллаагүй компаниудыг танилцуулсан байна уу?	
11.	Оролцсон бүх төрийн байгууллагууд болон бүрэн хамтран ажиллаагүй байгууллагуудыг танилцуулсан байна уу?	
12.	Компаниудын төлсөн болон тайлагнах шаардлагатай газрын тос, байгалийн хий, уул уурхайн бүх материаллаг төлбөрийг тайлагнасан байна уу?	
13.	Засгийн газрын хүлээн авсан болон тайлагнах шаардлагатай газрын тос, байгалийн хий, уул уурхайн бүх материаллаг төлбөрийг тайлагнасан байна уу?	
14.	Тэд бүх орлого, төлбөрийг бүрэн нэгтгэж чадсан эсэх, ямар нарийвчлалтай нэгтгэсэнэ дурдсан байна уу?	
15.	Илэрсэн бүх зөрүүтэй байдлын дүнг тогтоож, материаллаг эсэхийг нь тодорхойлсон байна уу?	
16.	Энгийн хэлээр бичсэн гүйцэтгэлийн хураангуй оруулсан байна уу?	
<i>Засгийн газар...</i>		
1.	Орлого хүлээн авдаг бүх төрийн байгууллагуудыг тайлагнуулах үүргээ ханган биелүүлсэн үү?	
2.	Бүх компаниудаар ОУИТБС-д хамаарах төлбөрүүдийг нь тайлагнуулах үүргээ ханган биелүүлсэн үү?	
<i>ИНБ-ууд...</i>		
1.	ОУИТБС-ын аудитын тайлангаас зөрүүтэй байдлын тайлангуудыг олж авсан уу?	
2.	ООТБ асуудлын эх сурвалжийг ойлгож байгаа эсэхийг шалгасан уу?	
3.	Асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авдаг байх нөхцлийг бүрдүүлсэн үү?	
4.	Шийдвэрлэвэл зохих бүтцийн асуудлууд байгаа эсэхийг тогтоосон уу?	

Аудиторууд буюу нэгтгэн тулгагчид...		Тийм/Үгүй
1.	Тоо баримтууд яагаад зөрүүтэй байгааг тогтоохын талд хоёр талтай хоёуланттай нь ажилласан уу?	
2.	Шийдэгдээгүй зөрүүтэй байдлын талаар болон түүнийг шийдвэрлэхийн тулд тэд юу хийснээ тайлагнасан уу?	
3.	Зөрүүтэй байдлыг багасгахын тулд ямар арга хэмжээ авбал зохих тухай санал бодлоо илэрхийлсэн үү?	
4.	Тухайн улс ОҮИТБС-ын баталгаажуулалтын шаардлагуудыг хангах чадвараа дээшлүүлэхийн тулд арга хэмжээ авах хэрэгтэй эсэх талаар санал бодлоо илэрхийлсэн үү?	
<i>ООТБ...</i>		
1.	Нэгтгэн тулгалт, эсхүл аудит хийхээр авч ажиллуулсан байгууллага хангалттай ажилласан эсэх талаар шийдвэр гаргасан уу?	
2.	Зөрүүтэй байдлыг хэн шийдвэрлэх ёстой талаар хэлэлцэж тогтсон уу?	
3.	Зөрүүтэй байдлыг бүрэн шийдвэрлэхийн тулд тайланг хойшлуулах шаардлагатай эсэх талаар хэлэлцэж тогтсон уу?	

БҮЛЭГ 4

᠐ᠵᠠᠭᠤᠢ ᠠᠶᠡᠭᠤᠳᠤᠵᠢᠶᠤᠰᠤ ᠵᠢᠶᠤᠰᠤᠨ ᠶᠤᠨ ᠶᠤᠨ

4.1 ОУТБС юу шаарддаг вэ?

ООТБ-ээс ОУИТБС-ын тайланг батлан хэвлүүлж тараахад бэлэн болсноор Түгээн дэлгэрүүлэлтийн үе шат эхэлдэг. ОУИТБС-ын Баталгаажуулалтын алхам 18-д ОУИТБС-ын тайланг нийтэд *хүртээмжтэй, дэлгэрэнгүй, ойлгомжтой байдлаар олны хүртээл болгохыг* шаарддаг. ОУИТБС-аас Хүснэгтийн Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгсэл 18-д үзүүлсэн жишээнд тайлангийн хувийг оролцогчдод цаасаар тараах, тайланг Интернэтэд тавих, олон нийтэд таниулах үйл ажиллагаа зохион байгуулах, тайланг зохих хэл дээр бэлтгэх, тодорхой, ойлгомжтой бичигдэх нөхцлөөр хангах тухай заажээ.

Хүснэгт 4.1-д үзүүлсэнчлэн одоогоор хэвлэгдээд байгаа тайлангууд эдгээр шалгуурыг бүгдийг биш ч, заримыг нь хангаж байна. Азербайжан⁴¹, Камерун⁴², Габон⁴³, Гвиней⁴⁴, Мавритани⁴⁵, Нигери⁴⁶, Гана⁴⁷ улсууд бүгд тайлангаа вэб дээр тавьсан байна. Нигери Улс тайлан гаргахаас өмнө, хойно нь сурталчилгааны аян явуулсан⁴⁸ боловч эдгээр тайлангийн ихэнх нь техникийн хэлээр бичигдсэн байв. Ашиг орлогын урсгалын ямар урсгалыг материаллагт тооцсоноо цөөхөн улс харуулж, цаад тоо бүртгэл нь олон улсын стандарт хангасан эсэх талаар аль нь ч дурдаагүй байна. Эдгээр сул талууд нь ИНБ-ууд ба ООТБ дэх ИНБ-ын төлөөлөгчид ОУИТБС-ын тайлангийнхаа хэлбэрт болон нэгэнт хэвлэгдээд гарчихсан тайлангуудаар юу хийх вэ гэдэгт ихээхэн анхаарах шаардлагатайг харуулж байна.

Хүснэгт 4.1: ОУИТБС-ын тайлангуудын түгээн дэлгэрүүлэлт

Улс	Дэлгэрэнгүй	Ойлгомжтой	Хүртээлтэй	Вэбсайт
Азербайжан (5-р тайлан)	Үгүй <ul style="list-style-type: none"> Тайлбар байхгүй Санал зөвлөмж байхгүй АОУС-н талаар бичээгүй Компанийн төлбөрүүд байхгүй 	Тийм <ul style="list-style-type: none"> Энгийн үг хэллэгтэй Тодорхой загвартай 	Тийм <ul style="list-style-type: none"> Онлайн Англи хэлээр Азербайжан хэлээр 	www.oilfund.az/index_en.php?n=10012
Камерун	Тийм <ul style="list-style-type: none"> Хүснэгтүүд, тайлбартай Санал зөвлөмжтэй Компаниудын төлбөр, Засгийн газрын хүлээн авалтуудтай Аргачлалтай 	Тийм <ul style="list-style-type: none"> Энгийн үг хэллэгтэй Тодорхой загвартай Нэр томъёоны тайлбартай Гүйцэтгэлийн хураангуйтай 	Тийм <ul style="list-style-type: none"> Онлайн Англи хэлээр Франц хэлээр 	www.eitransparency.org/UserFiles/File/cameroon/Cameroun_EITI%20Report_2005_Mar07.pdf
Габон	Тийм <ul style="list-style-type: none"> Хүснэгтүүд, тайлбартай Санал зөвлөмжтэй Салбарын танилцуулгатай Аргачлалтай 	Тийм <ul style="list-style-type: none"> Энгийн үг хэллэгтэй Тодорхой загвартай 	Ок <ul style="list-style-type: none"> Онлайн Франц хэлээр 	www.eitigabon.org/FRAN/PUBLICATIONS/rapport_2005/Rapport_EITI_Gabon_2005_version_definitive_050407.pdf
Гана	Тийм <ul style="list-style-type: none"> Хүснэгтүүд, тайлбартай Санал зөвлөмжтэй Салбарын танилцуулгатай Аргачлалтай 	Тийм <ul style="list-style-type: none"> Энгийн үг хэллэгтэй Тодорхой загвартай Гүйцэтгэлийн хураангуйтай 	Ок <ul style="list-style-type: none"> Онлайн Англи хэлээр 	www.eitransparency.org/UserFiles/File/ghana/ghana_first_aggregated_report_to_June_2004.pdf
Гвинея	Ок <ul style="list-style-type: none"> Хүснэгтүүдтэй Компаниудын төлбөр, Засгийн газрын хүлээн авалттай Хязгаарлагдмал тайлбартай Санал зөвлөмж ж байхгүй 	Тийм <ul style="list-style-type: none"> Энгийн үг хэллэгтэй Тодорхой загвартай 	Тийм <ul style="list-style-type: none"> Онлайн Англи хэлээр Франц хэлээр 	www.eitransparency.org/UserFiles/File/guinea/guineacommunique_2005english.pdf

Улс	Дэлгэрэнгүй	Ойлгомжтой	Хүртээлтэй	Вэбсайт
БН Кыргыз Улс	Үгүй <ul style="list-style-type: none"> Хүснэгтүүдтэй Хязгаарлагдмал тайлбартай Санал зөвлөмжгүй Компаниудын төлбөр байхгүй 	Тийм <ul style="list-style-type: none"> Энгийн үг хэллэгтэй Тодорхой загвартай 	Тийм <ul style="list-style-type: none"> Онлайн Орос хэлээр Англи хэлээр (албан бус орчуулга) 	www.eitransparency.org/UserFiles/File/kyrgyz/kyrgyzgovreportenglish.pdf
Мавритани	Тийм <ul style="list-style-type: none"> Хүснэгтүүд, тайлбартай Санал зөвлөмжтэй Салбарын танилцуулгатай Аргачлалтай 	Тийм <ul style="list-style-type: none"> Энгийн үг хэллэгтэй Тодорхой загвартай Нэр томъёоны тайлбартай 	Ок <ul style="list-style-type: none"> Онлайн Франц хэлээр 	www.cnitie.mr/documentspublic/RapportITIE.pdf
Нигери	Тийм <ul style="list-style-type: none"> Хүснэгтүүд, тайлбартай Санал зөвлөмжтэй Салбарын танилцуулгатай Аргачлалтай 	Тийм <ul style="list-style-type: none"> Техник үг хэллэгтэй Тодорхой загвартай Нэр томъёоны тайлбартай Гүйцэтгэлийн хураангуйтай 	Тийм <ul style="list-style-type: none"> Онлайн Англи хэлээр 	

4.2 Баталгаажуулалтын шалгууруудыг мөрдүүлэх

ИНБ-уудын (ООТБ дэх ИНБ-ын төлөөлөгчдийн) хийх ёстой эхний зүйл бол шалгуур хангагдсан эсэхийг үнэлэх явдал юм. Бүлэг 1 ба 2-т тэмдэглэсэнчлэн, ОУИТБС-ын тайлангийн гүйцэтгэлийн хураангуйг энгийн хэлээр бэлтгэх нөхцлийг хангах шилдэг арга бол аудиторын, эсхүл нэгтгэн тулгагчийн ажлын даалгаварт уг шаардлагыг оруулах, тайлангийн орчуулга, сурталчилгааны аян, гүйцэтгэлийн хураангуйн хэвлэмэл хувь зэргийн санхүүжилтийг төсөвт тусгасан байх явдал юм. Түүнчлэн ООТБ-ийн хувьд мэргэжлийн бичигч хөлсөлж, тайлангийн гүйцэтгэлийн хураангуйг мэргэжлийн бус хүн, эсхүл сонирхсон энгийн иргэн ойлгохуйц, хүртээмжтэй байдлаар бичүүлэх нь зүйтэй буюу шаардлагатай байж болно. Наад зах нь тайланг олон нийтэд танилцуулах хэрэгтэй. Боломжтой бол аудиторууд буюу нэгтгэн тулгагчдийг байлцуулсан танилцуулгыг тухайн улсын олон газруудад зохион байгуулж, иргэний нийгмийн бүлгүүд, хэвлэл мэдээллийн хэрэгсэлүүд ил тод байдалтай холбоотой олж мэдсэн зүйлсийг асуулт асууж илүү сайн ойлгох боломж олгох хэрэгтэй. Эдгээр олон нийтийн мэдээллийн ажлыг явуулах үүргийг аудиторууд буюу бусад шинжээчдийн ажлын даалгаварт оруулж өгөх ёстой.

4.3 Тайлангуудын ашиглалт

ОҮИТБС-ын тайлантай холбогдуулж иргэний нийгмийн хийх ёстой хамгийн чухал гурван зүйл бол:

- Үр дүнг ойлгох
- Үр дүнг мэдээлэх
- Шинэчлэлийн үнэлгээ хийх

4.4 Үр дүнг ойлгох

Аудиторууд тайлангаа энгийн, техникийн бус хэлээр бичихийг хичээсэн ч гэсэн аудитын тайлангуудыг ойлгоход хэцүү байж болно. ИНБ-уудын асуух ёстой дөрвөн төрлийн асуулт байдаг:

- Аудиторууд мөнгөний урсгалыг ОҮИТБС-ын стандартуудыг хангахуйц байдлаар нэгтгэж чадсан уу?
- Засаглалын асуудлуудыг илрүүлсэн үү?
- Компанийн зан үйлийн тухай асуудлуудыг илрүүлсэн үү?
- Аудиторууд ямар шинэчлэлүүд санал болгосон бэ?

4.5 Аудиторууд орлогын бүх урсгалыг шалгаж чадсан уу? Үгүй бол аль урсгалуудыг тайлагнаагүй вэ, яагаад?

Нэгтгэн тулгалтаас гарах ёстой хамгийн үндсэн төрлийн мэдээлэл бол нөөц баялгийн олборлолтоос засгийн газар хэр их мөнгө олсон бэ гэдэг асуудал юм. Тайлан танд дараахь зүйлийг хэлж өгөх ёстой:

- Засгийн газар нийт хэдий хэр орлого олсон бэ
- татвар, нөөц ашигласны төлбөр болон бусад зүйлсээс хэр их орлого олсон бэ
- компаниудын төлсөн төлбөр Засгийн газарт орсон орлоготой тохирсон уу
- бүх материаллаг урсгалыг нэгтгэсэн үү
- газрын тосыг хэрхэн бэлэн мөнгөнд хөрвүүлсэн бэ, Засгийн газар ямар үнээр өгсөн бэ (хэрэв Засгийн газарт газрын тосоор төлсөн бол)
- Засгийн газрын хүлээн авсан үнэ зах зээлийн үнэ байсан уу, эсхүл тоо хэмжээний хувьд шалгаж болохуйц бодитой үнэ байсан уу (гэвч ОҮИТБС-д үүнийг шаарддаггүй)
- ямар нэг зөрүүтэй байдал байсан эсэх
- тухайн тайлан ООТБ-ээс зөвшөөрсөн стандартыг хангасан эсэх

4.6 Одоогийн зарим жишээнүүд

Нэгдсэн тайлан. Олборлох үйлдвэрлэлээс 2006 оны 1-6 дугаар сард хүлээж авсан нэгдсэн орлогын талаар Бүгд Найрамдах Азербайжан Улсын Засгийн газрын (хүлээн авагч Засгийн газар) гаргасан тайланг Хүснэгт 4.2-т үзүүлэв⁴⁹.

Хүснэгт 4.2: Азербайжаны нэгдсэн тайлан (Тайлангийн хугацаа: 2006 оны 1-6 сар)*

	Үнийн дүн		Тоо хэмжээ	
	Сая Америк \$	Сая АЗН Манат	Газрын тос	Хий (байгалийн болон бусад)
1	2	3	4	5
1. Хүлээн авагч Засгийн газрын гадаадын компаниудаас авсан орлого Хүлээн авагч Засгийн газруудаас гадаадын компанид олгосон үйлдвэрлэлийн эрх (түүний дотор хүлээн авагч орны улсын үйлдвэрийн газраар дамжуулсан шууд бусаар олгосон эрх)			8,799	
1.1 Газрын тосны үйлдвэрлэлийн урсгал - бэлэн бусаар (сая баррель) - бэлнээр				
1.2 Хий үйлдвэрлэлийн урсгал - бэлэн бусаар (мянган метр куб) - бэлнээр				1,408,371.0
1.3 Үндсэн металлын үйлдвэрлэлийн урсгал - бэлэн бусаар (мянган тонн) - бэлнээр				
1.4 Үнэт металлын үйлдвэрлэлийн урсгал - бэлэн бусаар (мянган унци) - бэлнээр				
2. Хүлээн авагч Засгийн газрын дотоодын компаниудаас авсан орлого Хүлээн авагч Засгийн газруудаас дотоодын компанид олгосон үйлдвэрлэлийн эрх				
2.1 Газрын тосны үйлдвэрлэлийн урсгал - бэлэн бусаар (сая баррель) - бэлнээр				
2.2 Хий үйлдвэрлэлийн урсгал - бэлэн бусаар (мянган метр куб) - бэлнээр				3,460.0
2.3 Үндсэн металлын үйлдвэрлэлийн урсгал - бэлэн бусаар (мянган тонн) - бэлнээр				
2.4 Үнэт металлын үйлдвэрлэлийн урсгал - бэлэн бусаар (мянган унци) - бэлнээр				

	Үнийн дүн		Тоо хэмжээ	
	Сая Америк \$	Сая АЗН Манат	Газрын тос	Хий (байгалийн болон бусад)
1	2	3	4	5
3. Хүлээн авагч Засгийн газрын гадаадын компаниудаас авсан (түүний дотор, төрийн өмчийн компаниар дамжуулж авсан) бусад орлого				
3.1 Нөөц ашигласны төлбөр				
- бэлэн бусаар				
- бэлнээр				
3.2 Ашгийн татвар		213,005		
3.3 Бусад татвар (ажиллагсдын орлогын татвар, нийгмийн татвар, суутгал татварыг оруулахгүйгээр)				
3.4 Ногдол ашиг				
3.5 Гарын үсгийн болон бусад бонус	1,000			
3.6 Лицензийн төлбөр, орох хураамж, лицензтэй холбоотой бусад төлбөр				
3.7 Бусад хүлээн авсан нийт дүн, үүнээс:	1,286			
- талбайн хураамж	7,932			
- транзитын хураамж				
4. Хүлээн авагч Засгийн газрын дотоодын компаниудаас авсан бусад орлого				
4.1 Нөөц ашигласны төлбөр				
- бэлэн бусаар		42,907		
- бэлнээр				
4.2 Ашгийн татвар		11,608		
		136,095		
4.3 Бусад татвар (ажиллагсдын орлогын татвар, нийгмийн татвар, суутгал татварыг оруулахгүйгээр)				
4.4 Ногдол ашиг				
4.5 Гарын үсгийн болон бусад бонус				
4.6 Лицензийн төлбөр, орох хураамж, лицензтэй холбоотой бусад төлбөр				
Нийт дүн	10,218	403,615	8,779	1,411,831.0

* Олборлох үйлдвэрлэлээс хүлээж авсан нэгдсэн орлогын талаар Бүгд Найрамдах Азербайжан Улсын Засгийн газрын (хүлээн авагч засгийн газар) гаргасан тайлан. Тайлант хугацаа: 2006 оны 1-6 дугаар сар, www.oilfund.azlindex_en.php?n10012

Хүснэгт 4.3 Нигерийн нэгдсэн тайлан

Компаниудын төлснөөр

Сая ам.доллараар	1999	2000	2001	2002	2003	2004
Шелл Петролиум Девелопмент Компани	225	444	437	346	565	845
Мобил Продюсинг Найжериа Лимитед	257	418	405	309	460	627
Чеврон Найжериа Лимитед	172	308	299	217	266	323
Нигерийн Чеврон Ойл Компани	9	18	14	11	8	15
Тексако Оверсийс	9	18	14	12	8	9
Элф Петролиум	110	252	255	201	280	561
Нигерийн Агип Ойл Компани	61	124	141	118	134	241
Пан Оушиан	2	7	10	8	11	20
Аддах Петролиум	6	36	34	0	1	0
Амни	4	5	0	2	0	2
Атлас	6	11	9	13	6	1
Дюбри	0	0	0	0	0	0
Консолидате Ойл Продюсинг Лимитед (Конкойл)	3	9	6	3	5	2
Континентал	2	28	59	33	45	25
Экспресс Петролиум	0	1	1	0	0	0
Нигерийн Петролиум Девелопмент Компани	0	0	10	6	3	0
Филипс Ойл Компани	22	61	60	55	73	103
Кавендиш	0	0	0	0	0	0
Мони Пүло Петролиум Девелопмент Компани	0	40	33	34	40	39
Нийт дүн	888	1,781	1,787	1,368	1,905	2,813

Нигерийн төв банк (НТБ)-ны бүртгэлээр

Сая ам.доллараар	1999	2000	2001	2002	2003	2004
Шелл Петролиум Девелопмент Компани	218	474	462	346	523	845
Мобил Продюсинг Найжериа Лимитед	319	453	404	285	460	627
Чеврон Найжериа Лимитед	172	337	275	201	266	323
Нигерийн Чеврон Ойл Компани	2	27	0	6	8	15
Тексако Оверсийс	16	27	26	6	10	9
Элф Петролиум	103	239	256	185	280	561
Нигерийн Агип Ойл Компани	59	129	144	104	155	241
Пан Оушиан	2	6	14	7	9	18
Аддах Петролиум	6	33	32	0	1	0
Амни	4	6	0	2	0	2
Атлас	6	10	9	12	6	1
Дюбри	0	0	1	0	0	0
Консолидате Ойл Продюсинг Лимитед (Конкойл)	5	16	15	12	36	25
Континентал	2	28	24	24	11	16
Экспресс Петролиум	0	1	1	0	0	0
Нигерийн Петролиум Девелопмент Компани	0	0	0	0	0	0
Филипс Ойл Компани	25	61	61	59	55	83
Кавендиш	0	0	0	0	0	0
Мони Пуло Петролиум Девелопмент Компани	0	24	37	26	12	21
Нийт дүн	939	1,871	1,761	1,275	1,832	2,787
Зөрүү (компаниуд ба НТБ)	-51	-90	26	93	73	26

Төлбөрийн төрлөөр задалсан байдал. Санхүүгийн урсгалуудыг тодорхойлсон ангилалын дагуу 1999-2004 онд Холбооны засгийн газарт тогтоосон компаниудаас хүлээж авсан санхүүгийн урсгалууд.**

Компаниудын төлсөн гэж тайлагнаснаар

Сая ам.доллараар	1999	2000	2001	2002	2003	2004
Газрын тосны ашгийн татвар	758	3,230	3,615	1,829	3,225	6,275
Нөөц ашигласны төлбөр	888	1,781	1,787	1,368	1,905	2,813
Хий шатаасны торгууль	24	24	28	20	23	21
Нөөцийн нэмэлт бонусын нөхөн төлбөр	61	-	-	-	-	274
Лиценз олгосны гарын үсгийн бонус	25	-	137	37	235	53
Нийт дүн	1,756	5,035	5,567	3,254	5,388	9,436

НТБ-ны бүртгэлээр

Сая ам.доллараар	1999	2000	2001	2002	2003	2004
Газрын тосны ашгийн татвар	659	3,286	3,549	1,698	3,287	6,557
Нөөц ашигласны төлбөр	939	1,871	1,761	1,275	1,832	2,787
Хий шатаасны торгууль	22	22	25	20	38	28
Нөөцийн нэмэлт бонусын нөхөн төлбөр	61	-	-	-	-	-***
Лиценз олгосны гарын үсгийн бонус	25	-	137	37	235	53
Нийт дүн	1,706	5,179	5,472	3,030	5,392	9,425

* НОУИТБС-ын Санхүүгийн аудитын тайлан 1999-2004-н 19 дүгээр хуудсанд нөөц ашигласны төлбөр ба бусад орлогуудыг компаниар задалж харуулсныг Хүснэгт 4.3-т үзүүлэв. Нөөц ашигласны төлбөр бол НОУИТБС-ын Аудитын тайланд компаниар задалж харуулсан орлогын урсгалуудын зөвхөн нэг нь юм.

** НОУИТБС-ын Санхүүгийн Аудит 1999-2004, хуудас 12.

*** Үүнийг НТБ газрын тосны ашгийн татварт оруулсан байна.

4.7 Засаглалын ямар асуудлуудыг илрүүлсэн бэ?

Тайланг бэлтгэх явцад Засгийн газраас уг салбарыг удирдах арга барилаа сайжруулахыг сануулсан ямар нэг асуудал тулгарсан эсэхийг уг тайланд тайлбарлах ёстой. ОУИТБС-ын тайлан бэлтгэж байгаа хүмүүсээс дараахи зүйлсийг асуух хэрэгтэй:

- Сайн мэдээлэл олж авахад ямар нэг хүндрэл бэрхшээл тулгарсан эсэх
- Бүртгэл тооцоо нь бүрэн дүүрэн байсан эсэх
- Бүртгэл тооцоог компьютержүүлсэн эсэх
- Тэдний нэгтгэсэн тоо баримтууд өөрөө үнэн зөв эсэхийг шалгаж цаад гүйлгээнүүдийг нь шалгаж үзсэн эсэх.

Аудиторууд буюу нэгтгэн тулгагчдийн тогтоосон асуудлуудад дараахи зүйлс орж болох юм:

- Төв банк, эсхүл татварын газрууд бүртгэл муу хөтөлдөг
- Татварын албанаас хийдэг татвар төлөлтийн шалгалт учир дутагдалтай
- Зохицуулагч байгууллагаас хийдэг нөөц ашигласны төлбөрийн шалгалт учир дутагдалтай
- Үйлдвэрлэсэн газрын тос, байгалийн хий, ашигт малтмалын тоо хэмжээ, төлсөн татвар, нөөц ашигласны төлбөрийн хоорондын тулган шалгалт дутагдалтай
- Бүртгэлт хөтөлтийн автоматжуулалт дутагдалтай
- Татвар, нөөц ашигласны төлбөрийн өрийг тооцох, бусад асуудлуудыг шийдвэрлэх бодлогын хувьд зөрөлддөг

Гана Улсын жишээ

Гана Улсын тайланд⁵⁰ уул уурхайн төлбөрүүдийг хураах үүрэгтэй байгууллагууд (ө.х, татварын ба зохицуулалтын байгууллагууд) хамтран ажилладаггүй, уул уурхайн компаниудын мэдүүлсэн алтны зэрэглэлийг шалгах албан ёсны систем байдаггүй, ашигт малтмалын нөөц ашигласны

төлбөрийн орлогыг авах ямар нэг зохицуулалт, заавар байдаггүй, бүсийн газар нутгийн захирагчдад нөөц ашигласны төлбөрийг хуваарилан зарцуулсан тухай олигтой бүртгэл тооцоо байдаггүй зэрэг асуудлыг илрүүлсэн байна.

Нигерийн жишээ

Нигерийн аудитын үеэр ерөнхий аудитор нь дансны бүртгэл тооцоог үнэн зөв хөтлөөгүй, компаниуд газрын тосны ашигийн татвар, нөөц ашигласны төлбөр тооцохдоо маш олон янзын арга хэрэглэснийг аудиторрууд шалгаж тогтоосон байна⁵¹.

Азербайжаны жишээ

Азербайжанд тоог өөр өөрөөр тоймлосон, ХОСБ байгуулаагүй компаниудын төлбөр орсон, дутуу тайлагнасан зэргээс болж Засгийн газарт орж буй мөнгөний урсгал зөрүү гарсан байна⁵².

4.8 Компаний зан үйлтэй холбоотой ямар асуудлууд илэрсэн бэ?

Аудиторууд компаниудтай хамтран ажиллахад ямар нэг хүндрэл бэрхшээл тулгарсан эсэхийг асуух ёстой. Үүнд:

- Бүх компани маягтаа бүрэн дүүрэн, үнэн зөв бөглөж ирүүлсэн үү?
- Ямар компаниуд хамтран ажиллаагүй вэ?
- Хамтран ажиллахгүй байгаа компаниудад ямар арга хэмжээ авсан бэ?
- Засгийн газарт төлсөн төлбөрүүдийнх нь тайлан компаниудын өмнө нь тайлагнаж байсантай (хэрэв өмнө нь ямар нэг тайлан гарсан бол) тохирч байна уу?

Мавританий ОУИТБС-ын тайланд уул уурхайн 13, газрын тосны 7 компани маягтыг бөглөж хариу ирүүлээгүй талаар дурджээ⁵³.

4.9 Хараат бус шинжээчид ямар шинэчлэл хийхийг зөвлөмж болгосон бэ?

ОУИТБС-ын Батиалгаажуулалтын зааварт⁵⁴ аудиторууд буюу тулгагч нар нь сайжруулалтын санал зөвлөмж гаргахыг шаарддаг. Иргэний нийгмийнхэн шууд, эсхүл ООТБ-т байгаа төлөөлөгчөөрөө дамжуулж энэ үүргээ биелүүлж байгаа эсэхийг нь шалгах асуултууд тавих хэрэгтэй. Шинжээчид төрийн байгууллагууд ба компаниуд хэрхэн бүртгэл хөтөлдөг, мөн олон тохиолдолд тухайн салбарын үйл ажиллагаа хэрхэн зохицуулагддаг талаар их хэмжээний мэдээлэл авах боломжтой байх болно. Зөвхөн тэдний гаргаж өгсөн сайжруулалтын зөвлөмжөөр дамжуулж иргэний нийгмийнхэн уг салбарын ерөнхий засаглалыг хэрхэн сайжруулах талаар төсөөлөлтэй болох болно.

Аудиторууд буюу нэгтгэн тулгагчдаас дараахи асуултыг асуух хэрэгтэй:

- Засгийн газрын төлбөр тооцоог бүртгэх систем олон улсын стандартыг хангаж байна уу, үгүй бол ямар өөрчлөлтүүд хийх хэрэгтэй вэ?
- Засгийн газар татвар, нөөц ашигласны төлбөрүүдэд олон улсын тэргүүн туршлагад нийцэхүйц байдлаар хяналт шалгалт буюу аудит хийдэг үү?

- Засгийн газрын санхүүгийн тайлангуудад (хэдийгээр ООТБ өөр стандарт хэрэглэхийг зөршөөрсөн ч гэсэн) аудитын олон улсын стандартуудын дагуу аудит хийсэн үү?
- Компаниудын санхүүгийн тайлангаас авсан тоо баримтад (хэдийгээр ООТБ өөр стандарт хэрэглэхийг зөршөөрсөн ч гэсэн) аудитын олон улсын стандартуудын дагуу аудит хийсэн үү?
- Төрийн байгууллага ба компаниудын төлбөр төлөх үүргийг зохицуулдаг хууль тогтоомж, зохицуулалтууд нь тодорхой бөгөөд үр дүнтэй юу?

4.10 Үр дүнг мэдээлэх

Юу чухал ач холбогдолтойг шийдэх. ОУИТБС-ын аль талыг мэдээлэх нь чухал вэ гэдэг талаар иргэний нийгмийн бүлгүүд өөрийн гэсэн дүгнэлт хийх хэрэгтэй: Засгийн газар хэр их мөнгө зарцуулах, уг мөнгөөр юу хийсэн нь чухал уу? Засгийн газраас муж, орон нутгуудад илгээсэн мөнгөний эзлэх хувь чухал уу? Засгийн газрын системүүдийн сул талууд, тэдгээрийг сайжруулах шаардлага чухал уу? Эсхүл зарим компани ОУИТБС-д оролцохоос татгалзаж байгаа нь чухал уу?

Тайланг түгээн дэлгэрүүлэхэд туслах. Тухайн улсын ОУИТБС-ын Нарийн бичгийн газар, олон оролцогч талын бүлэгт хандаж тайланг өөр хаана, хэрхэн тарааж танилцуулвал зохих талаар иргэний нийгмийн бүлгүүд саналаа гаргах хэрэгтэй. Тухайлбал эвлэл холбоодын тэргүүнүүд, бизнесийн зүтгэлтнүүд, их дээд сургуулиуд, нутгийн иргэдэд (түүний дотор, хамгийн гол нь үйлдвэрлэл явагдаж байгаа нутгийн иргэдэд) тарааж болох бөгөөд дор бүрт нь ОУИТБС-ын тайлангийн тухай тайлбар өгөх шаардлагатай байж болно. Иргэний нийгмийн бүлгүүд товч мэдээлэл өгөх ажиллагааг өөрсдөө явуулахын зэрэгцээ ийм ажиллагаа явуулахыг ООТБ-ээс шаардах хэрэгтэй. Түүнчлэн, иргэний нийгмийн бүлгүүд нь:

- Үндэсний болон орон нутгийн сонинуудад булан гаргаж нийтлэл бичих;
- ОУИТБС-ын туршлага, тайлангуудын талаар радио ярицлага хийх;
- Үр дүнг тайлбарлах сургалт семинаруудыг удирдан явуулах;
- Хэвлэл мэдээллийн байгууллагууд ОУИТБ-ын үр дүнгийн талаар мэдээ материал тавьж, нийтлэл бичихийг дэмжих;
- Олон улсын нөлөөллийн бүлгүүдэд хандаж уг тайланг дотоодын хэлүүдээр орчуулж, үр дүнгүүдийг түгээн дэлгэрүүлэхэд туслахыг хүсэх

4.11 Дагалдах шинэчлэлийн ажлууд

ОУИТБС-ын анхны тайлан нэгэнт хэвлэгдсэн бол иргэний нийгмийн гишүүд уг мэдээллийг тодорхой үр дүнгүүд болгон хөрвүүлэх хэрэгтэй болно. ОУИТБС бол төр засгийг хариуцлагатай байлгахад шаардагдах мэдээллээр иргэдийг хангаж тэдэнд эрх мэдэл олгох хэрэгсэл юм. Дагалдах ажлын зарим гол алхмуудыг дурдвал:

- дараа дараагийн аудитын үндсийг тавих
- тайлагнах давтамжийг нэмэгдүүлэх
- шинэчлэлийн асуудал боловсруулах
- ил тод байдлын үйл явцыг гүнзгийрүүлэх

Дараа дараагийн аудитын үндсийг тавих. Олон оронд ОУИТБС-ыг хэрэгжүүлэх үүрэг амлалтыг ил тод байдлыг дэмждэг Ерөнхийлөгч, эсхүл Ерөнхий сайд авдаг. Гэхдээ ОУИТБС-ын тогтвортой байдлыг хангахын тулд аливаа улсын хууль тогтоомжийн нэг хэсэг болгох хэрэгтэй. ОУИТБС-ын аудитыг жил бүр хийхийг шаардсан ямар нэг хууль тогтоомж гаргуулж, төрийн өмчийн компаниуд ба хувийн хэвшлийн бүх компаниуд тухайн улсын ОУИТБС-ын хуулиудын дагуу тайлагнах үүрэг хүлээлгэхийн төлөө иргэний нийгмийн гишүүд ажиллах ёстой. Нигери гэх мэт зарим оронд хууль тогтоох байгууллагын гишүүд ООТБ-т орж ажилладаг бөгөөд ОУИТБС-ын хууль гаргахад нөлөөлж, дэмжлэг үзүүлж болдог.

Түүнчлэн иргэний нийгмийн гишүүд дараахи шаардлагыг нэмж оруулахыг хүсч болно:

- Олон талт бүлгийн бүрэлдэхүүнд төрөл бүрийн шаардлагууд тавих,
- ОУИТБС-ын Нарийн бичгийн газар, ОУИТБС-ын аудитад зориулсан бие даасан санхүүжилт болон мэдээлэл харилцааны ажил хүчтэй явуулах санхүүжилтээр хангах,
- ОУИТБС-ын аудитын шаардлагыг биелүүлэхгүй байгаа этгээдүүдэд хэрэглэх шийтгэлийн хүрээг бий болгох
- Тайлагнах үүрэг буюу шаардагдах тайлангийн хэлбэрийн талаар бусад заавар гаргах, түүний дотор нэгтгэсэн, эсхүл задалсан байдлаар тайлагнах арга хэрэглэх эсэхийг зааж өгөх.

Тайлагнах давтамжийг нэмэгдүүлэх. ОУИТБС-д жил бүр тайлагнахыг шаарддаг боловч танай улсын зохицуулах эрх бүхий байгууллагууд татвар, нөөц ашигласны төлбөр, бусад санхүүжилтийг илүү олон удаа тайлагнахыг шаардаж болно. Түүнчлэн, газрын тос, байгалийн хийн үйлдвэрлэл, ашигт малтмалын олборлолтын тайлангуудыг сар бүр, эсхүл улирал бүр гаргаж болох бөгөөд ингэж тайлагнуулах хэрэгтэй. Энэ мэдээллийг аудитлах, эсхүл нэгтгэн тулгах хүртэл нийтлэхгүй байх сонголтыг ООТБ хийж болохын зэрэгцээ энэ нь аудиторуд ба нэгтгэн тулгагчдийн ажилд тустай байх, улмаар төлбөрийн мэдээллийг тогтмол цуглуулж, шалгах үүрэгтэй зохицуулах эрх бүхий байгууллагуудын сонор сэрэмжийг ч дээшлүүлэх болно. Жишээлбэл, Нигери Улс *Эдийн засгийн байдлын тайлан*-г улирал тутамд гаргадаг⁵⁵. Мөн мэдээллийг цаг алдалгүй (тухайлбал, холбогдох тайлант үе дууссанаас хойш хэдхэн долоо хоногийн дотор) нийтэлдэг тохиолдолд ОУИТБС-ын үйл явцад итгэх итгэл дээшилж болно. Өөрсдийнх тоо баримт нийтлэгдэнэ гэдгийг мэдэж байгаа этгээдүүд ч уг мэдээллээ зөв байлгахад онцгой анхаарал тавих талтай.

Шинэчлэлийн асуудал боловсруулах. ОУИТБС-ын аудит хийгдэж дууссаны дараа аудиторуд зөрүүтэй байдлыг тайлагнаж, авах шаардлагатай арга хэмжээний талаар санал зөвлөмж гаргах үүрэгтэй. Эдгээр дүгнэлт нь иргэний нийгмээс танай орны гүйцэтгэх ба хууль тогтоох засаглал, зарим тохиолдолд шүүх засаглалд зориулсан шинэчлэлийн хөтөлбөр боловсруулан гаргах эхлэлийн цэг болох ёстой. Улс орнууд ОУИТБС-ыг хэрэгжүүлэх Үндсэн хүрээнээс Нэмэлт хүрээнд шилжих шаардлагыг бид энэхүү гарын авлагын III хэсэгт авч үзэхийн зэрэгцээ ОУИТБС-ын аливаа тайланд тулгуурлан шинэчлэлийг урагшлуулах арга зам болгож дараахи үйл ажиллагааг санал болгож байна.

Шигтгээ 4.1: Шинэчлэлийн зөвлөмжүүд: Байгууллагын чадавхи

“Газрын тосны зохицуулах газрын байгууллагын чадавхийг бэхжүүлэх шаардлагыг өмнөх тайлангуудад хэдэн жилийн турш санал болгосон. Нөхцөл байдал ерөнхийдөө сул хэвээр, мэдээллийн бэлэн байдал муу, компьютерийн систем дутагдалтай байна. Энэ асуудлыг шийвэрлэх талаар нухацтай хүчин чармайлт гаргах шаардлагатай байна.”

НОУИТБС-ын Санхүүгийн системүүдийн тайлан, хуудас 13

Гүйцэтгэх засаглалд зориулсан шинэчлэлийн боломжит асуудлууд. Зарим тохиолдолд татвар, эсхүл нөөц ашигласны төлбөртэй холбоотой дүрэм журам, зохицуулалтууд тодорхойгүй байна⁵⁶, эсхүл зохицуулагч байгууллагаас тухайн салбарын үйл ажиллагаанд хяналт тавихын тулд уг байгууллагын чадавхийг сайжруулах шаардлагатай гэж шинжээчид тайлагнах болно⁵⁷. Эдгээр төрлийн шинэчлэлүүд нь засгийн газраас компаниудыг хариуцлагатай байлгах чадвар, тухайн улс нөөц баялгийнхаа үр шимийг хамгийн сайн хүртэх чадварт шийдвэрлэх үүрэгтэй. Иргэний нийгэм дараахи арга замаар гүйцэтгэх засаглалын шинэчлэлд нөлөөлж болно:

- хийгдэх шаардлагатай шинэчлэлүүдийн тэргүүлэх ач холбогдлын жагсаалт гаргах
- холбогдох байгууллагын удирдлагатай уулзаж ОУИТБС-ын тайланг уншсан эсэх, юу хийхээр төлөвлөж байгааг нь асуух
- холбогдох байгууллагын шинэчлэлийг ООТБ-ийн хурлын сэдэв болгох явдлыг хөхиүлэн дэмжих
- тухайн байгууллагад хяналт тавих үүрэгтэй хууль тогтоох байнгын хороонд хандаж шинэчлэлийн асуудлаар хэлэлцүүлэг явуулахыг хүсэх
- тухайн байгууллага чадавхиа бэхжүүлэх зорилгоор төсвийн санхүүжилт авах хүсэлтийг дэмжих
- сонин, хэвлэлийн газрууд байгууллагын шинэчлэлийн сэдвээр нийтлэл, өгүүлэл бичихийг дэмжих
- байгууллагын удирдлагууд шинэчлэл хийх үед тэднийг дэмжсэн эерэг мэдэгдэл гаргах

Хууль тогтоох засаглалд зориулсан шинэчлэлийн боломжит асуудлууд. Аливаа улсын ОУИТБС-ын тайлан гарсны дараа хууль тогтоох байгууллага нь ямар арга хэмжээ авбал зохихыг иргэний нийгмийн бүлгүүд авч хэлэлцэх хэрэгтэй.

Аудиторууд дараахи зөвлөмж гаргаж болох юм:

- аудиттай хамтран ажиллах журмын мөрдөлтийг чангатгах
- зохицуулалтын чадавхийг бэхжүүлэх санхүүжилтийг нэмэгдүүлэх
- үндэсний нөөц баялгийг олборлож ашиглах тусгай зөвшөөрөлтэй холбоотой хууль тогтоомжийг өөрчлөх
- аудитын байгууллагууд буюу ОУИТБС-ын аудиторууд хууль тогтоох ба гүйцэтгэх засаглалын байгууллагад хоёуланд нь тайлагнах

Шигтгээ 4.2: Шинэчлэлийн зөвлөмжүүд: Байгууллагын чадавхи - Хэмжилтийн системүүдийг сайжруулах

Нигерид нүүрстөрөгчийн үйлдвэрлэлийн нийт хэмжээг (НТҮНХ) хэзээ ч тооцож байсангүй. Биет аудитаар ийм хэмжилт ихээхэн дутагдаж байгааг тогтоосон байна. Иймээс аудиторуудын санал болгосон шинэчлэлд НТҮНХ-г жил бүр тооцож, хэмжилтийн системүүдийг сайжруулах нь зүйтэй гэжээ.

ОУИТБС-ын Гүйцэтгэлийн хураангуй, хуудас 15

Мөн иргэний нийгмийн гишүүд дараахи асуултыг асуух замаар ОУИТБС-ын систем өөрөө хангалттай байгаа эсэхэд үнэлэлт өгч болно:

- Тайлагналт иж бүрэн үү?
- Тайлагналт хангалттай олон удаа хийгдэж байна уу?
- ОУИТБС-ын Нарийн бичгийн газарт энэ ажлыг сайн хийх хөрөнгө хүч байна уу?
- Үр дүнг мэдээлэхэд хангалттай санхүүжилт байна уу?
- Тухайн үйлдвэрлэлийн салбар хэрхэн ажилладаг талаар сэтгүүлчид, иргэний нийгмийн гишүүд, бусад хүмүүст боловсрол олгоход хүрэлцэхүйц санхүүжилт байна уу?

Түүнчлэн иргэний нийгэм нь Засгийн газрын олсон мөнгийг мөшгиж шалгах хэрэгтэй:

- Засгийн газрын эзэмших хувийг хэрхэн зарцуулсан бэ?
- Түүнийг хадгалсан уу, зарцуулсан уу?
- Муж, орон нутгийн эрх бүхий байгууллагад хэр их мөнгө орсон бэ?
- Эдгээр мөнгөн дүнг нийтэд ил болгосон уу?

Гол зохицуулагч нарт болон тухайн үйлдвэрлэлийн салбарын сонирхсон оролцогчдод (тухайлбал, газрын тос, байгалийн хий, эсхүл уул уурхайн үндэсний компани) хяналт тавьж ажиллахад хууль тогтоох байгууллага илүү идэвх чармайлттай оролцохыг иргэний нийгмийн гишүүд хөхиүлэн дэмжих ёстой. Аливаа төрийн байгууллага хууль ёсны үүргээ хэрхэн биелүүлж байгаа талаар хууль тогтоогчид асуулт асуух хэлэлцүүлэг явуулах, эсхүл хурал зохион байгуулах замаар хяналт тавьж болно. Энэ нь иргэний нийгмийн гишүүд хууль тогтоогчидтой уулзаж, холбогдох асуултыг асуухад зориулсан чухал хэрэгсэл юм.

Бүлэг 4: Түгээн дэлгэрүүлэх үе шат	Тийм/Үгүй
XVIII. Үр дүнг ойлгох	
<i>Аудиторууд холбогдох урсгалуудыг ОУИТБС-ын стандартын дагуу нэгтгэж чадсан уу? Тайланд дараахь зүйлсийг онцлон тэмдэглэсэн үү?</i>	
1. Засгийн газар нийт хэдий хэр орлого олсон бэ?	
2. Татвар, нөөц ашигласны төлбөр болон бусад зүйлсээс хэр их орлого олсон бэ?	
3. Компаниудын төлсөн төлбөр засгийн газарт орсон орлоготой тохирсон уу?	
4. Бүх материаллаг урсгалыг нэгтгэсэн эсэх?	
5. Хэрэв засгийн газарт газрын тосоор төлсөн бол газрын тосыг хэрхэн бэлэн мөнгөнд хөрвүүлсэн бэ, засгийн газар ямар үнээр өгсөн бэ?	
6. Ямар нэг зөрүүтэй байдал байсан эсэх?	
7. Тухайн тайлан ООТБ-ээр зөвшөөрөгдсөн стандартыг, эсхүл олон улсын стандартуудыг хангасан эсэх?	
<i>Засаглалын ямар асуудлууд илэрсэн бэ? Тайланд дараахи зүйлсийг онцлон тэмдэглэсэн үү?</i>	
1. Сайн мэдээ баримт олж авахад ямар нэг хүндрэл бэрхшээл тулгарсан эсэх?	
2. Бүртгэл тооцоо нь бүрэн байсан эсэх? Бүртгэл тооцоог компьютержүүлсэн үү?	
<i>Компанийн зан үйлтэй холбоотой ямар асуудлууд илэрсэн бэ? Тайланд дараахи зүйлийг танилцуулсан уу?</i>	
1. Бүх компани тайлангийн маягтаа бүрэн, үнэн зөв бөглөж ирүүлсэн эсэх?	
2. Ямар компаниуд хамтран ажиллаагүй вэ?	
3. Хамтран ажиллахгүй байгаа компаниудын талаар ямар арга хэмжээ авсан бэ?	
4. Засгийн газрын тайлагнасан төлбөр тооцоо компаниудын тайлагнасантай тохирсон эсэх?	
<i>Аудиторууд ямар шинэчлэлүүд зөвлөмж болгосон бэ? Аудитор буюу нэгтгэн тулгагчаас дараахь зүйлсийг асуусан уу?</i>	
1. Засгийн газрын төлбөр тооцоог бүртгэх системүүд олон улсын стандартуудыг хангасан эсэх? Үгүй бол уг тайланд сайжруулах зүйлсийг санал болгосон уу?	
2. Засгийн газар татвар, эсхүл нөөц ашигласны төлбөрүүдэд Аудитын олон улсын стандартад нийцсэн байдлаар хяналт шалгалт юмуу аудит хийсэн эсэх?	
3. Засгийн газрын санхүүгийн тайлангууд АОУС-г хангаж байгаа эсэх?	
4. Компаниудын санхүүгийн тайлан АОУС-ыг хангаж байгаа эсэх?	
5. Компаниудын төлбөр төлөх үүргийг зохицуулдаг хууль тогтоомж, зохицуулалтууд тодорхой бөгөөд үр дүнтэй эсэх?	

Бүлэг 4: Түгээн дэлгэрүүлэх үе шат		Тийм/Үгүй
XIX. Үр дүнг мэдээлэх		
<i>ИНБ-ууд...</i>		
1.	ОҮИТБС-ын тайлангийн юуг нь мэдээлэх нь чухал талаар өөрийн гэсэн дүгнэлтүүд гаргасан уу?	
2.	Тухайн улсын ОҮИТБС-ын Нарийн бичгийн газар ба ООТБ-т хандаж уг тайланг хаана, хэрхэн тарааж танилцуулах талаар санал тавьсан уу?	
3.	Товч мэдээлэл өгөх ажиллагааг явуулахыг ООТБ-ээс шаардахын зэрэгцээ өөрсдөө ийм ажиллагаа явуулсан уу?	
4.	Үндэсний болон орон нутгийн сонинуудад нийтлэл бичсэн үү?	
5.	ОҮИТБС-ын туршлага, тайлангуудын талаар радио ярилцлага хийсэн үү?	
6.	Үр дүнг тайлбарлах сургалт, семинарууд удирдан явуулсан уу?	
7.	Олон улсын нөлөөллийн бүлгүүдэд хандаж уг тайланг дотоодын хэлүүдээр орчуулж, үр дүнг түгээн дэлгэрүүлэхэд туслахыг хүссэн үү?	
XX. Дагалдах шинэчлэлийн ажлууд		
<i>ИНБ-ууд...</i>		
1.	Дараа дараагийн аудитуудын үндсийг тавих алхамууд хийсэн үү?	
2.	Тайлагнах давтамжийг нэмэгдүүлэх алхамууд хийсэн үү?	
3.	Шинэчлэлийн асуудал боловсруулах алхамууд хийсэн үү?	
4.	Ил тод байдлын үйл явцыг гүнзгийрүүлэх алхамууд хийсэн үү?	



|| ХЭСЭГ

ГҮН ӨРӨМДӨЖ ҮЗЭХҮЙ

Î ëáî ðëî õ

¿ éëäâýðëýëèéí

áèçí ãñèéí ¿ éë

àæèëëèàãààí óóäûã

î éëãî õ í ü

БҮЛЭГ 5

Үдөө чэеи аи өи и үәеөи чанәеөи өүдүү

Тухайн улсын байгалийн баялаг болох газрын тос, байгалийн хий, ашигт малтмалуудыг хэрхэн мөнгө болгон хувиргадгыг ОУИТБС-д оролцогч талууд ойлгох хэрэгтэй. Оролцогч талууд тухайн улсын систем хэрхэн ажилладаг болохыг мэдсэнээр компаниуд ямар төлбөрүүд буюу орлогын урсгалаа тайлагнах ёстой, төрийн ямар байгууллагууд тэдгээрийг хүлээн авснаа тайлагнах ёстойг тодорхойлж чадах юм. Мөн тухайн улс орлогоо хэрхэн олж байгааг (компаниуд татвар, нөөц ашигласны төлбөр төлөх, эсхүл үйлдвэрлэн гаргасан газрын тос, байгалийн хий, ашигт малтмалынхаа хувийг өгөх замаар) мэдэх нь хаана юм буруугаар эргэж болохыг ойлгох эхний алхам байдаг. Тооцоог буруу гаргах асар их боломж байдаг буюу энэ алдаа нь компаниуд төлвөл зохих өрөө хэрхэн тооцож байгаатай холбоотой бол түүнээс ч дор үр дагавартай байдаг. Хэрэв засгийн газрууд төлвөл зохих хэмжээгээрээ төлсөн эсэхийг нь шалгадаггүй, олж мэдсэнээ нийтлэхгүй бол санхүүгийн системүүд авлига, зохисгүй ашиглалтад өртөмтгий болдог. Гарын авлагын энэ бүлэгт олборлох үйлдвэрлэлийг зохицуулж буй эрх зүйн системүүд ба гэрээнүүдийн төрөлд эрсдэл, шагнал хоёр хэрхэн нөлөөлдөг болохыг тайлбарлана. Бүлэг 6-д олборлох үйлдвэрлэлийн салбарт зонхилдог гэрээнүүдийн хэлбэрийг авч үзнэ. Бүлэг 7-д засгийн газруудад төлбөр төлдөг арга замуудыг танилцуулна. Бүлэг 8-д эдгээр хөрөнгийг төрийн ямар байгууллагууд удирддаг талаар танилцуулна. Бүлэг 9-д засгийн газраас эдгээр дүнгүүдийг болон санхүүгийн системүүд авлига, зохисгүй удирдлагад өртөмтгий байдаг бусад чиглэлийг шалгах аргыг авч үзнэ. Эдгээр мэдээлэл нь иргэний нийгмийнхэнд төрийн байгууллагуудыг хариуцлагатай байлгах чадвар олгоно гэдэгт итгэлтэй байна. Хэрэв тэд энэ төрлийн шаардлагатай шалгалтуудыг хийдэггүй бол энэ шалгалтыг хийдэг болгох нэг хэрэгсэл нь ОУИТБС байх ёстой.

5.1 Эрх зүйн хүрээ

Аливаа улсын хууль тогтоомж, зохицуулалтын журмууд, гэрээний зохицуулалтууд нь нөөц баялгийг хэрхэн ашиглах, түүнийг олборлох эрхийг ямар нэг компанид олгосны хариуд тухайн компани ямар төлбөр авахыг тодорхойлдог. Энэ нь хоёр чиглэлтэй харилцаа бөгөөд аль аль тал нь бие биедээ хэрэгтэй учраас гэрээний нөхцлүүд тэгш шударга гэдэгт тал бүр итгэх шаардлагатай байдаг. Татвар ба бусад төлбөрийг зохицуулдаг эдгээр гэрээ ба хууль тогтоомжууд нь компаниудын төлөх ёстой төлбөрүүдийг болон тэд ямар байгууллагад төлөх ёстойг зааж өгдөг. Энэхүү хэлэлцүүлгийн сэдвийн ерөнхий хүрээг гаргахын тулд бид аливаа улсын эрх зүйн хүрээг тодорхойлоход эрсдэл, шагнал хоёрын гүйцэтгэх үүрэг, гэрээний зохицуулалтуудын үндсэн төрлүүд, гэрээний дагуу төлөгдөх төлбөрүүдийн төрлийн талаар танилцуулж байна.

Шигтгээ 5.1: Газрын тосны үндэсний компаниуд

Олон улс газрын тосныхоо нөөцийг олборлох, боловсруулах, экспортлох үүргийг газрын тосны үндэсний компаниуддаа хариуцуулах, эсхүл тэднийг бусад компаниудтай түншилж ажиллахыг зөвшөөрөх сонголт хийдэг. Эдгээр тохиолдолд ГТҮК-ууд ч засгийн газарт татвар, нөөц ашигласны төлбөр, бусад хэлбэрийн нөхөн төлбөр төлдөг. Мөн ГТҮК нь үр ашигтай үйлдвэрлэгч байж засгийн газрын санд төлвөл зохих мөнгөө үнэн зөв төлж байгаа эсэхэд хяналт тавих сонирхол тухайн засгийн газарт байдаг. Түүнчлэн засгийн газар нь ГТҮК нь үр ашигтай үйлдвэрлэгч байх нөхцлийг бүрдүүлэхээс өөр бусад сонирхолтой байж болно. Тухайлбал нийгмийн хөтөлбөрүүдийг удирдах, эсхүл ажлын байр бий болгох үүрэг хүлээхийг хүсч болно. Ямар ч байсан, засгийн газрын тавьж буй шаардлагууд, компаниудын гүйцэтгэлийг ил тод болгосноор иргэд хождог байна.

5.2 Эрсдэл, шагнал хоёр: Гэрээний нөхцөлд нөлөөлдөг хүчин зүйлс

Газрын тос, байгалийн хий, уул уурхайн гэрээний төсөл боловсруулагчид гэрээний хугацаанд тохиолдож болох бүхий л боломжийг тооцохыг оролдож, улмаар урьдаас тооцоологдоогүй гэнэтийн үйл явдал тохиолдоход талууд юу хийх ёстойг урьдчилан тодорхойлохыг хичээдэг учраас энэ төрлийн гэрээнүүд маш урт, нарийн төвөгтэй байж болно.

Гэхдээ аливаа гэрээнд ордог гол нөхцлүүд ба үндсэн асуудлын тоо харьцангуй цөөн байдаг. Гол ач холбогдолтой нөхцлүүдийн дотор дараахи асуудал ордог:


- Хайгуул, боловсруулалтын зардлыг хэн төлөх вэ?
- Үйлдвэрлэлийн зардлыг хэрхэн санхүүжүүлэх вэ?
- Үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хэн удирдах вэ?
- Үйлдвэрлэсэн баялгийг хэрхэн хуваах буюу борлуулах вэ?
- Талуудын төлбөрийг ямар дарааллаар төлөх вэ?

Гэрээний төрөл бүр эдгээр хүчин зүйлсэд өөр өөрөөр ханддаг.

Олборлох үйлдвэрлэлийн компаниуд эрсдэлтэй бизнес эрхэлдэг гэдгийг ойлгох нь чухал. Компаниуд хайгуул болон бараа, түүхий эдийн үнийн хэлбэлзэлтэй холбоотой эрсдлүүд хүлээдэг бөгөөд хайгуул, ашиглалт төдийгүй техникийн мэдлэг туршлага, үйл ажиллагааны удирдлагыг санхүүжүүлэлтээр хангах ёстой. Үүнийхээ хариуд компаниуд тэгш шударгаар шагнал хүртэх, хөрөнгийнхөө өгөөжийн хувийг шударгаар тогтоолгох, тухайн хөтөлбөрийн удирдлагыг гартаа авахыг хичээдэг.

Бараа, түүхий эдийн бүхий л олборлолт эрсдэлтэй байдаг боловч энэ нь тооцоологдсон эрсдэл байдаг. Эрсдэлийн тооцоог олон янзын хүчин зүйлсийн нөлөөлөх магадлалд тулгуурлаж гаргадаг. Үр дүнд нь, компаниуд бүтэлгүйтсэн хайгуулын ажиллагаанд алдсан мөнгөө нөхөж чадах (өөрөөр хэлбэл, эрсдэл) хэмжээний хангалттай амжилттай үйл ажиллагаа явуулах (өөрөөр хэлбэл, шагнал) нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай байдаг.

Зураг 5.1: Тогтвортой шагнал ба эрсдэл



Гаргасан цөөхөн амжилтаараа ирээдүйн хайгуулаа санхүүжүүлэх шаардлагатай болдог

Жишээлбэл, таван өөр улсад хайгуул хийх таван боломж байлаа гэж бодъё. Эдгээр орнуудад хайгуулын судалгаа хийж, тухайн улс бүрт байгаа орд газар бүрээс газрын тос илрүүлэх магадлал 20 хувьтай байгааг тогтоожээ. Өөрөөр хэлбэл, амжилтын магадлал (AM) 20 хувь байна гэсэн үг. Эдгээр таван орд газрын нэгд нь л арилжааны хувьд ашигтай орд байна гэж үзэж байна. Ийм тохиолдолд газрын тосны компани тогтвортой ажиллахын тулд амжилттай байгуулсан нэг үйлдвэр нь ирээдүйд тав, магадгүй түүнээс олон цооног өрөмдөхөд хангалттай санхүүжилт бий болгох ёстой байдаг.

Бүтээгдэхүүн хуваах гэрээг тохирсон, эсхүл хууль тогтоомжид заасан гэрээний нөхцлүүд нь аливаа компани хүлээж байгаа эрсдэлдээ тохирох хэмжээний шударга шагнал хүртэх боломж олгох ёстой. Хэрэв энэ эрсдэл нь өндөр бол гэрээний нөхцөл ерөнхийдөө тухайн компанид илүү тааламжтай тал руугаа ордог.

Гэрээ хэлэлцээр хийж буй үед мэдэгдэхгүй олон зүйл байдаг. Хэрэв хайгуулын талбай нь газрын тосны батлагдаагүй сав газар бол илрэлүүдэд тулгуурласан

төсөөлөл хийх ёстой бөгөөд газрын тос олдох магадлал, техникийн хувьд ашиглаж болох магадлал, тухайн цооногоос хэр их газрын тос гарах (“гарцын хувь” гэж нэрлэдэг), хийсэн ажлынхаа зардлыг нөхөх хэмжээний хангалттай үйлдвэрлэл явуулахад хэр их хугацаа шаардах вэ гэх мэт олон төсөөлөл хийх шаардлагатай.

Ямар нэг сав газарт газрын тос агуулагдаж байгаа нь тогтоогдсны дараа эдгээр үл мэдэгдэх зүйлсийн зарим нь арилдаг. Жишээлбэл, чулуулгын эх үүсвэр байгаа нь тогтоогдсон байх болно. Иймээс эрсдэл багасах бөгөөд улс орнууд энэхүү буурсан эрсдлийг тусгаж засгийн газарт илүү их ашигтай байлгахын тулд дараагийн үед гэрээнийхээ нөхцлүүдийг өөрчлөх нь олонтаа. Хожим нь, бүх хамгийн сайн илрэлүүдийг өрөмдөж үзсэний дараа, эсхүл уурхайн ашигтай нас дуусах үед, арай жижиг, эсхүл захын ордуудад хайгуул хийх компаниудыг татахын тулд санхүүгийн нөхцлүүдээ дахин зөөлрүүлж болно.

Иймээс гэрээний нөхцлүүд маш олон янз байдаг. Жишээлбэл, нүүрстөрөгчийн нэг сав газарт тухайн талбайн сонирхол татах байдал, сав газрын ашиглах хугацааны хэзээнээс гэрээ хэрэгжих вэ гэдгээс гэрээний нөхцлүүд хамаарах болно. Мөн гэрээ хийж байх үеийн газрын тосны үнийн ирээдүйн чиг хандлага ямар байх тухай төсөөлөл гэх мэт гадны хүчин зүйлс ч бас гэрээний нөхцөлд нөлөөлдөг. Байгалийн хий, уул уурхайн гэрээний хувьд ч мөн адил. Хэрэв гэрээнд гарын үсэг зурж байх үед үнэ буурах төлөвтэй байсан бол боловсруулагчид санхүүгийн эрсдэл өндөртэй гэж үзээд төслөө үнэ багатай орчинд амьдрах чадвартай байлгах нөхцлийг эрэлхийлэх болно. (Энэ нь газрын тосны олон улсын компаниудад төдийгүй шинэ үйлдвэрлэлд хөрөнгө оруулах эсэхээ шийдэж байгаа газрын тосны үндэсний компаниудад ч бодитойгоор нөлөөлнө.) Тухайлбал, газрын тос, байгалийн хий, түүхий эдийн үнэ бага байсан 1990-өөд оны сүүлээр гарын үсэг зурагдсан гэрээнүүдэд ийм зүйл тохиолдож байв. Нөгөө талаас, 2004-2008 оных шиг бараа, түүхий эдийн үнэ өндөр байж, цаашид өндөр хэвээр байх төлөвтэй байх үед хүлээн авагч орнууд үнийн эрсдэл багатай гэж үзээд төслөө үнэ багатай нөхцөлд амьдрах чадвартай байлгах шаарлагагүй нөхцөл шаардах болно. Жишээлбэл, 1990-өөд оны сүүл, 2000 оны эхээр газрын тосны үйлдвэрлэлд нэг баррель нь 20\$ гэсэн үнэ 10 жилийн турш голч үнэ байсаар ирсэн бөгөөд нэг баррель нефтийн үнэ 15\$ байхад амьдрах чадвартай төслийг компаниуд шаардаж байв. Тэр үед Канадын газрын тосны элс гэх мэт газрууд арилжааны чадвартайд тооцогдохгүй байлаа. Гэвч сүүлийн жилүүдэд газрын тосны үнэ 40\$-с хол давж, дунджаар 60\$-70\$ болсонтой холбогдуулан газрын тосны дэлхийн зах зээлийн үнэ 30\$-35\$ байхад амьдрах чадвартай газрын тосны элсний төслүүдийг ихээхэн арилжааны чадвартай гэж үзэх болжээ.

ОУИТБС-ын Үндсэн хүрээний хувьд эдгээр хувьсагчуудын ач холбогдол гэвэл аудиторуд буюу нэгтгэн тулгагчдийн зүгээс олон янзын гэрээний нөхцлүүд мөрдөгдөж байх нөхцлөөр хангахыг хичээх ёстой явдал юм. Харин ОУИТБС-ын Нэмэлт хүрээний хувьд улс орондоо хэрэгжиж байгаа гэрээнүүдийн хэлбэр, тэдгээрийн санал болгож буй нөхцөл нь тухайн улсад болон дэлхийн зах зээл дээр байгаа төрөл бүрийн эрсдэлүүдэд нийцэж байгаа эсэхийг оролцогч талууд шалгаж үзэх ёстой байдаг.

БҮЛЭГ 6

Аудууї èé ĸí äñуї ò°ðëĸĸä

Олборлох үйлдвэрлэлд хэрэглэгддэг янз бүрийн төрлийн гэрээнүүд тухайн улсын засгийн газар ба арилжааны үйл ажиллагаа явуулж байгаа этгээдийн эрх, үүргүүдийг тодорхойлдог. Янз бүрийн хэлбэр, зориулалттай эдгээр гэрээ нь тухайн үйлдвэрийн эрсдэлийг болон хэрэв амжилттай болвол хүртэх шагналыг гэрээний талуудад хуваарилж өгдөг.

Гэрээний гурван үндсэн төрөл байдаг нь: (1) бүтээгдэхүүн хуваах гэрээ, (2) хөнгөлөлтийн гэрээ, (3) техникийн үйлчилгээний гэрээ гурав юм.

Ашгийн түвшний гэрээ, эрсдэлийн үйлчилгээний гэрээ гэх мэт гэрээний бусад хэлбэрүүд нийтлэг бус хэрэглэгддэг бөгөөд энэхүү гарын авлагад зөвхөн товчхон авч үзэх болно. Түүнчлэн гэрээний үндсэн хэлбэрүүдийн шинэ хувилбарууд байнга төрөн гарч, засгийн газрууд үйлдвэрлэлийн салбарынхан тухайн бизнесийн талаарх ойлголтоо сайжруулах, шинэ эрэлт хэрэгцээ, зориулалтуудад хариу үйлчлэх, зах зээлийн бодит байдалд нийцүүлэх арга хэмжээ авах тусам хувьсан хөгжсөөр байна.

Иргэний нийгмийн гишүүд дараахь шалтгааны үүднээс эдгээр төрлийн гэрээнүүдийг ядаж ерөнхийд нь ойлгодог болох шаардлагатай:

1. Талуудын гэрээний дагуу ажиллаж байгаа байдал олборлох үйлдвэрлэлээс засгийн газарт орж байгаа орлого буюу хүртэж байгаа үр өгөөжид (тус салбарынхан “засгийн газрын авах хувь” гэж нэрлэдэг) хэрхэн нөлөөлж байгааг ойлгох
2. Тухайн улсын хувьд эдгээр зохицуулалтуудыг хэрэглэх нь зөв зүйтэй эсэхэд үнэлэлт өгөх

Бүтээгдэхүүн хуваах гэрээ

Бүтээгдэхүүн хуваах гэрээ гэдэг бол тухайн компани авсан талбайгаа засгийн газрын хяналтанд дор ашигладаг нэг төрлийн бартерийн солилцоо юм. Компани буюу гэрээлэгч нь бүх санхүүжилтийг, түүний дотор эрсдлийн бүх хөрөнгийг гаргах бөгөөд үйлдвэрлэсэн газрын тосоороо зардлаа нөхдөг байна. (Байгалийн хийн хувьд БХГ ашиглах нь туйлын ховор байдаг. Уул уурхайн салбарт бол засгийн газрууд бэлэн бус хэлбэрээр нөөц ашигласны төлбөр шаардаж болох боловч БХГ-ний бүтцийг хэрэглэдэггүй.)

Үүнээс гадна, олсон ашгийг засгийн газар компани хоёр харилцан тохирсон томъёоны дагуу хувааж, хоёр талд газрын тосны хэлбэрээр хуваарилдаг. Ихэнх оронд бүтээгдэхүүн хуваах зохицуулалтаараа татварын асуудлыг шийддэг бөгөөд засгийн газар нэгэнт газрын тосны ашгийн хувиа авчихсан тохиолдолд тухайн компанийн үйлдвэрлэлд татвар ногдуулдаггүй. БХГ-нд засгийн газар тухайн талбайг ашиглуулсны төлбөрийг “бэлэн бус” хэлбэрээр нөхөн төлүүлэхээр тохирдог ч гэсэн тухайн орд газрын нөөц засгийн газрын өмч хэвээр байдаг.

Шигтгээ 6.1: Засгийн газрын БХГ-ний төслүүдийн удирдлага

Засгийн газар газрын тосны үндэсний компани, эсхүл өөр бусад этгээдийн хэлбэрээр БХГ-ний төслүүдийг хэрхэн удирдаж байгааг оролцогч талууд анхааралтай ажиглахыг хүсч болно. Аливаа БХГ-ний тогтолцоонд тухайн талбайд үйл ажиллагааны хяналт тавих эрхийг гэрээлэгчид олгосон байдаг. Гэрээг удирдлагын зөвлөлөөр дамжуулан удирдах бөгөөд уг зөвлөл нь улсын үйлдвэрийн газрын болон гэрээлэгчийн талын оролцогчдын ижил тооны төлөөлөлтэй байдаг. Удирдлагын зөвлөл нь газрын тосны хайгуул, үйлдвэрлэлийн үе шат, төслийн явцад гарсан зардлуудад хяналт тавихын зэрэгцээ жилийн ажлын төлөвлөгөө, төсөв, томоохон гэрээ болон газрын тос, байгалийн хийн ордуудыг ашиглах стратегийн хөгжлийн төлөвлөгөө зэргийг хамтран боловсруулах замаар удирдлагын хяналтын чиг үүргийг гүйцэтгэдэг. Энэ бүх үйл ажиллагааг хэрэгжүүлж эхлэлийн өмнө ГТҮК-аар батлуулдаг.

ОУИТБС-ын зорилгод хамаарах ашиг орлогын ямар урсгалууд байдаг вэ? Аливаа БХГ-нээс гарах ашиг орлогын гол урсгал (буюу төлбөрийн эх сурвалж) бол засгийн газар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс хувь хүртэх эрх юм. Мөн үйлдвэрлэгч компаниудад бусад төрлийн татвар, төлбөрүүд ногдуулж болдог.

ОУИТБС-ын зорилго талаасаа нягтлан бодох бүртгэлийн ямар гол асуудлууд тавигддаг вэ? Энэ төрлийн гэрээтэй холбоотой ОУИТБС-ын гол асуудлууд бол:

1. Бэлэн бус төлбөрийн эзлэх хувийг тооцоолох
2. Бэлэн бус төлбөрүүдийн мөнгөн үнэ цэнийг тооцоолох явдал байдаг.

Газрын тосны БХГ-нд “газрын тосон зардал” гэдэг нэр томъёог гэрээлэгч хайгуул, ашиглалт, үйлдвэрлэлийн зардлаа нөхөхийн тулд авч үлдэж байгаа газрын тосны хэмжээ гэж тодорхойлдог. “Газрын тосон ашиг” гэдэг бол үүнээс үлдэж байгаа газрын тосыг хэлэх бөгөөд арилжааны үйл ажиллагаа явуулагч тал ба засгийн газар хоёрт урьдчилан тохиролцсон хувь хэмжээгээр хуваарилдаг. Заримдаа “газрын тосон татвар” гэсэн гурав дахь ойлголтыг хэрэглэдэг бөгөөд засгийн газарт төлөх татварын хувь хэмжээгээр (ашгийн хувь) засгийн газарт татвар болгож төлөх газрын тосны хувь хэмжээг газрын тосон ашгийн хувь хэмжээндээ оруулж тооцдог.

Шигтгээ 6.2: Газрын тосон ашгийн тооцоо

ОУИТБС-ын хувь тавигддаг гол асуудлууд бол газрын тосон зардал ба ашгийн төлбөрүүд, засгийн газраас газрын тосон ашгийн үнэлгээг тогтоосон байдал, компаниудаас төлсөн бусад татварууд, тухайн газрын тосыг хэрхэн мөнгө болгон хувиргасан бэ (тухайн компани засгийн газрын нэрийн өмнөөс, эсхүл ГТҮК өөрөө) гэдэг асуудал байдаг. ОУИТБС-ын үндсэн хүрээнээс хальсан гол асуудлууд гэвэл компаниуд газрын тосон зардлаа тооцож байгаа арга, тухайн салбар дахь засгийн газрын удирдлагын хангалттай байдал хоёр юм.

Шигтгээ 6.3: Газрын тосон зардлын тооцоо

Зардлуудад хэрхэн хяналт тавьж байна, удирдлагын зөвлөлд байгаа засгийн газрын төлөөлөгчид хэр үр нөлөөтэй ажиллаж байна, санхүүгийн зардлаа хэрхэн баррельд шилжүүлж байна гэдгийг анхаарах хэрэгтэй. (Хавсралт Д-г үзнэ үү)

Эдгээр хувь хэмжээг тооцох томъёо улс орон бүрт харилцан адилгүй байдаг. Тэдгээрийн талаар тухайн гэрээнд өөрт нь заасан байхаас гадна заримдаа хуульчлан заасан байдаг. Компаниуд эдгээр томъёог зөв ашиглан тооцож байгаа эсэх, засгийн газрууд улс орондоо зөв хувь хэмжээний орлого оруулж байгаа эсэхийг ОУИТБС-ын аудиторуд ба нэгтгэн тулгагчид шалгаж үзэх хэрэгтэй.

Гэрээний нөхцлийг энгийн үгээр уншлаа ч гэсэн засгийн газар БХГ бүрээс газрын тосны хэдэн хувийг авах эрхтэй гэдгийг нарийн тодорхойлоход хэцүү байх нь элбэг. Аудитор эхлээд өгөгдсөн жилд тухайн талбайгаас хэдий хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэснийг мэдэх хэрэгтэй. Үүний дараа гэрээний дагуу тухайн компани зардалдаа хэдий хэрийг үлдээх эрхтэй (өөрөөр хэлбэл, газрын тосон зардалд), үүний дараа хэдий хэмжээтэй үлдэж байна (өөрөөр хэлбэл, газрын тосон ашиг), газрын тосон ашгийн хэдэн хувийг засгийн газарт төлөх ёстойг тодорхойлохын тулд гэрээний нөхцлүүдэд шинжилгээ хийх хэрэгтэй болно. Компаний зөвшөөрөгдөх зардал ба газрын тосон зардлыг хэрхэн тодорхойлох тухай илүү дэлгэрэнгүй хэлэлцүүлгийг Хавсралт Д-гаас үзнэ үү. Мөн БХГ-ний дагуу компаний газрын тосон ашгийг хэрхэн тооцоолох тухай дэлгэрэнгүй хэлэлцүүлгийг Хавсралт Е-гээс үзнэ үү. БХГ-ний дагуу компаний хөрөнгийн хэдэн хувийг авч үлдэх эрхтэйг хэрхэн тооцоолох тухай Хавсралт Ё-гоос үзнэ үү.

БХГ-нүүдээс засаглалын ямар гол асуудлууд үүсэн гардаг вэ? БХГ-ний удирдлагад ямар нэг улсын үйлдвэрийн газар хяналт тавьж байдаг учраас БХГ-г хэрэгжүүлэх бүхий л шийдвэрийг, ялангуяа газрын тосон зардлаар нөхөх зардлуудыг төрийн байгууллагаар батлуулахыг шаарддаг. Мэдээж зарим зардлууд батлагдахгүй байх юмуу, тухайн зардлуудыг хуульчлан батлах ёстой тохиолдолд хүртэл цагтаа батлагдахгүй байх тохиолдол гарна. Дараа дараагийн шатуудад, улсаас томилогдсон байгууллага БХГ-нүүдийг үр нөлөөтэй удирдаж байгаа эсэхийг оролцогч талууд шалгахыг хүсч болно.

Засгийн газар БХГ-ний, эсхүл хөнгөлөлтийн гэрээний түнш болсон тохиолдолд гардаг бусад асуудлууд ч бий. Тэдгээрийн дотор дараахи асуудлыг оруулж болно:

- Засгийн газар өөрийн эзэмших хувиа төлж болох уу?
- Засгийн газрын гүйцэтгэх үүрэг хамтарсан үйлдвэрийн ашиг сонирхолд зөрчил үүсгэж байна уу?
- Хамтарсан компаний аудитлагдсан бүртгэл тооцоо ОУИТБС-ын зорилгод хангалттай нийцэж байна уу?

Эдгээр асуудлуудын талаар Хавсралт Д-ээс үзнэ үү.

6.2 Хөнгөлөлтийн гэрээ

Хөнгөлөлтийн гэрээ нь ямар нэг компани (ихэвчлэн тэргүүлэх компани ба түүний хамтарсан үйлдвэрийн түншлэгч нарт)-д тодорхой газар нутгийг ашиглах тусгай зөвшөөрөл олгодог. Нөөц баялгийг (газрын тос, эсхүл зэс гэх мэт) ашиглах эрхийг тухайн арилжааны үйл ажиллагаа явуулагч хууль ёсоор эзэмшдэг. Хөнгөлөлт эдлэгч нь хайгуул, ашиглалт, үйлдвэрлэлийн бүх зардлаа өөрөө санхүүжүүлдэг. Засгийн газар голдуу нөөц ашигласны төлбөр, талбайн хэмжээний хураамж, хамтарсан үйлдвэрийн хувьд төлөх татвар, бонус болон нийгмийн татварууд авдаг. Уул уурхайн салбарт бол нөхөн төлбөрийн нөхцлүүд ба хэрэгжүүлэлтийн зохицуулалтуудыг уул уурхайн хууль, журмуудад зааж өгсөн байж болно. Хэрэв засгийн газар хамтарсан үйлдвэрийн түншлэгчээр оролцож байгаа бол өөрийн эзэмшиж буй хувьтай тэнцэх хувь хэмжээний бүтээгдэхүүн авдаг.

ОУИТБС-ын зорилгод хамаарах ашиг орлогын ямар урсгалууд байдаг вэ? Нөөц ашигласны төлбөр, талбайн хэмжээний хураамж, уурхайн татвар, хамтарсан үйлдвэрийн төлөх албан татвар болон бонус, нийгмийн татварууд байна.

ОУИТБС-ын зорилго талаасаа нягтлан бодох бүртгэлийн ямар гол асуудлууд үүсдэг вэ? Гол асуудал бол компаниуд татвар, нөөц ашигласны төлбөр болон бусад төлбөрүүдээ хөнгөлөлтийн гэрээнд заасны дагуу зөв тооцож байгаа эсэх тухай байдаг. Татвар, нөөц ашигласны төлбөрийн тооцооноос үүсдэг асуудлуудын талаар Бүлэг 7-д авч үзнэ.

Шигтгээ 6.4: Нөөц ашигласны төлбөрийн тооцоог шалгах нь

ОУИТБС-д компаниудын нөөц ашигласны төлбөр (мөн ногдуулсан экспортын татвар, НӨТ-н)-ийн тооцоог засгийн газрынхтай тулгаж, хоорондоо тохирч байгаа эсэхийг нь шалгаж тайлагнахыг шаарддаг. Аудитор эдгээр тоог хэд хэдэн аргын аль нэгээр шалгаж үзэхийг оролцогч талууд шаардаж болно. Үүний нэг нь тухайн компанийн үйлдвэрлэсэн газрын тос, байгалийн хийн тоо хэмжээний цэвэр дүнг засгийн газрын тооцоотой тулгаж, таарч байгаа эсэхийг нь шалгах явдал юм. Хэрэв нөөц ашигласны төлбөр нь (дэлхийн зах зээлийн үнэ, эсхүл үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээнээс хамаарч) хувьсах бол тухайн аудитор засгийн газар ба компаниудын дүнг тулган, тэд хоёулаа нөөц ашигласны төлбөрийг тооцдог байх нөхцлийг бүрдүүлэх хэрэгтэй.

6.3 Техникийн үйлчилгээний гэрээнүүд

Техникийн үйлчилгээний гэрээний дагуу бол тухайн нөөц баялаг засгийн газрын хяналтанд байх бөгөөд хайгуулын ажил, барилгын ажил, ашиглалтын удирдлагын хэлбэрээр техникийн үйлчилгээ үзүүлэх компанитай ийм гэрээ байгуулдаг. Үйлдвэрлэн гаргасан бүтээгдэхүүнийг засгийн газар эзэмших бөгөөд тухайн компанид мөнгөн, эсхүл бараа, түүхий эд (газрын тос гэх мэт)-ийн хэлбэрээр төлбөр төлдөг.

Энэ төрлийн гэрээгээр олгох ажлын хөлсийг үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд бус, хийж гүйцэтгэсэн ажил (жишээ нь, гэрээлэгчийн ажилласан хүн цаг)-д тулгуурлан тооцдог байна. Эдгээр нь ерөнхийдөө газрын тосны компаниудын сонирхлыг татдаггүй боловч ирээдүйтэй талбай олж авах, эсхүл дараа нь тодорхой хэмжээний эрсдэлтэй талбай ашиглах үйл ажиллагаа болгох нэг арга зам гэж үзэж болно. Ийм төрлийн гэрээнүүдийг Ойрхи Дорнод дахь ОПЕК-ийн зарим орнууд, түүний дотор Иран, Кувейт, Саудын Араб зэрэг улсад тодорхой судалгаа хийлгэх юмуу барилгын төсөл хэрэгжүүлэх зорилгоор богино хугацаагаар байгуулж ирсэн байна.

ОУИТБС-ын зорилгод хамаарах ашиг орлогын ямар урсгалууд байдаг вэ? Техникийн үйлчилгээний гэрээнүүд ОУИТБС-д хамрагдахгүй, учир нь тухайн компани засгийн газарт ямар нэг төлбөр төлдөггүй байна.

6.4 Бусад төрлийн гэрээнүүд

Гэрээний нэмэлт боловч ховорхон хэрэглэгддэг хоёр төрөл бол ашгийн түвшний гэрээ ба эрсдэлийн үйлчилгээний гэрээ хоёр юм. Тэдгээр нь голлон газрын тосны салбарт хэрэглэгддэг бөгөөд зөвхөн товч ойлголт өгөх үүднээс энэхүү гарын авлагад авч үзлээ.

Ашгийн түвшний гэрээнүүд. Ашгийн түвшний гэрээнүүд нь хуучин цагийн хөнгөлөлтийн гэрээнүүдийн нэг бөгөөд хөнгөлөлтийн шинэ гэрээнүүдэд тэр бүр ийм нөхцөл ордоггүй. Ашгийн түвшний системд, хөнгөлөлт эдлэгч нь газрын тос үйлдвэрлэн гаргаж, түүний зах зээлийн үнийн тодорхой хувийг, эсхүл баррель газрын тос тутмаас тогтмол хэмжээтэй хэсгийг (зарим нөхцөлд тохируулга хийх боломжтой) авдаг байна. Хэдийгээр ашгийн түвшин ихэвчлэн бага (тухайлбал, баррель тутамд 2\$) байдаг боловч газрын тосны үнэ доогуур байгаа үед сонирхол татам зохицуулалт байж болох юм. Энэ төрлийн гэрээний нөхцөл одоо ч Абу Даби, Оманд байдаг боловч шинээр байгуулагдсан гэрээнүүдэд хэрэглэдэггүй байна.

Эрсдэлийн үйлчилгээний гэрээ. Энэ гэрээ нь хөнгөлөлт эдлэгч нь нөөц ашигласны төлбөр ба татвар төлдөг хөнгөлөлтийн системд байдаг. Ийм зохицуулалттай үед газрын тос худалдан авагч нь ГТҮК байх бөгөөд тогтсон бага үнээр худалдан авдаг байна. Иймэрхүү гэрээнүүд одоо ч гэсэн Өмнөд Америкийн зарим газар, тухайлбал Аргентинд байдаг. Энэ төрлийн гэрээнд газрын тосны үнийн өсөлтийн бүх үр шимийг ГТҮК хүртдэг бөгөөд хөнгөлөлт эдлэгч нь үнийн дээд хязгаарт баригдан үйлдвэрлэл, явуулж ашиг олох шахалтанд ордог байна.

6.5 ОҮИТБС-ын зорилгод хамаарах ашиг орлогын ямар урсгалууд байдаг вэ?

Үйлдвэрлэгч компани үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ болон тухайн бүтээгдэхүүнд төлсөн татвар, нөөц ашигласны төлбөр, бусад төлбөр хураамжаа тайлагнадаг. Үнийн дээд хязгаарын нөлөөгөөр ашиг нь хязгаарлагддаг учраас тухайн компанийн төлж буй ашгийн татварын хэмжээ бусад төрлийн гэрээний системийнхээс бага байх болно.

БҮЛЭГ 7

ᠴᠠᠨᠠᠭᠢᠨ ᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨ ᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨ ᠵᠢᠨᠠᠨᠠᠨᠠᠨ ᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨ

ОУИТБС-д засгийн газарт төлж байгаа газрын тос, байгалийн хий, уул уурхайн бүх материаллаг төлбөрийг нийтлэхийг шаарддаг. Засгийн газрууд газрын тос, байгалийн хий, ашигт малтмал ашигласны орлогыг янз бүрийн арга замаар авдаг боловч үндсэндээ дараахи хэлбэрүүд байдаг. Үүнд:

- Татвар
- Нөөц ашигласны төлбөр
- Бэлэн бус төлбөр
- Бонус
- Ногдол ашиг
- Түрээс

Газрын тос олборлох талбайгаас хувь эзэмших, эсхүл уурхай ашиглах эрх авсны хариуд зам, гүүр барьж өгөх гэх мэт шууд бус ашиг орлогыг ОУИТБС-ын маягтад тайлагнах шаардлагагүй байдаг. Харин дор дурдсан шалтгаанаар тэдгээрийг оруулж тооцохыг оролцогч талууд хүсч болно.

Бүлэг 5-д дурдсанчлан, газрын тос, байгалийн хий, уул уурхайн үйл ажиллагаанаас засгийн газрын эзэмших хувь нь хөрөнгө оруулалт хийж байх үеийн газар зүй, улс төр, арилжааны эрсдэлийн түвшнүүдээс хамаарч янз бүр байдаг. Засгийн газрын “авах хувь” гэдэг бол татвар, нөөц ашигласны төлбөр, бүтээгдэхүүний хувь болон үйл ажиллагааны авч буй бусад мөнгөн орлогын эзлэх хувийн нийлбэр дүн байдаг. Хүснэгт 7.1-д газрын тос, байгалийн хийн үйл ажиллагаануудаас засгийн газрын авдаг хувь маш олон янз байдгийг харуулж байна.

Хүснэгт 7.1: Газрын тос, байгалийн хийн үйл ажиллагаанаас Засгийн газрын хүртэж байгаа хувь, улсаар

Улс	Авдаг %
Камерун	11
Мексик	31
Канад	35
АНУ-ын Мексикийн булан	42
Филиппин	46
Бразил	48
Казахстан	52
Зааны ясан эрэг	55
АНУ-ын Техас эрэг орчимд	59
Экваторын Гвиней	60
Азербайжан	62
Нигери (усны гүнд)	65
Габоны эрэг орчимд	73
Судан	77
Оросын Сахалин 2	81
Норвеги	84
Нигерийн эрэг орчимд	87
Иран	93

Эх сурвалж: АНУ-ын Нягтлан бодох бүртгэлийн ерөнхий газар, 2007 оны 5 сарын 1

7.1 Татвар

Засгийн газар янз бүрийн татвараар дамжуулан олборлох үйлдвэрлэлээс орлого олж байдаг. Татварын ерөнхий хэлбэрүүдийг дор дүрслэн харуулав. Түүнчлэн татварын дэглэмийг дотоодын тодорхой хэрэгцээ шаардлага, зорилтуудад нийцүүлэн өөрчилж болох хэд хэдэн арга байдаг.

Шигтгээ 7.1: Татварын өрийн тооцоо

Газрын тосны үйлдвэрлэлийн хувьд ихэвчлэн их хэмжээний мөнгө эргэлддэг учраас татвар төлөгчид газрын тос үйлдвэрлэмэгц (ихэвчлэн сар тутамд) татварын өрийн тооцоо ашиглан төлбөр хийдэг. Ингээд жилийн эцэст дээрх тооцоонуудыг тухайн жилд төлвөл зохих татварын бодит дүнтэй харьцуулах бөгөөд илүү, эсхүл дутуу төлөлтүүд үүсч тэдгээрийг эцэслэн тулгах шаардлагатай болгодог.

Ашгийн татварууд. Олон орон аливаа үйлдвэрлэгчийн олборлолтоос олсон ашигт татвар ногдуулдаг. Эдгээр нь орлого ба зардлуудын зөрүүнд ногдуулдаг татвар юм. Зарим тохиолдолд ашгийн татварын үндсэн хувиас гадна үнэ тодорхой түвшнээс давсан үед олсон илүүдэл ашигт нэмэлт татвар ногдуулдаг.

Их Британид аж ахуйн нэгжийн орлогын татвараас гадна нефтийн орлогын татвар ногдуулдаг. Нигерид нефтийн ашгийн татвар (НАТ) ногдуулдаг. Анголд нефтийн орлогын татвар ногдуулдаг. АНУ-д гэнэтийн ашгийн татвар ногдуулдаг байна.

Энд анхаарвал зохих хоёр асуудал байдаг нь:

- Эдгээр татварыг зөв тооцоолсон уу? (өөрөөр хэлбэл, тухайн үйл ажиллагаа эрхлэгчийн мэдүүлсэн зардлын хэмжээ үнэн зөв үү, хасалт хийхийг зөвшөөрсөн үү)
- Татварыг цаг хугацаанд нь төлж байна уу? гэдэг асуудал юм.

Аж ахуйн нэгжийн орлогын татвар. Аж ахуйн нэгжийн орлогын татварыг аливаа компаний ашигт ногдуулдаг бөгөөд ашгийг тооцохдоо нийт борлуулалтын орлогоос үйл ажиллагааны зардлууд, капиталын төлбөрүүд, хүү, элэгдэл хорогдлын шимтгэлүүд болон бусад хасагдах зардлуудыг хасч тооцдог. Энэ нь ерөнхийдөө цэвэр ашгийн 15-45 хувийн хооронд байх боловч нүүрстөрөгчийн үйлдвэрлэлийн хувьд заримдаа цэвэр ашгийн 85 хувь хүртэл өндөр байж болдог. Энэ татварыг холбогдох татварын албанд бэлнээр төлөх үүрэгтэй.

Татварыг тооцоход зөвшөөрөгдөх “үйл ажиллагааны зардлын” хэмжээ шийдвэрлэх үүрэгтэй. ОУИТБС-ын хувьд үйл ажиллагааны зардалд маргаантай олон зүйл байдгийг анхаарах хэрэгтэй. Олон улсын олборлох үйлдвэрлэлийн олон компани гуравдагч оронд төвлөрсөн хангамжийн байгууллагуудтай байдаг. Иймээс дотоодын байгууллага гаргасан зардлаа ямар нэг бие даасан нийлүүлэгчээс биш, хангамжийн байгууллагаасаа нэхэмжилж авдаг бөгөөд гадны зардал байж болох зүйлстэй холбоотой ил тод байдал муу байж болох юм. Ийм байгууллагууд ихэвчлэн захиргааны болон үйл ажиллагааны зардлаа оруулсан тодорхой хувийг нэмж, магадгүй ашиг олдог байж болох юм.

Бүдэг бадаг байж болох өөр нэг чиглэл бол гадаадаас авч ажиллуулсан боловсон хүчний зардлыг дотоод үйл ажиллагааны зардалд оруулж тооцох явдал байдаг. Ийм зардал нь дотоодын холбогдох зардлаас хамаагүй өндөр байх талтай. Харин олон улсын компаниуд үндсэн цалингийн зардал ба бусад шууд зардал (тухайлбал, шилжин суурьшилтын, орон сууцны, нэмэлт боловсролын гэх мэт)-уудаас гадна үйл ажиллагааны зардлууд ба ашгийн элементийг оруулж тооцох болно. Дотоодын компанид иймэрхүү зардлын бүтэц ил харагдах нь ховор байдаг.

Шигтгээ 7.2: Татварын хөнгөлөлт

Засгийн газрууд заримдаа хөрөнгө оруулалтыг дэмжихийн тулд “татварын хөнгөлөлт” эдлүүлэхийг зөвшөөрдөг. Энэ нь хэдэн жилийн хугацаанд татвар огт ногдуулдаггүй, элэгдэл хорогдлыг чөлөөтэй тооцохыг зөвшөөрдөг, эхний хөрөнгө оруулалтыг төлөх татвараасаа бүхэлд нь суутган тооцож болдог хугацааны үе байдаг. Татварын хөнгөлөлтийг улс төрийн хувьд сөргөөр авч үзэх хандлагатай болсон учраас дэмжих нь багасаж байна. Шинээр үйл ажиллагаа явуулж буй уурхайн бэлэн мөнгөний урсгалд татварын хөнгөлөлтийн нөлөө тийм ч их биш байдаг нь тухайн уурхай тэртээ тэргүй эхний жилүүдэд алдагдалтай ажиллаж, ашгийн татвар төлж чаддаггүйтэй холбоотой.

Газрын тос, байгалийн хийн компаний хайгуулын зардлуудыг биет үйл ажиллагаатай нь холбоход хэцүү байдаг. Хайгуулын зардлуудын дийлэнх нь амжилтгүй ажиллагаанд зарцуулагддаг учраас ямар нэг биетээр харагдах зүйл байдаггүй. Иймээс хайгуулын зардлуудад хяналт тавьж удирдах хяналтын сайн системтэй байх шаардлагатай. Ийм зардлууд ихэвчлэн татвараас хасагдах зардал байдаг учраас тухайн компаний төлж байгаа татварын дүнд шууд нөлөөлдөг.

Шигтгээ 7.3: Татварын дэглэмүүд

ОУИТБС-д зөвхөн тухайн компани ба засгийн газрын тооцоолсон татварын тооцоо нийлж байхыг шаарддаг. Гэвч эдгээр тооцоололт нарийн төвөгтэй учраас тухайн компанид аудит хийсэн пүүс компаниуд тооцоог нь нягтлан шалгаж, тайлан нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн гэдгийг нотолсон эсэхийг оролцогч талуудын зүгээс асуух ёстой. Энэ нь уг тооцоонуудыг шалгаж байгаа хүний хувьд зөвшөөрөгдөх зардлуудыг хассан, тооцоо зөв хийгдсэн гэдэгт итгэлтэй байх нөхцлийг бүрдүүлдэг. Аливаа татварын систем дэх газрын тосны үйлдвэрлэлийн эхний жилүүдэд компаниуд газрын тос үйлдвэрлэхэд зарцуулсан хөрөнгө оруулалтын зардлаа бодитойгоор нөхөж эхэлдэг учраас засгийн газар нэг их орлого олохгүй гэдгийг ч бас оролцогч талууд ойлгодог байх хэрэгтэй.

Түүнчлэн ОУИТБС нь аливаа улсын татварын систем үнэ цэнийг дээд цэгт хүргэх, хөрөнгө оруулалтыг татах, эсхүл хяналт тавьж, мөрдөхөд илүү энгийн системүүд дөхөмтэй байж болох үүднээсээ тухайн улсад тохирох зөв систем эсэхийг олж харах үндэс суурь болдог.

Орон нутгийн орлогын татвар. Хөдөө орон нутагт ажиллаж байгаа компаниуд орон нутгийн засгийн газруудад шууд татвар төлөхийг улс орнууд (тухайлбал, Кыргызстан) шаардаж болно. Ийм татварууд нь цалингийн зардалтай холбоотой, эсхүл ашгийн татварын тодорхой хувь байж болно. Эдгээр зохицуулалт нь уул уурхайн ажиллагааны зарим үр шимийг орон нутагт нь хүртээхэд чиглэгддэг.

Хааяа уурхайн зүгээс нутгийн иргэдэд шууд бэлэн мөнгөн, эсхүл бэлэн бус хандивууд өгөх тохиолдол байдаг. Гэхдээ ийм хандив тусламжийг туйлын мэдрэмжтэй зохион байгуулах хэрэгтэй. Учир нь, уурхайн үйл ажиллагааг ажиллах хүч, ур чадвар, үйлчилгээгээр хангаж байгаа нутгийн иргэд эдгээр зохицуулалтын үр шимийг тэгш бус хүртэсний улмаас зөрчил мөргөлдөөн үүсгэж болох талтай. Саяхан Перу дахь алт олборлолтын томоохон ажиллагаанд ийм зүйл тохиолдож, орон нутгийн томоохон зөрчил маргаан төдийгүй зарим нэг хүчирхийлэл гарахад хүргэсэн билээ.

Хүн амын орлогын татвар. Хүн амын орлогын татварыг гадаадын удирдах ажилтнуудад ногдуулж болдог.

Нэмэгдсэн өртгийн татвар. Ихэнх орнууд 10-20 хувийн нэмэгдсэн өртгийн татвартай байдаг бөгөөд аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээнд үнэ өртөг нэмж байгаа үйл ажиллагаануудад ногдуулдаг. Эдгээр татвар засгийн газарт шууд хураагдах бөгөөд уул уурхайн салбарт бий болгосон эдийн засгийн үйл ажиллагаанд ч бас холбоотой байдаг.

Импортын ба экспортын татвар. Ихэнх орнууд дотоодын үйлдвэрлэлээ дэмжихийн тулд импортлогдсон бараа, бүтээгдэхүүнд импортын татвар ногдуулдаг. Заримдаа засгийн газарт нэмэлт орлого бий болгох зорилгоор экспортлогдсон бараа, бүтээгдэхүүнд ч татвар ногдуулдаг. Зарим орнууд хөрөнгө оруулалтын дотогш урсгалыг дэмжих үүднээс шинэ төслүүдийг эдгээр татвараас чөлөөлдөг байна.

Илүүдэл ашгийн татвар. “Илүүдэл ашгийн татвар”-ыг тухайн үйлдвэрийн ашигт ажиллагаатай холбож тодорхойлж болдог. Иймээс энэ татварыг зөвхөн хөрөнгийн өгөөж нь тодорхой, урьдчилан тодорхойлсон түвшнээс (тухайлбал, 20 хувь) хэтэрсэн төсөлд хэрэглэж болдог. Нөгөө талаас, бүх төслүүдийн ашигт “үндсэн татвар”-ыг ногдуулж болно. Цаашилбал, зөвхөн тодорхой төслүүдийн хэмжээ, байршлын өвөрмөц онцлогт тохируулсан татвар хэрэглэж болно. Энэ тохиолдолд ийм татварыг “тойруулан хашилт” гэж нэрлэдэг.

Папуа Шинэ Гвинейн жишээ

Папуа Шинэ Гвиней Улс нэмэлт ашгийн татвар бий болгох тал дээр тэргүүлэгч байж, хамгийн нарийн төвөгтэй системийн нэгийг авч хэрэглэсэн байдаг.

Салбар	Ашгийн татварын үндсэн хувь	НАТ-ын хувь
Уул уурхай	35%	35%
Нефть	50%	50%

Нэмэлт ашгийн татварыг “цэвэр мөнгөн орлого” эерэг гарах үед хэрэглэдэг. Өөрөөр хэлбэл, татвар ногдуулж болох орлогуудын дүнгээс зөвшөөрөгдөх хасалтуудыг хийсний дараахь ашиг нь төлсөн капиталын зарлага ба орлогын татвараас хэтэрч байгаа үед ногдуулдаг. (Эсрэг тохиолдолд тэдгээрийг урагшилуулан тооцож, валютын ханшны хэлбэлзэлд тохирууладаг байна.) Энэ нь ихэвчлэн хөрөнгө оруулалтын зардал нөхөгдсөний дараа НАТ эхэлдэг гэсэн үг юм. Үнэн чанартаа, ашгийн үндсэн татварыг хассаны дараа үлдэж байгаа ашигт (томъёонууд нь нарийн төвөгтэй) НАТ-ын хувийг хэрэглэдэг байна.

Гэнэтийн орлого ба татвар. Сүүлийн жилүүдэд Хятад, Энэтхэг улсын эдийн засаг өргөжин тэлж байгаатай холбогдон металлийн болон бусад бараа, түүхий эдийн үнийн огцом өсөлт гарах явцад олон компаниуд их хэмжээний ашиг олсон нь улс орнууд анх гэрээндээ заагаагүй байсан нэмэлт ашгийн татвар шинээр бий болгож ногдуулахад хүргэсэн юм. Эдгээр тохиолдолд заримдаа уг нэмэлт ашгийн татварыг “гэнэтийн ашгийн татвар” гэж нэрлэдэг байна. Энэ татварыг гэрээндээ оруулж байгаа улс орны тоо нэмэгдсээр байгаа бөгөөд татвар ногдуулж эхлэх цэгийг анхны хөрөнгө оруулалтын эргэн төлөлт, хөрөнгө оруулалтын өгөөжийн (ХОӨ) зөвшөөрөгдсөн хувь, бараа, түүхий эдийн суурь үнэтэй харьцуулсан түвшин, нийт ашиг зэргийг холбосон томъёогоор тодорхойлж байна. Энэ томъёог сайн томъёолсон тохиолдолд “гэнэтийн ашгийн” хуваарилалтад хоёр тал хоёулаа сэтгэл ханамжтай байх ёстой.

Ногдол ашигийн суутгалын татвар. Компаниуд нэг улсаас нөгөөд ногдол ашиг, эсхүл цэвэр ашиг шилжүүлэх үед нэмэлт ашгийн татварын нэг болох ноогдол ашгийн суутгалын татвар ногдуулж болно. Энэ татвар ихэвчлэн таваас арван таван хувийн хооронд байдаг. Зарим улс бусад орнуудтай давхар татварын гэрээтэй байдаг тул ногдол ашиг буюу ашигт хоёр удаа татвар ногдуулдаггүй. Үүний үр дүнд экспортлогч оронд төлөгдөх татварын хэмжээ буурах буюу татварыг бүр хүчингүй болгох талтай.

Шигтгээ 7.4: Төслийн үргэлжлэх хугацаан дахь татвар ногдуулалт

Ихэнх татварын хувь тогтмол байдаг буюу наанадаж үе үе засгийн газраас тодорхой хувиар өөрчлөн тогтоож байдаг. Гэвч улс орнууд нөөц баялгийнхаа ашиглалтын хугацааг сунгах үүднээс аливаа цооног буюу уурхайн нөөцийг аль болох бүрэн шавхаж авах сонирхолыг компаниудад төрүүлэхийг хичээдэг. Иймээс ашиглалтын зардал өндөр, үйлдвэрлэлийн хэмжээ бага байсан ч гэсэн үйлдвэрлэлээ үргэлжлүүлэн явуулах сонирхлыг татварын хувиар дамжуулан төрүүлэх нь элбэг. Энэ нь үнэ өндөр байхад засгийн газар илүү их орлого олохын тулд татварын хувиа өөрчилж болдог илүүдэл ашгийн татварын эсрэг үйлдэл юм. Зарим гэрээнд тухайн үйлдвэрийн ашигт ажиллагааг хэмждэг хөрөнгийн дотоод өгөөжийн түүхэн хүчин чадал (ХДӨ буюу ӨХ), эсхүл R/C харьцаа (гэрээлэгчийн нийт Шагнал/Өртөг зардлын харьцаа) буюу R хүчин зүйл гэх мэт шалгуур үзүүлэлтээс хамаарч татварын хувийг өөрчилж болдог байна.

Газрын тосны жишиг үнийн тухай санамж. Цөөнгүй тооны татварыг аливаа төслийн орлогод тулгуурлан тооцдог. Газрын тосны орлого нь газрын тосны үйлдвэрлэлийн хэмжээг газрын тосны үнээр үржүүлсэнтэй тэнцдэг. Хэдийгээр газрын тосны жишиг үнэ буюу тухайн үеийн үнийг нээлттэй нийтэлдэг (Брент, эсхүл Вест Тексас Интермидиэт гэх мэт) боловч аливаа улсаас экспортлосон түүхий нефтэд бодитойгоор төлсөн үнэ ихээхэн харилцан адилгүй байж болох юм.

Шигтгээ 7.5: Газрын тосны жишиг үнэ тогтоох

Янз бүрийн үнийг харьцуулан үзэж, татвар ногдуулалтын жишиг үнийг үндэслэлтэй тогтоосон эсэхийг шалгах хэрэгтэй.

Газрын тосны үнэд олон тооны хүчин зүйлс нөлөөлдөг. Хэдийгээр үнэ нь түүний API-н үзүүлэлттэй холбоотой байх хандлагатай байдаг боловч түүхий нефтийн бодит үнэ нь боловсруулах үйлдвэрт гарч буй бүтээгдэхүүнд тулгуурладаг (“боловсруулах үйлдвэрийн цэвэр гарцын үнэлгээ” гэж нэрлэдэг). Газрын тосны талбайг илрүүлсний дараа түүхий нефтийн дээжийг шинжилгээнд оруулдаг. Ингээд гарцад нь тулгуурласан үнэлгээ өгдөг. Үүний дараа тухайн бүтээгдэхүүний үнэ цэнээс боловсруулах үйлдвэрийн өртгийг (уг газрын тосыг бүтээгдэхүүн болгож боловсруулахад гарах зардал) хасна. Маш хүнд (газрын тосны элс шиг), эсхүл их хэмжээний хүхэр юмуу бусад хольцтой зарим газрын тосыг боловсруулж хэрэгтэй бүтээгдэхүүнээ гаргаж авахад өртөг зардал их шаарддаг байна. Бүтээгдэхүүн болгон хувиргахад хамгийн өндөр өртөгтэй аргууд шаарддаг эдгээр түүхий нефть нь боловсруулалтын зардал багатай хөнгөн чанарын түүхий нефтээс бага үнэтэй байдаг. Мөн газрын тосыг олборлолтын талбайгаас боловсруулах үйлдвэр рүү зөөх шаардлагатай учраас экспортын цэгийн үнийг гаргахдаа тээврийн зардлыг хасах бөгөөд энд ихэвчлэн түүхий нефтийг том хэмжээний тээвэрлэгч онгоцуудад ачдаг байна.

Хэрэв түүхий нефтийг хоолойгоор дамжуулан, ялангуяа Орос, Төв Азид байдаг шиг улс хоорондын хил дамнуулан түгээдэг бол нийлүүлэлтийн цэг буюу түүхий нефтийн хэмжээг татварын зорилгоор санхүүгийн талаас нь хэмждэг цэгүүдэд ирэх үнээс гаалийн тариф болон тээврийн бусад зардал хасагдах болно. Үнэ тогтоох цэгт түүхий нефтийн хэмжээг маш нарийн хэмждэг. Энэхүү цэг дээр түүхий нефтийн үнийг тогтоож, “Брент- баррель нь 1.50\$” гэх мэт байнга худалдагддаг түүхий нефтьтэй холбож өгөх болно.

Газрын тосны үнийг бодитойгоор тогтооход нөлөөлдөг, эсхүл зохистой үнэ тогтооход хэцүү болгодог бусад хүчин зүйлс ч байдаг. Хэрэв түүхий нефтийг харьцангуй бага хэмжээгээр үйлдвэрлэдэг бол түүнийг гуравдагч талуудад хэт өндөр үнээр буюу зах зээлийн бие даасан үнээр борлуулахад хэцүү байж болно. Хэрэв бүх түүхий нефтийг дотоодын боловсруулах үйлдвэрт борлуулах шаардлагатай бол мөн л олон улсын бодит үнэтэй тэнцэхүйц үнэ тогтооход хэцүү байж болзошгүй юм. Зарим орнууд түүхий нефтийн үнийг зах зээл дээр борлогдох үнээс албан ёсоор өндөр тогтоодог (ингэснээр татварын өөр нэг хэлбэрийг үр дүнтэй төлөөлж байдаг). Бусад оронд түүхий нефтийн үнэ мэдэгдэхээс нь өмнө борлуулж, дараа нь бусад түүхий нефтийн үнийн сагсад тулгуурлан үнэ тогтоодог (Оманд хэрэглэгддэг практик).

Хэрэв түүхий нефтийг чанарын хувьд өөр нефтьтэй холих болвол нэг бүрийнх нь үнийг яаж тооцох вэ? Оросод бол ихэнх түүхий нефть олон талбайн янз бүрийн чанартай нефтийн хольцоос бүрдсэн Уралын холимог байдлаар борлогддог. Одоогийн байдлаар тухайн системд орж байгаа илүү сайн чанарын нефтэд олгох нөхөн төлбөр, эсхүл арай чанар муутай түүхий нефтэд ногдуулах торгуулийн аль аль нь байхгүй байна.

Өөр нэг ярвигтай хүчин зүйл бол цаг хугацааны асуудал байж болох юм. Түүхий нефть түгээх цэгээс гараад урт хоолойгоор дамжин явах юм бол экспортын цэг хүрч борлогдохоосоо өмнө бас нэг хоёр долоо хоног зарцуулж магадгүй. Хэрэв энэ хугацаанд түүхий нефтийн үнэ өөрчлөгдөх юм бол түгээх цэг дээр ямар үнэ ашиглах ёстой вэ?

ГТҮК өөрийн нэрийн өмнөөс олборлож гаргасан түүхий нефтийн үнийг тогтоогч байж болно. Татвар ногдуулахад ашиглах үнэ нь нийтэд зарлагдсан үнээс стандарт хэмжээний ялгавартай (API-с хамаарч) байхаар тогтоогдож болно. Жишээлбэл, Нигерийн Засгийн газар түүхий нефтээ тогтоогдсон жишиг үнэд тулгуурласан үнээр борлуулдаг. Гэхдээ Нигерийн түүхий нефть үйлдвэрлэгчдэд татвар ногдуулахад ашигладаг үнэ нь уг үнээс доогуур байхаар ялгавартай тогтоогддог нь компаниудад ашигтай байдаг.

Энэ бүх асуудлыг гэрээнд зааж өгөх шаардлагатай бөгөөд ингэснээр газрын тосны үнийг хэрхэн тогтоох нь тодорхой болж, ялангуяа гуравдагч талын түншид экспортын борлуулалт тогтмол хийж чадахгүй үед чухал байдаг.

ОУИТБС-д холбоотой байдал. Зохих ёсны татвар (эсхүл нөөц ашигласны төлбөр) төлөгдснийг тогтоохын тулд аудитууд буюу нэгтгэн тулгагчид гэрээ бүрт газрын тосны жишиг үнэ ямар байхаар тохирсныг ойлгож мэдэх шаардлагатай.

7.2 Нөөц ашигласны төлбөр

Нөөц ашигласны төлбөр гэж юу вэ? Засгийн газраас хөнгөлөлт эдэлж байгаа үйлдвэрлэгчээс төлж байгаа мөнгөн дүнг нөөц ашигласны төлбөр гэж үздэг. Үүнийг тухайн нөөц баялгийг ашиглаж үйлдвэрлэл явуулж буй хувийн хэвшлийн, эсхүл төрийн өмчийн компани төлөх үүрэгтэй. Энэ нь орлогод суурилсан татвар боловч ямар орлогод татвар ногдуулах тодорхойлолт нь маш олон янз байж болно. Нөөц ашигласны төлбөрийг үйлдвэрлэсэн газрын тос, байгалийн хий, ашигт малтмалын хэмжээнээс олох нийт орлогын дүнд ногдуулж төлдөг бөгөөд уг орлогоос зардлын ямар нэг хасалт хийхгүйгээс гадна төсөл ашигтай ажиллаж байгаа эсэхээс үл хамаардаг. Мөн тухайн нөөц баялгийн нийт, эсхүл цэвэр борлуулалтаас тооцдог байж болох бөгөөд тухайн үйл ажиллагаа хэр ашигтай байгаагаас хамаарч гулсах хэмжээсээр өөрчлөгддөг байж болно. Эдгээрийн жишээг дор Хүснэгт 7.2-т үзүүлэв. Дүнг хууль тогтоомжид, эсхүл холбогдох лицензийн гэрээнд заасан томъёогоор тооцож болно. Ихэвчлэн олборлосон газрын тос, эсхүл ашигт малтмалын үнэ цэнийн тодорхой хувьд тулгуурладаг. Нөөц ашигласны төлбөр нь ихэвчлэн засгийн газрын орлогын нэг томоохон эх үүсвэрийг бүрдүүлдэг.

Шигтгээ 7.6: Газрын тосны нөөц ашигласны төлбөр-ОУИТБС-ын жишээ

Нигери Улсад газрын тосны хэмжилтийг цооногийн эхэнд, эсхүл хаа нэгтээ хийх эсэхийг хуулинд зааж өгөх асуудал маргаантай байна гэж ОУИТБС-ын аудитууд мэдээлжээ. Цооногоос гарч буй бүтээгдэхүүнийг нарийн хэмжихэд хэцүү байгаа нь тоог хэмжээг экспортын цэг дээр тодорхойлох практикт хүргэсэн бөгөөд энэ нь бүтээгдэхүүний тоо хэмжээг нарийн хэмжиж чадах хамгийн үр дүнтэй цэг байдаг оршино.

Ядаж хийсвэр утгаар нь авч үзсэн ч гэсэн нөөц ашигласны төлбөр бол газар эзэмшигч өөрийн талбайгаас үйлдвэрлэн гаргасан газрын тос, байгалийн хийнээс бэлэн бусаар хувь хүртэж байна гэсэн үг. АНУ гэх мэт улсуудад нөөц ашигласны төлбөрийг хувь хүмүүс ч төлж болох бөгөөд тэдгээр нь үндсэн хуулийнхаа дагуу газрын гадаргуу дээрх ба ба хөрсөн доорх баялгийг өмчлөх эрхтэй байдаг байна. Гэхдээ дийлэнх улс оронд газрын тос, байгалийн хийг төр засгаас гаргасан тусгай хууль тогтоомж, эсхүл олгосон тусгай зөвшөөрлийн дагуу олборлож болдог.

Шигтгээ 7.7: Газрын тосны нөөц ашигласны төлбөрийг тооцоолох нь

Газрын тосны бүтээгдэхүүнд төлдөг нөөц ашигласны төлбөрийн хэмжээ голдуу дараахи параметруудад тулгуурладаг:

- Тухайн үйл ажиллагаа явуулж буй компанийн талбай бүрийн үйлдвэрлэлийн тоо хэмжээ
- Талбай бүрийн API-н хүндийн хүч
- Үйлдвэрлэсэн газрын тосны зонхилох үнүүд
- Нөөц ашигласны төлбөрийн хувь (үнийн дүнгийн тодорхой хувь, эсхүл баррель тутамд ногдох хувиар тооцдог)

Хүснэгт 7.2: Нөөц ашигласны төлбөрийн төрлүүд

Нөөц ашигласны төлбөрийн төрөл (татвар тооцох суурь)	Энэ аргыг хэрэглэдэг орнууд (төлбөрийн хувийн жишээ)	Тайлбар
Борлуулалтын орлого	Гана 3%-12%	Үйл ажиллагааны харьцаанаас хамаарч янз бүрийн хувьтай (ерөнхийдөө, ашиг ба нийт орлогын харьцаагаар) 30% хүртэл: 3%-н нөөц ашигласны төлбөр 70%-с дээш:12%-н нөөц ашигласны төлбөр Энэ хооронд гулсах хуваарьтай
	Мозамбик Очир алмааст 8%-12% Бусад эрдэст 3%-8%	Уурхайн хэмжээнээс хамаарч хувийг тохиролцох боломжтой
	АНУ-ын Аризона муж 2%-аас багагүй	Коммиссараас тогтоодог
Борлуулалтын цэвэр орлого	Ботсвани Үнэт чулуунд 10% Үнэт металд 5% Бусад эрдэст 3%	
	Хятад Ашигт малтмалын нөөцийн нөхөн төлбөрийн хувь (янз бүр, нүүрсэнд 1%, алтанд 4% гэх мэт)	
Ашиг	Австралийн хойд нутаг дэвсгэр Цэвэр үлдэх ашгаас үйлдвэрлэлийн ба бусад зардлыг хасаад 18%	Австралын муж бүр өөрийн гэсэн нөөц ашигласны төлбөрийн хэмжээ тогтоодог
	Канадын Онтарио муж Ашгийн 10%	
Нэгжид суурилсан	Хятад (Юан/тонн мөнгөн дүнгээр)	Ашигт малтмал бүрээр хуульчлан заасан

Нөөц ашигласны төлбөр төлөлт. Нөөц ашигласны төлбөрийг бэлэн мөнгөөр, эсхүл бэлэн бусаар төлж болно. Хэрэв засгийн газар бэлэн мөнгөөр авах сонголт хийвэл компанийн бүх бүтээгдэхүүнээ борлуулаад түүндээ тулгуурлан нөөц ашигласны төлбөр төлдөг. Харин засгийн газар “бэлэн бусаар” төлүүлэх сонголт хийвэл, тухайлбал нийт үйлдвэрлэн гаргасан газрын тосныхоо нэг хэсгийг биетээр нь засгийн газрын төлөөлөгчид (гол төлөв тухайн орны газрын тосны үндэсний компанид) хүргүүлдэг. Засгийн газрууд дотоодын боловсруулах үйлдвэртээ түүхий эд хэрэгтэй үед, эсхүл дотоодын хэрэглэгчдийн хэрэгцээнд зориулах шаардлагатай үед газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийг бэлэн бусаар авах сонголт хийдэг. Хөнгөлөлтийн гэрээнд өөрөөр заагаагүй бол нийт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс (түүний дотор боловсруулах үйлдвэрт авсныг оруулаад) нөөц ашигласны төлбөр төлөх үүрэгтэй. Аль бүтээгдэхүүнд нөөц ашигласны төлбөр ногдуулахыг гэрээнд тодорхой зааж өгөх ёстой.

Нөөц ашигласны төлбөрийг ямар хэмжээгээр төлдөг вэ? Компаниуд гол төлөв “үйлдвэрлэж нөөцөлсөн” болон дараа нь зарж борлуулсан бүтээгдэхүүндээ

нөөц ашигласны төлбөр төлдөг. Цооногоос гаргаж авсан бүх нүүрстөрөгчийг нөөцөлдөггүй. Тэдний заримыг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх гэх мэт үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд өөрт нь зарцуулна. Ууршилт, асгаралт, тэр ч бүү хэл үйлдвэрлэлийн явцад хулгай гарснаас зарим нь алдагдана, иймээс цооногт үйлдвэрлэн гаргасан хэмжээгээр нөөц ашигласны төлбөр төлдөггүй⁵⁸. Түүнчлэн цооногоос гарч байгаа бүтээгдэхүүнийг гаргаж ирэх даруйд нь хэмжихэд туйлын хэцүү байдаг. Яагаад гэвэл, олон шаттай урсгалын явцад газрын тос, хий, ус тодорхой хувь хэмжээгээр холилдон гардаг бөгөөд найрлага нь байнга тогтвортой байдаггүй. Голдуу 0-100 хувийн хооронд нефтийн агууламж бүхий хольц гарч ирдэг. Нэгэнт газрын тосыг тогтворжуулсны дараа (усыг нь ялгаж, хийг нь хий цуглуулах системд оруулан нягтруулж, эргээд хадгалах саванд буцааж шахах, эсхүл шатаах замаар) газрын тосны хэмжээг ялган хэмжиж болдог. Энэ шатанд хийгдэх хэмжилт маш нарийн зөв байдаг. Ийнхүү ялгаж хэмжсэн түүхийн нефтэд тулгуурлан нөөц ашигласны төлбөрийн тогтоож болно⁵⁹.

Уул уурхайн салбарт тулгардаг гол асуудал бол ашигт малтмалууд нэг дор холилдон байрлах явдал байдаг. Аливаа компани очир алмаас, эсхүл зэс олборлох лицензтэй, эдгээр ашигт малтмалд тодорхой хувийн нөөц ашигласны төлбөр төлөхөөр тохирсон байж болно. Хэрэв олборлолтын явцад өөр нэг ашигт малтмалыг (тухайлбал, алт) бага боловч нилээдгүй хэмжээгээр олборлосон бол түүндээ ч бас нөөц ашигласны татвар төлөх ёстой. Иймээс бусад ашигт малтмалын үйлдвэрлэлийг шалгаж, төсөв санхүүгийн дэглэмдээ өөр төрлийн ашигт малтмалд ялгавартай хувиар нөөц ашигласны төлбөр төлүүлэх заалт оруулах нь зүйтэй.

Тогтмол хувь. Улс орнууд нөөц ашигласны төлбөр ногдуулах олон янзын хувилбарын аргууд хэрэглэдэг. Зарим улс нөөц ашигласны төлбөрөө тогтмол хувьтай тогтоосон байдаг. Иймээс үйлдвэрлэсэн газрын тос, байгалийн хийгээ борлуулснаас олсон орлогын тогтмол хувийг нөөц ашигласны төлбөрт авдаг. Нөөц ашигласны төлбөрийн бодит түвшин улс орон бүрт нилээд харилцан адилгүй байж болно (тухайлбал, Европ, Ойрхи Дорнодын олон оронд газрын тос үйлдвэрлэгчдэд ногдуулдаг төлбөрийн ердийн хувь 12,5 хувь байдаг бол бусад орнуудад 30 хүртэл хувь байдаг).

Уул уурхайн салбар дахь нөөц ашигласны төлбөрийг, алтны борлуулалтын үнэд таван хувийн, зэсийн борлуулалтын үнэд хоёр хувийн нөөц ашигласны төлбөр гэх мэтээр нийт борлуулалтад ногдох хувь хэлбэрээр тогтоож болдог. Жишээлбэл, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тодорхой нэг ашигт малтмалын тонн тутамд 1\$, өөр нэг ашигт малтмалын тонн тутамд 2\$-р ногдуулж болох юм. Зохицуулалтуудад ашигт малтмал бүрт хэрэглэх төлбөрийн хувийг хүснэгтлэн харуулсан байдаг. Тонн тутамд ногдох мөнгөн дүнг заасан зохицуулалтууд хурдан хоцрогддог талтай (инфляцийн нөлөөгөөр).

Хувьсах хувь. Зарим улсын нөөц ашигласны төлбөрийн хувь хувьсах чанартай буюу тухайлбал, үйлдвэрлэл нэмэгдэхэд дагаж нэмэгдэхээр заасан байдаг. Нөөц ашигласны төлбөрийн хувь ба үйлдвэрлэлийн хэмжээ, бусад параметруудийн нарийн уялдааг гэрээ бүрт тодорхой зааж өгсөн байна.

Нигерийн жишээ

Нигери Улс эх газарт буюу эрэг орчимд байрлах газрын тосны талбайнууддаа 20 хувийн нөөц ашигласны төлбөртэй байдаг. Эргээс цааших талбайнуудын

хувьд нөөц ашигласны төлбөрийн хувь буурч, гүехэн устай (0-100 метр) газар 18,5 хувь, 800-1000 метрийн гүнтэй усанд 4 хувь болох ба 1000 метрээс дээш гүнтэй усанд олборлолт явуулбал төлбөр ногдуулдаггүй байна. Энэхүү ялгавартай байдал нь гүн усанд өрөмдлөг хийх эдийн засгийн зардал өндөр байдаг, хэдийчинээ гүн усанд хайгуул хийх тусам тухайн компанид эрсдэлтэй байдагтай холбоотой.

Ганагийн жишээ

Гана Улсад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нь бүтээгдэхүүнд суурилсан татвар байдаг бөгөөд тус улсын Ашигт малтмал, уул уурхайн тухай хуулийн дагуу ногдуулдаг. Уг хуулинд ашигт малтмалын лиценз эзэмшигчийн олсон нийт орлогын гурваас зургаан хувь хүртэлх хэмжээгээр нөөц ашигласны төлбөр төлүүлэхээр заасан байдаг. Энэ хувь нь тухайн үйлдвэрийн газрын ашигт ажиллагаанаас хамаардаг. Ашигт ажиллагааг үйл ажиллагааны харьцаагаар тодорхойлдог бөгөөд энэ нь олборлосон ашигт малтмалын нийт үнэ цэнэ ба үйл ажиллагааны ашгийн түвшин хоорондын харьцаа байдаг. Үйл ажиллагааны ашгийн түвшин гэдэг нь нийт олборлосон ашигт малтмалын үнийн дүнгээс үйл ажиллагааны зардлыг хассантай тэнцүү байна. 2004 оны байдлаар бүх компани гурван хувийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлсөн байна.

Зарим орнууд нөөц ашигласны төлбөрт суурилсан схем ашиглаж ирсэн түүхэн уламжлалтай боловч удалгүй энэ практикаа орхисон байдаг. Жишээлбэл, Их Британи улсад 12,5 хувиар тогтоосон байсан нөөц ашигласны төлбөрийн схемээ Умард Хойд тэнгист ашиглаж байсан газрын тосны талбайдаа 1982 оноос, Өмнөд Хойд тэнгис дэх байгалийн хийн талбайдаа 1988 оноос эхлэн хэрэглэхээ больсон байна. Харин түүнээс өмнө ашиглаж эхэлсэн талбайнуудын хувьд нөөц ашигласны төлбөрийн схемээ хэвээр үлдээгээд байна.

Бэлэн бус төлбөр. Нөөц ашигласны төлбөрийг “бэлэн бусаар” төлж болох бөгөөд засгийн газар БХГ-нүүдийн дагуу тухайн бүтээгдэхүүний тодорхой хувийг авах эрхтэй байж болно. АНУ, Конго, Анголд нөөц ашигласны төлбөрийг бэлэн бусаар төлж болдог. Ер нь, газрын тос, байгалийн хийн салбарт шагналыг хуваарилах үүднээс иймэрхүү бүтээгдэхүүн хуваалтыг ашигладаг. ОҮИТБС-ын хувьд анхаарах гол асуудал бол:

- Түүхий нефть, эсхүл хийг хэрхэн борлуулж байгаа байдал
- Үнэ тогтоох, бүтээгдэхүүнээ хэнд борлуулахаа сонгох журмууд
- Бүтээгдэхүүнийг борлуулсны дараа тухайн мөнгө засгийн газарт хэрхэн орж ирэх вэ гэдэг асуудал байдаг.

Дотоодод нийлүүлэх үүрэг. Гэрээнд заримдаа тодорхой хэмжээний газрын тосыг дотоодын зах зээлд нийлүүлэхийг шаарддаг. Энэ газрын тосыг ихэвчлэн олон улсын үнээр борлуулдаг боловч зарим гэрээнд нэг хэсгийг нь арай бага үнээр нийлүүлэх талаар заасан байдаг. Үүнийг хямдруулсан үнээр дотоодод нийлүүлэх үүрэг гэж нэрлэдэг бөгөөд энэ утгаараа орлогод ногдуулах татварын үүргийг гүйцэтгэж байдаг. Жишээ нь, Индонезийн зарим БХГ-нд гэрээлэгч эхний таван жилд үйлдвэрлэсэн газрын тосныхоо зах зээлийн үнийг бүрэн авахаар заасан байдаг. Энэ хугацаа өнгөрсний дараа, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний 25 хувийг зах зээлийн үнээс 10 хувь хямдруулан засгийн газарт борлуулах шаардлагатай байдаг. Эцсийн дүндээ үйлдвэрлэгч компанийн бий болгож буй орлого багасах (зах зээлд арай бага хэмжээний бүтээгдэхүүн борлуулж байгаа учраас) тул төлөх нөөц ашигласны төлбөр нь ч бас багасдаг байна.

7.3 Бонус

Гарын үсгийн бонус. Компани тендер шалгаруулалтад ялж гэрээг авсан, эсхүл талууд гэрээ байгуулж гарын үсэг зурсан үед тухайн компани засгийн газарт гарын үсгийн бонус төлдөг. Энэ нь гэрээнд заасан хууль ёсны зардал бөгөөд гол төлөв татвараас хасагдах, БХГ-гээр нөхөж болох зардал байдаг. Энэхүү бонус нь тухайн талбайгаас олохоор төлөвлөсөн орлогоос хамаарч хэдэн зуун мянган доллараас 100 сая доллар хүртэл янз бүрийн хэмжээтэй байж болно. Гарын үсгийн бонус нь нэн тэргүүнд орох орлогын эх үүсвэр бөгөөд тухайн үйлдвэрийн газрын ажлын амжилтаас үл хамаардаг.

Нээлтийн бонус. Компани ямар нэг орд газар олж нээсэн үед засгийн газарт нээлтийн бонус төлж болдог.

Үйлдвэрлэлтийн бонус. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт эхлэх буюу өдрийн үйлдвэрлэлийн хэмжээ тодорхой түвшинд хүрэх үед үйлдвэрлэлтийн бонус төлж болно. Энэ нь татвараас хасагдах, эсхүл нөхөж болох зардал байх ёстой. Энэ бонусын нөхцлийг тухайн засгийн газартай байгуулсан гэрээний зохицуулалтаар зааж өгдөг. Энэ төлбөр нь БХГ-ний үед гарч ирэх хандлагатай байдаг боловч хөнгөлөлтийн гэрээнд ч энэ талаар заасан байж болно.

7.4 Ногдол ашиг

Ногдол ашгийн төлбөр бол ашиглалтын компанийн хувьцаа эзэмшигчдэд өгч буй ашиг хуваарилалт юм. Засгийн газар ашиглалтын компанийн үйл ажиллагаанд жинхэнэ хувьцаа эзэмшигчээр оролцож байгаа тохиолдолд ногдол ашиг авах эрхтэй болдог. Засгийн газарт төлж буй ногдол ашгийн төлбөр бол ашиг орлогын нэг урсгал бөгөөд ОУИТБС-ын тайланд оруулж тайлагнах ёстой. Ногдол ашиг тодорхойлох, төлөх журмыг тухайн улсын компаний тухай хууль, эсхүл дотоод журам, аль эсхүл компанийн өөрийн дүрэм ба байгууллагын бусад баримт бичгээс олж авч болно.

Шигтгээ 7.8: Ногдол ашиг төлөлт

ОУИТБС-д зөвхөн ногдол ашгийн төлбөрийг засгийн газрын хүлээн авсан орлоготой тулгаж үзэхийг шаарддаг боловч зарим орнууд уг ногдол ашгийг зохих хугацаанд нь төлж байгаа эсэх, засгийн газар хамтарсан үйлдвэрийн хувьцааныхаа ашгийг дахин хөрөнгө оруулахаар шийдсэн эсэхийг нарийн тодорхойлохыг хүсч болно. Түүнчлэн ногдол ашиг төлөх хугацааг тодорхойлж, тухайн ногдол ашгийг ямар цэгт ашиг орлого гэж үзэхийг тодорхойлох шаардлагатай. Тухайн үед гарч болох боломжууд гэвэл:

- Цаад ашгийг нь хүртсэн байх;
- Ногдол ашгийг захирлууд нь тодорхойлдог байх;
- Ногдол ашгийг хувь эзэмшигчдийн хурлаар баталдаг байх;
- Ногдол ашгийг бодитойгоор төлсөн хугацаа зэрэг юм.

Ердийн шийдэл бол тухайн ногдол ашиг төлөгдсөн үед ашиг орлогын урсгал гэж үзэх явдал юм. Гэхдээ үүнтэй адил хүчинтэй бусад боломжууд байж болох юм. Жишээлбэл, ногдол ашиг нь батлагдсан боловч түүнийгээ төлөхийг засгийн газраас шаардаагүй байсан байж болно. Хэрэв засгийн газар компанийн шинэ үйл ажиллагаанд хөрөнгө оруулж капиталжуулах үүргээ энэ ашгаар дарж байгаа тохиолдолд ийм зүйл тохиолдож болно. Энэ тохиолдолд (1) ногдол ашгийн төлөлт, (2) (үүнтэй адил бөгөөд эсрэгээр нь) засгийн газраас шинэ хөрөнгө оруулалт хийсэн гэсэн хоёр тусдаа гүйлгээ хийгдсэн байна гэж үзэж болох юм. Хэрэв ийм нөхцөл байдал үүссэн, тэр нь нилээд хэмжээний хөрөнгөтэй холбоотой тохиолдолд ООТБ аудиторуудтай зөвлөлдөж, яаж тайлагнахаа тохирох хэрэгтэй.

7.5 Эзэмших эрхийн түрээсийн төлбөр

Түрээсийн төлбөрийг талбай ашиглах эрхтэй холбогдуулан төлдөг бөгөөд нэг бол түрээс, эсхүл лиценз байж болдог.

Нигери Улсад олгодог газрын тосны хайгуулын лицензийн хувьд жилд төлвөл зохих түрээсийн төлбөрийг тухайн лицензтэй газрын шоо километрээр хэмжигдэх талбайн хэмжээг нэг шоо километр төлвөл зохих жилийн түрээсийн төлбөрөөр үржүүлж тооцдог. Жилд төлвөл зохих түрээсийн төлбөр нь тухайн газрын байршлаас хамаарч янз бүр байж болно.

Зохицуулагч байгууллагын зүгээс тухайн компанийн төлвөл зохих түрээсийг мэдэгдэх ёстой. Компани харин заасан ёсоор холбогдох дансанд төлбөрөө шилжүүлэх ёстой.

Мөн лицензтэй холбоотой дараахи нэмэлт хураамжийг төлөх үүрэгтэй байдаг.

- Жилийн түрээсийн төлбөр
- Лицензийн өргөдлийн хураамж
- Боловсруулалтын хураамж
- Шинэчлэх өргөдлийн хураамж
- Буцаах өргөдлийн хураамж
- Шилжүүлэх өргөдлийн хураамж
- Цуцлах өргөдлийн хураамж

Эзэмших эрхийн түрээсийн төлбөрүүдийг эрх авсны жилийн ой дээр, эсхүл урьдчилж төлж болдог. Ихэнх тохиолдолд түрээсийн төлбөрүүд ба холбогдох хураамжийн хэмжээ нь олборлох үйлдвэрлэлээс засгийн газрын олж байгаа нийт орлогын дүнтэй харьцуулахад ач холбогдол багатай байдаг.

7.6 Шууд бус үр өгөөж

Компаниуд ба засгийн газрууд тухайн оронд үйл ажиллагаа явуулж байгаагийн эдийн засгийн үр өгөөжид (тухайлбал, шинээр ажлын байр бий болгох, зам, эрчим хүчний хангамж гэх мэт дэд бүтцэд) анхаарлаа хандуулах нь элбэг байдаг. Гэхдээ ОУИТБС-д олборлох үйлдвэрлэлээс тухайн оронд орж байгаа ашиг орлогын шууд бус урсгалыг тайлагнахыг шаарддаггүй.

Харин аливаа улсын хүлээн авч буй шууд бус үр өгөөж ба бодитойгоор төлсөн “орон нутгийн татвар” хоёрын ялгаж өгөх нь зүйтэй. Жишээлбэл, компани лиценз эзэмших нөхцөлд үйл ажиллагаа явуулж буй газрынхаа ойролцоо сургууль барьж ажиллуулах шаардлага тавьсан бол түүнийг тухайн улсын хүртэж буй үр өгөөж гэж үзэх ёстой юу? Хэрэв тендерт оролцогч уул уурхай, газрын тос, эсхүл байлгалийн хийн орд газар эзэмших давуу эрх авсныхаа хариуд хурдны зам, төмөр зам гэх мэт томоохон төслүүд хэрэгжүүлэхээр тохирсон бол ООТБ тухайн улс үндэстэн энэ наймаанаас багагүй мөнгө олж байгаа эсэхийг үнэлэх үүднээс тухайн хандивын үнэ цэнийг мэдэж авахыг хүсч болно. Хэрэв уул уурхайн ашиглалтын компаниас гэрээнд заагаагүй төлбөрийг муж, эсхүл орон нутгийн иргэдэд төлж байгаа бол хэдийгээр энэ төлбөр нь нийт ашиг орлогын урсгалтай харьцуулахад бага төдийгүй материаллагт тооцогдохооргүй байсан ч гэсэн хэдий хэр хэмжээтэй болохыг нь орон нутгийн оролцогч талууд

мэдэхийг хүсч болно. ОУИТБС-ын дагуу ООТБ-үүд хэрэгцээ шаардлагадаа тохирох ямар ч нөхцлийг хүлээн авахуйц уян хатан байдаг.

Шууд бус үр өгөөжийг шалгаж тогтоох. Компаниас орон нутгийн иргэдэд шууд төлж буй төлбөрүүд ба бусад шууд бус үр өгөөжийн үр шимийг хүртэгчид голдуу өргөн хүрээтэй тархсан байдаг учраас шалгаж тогтооход хэцүү байдаг. Уг санхүүжилтийг ганцхан газар хүлээж аваагүй учраас төлөгчийн мэдүүлсэн дүнг нотлох ямар нэг практик механизм байхгүй байж болно. Эдгээр үр өгөөжийг сайн дураар тайлагнах нь ч бас эрсдэлтэй. Тухайн үр өгөөжийг үнэ өртгийг тооцох ажиллагаа субъектив шинжтэй байж болохоос гадна мэдүүлсэн зардалдаа түүнтэй холбоотой үйл ажиллагааны зардлуудыг оруулсан байж болно. ООТБ эдгээр дүнг нийтэлснээр үр дүнтэй шинжилж, тулган үзэж болохгүй үр өгөөжийг баталгаажуулсан буюу итгэл үзүүлсэнд тооцогдож болох юм. Хэрэв эдгээр үр өгөөжийг тайлагнахыг зөвшөөрсөн буюу шаардсан тохиолдолд тэдгээрийг бүх компани тайлагнадаг болгох, мөн материаллаг тохиолдолд зохих ёсоор шалган тогтоох боломжтой байхын тулд нягтлан бодох бүртгэлийн ба тайлагналтын хангалттай дүрэм журмууд бий болгох шаардлагатай болно. Барилга байгууламж барихад зориулсан засгийн газрын зээл гэх мэт шууд бус үр өгөөжийг хэрхэн үнэлэх тухай нэмэлт хэлэлцүүлгийг Хавсралт 3-гээс үзнэ үү.

7.7 Хамтад нь авч үзэх нь

6 дугаар бүлэгт бид гэрээний янз бүрийн төрлүүдийн талаар авч үзсэн. Харин бид энэ бүлэгт засгийн газрууд эдгээр гэрээний дагуу мөнгө авдаг янз бүрийн арга замын талаар авч үзээд байна. Улс орнуудын хооронд болон дотоодод асар олон янзын ялгаа байдаг. ОУИТБС-ыг хэрэгжүүлдэг тохиолдол бүрт оролцогч талуудын зүгээс ашиг орлогын ямар урсгалууд явагдаж байгаа, аль нь материаллаг болохыг мэдэхийн тулд хүлээн авагч засгийн газрын зохицуулагч байгууллага юмуу газрын тосны үндэсний компани, дотоодод үйл ажиллагаа явуулж буй компаниуд, эсхүл аль алианаар нь төрөл бүрийн гэрээнүүд ба засгийн газрын авах хувийн янз бүрийн хэлбэрийн талаар товч мэдээлэл хийлгэх зайлшгүй шаардлагатай байх болно. Засгийн газар газрын тос, байгалийн хий, ашигт малтмалын олборлолт явуулахын тулд гадаадын компаниуд хөлслөн ажиллуулж байгаа тохиолдолд компаниуд гэрээний дагуу энэ мэдээллээ хувийн нууцад байлгах шаардлагаас засгийн газар түр татгалзах хэрэгтэй болж болно. Ийм учраас, энэ мэдээлэл нийтэд зориулагдаагүй тохиолдолд засгийн газраас компаниудыг урьж ирүүлэн гэрээнийх нь талаар товч мэдээлэл авах нь зүйтэй. Гадны шинжээч нар уг мэдээллийг хөтлөн явуулахад тусалж болох боловч хүлээн авагч засгийн газар ба холбогдох компаниудын төлөөлөгчдөөс өөр тухайн гэрээний зохицуулалтуудын нарийн ширийнийг сайн мэдэх хүн үгүй билээ.


Энэ хэсэгт бид газрын тос, уул уурхайн салбар дахь олон янзын байдлыг авч үзэх бөгөөд мөн эдгээр ялгаа байгалийн хийн үйлдвэрлэл ба шингэрүүлсэн байгалийн хий (ШБХ)-н үйлдвэрлэлд хэрхэн харагдаж байгааг жишээгээр авч үзье:

Уул уурхайн жишээ

Гана Улсын уул уурхайн салбарын жишээнээс засгийн газруудын орлого олдог олон арга зам харагдаж байна. Гана Улс аж ахуйн нэгжийн орлогын татвар (цэвэр ашгийн 25%), нөөц ашигласны төлбөр (ашигт ажиллагаанаас хамаарч

3-6 хувь), ногдол ашиг (эзэмшигч бүрийн хувьцааны 10%), дээр нь хайгуул шинжилгээний хураамж, уурхайн түрээс, газрын хөрсний түрээс болон бусад хураамж ногдуулдаг. 2005 онд Гана Улсын уул уурхайн компаниуд хууль ёсны төрөл бүрийн төлбөрт нийт 185 сая ам.доллар төлсөн байна. Задаргааг Зураг 7.1-д үзүүлэв.

Зураг 7.1: Гана Улсын уул уурхайн салбар дахь хууль ёсны төлбөрүүдийн ангилал



Шигтгээ 7.9: Засгийн газар ба арилжааны харилцааны хэлбэрүүд

Байгалийн баялгийн ашиглалтад оролцож буй засгийн газар ба бизнесийн компаниудын гэрээний харилцааны хэлбэр, гэрээний тусгай нөхцлүүд нь аливаа улсын ОҮИТБС-ын хэрэгжилтэд дараахь байдлаар шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг:

Шинжилгээ хийх санхүүгийн урсгалууд: Аудитлагдах ашиг орлогын урсгалууд нь хөнгөлөлтийн гэрээний дагуу төлөх татвар ба нөөц ашигласны төлбөрүүдээс эхлээд бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу засгийн газарт нийлүүлэх газрын тос хүртэл олон янз байж болно.

Аудитын гол асуудал: ОҮИТБС-ын аудитын гол асуудлууд нь: (1) компаниуд татвар ба нөөц ашигласны төлбөрт төлсөн, тэдгээрийг тухайн засгийн газар хүлээн авснаа нотолсон эсэх, (2) БХГ-ний дагуу нийлүүлсэн газрын тосны хуваарилалт зөв байсан эсэх, (3) Засгийн газар газрын тосны эзэмшил хувиараа юу хийсэн, энэхүү газрын тосны борлуулалтаас олсон санхүүгийн ашгийг юунд зарцуулсан эсэхийг шалгаж тогтоох явдал байна.

Нэмэлт асуудлууд: Засгийн газар удирдлага зохицуулалт, хяналтынхаа үүргийг үр нөлөөтэй биелүүлж байгаа эсэхийг бүрэн дүүрэн үнэлэхийн тулд санхүүгийн гүйлгээнүүдийг илүү нарийвчилсан түвшинд үнэлэх зайлшгүй шаардлагатай байдаг бөгөөд үүний тулд: (1) компаниуд төлбөрөө цаг тухайд нь төлж байгаа эсэх, (2) мөнгөн дүнг нь зөв тооцсон эсэх, (3) компаниудаас газрын тосны үндэсний компанид төлсөн мөнгийг Газрын тосны үндэсний компани эргүүлээд төрийн санд цаг тухайд нь, үнэн зөв тушаасан эсэхийг тодорхойлох шаардлагатай.

Газрын тосны жишээ

9 дүгээр бүлгийн Хайрцаг 9.1-т үзүүлсэнчлэн нэг улсад хөнгөлөлтийн гэрээний болон БХГ-ний аль аль нь байж болох төдийгүй ашиглалтын талбай бүрт өөр өөр хувь хэмжээтэй байж болдог байна. Нигерийн газрын тосны хөнгөлөлтийн болон БХГ-нүүдээс үзэхэд хамтарсан үйлдвэр бүр бүтээгдэхүүнээ харилцан адилгүй хуваарилсан, хөнгөлөлтийн гэрээтэй хамтарсан үйлдвэрүүдэд ногдуулсан нөөц ашигласны төлбөрүүд усны гүнээс хамааралтай байгаа нь харагдаж байна. Түүнчлэн Нигерийн харьцангуй саяхан байгуулсан БХГ-нүүд үр дүнгээ өгч эхлээгүй учраас засгийн газрын ба компаний эзэмшил хувь (гэрээний дагуу тухайн компанид зөвшөөрөгдсөн зардал нөхөх хэмжээнээс хамаарна) хараахан тодорхой болоогүй байна.

Байгалийн хийн хувьд өөр үү? Байгалийн хийн олборлолт, үйлдвэрлэлтийн төсөв санхүүгийн зохицуулалт газрын тосныхтой тун төстэй боловч холбогдолтой ба холбогдолгүй хийг боловсруулахад өөр өөр нөхцөл хэрэглэх нь олонтаа байдаг. Холбогдолгүй хийн хувьд нэмэлт боловсруулалт хийж, зохих зах зээлийг олоход илүү их хугацаа шаарддаг байна. Байгалийн хийг хөнгөлөлтийн гэрээ, бүтээгдэхүүн хуваах гэрээ, эсхүл ашгийн түвшний зохицуулалтын дагуу боловсруулан ашиглаж болдог. Засгийн газрууд байгалийн хийн үйлдвэрлэлээс авах хувиа татвар, нөөц ашигласны төлбөрийн хэлбэрээр олж авахаас гадна байгалийн хийн хоолойг газар нутгаараа дамжуулан өнгөрүүлэхийг зөвшөөрөх замаар хураамж авдаг байна.

Шигтгээ 7.10: Байгалийн хийн үйлдвэрлэл дэх төсөв, санхүүгийн зохицуулалтууд

Газрын тосны үйлдвэрлэлтэй ижил төстэй нь, байгалийн хийн үйлдвэрлэлтэй холбоотойгоор засгийн газарт ордог ашиг орлогын гол урсгал бол хөнгөлөлтийн гэрээтэй нөхцөлд татвар, нөөц ашигласны төлбөр, харин БХГ-тэй нөхцөлд хийн ашгийн төлбөр буюу нийлүүлэлт байдаг. Энд тавигддаг аудитын гол асуудлууд бол компаниуд төлбөрийг цаг тухайд нь төлж байгаа эсэх, зохих хууль тогтоомж, зохицуулалтуудыг мөрдөж байгаа эсэх, хийн зардлын ба ашгийн үнэлгээг зөв хийж ирсэн эсэхтэй холбоотой байдаг.

Шингэрүүлсэн байгалийн хий. Орон нутгийн зах зээл байхгүй, хангалттай хэмжээний холбогдолгүй хийн орд нээж илрүүлсэн тохиолдолд засгийн газрууд шингэрүүлсэн байгалийн хий (ШБХ)-н үйлдвэр барьж, хийг тусгай зориулалтын ШБХ тээвэрлэгчээр шингэн байдлаар экспортлох боломжийг авч үзэх болно. Энэ тохиолдолд үйлдвэрлэлийн өмнөх ба дараахи шатны ШБХ-н тоног төхөөрөмжүүдэд шаардагдах хөрөнгө оруулалт 3-7 тэрбум ам.доллар байдаг учраас засгийн газрууд ихэвчлэн тухайн үйлдвэрт хувь эзэмших замаар нэмэлт орлогын урсгал бий болгодог байна. Жишээлбэл, төрийн эзэмшлийн хувь КатарГаз ба РасГаз-н 65-70 хувь, ОманШБХ-н 51 хувь, НигериШБХ-н үйлдвэрийн 49 хувь байдаг. Шинэ үйлдвэрүүдэд засгийн газар илүү их хувь эзэмших ерөнхий хандлагатай байна. Тухайлбал, Оман Калхат ШБХ-н үйлдвэрийн 75 орчим хувийг төр эзэмшиж байна. Засгийн газрын эзэмшил хувь нь ихэвчлэн гадны санхүүжилттэй байна.

ШБХ-ийн үйлдвэрийн хувьд орлогын урсгалууд нь нарийн төвөгтэй байж болно. Үйлдвэрлэлийн өмнөх шатны түүхий эд үйлдвэрлэгчид олборлосон хийгээ ШБХ-н үйлдвэрүүдэд борлуулж, тэндээс олсон орлогоосоо төсөв санхүүгийн янз бүрийн зохицуулалтын дагуу татвар төлдөг. Үйлдвэрлэлийн

өмнөх болон дараахи үйл ажиллагаанууд ихэвчлэн тусдаа байдаг хэдий ч Катарт бүрэн нэгтгэсэн байдлаар явуулдаг. ШБХ-н борлуулалтаас боловсруулалтын ба тээврийн зардлуудыг хассаны дараа ашиг гарах бөгөөд дараа нь түүнээс татвар тооцдог байна. ШБХ-ийн үнэ газрын тосны үнэтэй уялдаатай байх хандлагатай байдаг. Шингэрүүлэлтийн явцад гардаг үнэ цэнэтэй дагавар бүтээгдэхүүн бол байгалийн хийн шингэн (БХШ) ба баяжмалууд байдаг бөгөөд эдгээр бүтээгдэхүүнээс олсон ашигт ч татвар ногдуулдаг. Зарим улсад (тухайлбал, Катар) БХШ-д нөөц ашигласны татвар ногдуулдаг. Хэрэв засгийн газар, эсхүл засгийн газрын байгууллага тээвэрлэгч савнуудыг эзэмшдэг бол тарифийн, эсхүл түрээсийн орлого олж болно. Засгийн газар ямар нэг ШБХ-ийн төсөлд хувь эзэмшиж байгаа бол төслийн орлого, эсхүл ногдол ашгийн урсгалаас хувь хүртэх эрхтэй байх болно. Мөн гадны санхүүжилттэй тохиолдолд засгийн газарт төсөл санхүүжүүлэх зардал гарахаас гадна татварын хөнгөлөлт ч (зарим тохиолдолд 10 жил хүртэл) үзүүлэх нь элбэг.

Шигтгээ 7.11: ШБХ-н төслүүдийг үнэлэх нь

ШБХ-н төсөл бүр давтагдашгүй бүтэц зохион байгуулалттай байдаг. ОУИТБС-ын хувьд анхаарах гол асуудал бол холбогдох орлогын урсгалыг тогтоох, төлсөн төлбөр ба хүлээн авсан орлогууд нь төрөл бүрийн гэрээний дагуу, үнэн зөв хийгдсэн байх нөхцлийг бүрдүүлэх явдал юм.

Зарим тохиолдолд улс орнууд нутаг дэвсгэр дээгүүрээ газрын тос, байгалийн хийн хоолой тавиулсны хураамжаар орлого олж болдог. Транзитын хураамж хэмээх энэ төлбөр нилээд хэмжээтэй байж болно. Жишээлбэл, Баку-Тбилис-Цейханы газрын тосны хоолой Турк хүрэхээсээ өмнө Азербайжан, Гүрж улсуудыг дамжин өнгөрдөг. Гүрж Улс уг газрын тосны үйлдвэрлэгч ч биш, хүлээн авагч ч биш боловч тус улсаар дамжин өнгөрч байгаа баррель нефть бүрээс хураамж авч байдаг. Хэрэв газар нутгаар нь хоолой дамжин өнгөрч байгаа бол хураамж нь хэр их байдаг, жилийн орлого нь ямар байдгийг оролцогч талууд мэдэх хэрэгтэй бөгөөд тэдний бодлоор эдгээр дүн нь их хэмжээтэй, эсхүл “материаллаг” эсэхийг тодорхойлох хэрэгтэй. Тийм бол тэд энэ орлогыг ил болгож, тайлагнаж болно

ОУИТБС-ын зорилгын хувьд, ялангуяа Хүснэгтийн үзүүлэлт 9-д заасан маягтын загвар гаргах, ашиг орлогын аль урсгал материаллаг вэ гэдгийг тогтоохын тулд орлогыг Зураг 7.1-д үзүүлсэнчлэн улс орныхоо дотоодод буй ОУИТБС-д хамрагдсан салбар бүрт орлого хэрхэн хуваарилж байгааг оролцогч талууд ойлгодог байх хэрэгтэй.



БҮЛЭГ 8

ᠴᠢᠨᠠᠭᠡᠭᠡᠢ ᠠᠠᠴᠣᠳᠤᠢ ᠦᠢ ᠠᠳᠢ ᠠᠠᠭᠡᠠᠳᠣᠳᠡᠢᠠᠳᠣᠳᠠ ᠠᠳᠡᠢ ᠠᠠᠨ ᠠᠠᠳᠡᠳᠡᠠᠠᠠᠠ ᠠᠠᠮᠤ?


ОУИТБС-д Засгийн газар олборлох үйлдвэрлэлээс хүлээн авч буй орлогынхоо маягтыг бэлтгэхийг шаарддаг. Дараа нь эдгээр хүлээн авсан орлогоо засгийн газарт төлсөн гэж компаниудын мэдүүлээд байгаа төлбөрүүдтэй харьцуулж, орлого, төлбөрийн хоорондох ямар нэг зөрүүтэй байдлыг тайлагнах ёстой. Энэ нь хялбархан мэт сонсогдож байгаа боловч бодит байдал дээр ОУИТБС-ын дагуу тайлагнах, тулган шалгах ажиллагаа маш нарийн төвөгтэй байж болно.

8.1 ОУИТБС-ын ООТБ бүр бүдүүвч зураг шаардлагатай

Санхүүгийн урсгалуудыг хөөн шалгах боломжтой байхын тулд хийвэл зохих хамгийн чухал эхний алхам бол санхүүгийн урсгалуудын бүдүүвч зураг гаргах явдал юм. Энэ нь хэн ямар төлбөр төлж байна, хаана төлж байна гэдгийг хялбарчилсан ерөнхий тойм хэлбэрээр харуулах юм. ОУИТБС-ыг хэрэгжүүлж буй ихэнх улс энэхүү ерөнхий тойм зургаа гаргаж нийтлээгүй байна.

Нигери Улс мөн л энэхүү олж мэдсэн ерөнхий зүйлээс ялгарах онцлогтой байна. Нигери Улс санхүүгийн янз бүрийн урсгалаа “газрын тосны урсгал” (зөвхөн газрын тос, байгалийн хийн салбарт тохиолддог төрлийн урсгалууд), “газрын тосны бус урсгал” (дан ганц олборлох үйлдвэрлэлийн салбарт биш, бус аль ч байгууллагад хэрэглэгддэг цалингийн татвар гэх мэт урсгалууд) гэж хуваасан байна. Зураг 8.1-д газрын тосны ба газрын тосны бус санхүүжилтийн график дүрслэлийг харуулсан байна. Зураг 8.2 нь тайлбар буюу янз бүрийн байгууллагууд ба санхүүгийн урсгалуудын дүрслэл юм. Тухайлбал, уг бүдүүвч зурагт түүхий нефтийг (зурагт “1” гэж дугаарласан, тайлбарын 1 дэх зүйл) түүнийг хэрэглэгчээс холбооны сангийн доллар, найрагийн дансанд төлсөн байна. ОУИТБС-ын санаа бол оролцогч талууд биет нөөц баялаг ба санхүүгийн урсгалын аль алиных нь гинжин хэлхээнд хэн байгааг мэдэхгүй бол аль байгууллагатай хариуцлага тооцохоо мэдэж чадахгүй гэсэн үг юм.

Зураг 8.1: Нигерийн газрын тос ба орлогын урсгалуудын бодуувч зураг*



* Санхүүгийн урсгалуудын бодуувч зураг, НОУИТБС-ын Санхүүгийн аудитын суурь шинжилгээ ба явцын тайлан, 2005 оны 8 сарын 8, хуудас 5

Зураг 8.2: Нигерийн газрын тос ба орлогын урсгалуудын бүдүүвч зураг-Тайлбар

1. **Түүхий нефтийн борлуулалт**
НҮГТК түүхий нефтийг зах зээл дээр борлуулахдаа борлуулалтын үнийн дүнг Нигерийн Төв Банкинд мэдэгдэж, НТБ дахь Холбооны төсвийн холбогдох дансанд АМД-р санхүүжилт орж ирэх талаар анхааруулна.
2. **Бэлэн мөнгө татан авалт**
НҮГТК ба НХЗГ-ын баталсны дагуу ГТООК-дад орох бэлэн мөнгө татан авах төлбөрүүдийг Холбооны төсвийн данснаас ХҮ эрхлэгчдэд календарчилсан байдлаар АМД-р шилжүүлнэ.
3. **НҮГТК-ҮГТХОУГ-ын санхүүжилт**
НҮГТК-ҮГТХОУГ нь үйл ажиллагааны төсвийн төслөө бэлтгэж, төслийг Холбооны төсвийн данснаас АМД-р шилжүүлнэ.
4. **Тусгай зөвшөөрлийн хураамжууд**
ГТООК-д ба газрын тосны бие даасан компаниуд ГТНГ-тай тохиролцож, төлбөрөө НТБ дахь Холбооны төсвийн дансанд АМД-р болон Найрагаар төлнө.
5. **Хий болон хоолой ашиглалтын төлбөр**
Энэ нь ГТООК-даас НҮГТК-ҮХК ба НШБХК-д худалдан авсан хий болон бие даасан үйлдвэрлэгчдээс ГТООК-дад төлвөл зохих хоолой ашиглалтын төлбөрүүдийг илэрхийлнэ. ХҮ-н хий болон ашиглалтын орлогоос Холбооны эзэмших хувийг Холбооны төсвийн дансанд шилжүүлнэ.
6. **Нөөц ашигласны төлбөр**
Тооцоолсон нөөц ашигласны төлбөрийг ГТООК-д ба газрын тосны бие даасан компаниуд Нью-Йорк дахь Холбооны нөөцийн дансанд АМД-р төлнө. Тооцоолсон ба төлсөн дүнгүүдийн талаар ГТООК-ууд ба газрын тосны бие даасан компаниуд ГТНГ-тай зөвлөлдөнө.
7. **Нефтийн ашгийн татвар**
НАТ-ыг сар бүрийн суутгал төлбөрийн төлөвлөгөөний дагуу тооцож, бүх үйлдвэрлэгчид Нью-Йорк дахь Холбооны нөөцийн дансанд АМД-р төлөх бөгөөд энэ талаар ХДОА-нд урьдчилж мэдэгдэнэ.
8. **НҮГТК-НБМК-наас төлөх түүхий нефтийн хуваарилалтын төлбөр**
НҮГТК-НБМК-наас боловсруулалтын зорилгоор анх хуваарилагдсан түүхий нефтийн үнэд төлөх төлбөр. Энэхүү түүхий нефтийн аль ч боловсруулагдаагүй хэсгийг НҮГТК-НБМК борлуулна.
9. **Боловсруулалтын төлбөр**
Энэ төлбөрийг НҮГТК-НБМК-с НҮГТК-ний боловсруулах үйлдвэрүүдэд боловсруулсан бүтээгдэхүүний үнэд төлнө.
10. **НҮГТК-ний түүхий нефтийн борлуулалт**
НҮГТК-д хуваарилагдсан боловсруулагдаагүй түүхий нефтийг борлуулсны орлого АМД-р. Тэмдэглэл 8-г үзнэ үү.
11. **НҮГТК-ний боловсруулсан бүтээгдэхүүний импорт**
Гадаадын зах зээлээс худалдаж авсан боловсруулсан бүтээгдэхүүний төлбөр, АМД
12. **НҮГТК-иас маркетингийн компаниудад хийх борлуулалт**
Нефть бүтээгдэхүүний маркетингийн компаниудад Холбооны засгийн газрын хөнгөлөлттэй үнээр борлуулсан боловсруулсан бүтээгдэхүүний борлуулалтын орлого, Найрагаар
13. **ГТНГ-ын санхүүжилт**
ГТНГ нь үйл ажиллагааны зардлынхаа санхүүжилтыг Холбооны Газрын тосны нөөцийн яамнаас авна.
14. **ХДОА-ны санхүүжилт**
ХДОА нь үйл ажиллагааны зардлынхаа санхүүжилтыг Холбооны Сангийн яамнаас авна.
15. **Нефть бүтээгдэхүүний тогтворжуулалтын сан**
НБТС нь холын зайн тээвэр зуучлалын хөлсийг Маркетингийн компаниудад Найрагаар төлнө. Мөн НБТС нь үнийн нэгдмэл механизмыг удирддаг. Маркетингийн компаниуд тээврийн зардлын үндэсний дунджаас доогуур зардлаар тээвэрлэсэн тохиолдолд НБТС-д Найрагаар төлбөр төлөх бөгөөд тээврийн зардлын үндэсний дунджаас дээгүүр зардлаар тээвэрлэсэн бол тус сангаас санхүүжилт авдаг байна.

Тодорхойлолтууд

НТБ	Нигерийн Төв Банк
ГТНГ	Газрын Тосны Нөөцийн Газар
ХДОА	Холбооны Дотоод Орлогын Алба
ГТООК-д	Газрын Тосны Олон Улсын Компаниуд
ХҮ	Хамтарсан Үйлдвэр
ҮГТХОУГ	Үндэсний Газрын Тосны Хөрөнгө Оруулалтыг Удирдах Газар
ҮХК	Үндэсний Хийн Компани
НШБХК	Нигерийн Шингэрүүлсэн Байгалийн Хийн Компани
НҮГТК	Нигерийн Үндэсний Газрын Тосны Компани
НБМК	Нефть Бүтээгдэхүүний Маркетингийн Компани
НАТ	Нефтийн Ашгийн Татвар
АМД	АНУ-ын доллар

8.2 Төрийн нийтлэг байгууллагууд ба тэдгээрийн гүйцэтгэх үүрэг

Эдгээр санхүүгийн урсгалд хамгийн их төвлөрсөн байдлаар оролцдог, оролцогч талуудын зүгээс асуулт асуувал зохих төр засгийн удирдах байгууллага, эрх бүхий этгээдүүдийн жагсаалтыг дор товч танилцуулав.

Төв банк. Засгийн газар төлбөр хүлээн авсныг илтгэх хамгийн сайн нотолгоо бол төв банкинд тогтоогдсон байх явдал юм. Засгийн газар ихэвчлэн улсын төсвийн санхүүгийн (орлого, зарлагын) бүртгэл тооцоог хөтөлж байдаг нэг ажилтантай байдаг. Иймээс олборлох үйлдвэрлэлээс засгийн газарт орж байгаа орлогуудыг маягтын дагуу бөглөж ирүүлэхийг тухайн ажилтнаас хүсэх нь зүйтэй.

Татварын алба. Татварын алба нь татвар ногдуулах, хураах үүргийг голлон хариуцдаг. Юуны түрүүнд татварын алба бодитойгоор мөнгө хурааж байна уу, аль эсхүл зөвхөн татвар төлөгчдөөс засгийн газарт шууд орж буй мөнгөний урсгалыг удирдаж байна уу гэдгийг тодорхойлох шаардлагатай. Энэ нь санхүүгийн урсгалуудын бүдүүвч зургаас тодорхой харагдах ёстой. Хэрэв татварын мөнгө төрийн сангийн төв дансанд шууд шилжиж байвал нийт дүнг засгийн газраас баталгаажуулж авах ёстой. Харин энэ дүнд оруулж буй хувь нэмрийн мэдээллийг нэг бүрчлэн авъя гэвэл зөвхөн татварын албанд хандах зүйтэй байх.

Шигтгээ 8.1: Хөнгөлөлтийн гэрээний дагуу татварыг тооцох нь- Аргачлал

Аливаа хөнгөлөлтийн гэрээ нь нийт орлогод урьдчилан тогтоосон хувиар ногдуулсан нөөц ашигласны төлбөр, мөн ашигт, эсхүл татвар ногдох орлогод (ТНО) ямар нэг хувиар ногдуулсан татвар хоёроор тодорхойлогддог.

Нийт орлого нь үйлдвэрлэлийн хэмжээг түүнийг борлуулах үеийн газрын тосны үнээр үржүүлсэн нийт дүн юм. Энэхүү нийт орлогод нөөц ашигласны төлбөр ногдуулдаг. Харин нийт орлогоос нөөц ашигласны төлбөрийг хассан дүнг цэвэр орлого гэнэ. Ашиг (буюу татвар ногдох орлого) нь цэвэр орлогоос гарсан зардлуудыг хассан дүнг хэлнэ.

Зардлыг ерөнхийд нь үйл ажиллагааны зардал (Опэкс), капиталын зардал (Капэкс) гэж ангилдаг. Капиталын зардалд, нэгээс дээш жилийн амьдрах хугацаатай хөрөнгө, тухайлбал барилга, тээвэрлэгч машин, дамжуулах хоолой, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж гэх мэт зүйл авах зардлууд ордог. Эдгээр зардалд тогтоосон санхүүгийн дүрэм, хувийн дагуу тооцдог элэгдэл хорогдол ордог.

Тэгвэл нийт зардал нь Үйл ажиллагааны зардлууд (Опэкс) дээр Капиталын зардлуудын санхүүгийн элэгдэл хорогдлыг (Элхо) нэмсэнтэй тэнцүү байна.

Татвар ногдох орлого = {(Үйлдвэрлэл х Газрын тосны үнэ) - Нөөц ашигласны төлбөр} - (Опэкс + Элхо)

Ингээд татвар ногдох орлогыг зохих татварын хувиар үржүүлж төлвөл зохих татварын хэмжээг тооцдог.

Хэрэв татварын албаны дансаар компаниудаас мөнгө авч байгаа бол уг мөнгийг засгийн газар хүлээн авсанд тооцох эсэхийг зайлшгүй судалж тодорхойлох шаардлагатай. Жишээлбэл, хэрэв татварын албаны дансанд орж байгаа мөнгийг зүгээр нэг дор төвлөрүүлж хураагаад бүрэн бүтнээр нь төрийн сангийн дансанд

шилжүүлдэг бол магадгүй төрийн сангийн дансанд хүлээж авсных нь дараа засгийн газар хүлээн авсанд тооцох нь хамгийн зөв биз. Гэхдээ уг дүнгийн бүтцийн тухай нарийвчилсан мэдээлэл засгийн газарт дутагддаг учраас үүнд татварын албаны тоо баримт шаардлагатай болно. Нөгөө талаас, хэрвээ татварын алба татвар төлөгчдөөс хүлээж авсан мөнгөө өөрийн байгууллагын үйл ажиллагаанд ашиглаад үлдэгдлийг төрийн сангийн дансанд шилжүүлдэг бол үнэн хэрэгтээ хаана нь засгийн газрын “хүлээн авалт” явагдаж байгааг тодорхойлох нь чухал байх болно.

Зохицуулах эрх бүхий байгууллагууд. Ихэвчлэн салбарын зохицуулах эрх бүхий байгууллага байдаг бөгөөд энэ нь гол төлөв ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр гэх мэт салбарын чанартай ашиг орлогын урсгалын бүрдүүлэлтийг удирдан зохицуулдаг байгууллага байдаг. Тавигдах асуудлууд нь татварын албатай холбоотой асуудлуудтай төстэй бөгөөд тухайн эрх бүхий байгууллага мөнгийг бодитойгоор хүлээн авч байгаа эсэх, эсхүл зөвхөн засгийн газрын дансанд орж байгаа урсгалыг удирдаж байгаа эсэхийг тодорхойлох зайлшгүй шаардлагатай.

Газрын тосны үндэсний компани. Газрын тосны үндэсний компани (ГТҮК)-ийн гүйцэтгэх үүргийг анхааралтай авч үзэх шаардлагатай. Зарим улсын газрын тосны үндэсний компани газрын тосны салбарын яам маягийн үүрэг гүйцэтгэдэг. Ийм учраас үүнийг засгийн газрын нэг хэсэг гэж үзэх үндэслэлтэй байж болно. Бусад орны ГТҮК-ууд хамаагүй илүү бие даасан байдалтай бөгөөд тэр хэрээрээ гүйцэтгэж байгаа үүргийн хувьд төрийн өмчит газрын тосны хувийн компанитай төстэй байдаг.


Анхаарлаа хандуулвал зохих гол асуудал бол бэлэн бусаар хийгдэж байгаа гүйлгээнүүдэд ГТҮК томоохон үүрэг гүйцэтгэдэг эсэх юм. Ил тод байдлыг хангахын тулд ашиг орлогын бэлэн бус урсгалуудыг ГТҮК хэрхэн үнэлж байгаад онцгой анхаарал хандуулах шаардлагатай. Учир нь, энэ нь нилээд зөрүүтэй байдал гардаг асуудал юм. Жишээлбэл, Бүгд Найрамдах Конго Улс бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хуваах газрын тосон ашгийг тооцоолохдоо “доллараар гарсан зардлыг” “баррелиар гарсан зардал”-д хөрвүүлэхэд зориулсан “төсвийн үнэ” (баррель тутмаар тохиролцсон үнэ) ашигладаг байна. Тайлангийн маягтуудад иймэрхүү жишиг үнэ ашиглахдаа тухайн газрын тосыг аль аж ахуйн нэгж, байгууллага зарсан, уг борлуулалтын үр ашгийг хэн хүртсэн, ямар үнээр олж авсан, эдгээр үнүүд уг жишиг үнэтэй харьцуулахад ямар байгааг тайлбарласан тэмдэглэл дагалдуулах шаардлагатай болно. Түүнчлэн энэхүү жишиг үнэ нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн жишиг үнэтэй харьцуулахад ямар байгааг тайлбарлаж болох юм.

Тухайлбал, Нигерийн ГТҮК-ний Түүхий нефтийн маркетингийн газар (ТНМГ) засгийн газрын мэдлийн түүхий нефтийг батлагдсан гэрээлэгч нарт олон улсын жишгээр тооцсон үнээр худалддаг. Үүнтэй холбогдуулан ТНМГ-ын гүйцэтгэх чиг үүрэгт дараахи үйл ажиллагаа ордог:

- Гэрээ эзэмшигчдийг сонгох
- Гэрээний төсөл боловсруулах, гарын үсэг зурах
- Түүхий нефть гаргах зохицуулалтууд хийх
- Холбогдох албан тушаалтнуудтай тооцоо хийх
- Ачуулахын өмнөх ба дараах үнийг тооцож төсөвжүүлэх
- Онгоцонд ачаалах

- Үнэлгээг тогтоож нэхэмжлэл гаргах
- Орлогыг бүртгэж тайлагнах
- Холбооны төсөв хуваарилах хороотой харилцаж хамтран ажиллах

Зураг 8.3: Төв банкны дансанд хийгддэг үндсэн гүйлгээнүүд



Дотоодын түүхий нефтийн борлуулалтыг нэг бол Нигерийн найрагаар, эсхүл ам.доллараар хийж болох бөгөөд үүнийг Нигерийн ГТҮК болох Нигерийн үндэсний газрын тосны компаний (НҮГТК) сонголтоор хийдэг. Бүх төлбөрийг заавал энэ дансанд төлөх албагүй байдаг.

Бүдүүвч зурагт “бэлэн бус” төлбөрийн борлуулалтын орлогыг шилжүүлэхэд клирингийн данс ашиглаж байгаа нь харагдаж байна. Энэ дансыг төв засгийн газрын данс мэтээр удирдах бөгөөд энэ дансанд хүлээж авсан бүх орлогыг засгийн газрын ашиг орлого гэж үздэг. Харин төлбөрийн талыг нь зөвхөн Нигери Улсын хэрэгжүүлэхээр сонгосон ОУИТБС-ын өргөтгөсөн хэсэг байдлаар сонирхдог.

Бүсийн ба орон нутгийн засгийн газар. Ашиг орлогын зарим урсгалыг компаниудаас шууд бүсийн, эсхүл орон нутгийн засгийн газруудад төлдөг байж болох юм. Эдгээрийн үр шимийг тухайн улс хүртэх бөгөөд хэрвээ ОУИТБС-ын хэрэгжүүлэлтийн дагуу тайлагнах хүрээнд орохуйц материаллаг төлбөр мөн бол илүү орон нутгийн шинжтэйгээр хийгддэг янз бүрийн төлбөрүүдийн тайлагнагдах байдал ба баттай байдлын тухай өмнө тэмдэглэсэн асуудлуудыг харгалзан үзнэ. Мөн ийм тохиолдолд зүгээр л тухайн мөнгө улс орны хаана орсныг бүх оролцогч талд ойлгуулахад туслахын тулд ООТБ-ийн зүгээс тухайн төлбөрүүд материаллаг бус байсан ч гэсэн шалгаж тогтоох хүсэлт гаргаж болно. Мөн олборлох үйлдвэрлэлээс орлого хүлээж авснаа нотлохыг бүсийн ба орон нутгийн түвшний холбогдох байгууллагаас шаардах хэрэгтэй. Бүсийн ба орон нутгийн засгийн газраас утга төгөлдөр мэдээлэл олж авахад хэцүү байх нь олонтаа. Тухайн түвшний засгийн газрын санхүүгийн удирдлагын болон тайлагналтын боловсронгуй байдлын түвшин хязгаарлагдмал байж болно. Хэрэв шаардагдах ур чадварын түвшин дутагдалтай бол засгийн газраас хүн хүч зарсан өргөн хүрээтэй ажил зохиож холбогдох төлбөрүүдийг тогтоох шаардлагатай болох бөгөөд энэ нь ОУИТБС-ыг хэрэгжүүлэх цагийн хуваарь,

зардал хоёрын аль алинд сөрөг нөлөө үзүүлж болох юм. Нөгөө талаас, ООТБ-ийг сонгох үеэр орон нутгийн түвшний санхүүгийн хариуцлагатай байдлыг сайжруулах асуудал ОУИТБС-ын хөтөлбөрийн нэг гол зорилго байж болно.

Засгийн газрын хүлээн авсан нийт орлогыг нэгдсэн байдлаар хэдийн хэвлэн нийтлээд байгаа зарим орны хувьд төв, орон нутгийн засгийн газар ба нутгийн иргэдийн хоорондох орлогын хуваарилалтыг ил тод болгоход нь ОУИТБС тусалж болно.

Перугийн жишээ

Перу бол газрын тос, байгалийн хий, ашигт малтмалын орлогуудыг хураах, хуваарилах тал дээр ил тод, хариуцлагатай байдлын харьцангуй өндөр стандарттай улс юм. Энэ ажил нь төсвийн төвлөрлийг сааруулах өргөн хүрээтэй ажлын нэг хэсэг бөгөөд мэдээлэл авах эрхтэй холбоотой одоо байгаа хууль тогтоомжид тулгуурласан байдаг төдийгүй Их8-н Ил тод байдлын багцад Перу улсын авсан үүрэг амлалттай нь нийцдэг байна. Засгийн газрын аль түвшин нь эдгээр орлогыг хүлээн авагч байх, мөн нийгмийн ямар зорилгуудад үйлчлэх вэ гэдэг утгаараа эдгээр орлогыг орон нутгийн түвшинд хэрхэн хуваарилах асуудал дотооддоо ихээхэн сонирхол татах болжээ.


Перугийн хувьд орон нутгийн оролцогч талуудын тоо нилээд олон байдаг. Уул уурхайн тухай дүрмийн⁶⁰ дагуу 50 хувийн уул уурхайн татвар төлөх шаардлагатай байдгийг дараахи байдлаар хуваарилан төлдөг:

- Тухайн уурхайн үйлдвэрлэл явуулж буй газрын дүүргийн захиргаа: 10%
- Үйлдвэрлэл явуулж буй газрын харьяалах аймгийн захиргаа: 25%
- Тухайн бүсийн харьяа аймаг, дүүргүүд: 40%
- Бүсийн засгийн газрууд: 25%

Уул уурхайн татварын орлогын хуваарилалтын (жилд 25 сая орчим ам.доллар) үр шимийг хүртэгч бусад газрууд гэвэл:

- Эрчим хүч, эрдэс баялгийн яам
- Уул уурхайн судалгаа, кадастрын хүрээлэн
- Геологи, уул уурхай, металлургийн хүрээлэн
- Холбогдох дүүргүүд
- Туйлын ядуу дүүргүүд
- Холбогдох нутаг дэвсгэрийн нэгжүүд

Зураг 8.4: Перу Улсын 2004 оны төлбөрийн хуваарилалт, яам газруудаар



Зураг 8.5: Перу Улс уул уурхайн татварын орлогыг төрийн байгууллагуудад хуваарилсан байдал



Уул уурхайгаас иргэдэд үзүүлэх нөлөө болон уул уурхайн татварын орлогын механизмууд, хуваарилалтад санаа зовсон нутгийн иргэд ОУИТБС-ын хүрээнд хийхийг хүссэн өөрчлөлтүүдээ хэлэлцэж чадах бааз суурьтай учраас Перуд орон нутгийн түвшний ил тод байдал ач холбогдолтой байдаг.

Хагас төрийн байгууллагууд. Газрын тос, байгалийн хийн үйлдвэрлэлийн салбарын хандив тусламжаар санхүүждэг төрийн байгууллагууд, түүний дотор сургалтын байгууллагууд, хөгжлийн корпорациуд түгээмэл байдаг. Ийм санхүүжилттэй байгууллагуудад үнэлгээ хийж, ОУИТБС-ын хувьд тэдгээрийг төрийн байгууллагын нэг хэсэг гэж үзэх ёстой эсэхийг тодорхойлох зайлшгүй

шаардлагатай. Энэ нь тухайн байгууллага төрөөс хэр хараат бус эсэхээс ихээхэн хамаарна. Ийм байгууллагууд нь илт хувийн байгууллага биш л бол ихэвчлэн төрийн байгууллага гэж ангилан, улмаар бүртгэл тооцоог нь ОҮИТБС-ын үнэлгээний хүрээнд оруулж авч үзэх болно.



БҮЛЭГ 9

ᠲᠡᠭᠡᠨ ᠭᠠᠷᠤᠭᠤᠨ ᠪᠠ ᠶ᠋ᠢᠨᠪᠤ-ᠤᠭᠤᠨ ᠰᠠᠨᠠᠭ ᠵ᠋ᠠᠭᠤᠨ ᠨᠡᠭ ᠭᠣᠯ ᠵᠡᠶᠢᠯ ᠪᠣᠯ ᠲᠤᠬᠠᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠣᠪᠪᠣᠷᠯᠣᠰᠣᠨ ᠨᠥᠶ᠋ᠨ ᠪᠠᠶᠠᠯᠭᠢᠨᠬᠠᠭ ᠲᠡᠯᠪᠦᠷᠢᠭᠢᠭ ᠵᠣᠬᠢᠬᠤ ᠶ᠋ᠢᠨᠪᠤ ᠠᠪᠴᠢ ᠪᠠᠶᠢᠭᠠᠭ ᠡᠰᠢᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ ᠠᠰᠤᠭᠤᠳᠠᠯ ᠶ᠋ᠮ. ᠵᠠᠰᠭᠢᠨ ᠭᠠᠷᠤᠭᠤᠨ ᠵᠣᠬᠢᠬᠤ ᠬᠤᠭᠤᠯᠤᠰ ᠲᠣᠭᠲᠣᠮᠵᠢᠨᠬᠣᠭ ᠳᠠᠭᠤᠭ ᠪᠣᠯᠢᠨ ᠴᠣᠮᠠᠨᠢᠭᠤᠳᠠᠢ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠰᠠᠨ ᠭᠡᠷᠡᠨᠭᠦᠳᠢᠶᠢᠬᠡᠭᠡ ᠳᠠᠭᠤᠭ ᠤᠯᠤᠰ ᠣᠷᠨᠢᠬᠣᠭ ᠨᠥᠶ᠋ᠨ ᠪᠠᠶᠠᠯᠭᠢᠨ ᠦᠨᠢᠶᠢᠭ ᠪᠦᠷᠦᠨ ᠠᠪᠠᠬᠤ ᠪᠠᠶᠢᠬᠢᠭᠢᠭ ᠬᠦᠰᠢᠬᠢᠨ ᠵᠡᠷᠭᠢᠴᠡᠭᠡ ᠶᠠᠮᠠᠷ ᠦᠨᠡ ᠲᠡᠯᠰᠢᠨᠢᠭᠢ ᠨᠢ ᠬᠡᠨ ᠴᠢ ᠰᠠᠯᠭᠠᠬᠢᠭᠢᠯᠢ, ᠬᠡᠨ ᠴᠢ ᠨᠢᠶᠢᠲᠡᠬᠢᠭᠢᠯᠢ ᠪᠣᠯ ᠠᠪᠯᠢᠭᠠ ᠬᠡᠭᠡᠯ ᠬᠠᠬᠤᠭᠤᠯᠢ, ᠠᠰᠢᠭᠢᠯᠠᠨ ᠰᠠᠮᠰᠢᠭᠢᠳᠤᠯᠠᠯᠲᠤ ᠭᠠᠵᠠᠷ ᠠᠪᠠᠬᠤ ᠪᠣᠯᠣᠮᠵᠣᠬᠤ ᠭᠡᠳᠡᠭ ᠦᠳᠤᠨᠡᠰᠢ ᠰᠠᠨᠠᠭ ᠲᠠᠪᠢᠪᠢᠬᠤ ᠶ᠋ᠮ. ᠣᠶᠢᠲᠦᠪᠰ-ᠶᠢᠭ ᠬᠠᠮᠭᠢᠨ ᠨᠠᠭᠳᠢ ᠵᠠᠬᠢᠨ ᠬᠡᠮᠵᠡᠨᠳᠡ ᠬᠡᠷᠭᠡᠵᠦᠭᠦᠳᠡᠭ ᠣᠶᠢᠲᠦᠪᠰ-ᠶᠢᠨ ᠦᠨᠳᠦᠰᠢᠨ ᠬᠦᠷᠡᠭᠡᠨᠢᠶᠢ ᠨᠡᠭ ᠭᠣᠯ ᠳᠤᠲᠠᠭᠳᠠᠯ ᠪᠣᠯ ᠬᠦᠯᠡᠨ ᠠᠪᠰᠠᠨ ᠣᠷᠯᠣᠭᠤᠭᠢᠭᠢᠭ ᠬᠡᠨ ᠨᠡᠭ ᠨᠢ ᠰᠠᠯᠭᠠᠵᠢ ᠪᠠᠶᠢᠭᠠᠭ ᠡᠰᠢᠬᠤ ᠲᠠᠯᠠᠷ ᠪᠠᠲᠠᠯᠭᠠᠭ ᠪᠠᠭᠠ ᠪᠠᠶᠢᠳᠠᠭᠲᠤ ᠣᠷᠰᠢᠨᠣ. ᠡᠨᠡ ᠪᠦᠯᠡᠭᠲᠤ ᠬᠦᠯᠡᠨ ᠠᠪᠰᠠᠨ ᠨᠥᠶ᠋ᠨ ᠠᠰᠢᠭᠢᠯᠰᠠᠨ ᠲᠡᠯᠪᠦᠷᠦᠭᠦᠳᠤ ᠪᠠ ᠠᠰᠢᠭᠢᠨ ᠲᠠᠲᠠᠪᠠᠷᠢᠨ ᠲᠣᠭ ᠪᠠᠷᠢᠮᠲᠤᠭᠦᠳᠤ ᠵᠥᠪ ᠡᠰᠢᠬᠢᠭᠢᠭ ᠰᠠᠯᠭᠠᠬᠠᠳᠤ ᠶᠣᠶᠤ ᠬᠢᠶᠢᠭᠳᠡᠭᠢᠭᠢᠭ ᠠᠪᠴᠢ ᠦᠵᠢᠨᠡ. ᠮᠥᠨ ᠡᠨᠡ ᠪᠦᠯᠡᠭᠲᠤ ᠡᠳᠭᠡᠷ ᠦᠶᠢᠯ ᠶᠠᠪᠴᠢᠭᠢᠭ ᠵᠠᠰᠭᠢᠨ ᠭᠠᠷᠤᠭᠤᠨ, ᠡᠰᠬᠦᠯ ᠴᠣᠮᠠᠨᠢᠭᠤᠳᠤ ᠪᠠᠷᠢᠮᠲᠠᠯᠵᠢ ᠪᠠᠶᠢᠭᠠᠭ ᠡᠰᠢᠬᠢᠭᠢᠭ ᠲᠣᠳᠣᠷᠬᠣᠶᠢᠯᠣᠬᠤ, ᠡᠰᠬᠦᠯ ᠶ᠋ᠢᠨᠪᠤ-ᠤᠭᠤᠨ ᠣᠳᠣᠭ ᠪᠠᠶᠢᠭᠠᠭ ᠠᠭᠤᠳᠢᠲᠠᠯᠭᠳᠠᠨ ᠪᠦᠷᠲᠦᠭᠡᠯ ᠲᠣᠣᠴᠣᠨᠳᠤ ᠨᠠᠶᠢᠳᠠᠬᠢᠭᠢᠭ ᠬᠦᠰᠦᠰᠢᠨ ᠲᠣᠬᠢᠣᠯᠳᠣᠯᠳᠤ ᠰᠠᠠᠷᠳᠠᠭᠳᠠᠬᠤ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠭᠡᠷ ᠶ᠋ᠢᠨᠪᠤ-ᠤᠭᠤᠳᠢᠭᠢᠭ ᠬᠠᠨᠭᠠᠬᠢᠨ ᠲᠤᠯᠳᠤ ᠶᠣᠶᠤ ᠬᠢᠶᠢᠬᠤ ᠲᠠᠯᠠᠷ ᠶᠠᠷᠢᠯᠴᠠᠨᠠ. ᠣᠯᠣᠨ ᠶᠠᠮ ᠦᠶᠢᠯᠳᠦᠪᠦᠷᠯᠡᠨ ᠭᠠᠷᠭᠠᠰᠠᠨ ᠠᠰᠢᠭᠢᠭᠲᠤ ᠮᠠᠯᠲᠠᠮᠠᠯᠢᠨ ᠬᠡᠮᠵᠡᠭᠡ, ᠡᠰᠬᠦᠯ ᠲᠠᠲᠠᠪᠠᠷᠢᠨ ᠪᠠ ᠨᠥᠶ᠋ᠨ ᠠᠰᠢᠭᠢᠯᠰᠠᠨ ᠲᠡᠯᠪᠦᠷᠢᠨ ᠬᠤᠪᠢᠭᠤᠳᠠᠭ ᠨᠢᠶᠢᠭᠡᠳᠤᠭᠢ ᠪᠣᠯᠣᠪᠴᠣᠭᠴᠢ ᠲᠠᠯᠤᠭᠤᠳᠤ ᠡᠳᠭᠡᠷ ᠲᠣᠭᠢ ᠵᠥᠪ ᠲᠣᠣᠴᠣᠬᠤ ᠦᠳᠤᠨᠡᠰᠢ ᠦᠶᠢᠯᠳᠦᠪᠦᠷᠯᠡᠯᠢᠨ ᠬᠡᠮᠵᠡᠭᠡ, ᠲᠠᠲᠠᠪᠠᠷ, ᠨᠥᠶ᠋ᠨ ᠠᠰᠢᠭᠢᠯᠰᠠᠨ ᠲᠡᠯᠪᠦᠷᠢᠨ ᠬᠤᠪᠢᠭᠤ ᠵᠡᠷᠭᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠮᠭᠢᠨ ᠰᠦᠭᠢᠯᠢᠨ ᠦᠡᠶᠢᠨ, ᠦᠨᠦᠨ ᠵᠥᠪ, ᠢᠵᠢ ᠪᠦᠷᠦᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠣᠯᠵᠢ ᠠᠪᠠᠬᠤ ᠲᠠᠯ ᠳᠡᠭᠡᠷ ᠠᠭᠤᠳᠢᠲᠣᠷᠤᠭᠤᠳᠤ ᠪᠣᠶᠣᠶᠤ ᠨᠡᠭᠲᠦᠭᠢᠨ ᠲᠤᠯᠭᠠᠭᠴᠢ ᠨᠠᠷᠲᠤ ᠨᠠᠶᠢᠳᠠᠬᠤ ᠰᠠᠠᠷᠳᠠᠭᠠᠲᠠᠭᠠᠢ ᠪᠣᠯᠢᠨ. ᠢᠨᠭᠡᠳᠤ ᠡᠳᠭᠡᠷ ᠲᠣᠭᠢ ᠵᠥᠪ ᠲᠣᠣᠴᠣᠬᠢᠨ ᠲᠤᠯᠳᠤ ᠶᠣᠶᠤ ᠬᠢᠶᠢᠬᠤ ᠶ᠋ᠢᠨᠪᠤ ᠮᠡᠳᠦᠰᠢᠨᠡᠷ ᠣᠷᠣᠯᠴᠣᠭᠴᠢ ᠲᠠᠯᠤᠭᠤᠳᠤ ᠠᠭᠤᠳᠢᠲᠣᠷᠤᠭᠤᠳᠤ ᠪᠠ ᠨᠡᠭᠲᠦᠭᠢᠨ ᠲᠤᠯᠭᠠᠭᠴᠢ ᠨᠠᠷᠢᠨ ᠬᠢᠶᠢᠭᠢ ᠪᠠᠶᠢᠭᠠᠭ ᠵᠦᠶᠢᠯᠢᠭᠢᠭ ᠣᠶᠢᠯᠭᠣᠵᠢ, ᠤᠭ ᠠᠵᠢᠯᠠᠭ ᠬᠢᠶᠢᠭᠢ ᠪᠠᠶᠢᠭᠠᠭ ᠡᠰᠢᠬᠢᠭᠢᠭ ᠨᠢ ᠨᠠᠶᠢᠭᠲᠠᠨ ᠰᠠᠯᠭᠠᠬᠤ ᠪᠣᠯᠣᠮᠵᠣᠬᠤ ᠪᠣᠯᠣᠬᠤ ᠶ᠋ᠮ.

Засгийн газрууд ба ИНБ-уудын санааг зовоодог нэг гол зүйл бол тухайн улс олборлосон нөөц баялгийнхаа төлбөрийг зохих ёсоор авч байгаа эсэх тухай асуудал юм. Засгийн газрууд зохих хууль тогтоомжийнхоо дагуу болон компаниудтай байгуулсан гэрээнүүдийхээ дагуу улс орныхоо нөөц баялгийн үнийг бүрэн авах нөхцөл бүрдүүлэхийг хүсэх ёстой. ИНБ-ууд ч бас улс орныхоо нөөц баялгийн үнийг бүрэн авдаг байхыг хүсэхийн зэрэгцээ ямар үнэ төлснийг нь хэн ч шалгахгүй, хэн ч нийтлэхгүй бол авлига хээл хахууль, ашиглан шамшигдуулалт газар авах боломжтой гэдэг үүднээс санаа тавих ёстой. ОУИТБС-ыг хамгийн наад захын хэмжээнд хэрэгжүүлдэг ОУИТБС-ын Үндсэн хүрээний нэг гол дутагдал бол хүлээн авсан орлогуудыг хэн нэг нь шалгаж байгаа эсэх талаар баталгаа бага байдагт оршино. Энэ бүлэгт хүлээн авсан нөөц ашигласны төлбөрүүд ба ашгийн татварын тоо баримтууд зөв эсэхийг шалгахад юу хийгддэгийг авч үзнэ. Мөн энэ бүлэгт эдгээр үйл явцыг засгийн газрууд, эсхүл компаниуд баримталж байгаа эсэхийг тодорхойлох, эсхүл ИНБ-ууд одоо байгаа аудитлагдсан бүртгэл тооцоонд найдахыг хүссэн тохиолдолд шаардагдах мэдээллээр ИНБ-уудыг хангахын тулд юу хийх талаар ярилцана. Олон яам үйлдвэрлэн гаргасан ашигт малтмалын хэмжээ, эсхүл татварын ба нөөц ашигласны төлбөрийн хувиудаа нийтэлдэг боловч оролцогч талууд эдгээр тоог зөв тооцох үүднээс үйлдвэрлэлийн хэмжээ, татвар, нөөц ашигласны төлбөрийн хувь зэргийн тухай хамгийн сүүлийн үеийн, үнэн зөв, иж бүрэн мэдээлэл олж авах тал дээр аудиторүүд буюу нэгтгэн тулгагч нарт найдах шаардлагатай болно. Ингээд эдгээр тоог зөв тооцохын тулд юу хийх ёстойгоо мэдсэнээр оролцогч талууд аудиторүүд ба нэгтгэн тулгагч нарын хийж байгаа зүйлийг ойлгож, уг ажлаа хийж байгаа эсэхийг нь нягтлан шалгах боломжтой болох юм.

9.1 Нөөц ашигласны төлбөрийн хүлээн авалтыг шалгах

Улс орон бүрт нөөц ашигласны төлбөрийн системийн ажиллагаа харилцан адилгүй байдаг. Ийм олон янз байдаг учраас улс бүр өөрийн гэсэн онцлогтой дотоодын системээ үнэлэхэд тусгайлан зориулсан шалгах журам боловсруулах шаардлагатай байдаг. Ийм системүүдийн төрөл нь дараахи зүйлсэд суурилсан нөөц ашигласны төлбөр ногдуулж байгаа эсэхээс хамаарч янз бүр байдаг:

- Түүхий нефть буюу ашиг малтмалын төлбөр ногдуулж болох дүн
- Хөнгөлөлт эзэмшигчийн ашиг
- Ямар нэг нэгжид суурилсан систем (өөрөөр хэлбэр баррель, эсхүл тонн тутамд ногдох хувь)
- Ашигт малтмалын төрөл, эсхүл газрын тосны API
- Талбай бүрийн онцлог шинж (газар нутгийн онцлог эсвэл байршилыг харгалзсан ялгавартай хувь)

Бүр онцгой тохиолдолд талбай эзэмшигч нэг бүрээр нөөц ашигласны төлбөрийн зохицуулалт хийдэг байж болно. Тухайлбал, ийм жишээ Хятадад байдаг.

Газрын тосны хувьд хамгийн нийтлэг төрөл нь түүхий нефтийн үнийн дүнгийн систем байдаг. Ашигт малтмалын хувьд маш олон янзын арга байдаг. Арай хуучин системүүд бол нөөц ашигласны төлбөрийг тонн тутамд ногдох хувиар тогтоож, үүнийгээ хууль тогтоомжид суулгаж өгсөн байж болох талтай. Гэхдээ инфляцийн нөлөө болон бараа түүхий эдийн үнэд өөрчлөлт оруулахад хэцүү байдгаас шалгаалж энэ систем хоцрогдож байна.

Нөөц ашигласны төлбөрийг шалгах үүрэгтэй байгууллага нь ихэвчлэн төрөлжсөн төрийн байгууллага байдаг бөгөөд магадгүй тухайн салбарын зохицуулагч байгууллага байж болно. Энэ ажлыг хийхэд маш нарийн ур чадвар шаарддаг учраас ихэнх орнууд засгийн газрын яам, газар, эсхүл татвар хураах газар гэх мэт өөр ерөнхий чиг үүрэгтэй байгууллагуудад энэ ажлыг хариуцуулснаас тусгайлан зориулсан байгууллагад хариуцуулж ажиллуулах нь илүү зохистой гэж үзэх болжээ.

Шигтгээ 9.1: Нэг улс олон тооны гэрээний тогтолцоо, нөөц ашигласны төлбөрийн өөр өөр хувьтай байж болно

Нигерийн хөнгөлөлтийн гэрээний бүдүүвч					
Хамтарсан үйлдвэр эрхлэгч	ГҮГТК	ГТОУК-ний эзэмшил хувь	Нефтийн ашгийн татварын хувь	Хийн ашгийн татварын хувь	Нөөц ашигласны төлбөрийн хувь
Чеврон	60%	40%	85%	30%	0%-20% (дор тэмдэглэлээс үзнэ үү)
Элф	60%	40%	85%	30%	
Мобил	60%	40%	85%	30%	
НАОС	60%	40%	85%	30%	
SPDC	55%	45%	85%	30%	
Топкон	60%	40%	85%	30%	
Паноушин	60%	40%	85%	30%	

Хуулиар тогтоосон нөөц ашигласны төлбөрийн хувиуд:

- Эрэг дээр 20%
- Эргээс цааш
 - усны гүн 0-100 метр 18.5%
 - усны гүн 101-200 метр 16.5%
 - усны гүн 201-500 метр 12.5%
 - усны гүн 501-800 метр 8.0%
 - усны гүн 801-1000 метр 4.0%
 - усны гүн 1000 метрээс дээш 0%

Нигерийн БХГ-ний бүдүүвч		
Алдакс Петролиум	Үл мэдэгдэх	Үл мэдэгдэх
Агип ENR	Хувьсах	Хувьсах
Шелл Эн Эксплорэйшн энд Продакшн Ко	Үл мэдэгдэх	Үл мэдэгдэх

Санамж: Эдгээр эзэмших хувь нь газрын тосон зардлаар дамжуулан зардлаа хэрхэн нөхөхөөс хамаарна.

Уул уурхайн салбар дахь нөөц ашигласны төлбөрийн жишээ. Давс үйлдвэрлэлд ногдуулах нөөц ашигласны төлбөр үйлдвэрлэсэн нэг тонн тутамд 0.05\$ гэж бодъё. Энэ системд хяналт тавих үндсэн алхмууд гэвэл:

- Хэдэн тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэснийг тогтоох
- Тооцоололтыг шалгах
- Холбогдох байгууллагад хүлээн авсан төлбөрийн дүнг нотлон шалгах явдал юм.

Эхний алхамын хувьд үйлдвэрлэсэн тоо хэмжээг шалгахад хэцүү байж болно. Үйлдвэрлэлийн хэмжээг шалгах гурван үндсэн арга байдаг:

- Борлуулснаар бүртгэгдсэн дүнгүүдийг шалгах
- Уурхайгаас олборлож гаргасан бүтээгдэхүүний дүнг шалгах
- Уурхайг судлах

Ямар ч тохиолдолд тухайн байгууллага ашиглалтын эрх эзэмшигч байгууллагад хандаж нөөц ашигласны төлбөрийн тооцоогоо төлбөрийн баримтын хамт ирүүлэхийг хүсэх хэрэгтэй.

Уул уурхайн салбарт, ялангуяа уг салбарын зах хязгаарт ашигт малтмал олборлон гаргаад түүнийгээ бүртгэдэггүй уламжлал тогтсон, улмаар бүртгэл нь бүхэлдээ багтай бус байх тохиолдол гардаг. Заримдаа энэ байдлыг нь уурхайн хяналтын байцаагч нар мэддэг учраас албан тушаалтнуудад хээл хахууль өгч дутууг нь хэрэгсэхгүй байлгах тохиолдол байдаг. Мөн зарим үед уурхайн хяналтын байцаагч нар уурхайгаас гарч буй ачааны машинуудад судалгаа явуулж, үйлдвэрлэн гаргаж байгаа материалын жинг үнэлж болох юм. Түүнчлэн ачааны машинд хэр их ачаа ачиж явааг шалгах хяналтын гүүрэн жин тавих шаардлагатай байж болох юм.

Энэ бүх хүндрэл бүрхшээлээс үүдэн шалгалтын гурав дахь арга болох уурхайн судалгааны аргыг үе үе хэрэглэх шаардлагатай. Үүний тулд уурхайн дотор талд геологийн судалгаа явуулж, газрын гүнд гаргасан нүхний хэмжээг тодорхойлон, улмаар тэндээс олборлосон ашигт малтмалын хэмжээг тооцон гаргаж болно. Уурхайн судалгааны өмнөх бичлэгүүдийг ашигласнаар олборлосон материалын эзлэх хувийг тогтоож болно. (Давсны уурхайн хувьд олборлосон материалын нэг хэсэг нь давс, нөгөө хэсэг нь хаягдал материал байж болно). Үүний дараа тухайн материалын тогтоогдсон нягтралыг ашиглан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээг тодорхойлж болно. Мэдээж энэ нь ойролцоогоор тооцох арга боловч яваандаа бодит үйлдвэрлэлтэй харьцангуй хүчтэй корреляцийн хамааралтай гарах болно.

Нөөц ашигласны төлбөрийн ганцхан үеийн турших тооцоог хэмжихэд уурхай судлаачын болон нягтлан бодогчийн зүгээс багагүй ур чадвар шаарддаг. Үнэлгээ хийх хугацаа нь ихэвчлэн нэг жил байдаг боловч тухайн материалын шинж чанараас хамаарч нэг сарын хугацаатай богино ч байж болох юм.

Төлвөл зохих дүнг тохирсон гэж үзвэл уурхайн эрх эзэмшигч нь төлбөр төлснийг нотлох баримтаа харуулж чаддаг байх ёстой. Сүүлчийн алхам бол уг дүнг хүлээн авсан байгууллагын санхүүгийн бүртгэлтэй харьцуулан шалгах явдал юм. Энэ нь хяналтын байгууллагын данс, эсхүл засгийн газрын данс байж болох бөгөөд шалгах зорилгоор тухайн байгууллагад хандан авч үзэх шаардлагатай.

Зохицуулагч байгууллагууд үйлдвэрлэгчдийн бүртгэл хөтөлж, хяналт шалгалтын хөтөлбөрүүд хэрэгжүүлж болно. Энэ нь үечлэн шалгах хөтөлбөр, эсхүл санамсаргүй шалгалт байж болох юм. Ашиглалтын эрх эзэмшигч бүрийг тодорхой хугацааны дараа шалгаж байх ёстой бөгөөд магадгүй нөөц ашигласны төлбөр хамгийн ихтэй байж болох уурхайнуудыг илүү олон удаа шалгадаг байх байдлаар шалгалтын журмууддаа ангилал тогтоох боломжтой.

Бас нэг уурхайн жишээ. Хэрэв үйлдвэрлэсэн материалын үнийн дүнд тулгуурлан нөөц ашигласны төлбөр ногдуулдаг бол дараагийн шатны хяналт шалгалтыг хийх шаардлагатай.

Нүүрсний үйлдвэрлэлд ногдуулах нөөц ашигласны төлбөрийг борлуулалтын үнийн дүнгийн 10 хувиар тогтоосон гэж үзье. Иймээс хяналтын байгууллага үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтын үнийн дүнг тогтоох шаардлагатай. Энэ жишээнд авч үзэж байгаа нөөц ашигласны төлбөрийг борлуулсан бүтээгдэхүүнд бус үйлдвэрлэн гаргасан бүтээгдэхүүнд ногдуулж байгааг тэмдэглэх хэрэгтэй. Нягтлан бодох бүртгэлийн үүднээс авч үзэх юм бол энэ системийг хэрэглэхэд хэцүү байдаг боловч хууль тогтоогчид үүнийг ашиглах нь олонтаа байдаг. Үйлдвэрлэл, борлуулалт хоёр хоорондоо тохирохгүй байх явдал байдаг: энэ хоёр нь нөөцийн түвшний өөрчлөлтөөс болон үйлдвэрлэлт борлуулалтын хоорондох алдагдлуудаас болж үе үе зөрдөг. (Зарим төрлийн нүүрсний нөөц галд шатамхай байдаг нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний нэг хэсэг нь алдагдахад хүргэж болно. Нөөц ашигласны төлбөрийн дүрмэнд юу гэж зааснаас хамаарч тухайн бүтээгдэхүүнд нөөц ашигласны төлбөр төлөх үүрэгтэй байж болно).

Цаашилбал, борлуулалтын цэгийг тодорхойлоход хэцүү байж болно. Хэрэв уурхайн үйл ажиллагаа эрхлэгч уурхайнхаа амнаас нүүрсээ борлуулдаг, эсхүл дамжуулан борлуулагчид хандан жижиглэнгийн худалдаанд борлуулдаг (жижиглэн худалдааны цэг дээр нөөц ашигласны төлбөрийг тооцохоор) бол нөөц ашигласны төлбөр өөр өөр байх ёстойгоор тогтоосон уу?

Зохицуулагч байгууллага эдгээр тодорхойгүй байдлыг шийдсэн гэж үзвэл тухайн тоо баримтыг хэрхэн шалгаж болох вэ? Борлуулсан тонн тутмын борлуулалтын үнийг тооцож гарган түүнийгээ тухайн үед үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний нийт хэмжээнд хэрэглэх шаардлагатай болно. Мөн л нягтлан бодогч нар хэрэгтэй. Ерөнхий шалгалтын хувьд ашиглалтын эрх эзэмшигчийн жилийн санхүүгийн тайлангуудыг (болж өгвөл аудитлагдсан) олж аван нийт борлуулалтын дүнг нөөц ашигласны төлбөрийн хамт ирүүлсэн тоон мэдээлэлтэй харьцуулж үзэх хэрэгтэй. Яваандаа хэсэг хугацааны дараа нөөцийн хэмжээний өөрчлөлтөөс үүдсэн зөрүү нь тухайн тооцоотой харьцуулахад материаллаг бус болж хувирах бөгөөд борлуулалт, үйлдвэрлэл хоёрын харилцан хамаарал улам их болох болно.

Түүхий нефтийн жишээ. Энэ жишээнд үйлдвэрлэсэн түүхий нефтийн борлуулалтын үнийн дүнгийн дөрвөн хувьд нөөц ашигласны төлбөр ногдуулна гэж үзье:

Нөөц ашигласны төлбөрийн энэ системд хяналт тавих дөрвөн үндсэн алхам байдаг:

- Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээг тогтоох (зарим оронд оролцогч талууд энэ мэдээллийг засгийн газрын ном хэвлэлүүд, эсхүл ОУИТБС-ын маягтаар дамжуулан олж авдаг)
- Борлуулалтын үнийн дүнг тодорхойлох
- Тооцоог шалгах
- Уг дүнг хүлээн авагч байгууллагад төлөгдсөн эсэхийг шалгах

Уурхайн жишээний нэг адил шалгалтын үе шат бүрт сорилт бэрхшээл тулгардаг. Юуны өмнө юу үйлдвэрлэснийг нь шалгах хэрэгтэй. Хэдийгээр энэ нэр томъёог нийтлэг хэрэглэдэг боловч “үйлдвэрлэсэн” гэдэг үгийн нарийн тодорхойлолтыг хуульчлан зааж өгсөн байх болно. Энэ нь, цооногоос гаргасан бүтээгдэхүүний хэмжээ, экспортлосон хэмжээ, эсхүл энэ хоёрын дунд хаа нэгтээ тогтоосон хэмжээ байж болох юм. Түүхий нефтийн урсгал ихэвчлэн

нарийн биет хяналт, нягт нямбай хэмжилтүүдэд (“төсөвжүүлэлт” гэж нэрлэж болно) ордог. Хэмжилтийг зохицуулагч байгууллагын болон түүхий нефть эзэмшигчийн төлөөлөгчдийн аль алиныг байлцуулан хийх болно.

Үйлдвэрлэлийн хэмжээнээс гадна бүтээгдэхүүний үнийг мэдэх шаардлагатай. Энэ нь нэг талаас олон улсын зах зээлийн асуудал, нөгөө талаас техник асуудал байдаг. Үнэ тогтоолт нь олон улсын жишиг үнэд тулгуурлан тухайн газрын тосны байршлаас хамааран тохируулга хийсэн байж болно. Хэрэв хууль тогтоомжид ямар нэг үнэ тогтоохыг шаарддаг бол ихэвчлэн агентлаг өөрөө уг үнийг тогтоож, үйлдвэрлэгч нарт зарлах болно. Бодит борлуулалтын үнийг хэрэглэх практик тэр бүр байдаггүй нь газрын тосны салбар дахь босоо нэгдэлтүүдийн хамрах хүрээтэй холбоотой. Ихэнх үйлдвэрлэгчид түүхий нефтиэ харьяа компанидаа өгч боловсруулалт хийлгэдэг учраас харьяа газартаа шилжүүлэх үнэ нь зах зээлийн үнийг тусгаагүй байж болно.

Түүнчлэн үнийн тохируулга хийхийн тулд тухайн газрын тосны API үзүүлэлтийг мэдэх шаардлагатай. Үүний тулд каргонд шалгалт хийх, талбайн онцлогыг ойлгох, лабораторын шинжилгээ хийх шаардлагатай. Бүх ачааг үйлдвэрлэгч, тээвэрлэгч (мөн өөрийн гэсэн жижиг лабораторитай байна), зохицуулагч байгууллагын нэрийн өмнөөс шалгаж шинжлэн, улмаар тухайн түүхий нефтийн олборлолтын API-тай тулган баталгаажуулдаг.

Түүхий нефтийн нөөц ашигласны төлбөрт зориулсан төлбөрийн баримтууд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийнхтэй төстэй байдаг боловч нэг чухал ялгаа бол газрын тосны нөөц ашигласны төлбөрийг ихэвчлэн АНУ-ын доллараар төлөх үүрэгтэй байдаг. Иймээс энэ гүйлгээ ихэвчлэн хилийн чанадад, магадгүй Нью-Йоркод хийгдэх бөгөөд төлбөр нь тухайн банкнаас гаргасан SWIFT мэдэгдэл хэлбэртэй байна.

9.2 Ашгийн татваруудыг шалгах

Газрын тосны бүтээгдэхүүний татвар ногдуулалт бол маш нарийн төвөгтэй чиглэл бөгөөд төлвөл зохих татварыг тооцоолон бодох дүрмүүдийг⁶¹ ихэвчлэн хууль тогтоомжид нарийвчлан зааж өгсөн байдаг. Татвар ногдуулалтын энэ хэлбэр нь агуулгын хувьд ашигт тулгуурласан байдаг.

Ашигт малтмалын татвар нь бусад аль ч салбарын үйл ажиллагааны татвартай тун төстэй байдаг бөгөөд бид энд дахиж авч үзэхгүй. Харин газрын тосны татвар бол зарим нэг өвөрмөц онцлогтой төдийгүй улс орон бүрт харилцан адилгүй байдаг бөгөөд заримдаа бүр зарчмын үндсэн ялгаатай байж болно. Жишээлбэл, зарим оронд бүтээгдэхүүн хуваах гэрээг татвараас чөлөөлдөг (учир нь бүтээгдэхүүн хуваах гэрээ өөрөө ашигт татвар ногдуулсан байдаг). Бусад орнуудын хувьд бүтээгдэхүүн хуваасны дараа үлдэх үр дүнд татвар ногдуулдаг байна. Татварын дүрэм журмуудыг үнэлж дүгнэх нь энэ хэсгийн зорилго биш, харин тодорхой шалгалтын үйл явцуудад тайлбар өгөх явдлаар хязгаарлагдана.

Татварын тогтолцооны онцгой өөр хоёр төрөл байдаг:

- Татварын алба мэдээлэл хүлээн авч, түүндээ тулгуурлан татвар төлөгчид татвар ногдуулдаг системүүд
- Татвар төлөгч төлөх татварынхаа хэмжээг өөрөө үнэлж, тооцоогоо татварын албанд ирүүлдэг системүүд

Эдгээрийн эхнийх нь татвар ногдуулалтын уламжлалт арга байж ирсэн юм. Гэхдээ улс орнууд өөрөө үнэлэх системд шилжих нь улам бүр нэмэгдэж байна. Учир нь, өөрөө үнэлэх систем нь татвараа өөрөө тооцоолоод зохих дүнг өөрөө төлдөг утгаараа татвар төлөгчийн үүрэг хариуцлагыг дээшлүүлж өгдөг байна. Өөрөө үнэлэх системүүдэд татварын алба санамсаргүй сонголтоор, татвар төлөгчийн онцлогт тулгуурласан хяналт шалгалт хийдэг учраас хэрэгжилт нь илүү үр ашигтай байдаг байна. Мөн өөрөө үнэлэх системд хэрвээ татвараа худал мэдүүлсэн, дутуу төлсөн нь тогтоогдох юм бол ихэвчлэн хүнд торгууль ногдуулдаг байна.

Ихэвчлэн тухайн улсын татварын алба татварын асуудлыг удирддаг боловч газрын тосны татвар бусад салбарын татвараас өөр учраас татварын алба өөрийн газрынхаа хүрээнд тусдаа тасаг байгуулж энэ чиглэлийн мэргэшсэн удирдлагаар хангадаг байна. Газрын тосны татварт их хэмжээний мөнгөний асуудал хөндөгддөг учраас татварын албанд газрын тосны чиглэлээр мэргэжин ажиллаж байгаа хүмүүсийг зохих ёсоор сургаж дадлагажуулах нь чухал. Мэдээж хэрэг, газрын тосны компаниудад ажиллаж байгаа татварын мэргэжилтнүүд төлвөл зохих хэмжээнээсээ илүү татвар төлөхгүй байхын төлөө ажилладаг учраас татварын албанд тэднээс дутахааргүй хэмжээний мэдлэг туршлагатай ажилтнууд хэрэгтэй.

Ерөнхийдөө, газрын тосны компаниуд татварын өрийн дансандаа сар бүр төлбөр хийж байдаг. Ийнхүү татвар төлөгдөж байгаа үед үнэхээр үндэслэлтэй хэмжээний татвар төлж байгаа эсэхийг нь шалгах ямар нэг мэдээлэл татварын албанд байдаггүй. Үндсэн шалгалтууд нь сүүлд хийгдэх бөгөөд ингэхдээ жилийн ашиг орлого, санхүүгийн тайлангуудад нь тулгуурладаг байна.

Тухайн тайлангаас шалгах шаардлагатай гол элементүүд бол:

- Аудитлагдсан санхүүгийн тайлангуудтай тулгаж шалгах ажиллагаа
- Нийт орлогын дүн нь зөв эсэх
- Капиталын зардалд оруулж мэдүүлсэн зүйлс (тухайлбал, барилгын ажил, эсхүл нэгээс дээш жилийн ашиглалтын настай хөрөнгүүд, түүний дотор өрөмдлөгийн тавцангууд, барилга байгуулж, машин механизмд зарцуулсан зардал)
- Гол зардлын зүйлсийг зохих ёсоор хасч тооцсон эсэх.

Тухайн компаниас ирүүлсэн татварын тайланд татварын албаныхан ширээн дээрээ шалгалт хийдэг. Үүний дараа татварын албанаас компанитай холбоо барьж уг тайланг нотлох тодорхой баримт бичиг, мэдээллүүд ирүүлэхийг шаардаж болно. Энэхүү нэмэлт мэдээллийг цаашид хянан үзсэний үндсэн дээр нэмэлт татвар ногдуулж болох талтай.

Татвар төлөгчийн ирүүлсэн татварын бүх тайланд аудитлагдсан бүртгэл тооцоог дагалдуулсан байх бөгөөд энэ нь татвар ногдуулалт хийх эхний цэг байх ёстой. Тэд мөн аудитлагдсан бүртгэл тооцоо ба татварын тайлангийн хооронд гарсан аливаа зөрүүг хангалттай тайлбарласан байх ёстой.

Нигерид хийсэн аудитаар татварын тооцоонуудыг аудитлагдсан бүртгэлтэй нь тулгаж шалгаагүй, татварын албанд үүнийг хийх мэдлэг туршлага дутагдаж байгааг тогтоосон байна. Аудиторуудын зүгээс татварын албаны чадавхийг бэхжүүлэхэд шаардлагатай алхмуудыг зөвлөмж болгожээ. Үүний үр дүнд чадавхийг бэхжүүлэх томоохон арга хэмжээ авсан байна.

Татварын зорилгоор тооцсон нийт орлого нь санхүүгийн тайлангуудад заасан нийт орлогоос өөр байж болох юм. Нөөц ашигласны төлбөрийн жишээнд гарсан шиг, ашгийн татварын тооцоонд газрын тосны борлуулалтын бодит үнийг бараг ашигладаггүй байна. Харин түүний оронд засгийн газраас урьдчилан тогтоосон үнэд тулгуурлан тооцдог байна. Үүнийг зөв зохистой хийсэн эсэхийг татварын алба шалгахыг хүсэх болно. Энд гурван үндсэн элемент байдаг:

- Орлого олоход ашигласан үнүүдийг нотлох
- Зохицуулагч байгууллагаар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээг нотлуулах
- Газрын тосны олборлолтыг ГТҮК-аар нотлуулах

Санхүүгийн тайланд болон татварын тооцоонд ашигласан газрын тосны борлуулалтын хэмжээ нь нөөц ашигласны төлбөрийг тооцоход ашигласан дүнтэй тохирох буюу тулгаж болохоор байх ёстой. Нөөц ашигласны төлбөрийн тооцоог шалгасан зохицуулагч байгууллага нь үйлдвэрлэсэн газрын тосны хэмжээг шалгаж үзсэн байх учраас тэр хэмжээ нь ашгийн татвар тооцох үндсийг бүрдүүлэх ёстой. Энэ нь татварын алба ба зохицуулагч байгууллагын хооронд ажил төрлийн харилцаа холбоотой байх ёстой гэсэн үг. Хэдийгээр энэ нь энгийн хялбар мэт санагдах боловч хүндрэл бэрхшээлийн нэг байх нь олонтаа. Засгийн газрын байгууллагууд тус тусдаа ажиллах, хоорондоо мэдээлэл солилцохгүй байх хандлагатай байдаг. Заримдаа тэднийг мэдээлэл солилцоход хууль тогтоомж, эсхүл нууцлалын гэрээнүүдээр илт саад учруулсан байдаг. Иймээс тэд орлогыг эрсдэлд оруулж байгаа эсэх, засгийн газрын дотоод мэдээлэл солилцоог зөвшөөрсөн арга хэмжээ авагдаж байгаа эсэхийг тодорхойлохын тулд эдгээр асуудлыг шалгаж үзэх хэрэгтэй.

Нигерид хийсэн аудитаар, татварын тооцоо нь зохицуулагч байгууллагаас шалган тогтоож, нөөц ашигласны төлбөр тооцоход ашиглаж байсан тоон мэдээлэлд тулгуурласан байх нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн ямар нэг үйл явц байхгүй байгааг тогтоосон байна. Уг аудитын үр дүнд, засгийн газрын байгууллагуудын уялдаа холбоог хянан үзсэн байна.

Татварын бүх хууль тогтоомжид капиталын зардлуудад онцгой анхаарал хандуулсан байдгийг хүлээн зөвшөөрөх нь чухал. Капиталын зардлын дүнгүүд маш том байдаг бөгөөд татварын тооцоонд нөлөөлөхийн тулд тэдгээрийн хандлагыг “зөөлрүүлэх” боломж бол хөнгөлөлтүүдэд (“капиталын хөнгөлөлт”, эсхүл “хөрөнгө оруулалтын хөнгөлөлт” гэх нь элбэг) татварын байр сууринаас хэрхэн хандахыг нарийвчлан заасан хууль тогтоомж батлан гаргана гэсэн үг юм. Татварын алба зардлын шинжилгээг шалган зарим капиталыг өөр зардалд, тухайлбал засварын зардалд нуугаагүй гэдгийг тогтоох хэрэгтэй болно. Мөн тэд компаний үйл ажиллагааг хааяа газар дээр нь очиж үзэн, тухайн талбайг заасан ёсоор ашиглаж байгаа эсэхийг шалгаж болох юм.

ОУИТБС-д холбоотой байдал. Татварын албанд энэ төрлийн хяналт шалгалт хийхэд шаардлагатай ур чадвар, боловсон хүчин хангалттай байгаа эсэхийг асуу. Хэрэв тийм биш бол татварыг зохих ёсоор төлж байгаа гэдэгт яаж итгэлтэй байж чадна вэ?

Татварын алба нь татварын хяналт шалгалт буюу аудит хийх эрх мэдэлтэй байж болно. Зарим улсад (тухайлбал, Их Британи) ийм хяналт шалгалт хийх хууль ёсны эрх байдаггүй боловч эрх бүхий байгууллагууд шалгалтанд шаардагдах мэдээллийг олж авах өөр бусад аргуудыг хэрэглэдэг. Татварын хяналт шалгалтыг

жил бүр, компани бүрт хийдэггүй. Ийм хяналт шалгалт хийх тохиолдолд ерөнхийдөө тогтмол ирүүлдэг татварын тайлан ба санхүүгийн тайлангуудад ороогүй баримт бичгүүдийг шалгахад гол анхаарлаа хандуулдаг.

Төлвөл зохих татварын хэмжээ нь зардлын дүнгээс ихээхэн хамаардаг. Гэхдээ эдгээр нь шалгахад хамгийн хэцүү элементүүд байдаг. Зардлыг зөвхөн Мөнгөний үнэ цэнийн (МҮЦ) үнэлгээгээр зөв зохистой баталгаажуулж чадах бөгөөд энэ үнэлгээ нь зардлын элементүүдийн хэмнэлт, үр ашигтай байдал, үр нөлөөтэй байдал гурвыг шалгадаг:

- *Хэмнэлт* гэдэг нь салбарын үйлдвэрлэлд оролцогчид зарлагын удирдлагадаа ариг гамтай хандах, ерөнхийдөө “аж ахуйгаа сайн авч явах” практикийг хэлнэ. Иймээс МҮЦ-ийн аудит нь зохих чанар, тоо хэмжээтэй хөрөнгө нөөцийг хамгийн бага зардлаар олж авч байгаа эсэхийг шалгадаг.
- *Үр ашигтай байдал* нь орц ба холбогдох гарцын харьцааг хамгийн бага болгохтой холбоотой ойлголт юм. Тухайлбал, МҮЦ-ийн аудит нь чухал зорилгогүй, эсхүл материалын илүүдэл хуримтлал үүсгэхэд хүргэдэг үйл ажиллагаануудыг тогтоох гэх мэтээр тухайн үйл ажиллагаанд байгаа үр ашиггүй байдлуудыг илрүүлэхийг зорьдог.
- *Үр нөлөөтэй байдал* гэдэг нь өгөгдсөн үйл ажиллагааны гарц буюу үр дүн нь хүлээгдэж байсан түвшинд хүрсэн, эсхүл хүссэн зорилго, зорилтуудыг хангасан байхыг хэлнэ. Үр нөлөөтэй байдлыг үнэлэхийн тулд, нэгдүгээрт зорилтуудаа тодорхойлж гаргах, хоёрдугаарт гүйцэтгэлээ тавьсан зорилтуудтайгаа харьцуулж үнэлэх шаардлагатай.



||| ХЭСЭГ

ГҮН ӨРӨМДӨЖ ҮЗЭХҮЙ

Î - È Ò Á Ñ - û í
í ã ñ ý í õ ç ð ý ÿ ã
ã ç í ç ã è é ð ç ç è ý õ í ü

БҮЛЭГ 10

10.1 ОУИТБС-ын Үндсэн хүрээг гүнзгийрүүлэх нь

ОУИТБС-ыг хэрэгжүүлэхийг зорьж байгаа аливаа улсын хувьд эхлээд “нэр дэвшигч” улс болоод дараа нь “дагаж мөрдөгч” орон болох чиглэлд орох нь томоохон алхам юм. Зөвхөн ОУИТБС-ын Үндсэн хөтөлбөрийг эхлүүлэхэд л багагүй хугацаа, итгэлцэл, туршлага шаарддаг. Оролцогч талууд бие биедээ дасч, тухайн салбарын тухай ойлголтоо гүнзгийрүүлэх, үл итгэлцэлийг даван туулах, авлига, зохисгүй удирдлагын үр үндсийг таслахын хэрээр ОУИТБС-ын үндсэн хэрэгжилтээс цааш харж, илүү гүн гүнзгий шаардлага тавихад анхаарах хэрэгтэй.

Энэхүү бүлэгт иргэний нийгмийн шийдвэрлэвэл зохих гурван чухал асуудлыг авч үзнэ:

- Улс орныхоо ОУИТБС-ын хөтөлбөрийн хувьсал хөгжлийг хэрхэн төсөөлөх вэ
- ОУИТБС-ын оролцогч талууд ОУИТБС-ын бүрэн эрхийг өөрийн улс орны өвөрмөц онцлог бүхий зорилтууд, дотоодын нөхцөл байдалд тохируулан хэрэглэхийг хүсч болох шалтгаанууд
- Анхаарах бусад гол асуудлууд

10.2 Аливаа улсын ОУИТБС-ын хөтөлбөрийн хувьсал хөгжлийг хэрхэн төсөөлөх вэ

Олон орны хувьд ОУИТБС бол ил тод байдал ба авлигын эсрэг арга хэмжээнүүдийг хамарсан өргөн хүрээтэй хөтөлбөрийн зөвхөн нэг элемент байх юм⁶². Магадгүй олон оролцогч талын форумын хувьд хамгийн хэрэгтэй нь байж ч болно. Бусад оронд бол олборлох үйлдвэрлэлийн салбарт ил тод байдал авчрахад чиглэсэн тэргүүлэх хүчин чармайлтуудын нэг байж болох юм. Иймээс дараахи зарчмуудыг баримталж байх нь чухал:

- *ОУИТБС бол ямар нэг төгсгөлгүй арга хэрэгсэл.* ОУИТБС нь оролцогч талуудыг нэгтгэн цуглуулах сайн дурын арга юм (гэхдээ боломжтой бол үндэсний хууль тогтоомжид тусгахыг бид зөвлөмж болгодог). Энэ нь, иргэд үндэснийхээ төсөвт байгаа улс орныхоо санхүүгийн нөөцийн талаар суурь боловч үнэн зөв мэдээлэлтэй байх баталгаагаар хангаж, ард түмэн төр засгийнхаа үйл ажиллагаанд хариуцлага тооцоход тусалдаг.
- *ОУИТБС бол сайн дурын хөтөлбөр.* Аливаа улс ОУИТБС-ын нэрийг ашиглахын тулд авбал зохих чухал алхамуудыг ОУИТБС-ын Баталгаажуулалтын зааварт зааж өгсөн байдаг боловч танай улсын ОУИТБС-ын хөтөлбөр та бүхний онцлог нөхцөл байдалд тохирсон, мөн иргэний нийгэм, компаниуд, засгийн газрын санал нэгтгэйгээр тавьсан зорилгуудад нийцэхээр засч тохируулсан байх ёстой.
- *ОУИТБС-ын хөтөлбөр хувьсан хөгжих ёстой.* Энэ хөтөлбөрийг зөвхөн эхлүүлэхэд л асар их ашиг тустай байдаг. Олборлох үйлдвэрлэлийн орлого, практикуудын талаар хэлэлцэх олон оролцогч талын бүлэгтэй байх нь бараг улс болгонд цоо шинэ зүйл байх болно. Зүгээр л ООТБ-ээ байгуулж чадна гэдэг бол нэг ололт амжилт юм. Бүлгийн гишүүд бие биенээ таньж мэдэх, итгэлцэл бий болгох, мэдлэгийн нийтлэг нэг суурьтай болоход тодорхой хугацаа шаардагдана. Харин эдгээр үндсэн шаардлагууд хангагдсаны дараа иргэний нийгмийнхэн (оролцогч талуудын төлөөлөгчидтэй хамтран) уг хөтөлбөрийг хэрхэн сайжруулах, оролцогч талуудын чадавхийг хэрхэн бэхжүүлэх, үр дүнгийн мэдээлэл сурталчилгааг хэрхэн дээшлүүлэх вэ гэдэгт анхаарлаа хандуулах хэрэгтэй.
- *ОУИТБС нь “дотооддоо хөгжүүлсэн” хүчин чармайлт байх ёстой.* Улс орнууд ОУИТБС-ыг авч хэрэглэж байгаа шалтгааны хувьд харилцан адилгүй байдаг. Орлого, төлбөрүүдийн талаар дөнгөж мэдээлж эхэлж байгаа орнуудын хувьд ОУИТБС бол ил тод байдлыг нэвтрүүлэх нэг арга зам юм. Иргэний нийгмийн байгууллагууд юуны өмнө гол алхамуудаа хийх, түүний дотор ажлын төлөвлөгөө боловсруулах, нэгтгэн тулгагчдийг авч ажиллуулах, тайлангаа хэвлэн нийтлэх, үр дүнг түгээн дэлгэрүүлэх хэрэгтэй. Харин үндэсний болон гадаадын компаниуддаа хэдийн аудит хийж, орлого, төлбөрийн тоо баримтуудаа нийтэлчихсэн улсуудын хувьд төв банкны хүлээн авсан мөнгө хаашаа орж байгаа талаархи олон нийтийн мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд гол анхаарлаа хандуулдаг: Энэ мөнгө муж, аймаг орон нутгууд руу шилжиж байна уу? Тийм бол хэдий хэр мөнгө шилжиж байна вэ? Эдгээр мөнгийг хэрхэн зарцуулж байна? Түүнчлэн ОУИТБС нь тухайн улсын хөрөнгө оруулалтын хүрээг сайжруулах хэрэгсэл байж болох төдийгүй аливаа улс нөөц баялгаа ашиглуулах тусгай зөвшөөрөл олгох, тэдгээрийг зохицуулах, зах зээлд борлуулах замаар нөөц баялгийнхаа үр шимийг маш сайн хүртэж чадаж байгаа эсэхийг хамтран судлах хэрэгсэл байж болно.

10.3 ОУИТБС-ЫГ ХЭВШҮҮЛЭХ ЁСТОЙ

ОУИТБС нь олборлох үйлдвэрлэлийн салбарт хандлагын өөрчлөлт гаргах хэрэгтэй. Олон улсын олон оролцогч талын зөвлөлөөс тодорхойлсон ОУИТБС-ын нэг илэрхий зорилго бол ойрын жилүүдэд ОУИТБС-ыг засгийн газрууд, компаниудын үйл ажиллагааны ил тод, хариуцлагатай байдлын олон улсын шинэ стандарт болгон хэвшүүлэх явдал юм. Үүний тулд ОУИТБС-ын орнууд өөрсдийн практик, зарчмуудыг олборлох үйлдвэрлэлийн засаглалын байнгын онцлог шинж болгож институтжуулах шаардлагатай. Улс орнуудын олон оролцогч талын бүлгүүд ОУИТБС-ын үйл явцыг анхнаас нь тогтвортой байлгахад онцгой анхаарч, ОУИТБС бол нэг удаагийн дасгал биш, цаашид үргэлжлэн улам гүнзгийрэх ажиллагаа болгох алхамуудыг авах хэрэгтэй. Азербайжан Улс ОУИТБС-ыг НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаар батлуулахыг эрмэлзэж байгаа нь түүний олон улсын хэм хэмжээний статусыг бататгаж өгөх зорилготой юм. Тус салбарын ажиллах арга барилд ил тод байдал хэвшиж, олон нийтийн сонирхсон мэдээллийг тогтмол хэвлэн нийтлэх ажил хэвийн үзэгдэл болох болно. ООТБ-ийн зүгээс ОУИТБС-ыг хууль тогтоомжид суулгаж өгөхөөс гадна тус санаачилга олборлох үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд алхам алхамаар нэвтэрч, энэ салбарын үйл ажиллагаа хэрхэн явагдаж байгаа, эцсийн дүндээ тухайн улсын ашиг тусын төлөө байгаа эсэхийг иргэний нийгмийнхэнд тайлбарлан ойлгуулна гэдгийг онцлон тэмдэглэх хэрэгтэй.

10.4 Бүх оролцогч талууд ОУИТБС-ын бүрэн эрхийг өөрийн улсад тохируулан хэрэглэхийг хүсч болох шалтгаанууд

ОУИТБС-ын Баталгаажуулалтын зааварт шаардсан элементүүдээс цааш явах талаар бүх оролцогч талуудын дунд ямар нэг зөвшилцөлд хүрсэн байх ёстой. Зарим улсын иргэний нийгэм, компаниуд ба засгийн газрууд ОУИТБС-ын Үндсэн хүрээнээс ОУИТБС-ын Нэмэлт хүрээнд шилжих болсон олон шалтгаан байдаг. Үүнд:

- Авлигыг бууруулах
- Тухайн улс мөнгөний үнэ цэнийг хүртэх нөхцөл бүрдүүлэх
- Үндэсний итгэлцэлийг бэхжүүлэх
- Улс орны нэр хүнийг дээшлүүлэх
- Хөрөнгө оруулалтын илүү өрсөлдөөнт уур амьсгал бий болгох
- Татвар, нөөц ашигласны төлбөрийн хураалтыг дээд цэгт хүргэх
- Муж, орон нутгийн зарцуулалтын талаар олон нийтэд мэдлэг боловсрол олгох

Авлигыг бууруулах. Санхүүгийн тулгалт хийж, олборлох үйлдвэрлэлийн тухай яриа хэлэлцүүлэгт иргэний нийгмийг оролцуулах нь ихээхэн нууцлагдмал энэ салбарт асар их хэмжээний “гэрэл гэгээ” авчирдаг байна. Ийм учраас иргэний нийгмийн нэн тэргүүний зорилт бол ОУИТБС-ын үйл явцыг эхлүүлж, эхний тайланг гаргах явдал байх ёстой. Харин тус санаачилгын ажил урагшилж тодорхой “сургамжууд” авч суралцаж болохоор хэмжээнд нэгэнт хүрсэн тохиолдолд оролцогч талууд тэднийг анх нэг ширээнд авчрахад хүргэсэн үндсэн асуудлууд шийдэгдсэн эсэх талаар өөрсдөөсөө асуух хэрэгтэй. Энэхүү үндсэн асуудал нь авлига үүсэх боломж байсан тохиолдолд магадгүй ОУИТБС-ыг үйл явцыг гүнзгийрүүлэх цаг болсон байж болно.

Тулгалтын дүнд зарим зөрүүтэй байдал гарч болох боловч авлига, зохисгүй удирдлагад хүргэж болох зарим төрлийн дутагдал, эмзэг байдлыг илрүүлж чадахгүй байж болзошгүй. Авлига маш олон нарийн байдлаар явагдаж болно. Хэрэв нэг албан тушаалтны гарт хэтэрхий их дур зоргоор ажиллах боломж олговол төслийн эрхийг компаниудад олгох тал дээр нөлөөлөлд автаж болзошгүй. Дотоод агууламжаар хангагч, үйл ажиллагаа эрхлэгч, эсхүл бүр түүхий нефть, ашигт малтмал худалдан авагч байх шаардлагуудыг ямар компани, эсхүл хувь хүмүүс хангаж чадах вэ гэдэгт ямар нэг техникийн шаардлага тавиагүй тохиолдолд огт шаардлага хангахгүй тал (магадгүй засгийн газар, эсхүл компаний албан тушаалтнуудтай холбоо сүлбээтэй) эдгээр эрхийг авахад “ялалт байгуулж”, түүнийгээ хэн нэгэнд зүгээр худалдчихаж болно. Эдгээр эмзэг талуудыг шийдвэрлэхийн тулд тодорхой нэг улсад байгаа ОУИТБС-аас олборлох үйлдвэрлэлийн бизнес одоо хэрхэн ажиллаж байгаа, техникийн шалгууруудыг хэрхэн тогтоодог, эдгээр эмзэг талуудыг арилгахын тулд ОУИТБС-ын төслүүдийг хэрхэн боловсруулсан талаар мэдэхийг хүсч болно.

Үндэсний итгэлцэлийг бэхжүүлэх. Зарим орнуудад олборлох үйлдвэрлэлд оролцогчдод үл итгэх байдал ихээхэн газар авсан байдаг. Энэ нь гол төлөв засгийн газар хэр их мөнгө олдог, компаниуд засгийн газарт хэр ихийг төлдөг, компаниуд дотоодод хэр ихийг зарцуулдаг талаархи олон нийтийн ойлголт ба бодит байдал хоёр зөрсөнтэй холбоотой байдаг. Олборлох үйлдвэрлэлийг гүн гүнзгий шалгаж үзсэнээр итгэлцэлийг бэхжүүлж, хүлээлтийг илүү бодитой болгоход тусалж болно.

Жишээлбэл, Мавритани Улсад ОУИТБС-ыг эхлүүлсэн нь тухайн үеийн засгийн газар ил тод байж, сонгууль болохоос өмнө ил тод байдлыг институтжүүлэхэд бэлэн гэдгээ харуулахад чиглэгдсэн олныг хамарсан ил тод байдлын хөдөлгөөний нэг хэсэг байв. Нигери Улсын Ерөнхийлөгч Обасанжо ба түүний шинэчлэлийн баг олборлох үйлдвэрлэлд оролцож буй төрийн байгууллагууд ба компаниудын газрын тосны үйлдвэрлэлээс эхлээд түүнийг төсөвжүүлэх хүртэл ажиллагаанд өргөн хүрээтэй аудит хийж, тус салбарын томоохон үйл ажиллагаануудыг (лиценз олголт гэх мэт) олон улсын стандартуудтай харьцуулах замаар итгэлцэлийг бэхжүүлэх нэг арга зам бол ОУИТБС гэж үзсэн байна. Энэ үеэр системийн чанартай томоохон дутагдалууд илэрсэн боловч компаниуд ба засгийн газрын хувьд тус салбарт энэхүү гүнзгий, хараат бус шалгалт хийхэд бэлэн байгаагаа харуулсныхаа үр шимийг хүртсэн байна.

Улс орны нэр хүндийг дээшлүүлэх. Олон орон дэлхий дахины хөгжлийн индексүүдэд бага оноо авах, авлигын индексэд өндөр оноо авах гэх мэт сөрөг нэр хүндтэй байдаг. Ашиглалтын талбай эзэмших эрхийг сайдын дур зоргоор биш, тендер шалгаруулалтын аргаар олгох гэх мэтээр тухайн улсад бизнес эрхлэх арга замыг сайжруулах боломжуудыг авч үзэхэд бэлэн байдал нь улс орны нэр хүндийг дээшлүүлж болно. Мөн компаниуд (ашиглалтын талбайн төлөө өрсөлдөх адил тэгш тоглолтын талбайн үр шимийг хүртэх), засгийн газрууд (өрсөлдөөний үр дүнд хоёр талын хэлэлцээрээс ч илүү орлого олж болох), иргэний нийгмийн (ил тод байдлын үр шимийг хүртэх) хүрээнд зөвшилцөл бий болгож болно.

Хөрөнгө оруулалтын илүү өрсөлдөөнт уур амьсгал бий болгох. Улс орнууд хөгжилдөө зориулж илүү их орлого олохын тулд хөрөнгө оруулалтын илүү өрсөлдөөнт хүрээ бий болгохыг хүсч болно. ОУИТБС-ын үйл явц нь тухайн улсын хөрөнгө оруулалтын хүрээний өнөөгийн байдлын үнэлгээг болон дүрэм журмаа илүү

ил тод болгосноор засгийн газрын авах хувь, эсхүл гарын үсгийн бонусын хэмжээг нэмэгдүүлж болох эсэх тухай үнэлгээг ажлын төлөвлөгөөндөө оруулж болох юм.

Шигтгээ 10.1: Сонгон шалгаруулалтыг ил тод явуулах нь үр өгөөжийг дээд зэргээр нэмэгдүүлж байна.

“Ливичууд одоогоор гартаа байгаа хэзрээр онцгой сайн тоглож, үйлдвэрлэлийн өсөлтөөс хүртэх боломжит ашгаа дээд цэгт хүргэсний хариуд тендер шалгаруулалтын үйл явцын ил тод байдлыг баталгаажуулахаа дахин нотлож байна гэж шинжээчид ярьж байна.”

Уаллис, Уиллиам: “Ливи улс: Гадаффи гарч ирснээр том бооцоо хожиж байна”

Файнаншиал Таймс, 2006 оны 2 дугаар сарын 28

Татвар ба нөөц ашигласны төлбөрийн хураалтыг дээд цэгт хүргэх. Төрийн институцүүд султай орнуудад компаниуд төлөх ёстой татвар, нөөц ашигласны төлбөрөө төлөхгүй байна, эсхүл засгийн газар зохицуулах үүргээ биелүүлэхгүй байна гэсэн ойлголтууд төрж болно. Хуулийг даган мөрдөж, сахиулж байна гэдгийг батлах сонирхол бүх оролцогч талуудад байдаг. Энэ тохиолдолд, компаниудыг түүвэрлэн сонгож, тэдний төлсөн татвар, нөөц ашигласны төлбөрийн тооцооны үнэн зөвийг шалгадаг аудитортой болох зөвшилцөлд хүрч болно. Ийнхүү санамсаргүйгээр “сорин шалгах” явцад зохицуулалтын тодорхойгүй байдлууд болон аудитын хувьд дутагдалтай талуудыг илрүүлэх, татвар ба нөөц ашигласны төлбөрүүдийг үнэн зөв хураасан, эсхүл төлсөн эсэхийг тогтоох боломжтой.

Орон нутгийн орлого, зарцуулалтуудын талаар олон нийтэд мэдлэг боловсрол олгох. Засгийн газар ба компаниудын бүртгэл тооцоог аудитлаж нийтэлдэг зарим оронд мөнгө төв засгийн газарт орсны дараа хаашаа ордог, эсхүл төв засгийн газраас өөр хаана очдог талаар олон нийтэд ойлгуулахад туслах нэг механзм бол ОУИТБС байдаг. Олон оронд үйлдвэрлэгч бүс нутаг ба үйлдвэрлэгч бүс бүс нутгийн аль алиных нь орон нутгийн засгийн газарт нилээд хэмжээний мөнгө төлдөг⁶³. Зураг 8.5-д энэ төрлийн хуваарилалтыг үзүүлжээ. Компаниуд ч бас орон нутагт үзүүлэх дэмжлэгт нилээд мөнгө зарцуулж болно. Эдгээр орлого нь нийт орлогын тодорхой хувийг эзлэх материаллаг урсгал биш байж болох ч эдгээр дүнг тоогоор илэрхийлэн нийтлэхийг иргэд хүсч байж болно. Компаниуд мөн тухайн улсад оруулж байгаа хувь нэмрийнхээ дүр зургийг олон нийтэд иж бүрэн, үнэн зөвөөр нь харуулахыг хүсч болно. Нийт ямар хэмжээний төлбөрийг хэнд төлөв гэдгийг иргэний нийгмийнхэн мэдэхийг хүсч байж болно. Муж, орон нутагт амьдарч байгаа иргэд ч орон нутгийн засгийн газруудад өгсөн мөнгөний хэмжээг мэдэж, улмаар хариуцлага тооцохыг хүсэх болно. Эдгээр тохиолдолд, аудиторууд болон нэгтгэн тулгагч нарын зүгээс бүх шатны засгийн газарт орж буй санхүүжилтын урсгалыг хөөн тодорхойлж, нийтлэх зөвшилцөлд хүрч болох юм.

Оролцогч талуудын зөвшилцөл, танай оронд тулгамдсан чухал асуудлуудаас хамаарч иргэний нийгмийн бүлгүүд ОУИТБС-ын хэрэгжилтийг өргөжүүлэн гүнзгийрүүлэх хүсэлтэй байж болно. Иймээс ОУИТБС-ыг хэрэгжүүлэх үндсэн хэлбэрээс хальж, олборлох үйлдвэрлэлээс гарсан нөөц баялгийн орлогын санхүүгийн удирдлагыг сайжруулах үндсэн зорилгод бодитойгоор үйлчлэхүйц өргөн хүрээтэй, алсын хараатай, найдвартай санаачилга (ө.х, ОУИТБС-ын Нэмэлт хүрээ) болгох зорилт тавигдаж байна.

Хүснэгт 10.1: Нигерийн Засгийн газраас мужуудад хуваарилж буй орлого

Холбооны Сангийн яам, Абужа

2008 оны 1 дүгээр сард Холбооны төсвийн хуваарилалтын хорооноос мужийн засгийн газруудад олгосон орлогын хуваарилалт, 2008 оны 2 дугаар сард гаргаж өгсөн мэдээ

1	2	3	4	5	6=4+5	7	8	9	10=6-(7+8+9)	11	12	13=6+11+12	14=10+11+12
№	Хүлээн авагч	ОНЗН-дийн тоо	Нийт хууль ёсны хуваарилалт	Эх үүсвэрийн 13%-н ногдол	Ерөнхий дүн	Хасалтууд			Цэвэр хууль ёсны хуваарилалт	Дотоодын илүүдэл түүхий нефтийн ашгаас олгох нэмэлт хувь	НӨГ-ын хуваарилалт	Нийт ерөнхий дүн	Нийт цэвэр дүн
						Гадаад өр	Гэрээний үүрэг (SPO)	Бусад хасалтууд (Тайлбарыг үзнэ үү)					
1	Абия	17	1,513,135,352.94	304,474,767.00	1,817,610,119.94	25,267,104.66	—	44,583,483.33	1,747,759,531.95	—	359,091,652.22	2,176,701,772.16	2,106,851,184.17
2	Адамава	21	1,687,918,434.14	—	1,687,918,434.14	27,519,435.69	—	111,562,500.00	1,548,836,498.45	—	336,330,639.19	2,024,249,073.32	1,885,167,137.63
3	Ахва лбом	31	1,667,122,866.72	6,311,560,667.44	7,978,683,534.16	103,122,388.37	—	—	7,875,561,145.79	—	399,404,571.85	8,378,088,106.01	8,274,965,717.64
4	Анамбра	21	1,690,094,025.30	—	1,690,094,025.30	44,364,368.98	10,000,000.00	16,308,000.00	1,619,421,656.32	—	385,830,356.09	2,075,924,381.39	2,005,252,012.41
5	Баучи	20	1,904,489,618.88	—	1,904,489,618.88	77,325,489.24	56,879,023.19	83,152,575.00	1,687,132,531.45	—	381,198,302.56	2,285,687,921.44	2,068,330,834.01
6	Баялса	8	1,311,404,878.27	4,230,118,632.53	5,541,523,510.80	25,302,536.39	—	7,087,500.00	5,509,133,474.41	—	299,144,248.26	5,840,667,759.06	5,808,277,722.67
7	Бэнүэ	23	1,821,250,695.80	—	1,821,250,695.80	21,357,530.31	—	131,999,000.00	1,667,894,165.49	—	372,282,531.07	2,193,533,226.88	2,040,176,696.57
8	Борно	27	1,933,320,606.43	—	1,933,320,606.43	22,927,402.71	—	109,932,650.00	1,800,460,553.72	—	362,618,953.14	2,295,939,559.57	2,163,079,506.86
9	Кросс Ривер	18	1,580,900,793.25	552,840,092.69	2,133,740,885.94	173,055,810.86	258,954,275.11	15,700,000.00	1,686,030,799.97	—	335,440,606.74	2,469,181,492.68	2,021,471,406.71
10	Дельта	25	1,688,517,126.84	3,797,313,993.77	5,485,831,120.61	96,507,348.26	—	6,120,000.00	5,383,203,772.35	—	446,127,557.10	5,931,958,677.71	5,829,331,329.45
11	Эбоний	13	1,428,133,508.76	—	1,428,133,508.76	23,360,077.74	—	17,000,000.00	1,387,773,431.02	—	303,234,854.91	1,731,368,363.67	1,691,008,285.93
12	Эро	18	1,679,936,776.56	64,400,955.55	1,744,337,732.11	102,415,602.89	—	32,115,000.00	1,609,807,129.22	—	344,395,489.83	2,088,733,221.95	1,954,202,619.06
13	Экити	16	1,420,204,919.09	—	1,420,204,919.09	6,101,320.03	—	39,545,000.00	1,374,558,599.06	—	308,400,404.82	1,728,605,323.92	1,682,959,003.89
14	Энүгу	17	1,571,410,761.06	—	1,571,410,761.06	58,312,768.82	—	42,789,412.50	1,470,308,579.74	—	419,351,151.79	1,990,761,912.85	1,889,659,731.53
15	Гомбс	11	1,445,698,713.77	—	1,445,698,713.77	9,235,406.98	—	145,501,250.00	1,290,962,056.79	—	303,607,151.80	1,749,305,865.58	1,594,569,208.60
16	Илю	27	1,665,644,975.94	432,383,074.19	2,098,028,050.12	75,864,559.98	—	19,325,000.00	2,002,838,490.14	—	367,367,396.31	2,465,395,446.43	2,370,205,886.45
17	Жигваа	27	1,849,437,932.68	—	1,849,437,932.68	16,486,132.89	1,000,000.00	76,187,692.00	1,755,764,107.79	—	385,740,612.48	2,235,178,545.16	2,141,504,720.27
18	Каруна	23	2,069,094,918.28	—	2,069,094,918.28	34,026,695.98	33,187,500.00	220,208,837.50	1,781,671,884.80	—	458,847,154.88	2,527,942,073.16	2,240,519,039.68

19	Каню	44	2,516,901,272.27	—	2,516,901,272.27	38,686,808.58	—	148,675,000.00	2,329,559,463.69	—	613,453,969.70	3,130,355,241.97	2,942,993,493.39
20	Кашина	34	1,973,507,250.61	—	1,973,507,250.61	18,533,397.02	—	—	1,954,973,853.59	—	425,185,933.24	2,398,693,183.84	2,380,159,786.82
21	Кебби	21	1,641,179,185.03	—	1,641,179,185.03	28,049,632.75	119,621,704.15	16,200,000.00	1,477,307,848.13	—	333,548,867.00	1,974,728,052.03	1,810,856,715.13
22	Когл	21	1,646,096,019.51	—	1,646,096,019.51	35,065,926.82	—	247,890,000.00	1,363,140,092.69	—	341,313,279.07	1,987,409,298.57	1,704,453,371.75
23	Квара	16	1,498,639,987.20	—	1,498,639,987.20	13,601,813.03	—	—	1,485,038,174.17	—	304,792,168.42	1,803,432,155.62	1,789,830,342.59
24	Лалос	20	2,378,443,772.27	—	2,378,443,772.27	196,903,270.15	351,404,109.59	225,000,000.00	1,605,136,392.53	—	2,542,937,606.30	4,921,381,378.57	4,148,073,998.83
25	Насарва	13	1,417,880,943.73	—	1,417,880,943.73	105,162,120.13	—	101,662,937.50	1,211,055,886.10	—	342,614,763.47	1,760,495,707.19	1,553,670,649.56
26	Нигер	25	1,906,720,094.12	—	1,906,720,094.12	112,529,284.72	—	250,247,550.00	1,543,943,259.40	—	352,598,630.76	2,259,318,724.88	1,896,541,890.16
27	Огун	20	1,606,075,211.44	—	1,606,075,211.44	53,550,240.88	33,750,000.00	16,051,000.00	1,502,723,970.56	—	383,565,189.90	1,989,640,401.34	1,886,289,160.46
28	Ондю	18	1,578,481,817.37	1,585,161,083.61	3,163,642,900.98	66,507,533.99	—	—	3,097,135,366.99	—	351,887,489.47	3,515,530,390.45	3,449,022,856.46
29	Осун	30	1,543,567,150.23	—	1,543,567,150.23	54,001,466.80	—	24,844,659.00	1,464,721,024.43	—	343,677,232.79	1,887,244,383.02	1,808,398,257.22
30	Обо	33	1,926,433,008.44	—	1,926,433,008.44	179,285,214.20	—	106,669,143.17	1,640,478,651.08	—	444,358,373.21	2,370,791,381.66	2,084,837,024.29
31	Плато	17	1,642,844,397.80	—	1,642,844,397.80	66,919,883.94	—	133,720,275.00	1,442,204,238.86	—	337,557,607.68	1,980,402,005.48	1,779,761,846.54
32	Риверс	23	1,817,256,470.10	10,088,250,448.49	11,905,506,918.58	65,668,959.34	—	89,325,000.00	11,750,512,959.24	—	758,934,110.44	12,664,441,029.03	12,509,447,069.69
33	Сокото	23	1,738,467,066.81	—	1,738,467,066.81	20,625,067.97	—	115,327,500.00	1,602,514,498.84	—	356,129,711.60	2,094,596,778.41	1,958,644,210.44
34	Тараба	16	1,624,769,944.85	—	1,624,769,944.85	17,463,405.51	—	160,145,000.00	1,447,161,539.34	—	353,387,596.22	1,978,157,541.07	1,800,549,135.56
35	Ёбэ	17	1,578,891,227.22	—	1,578,891,227.22	34,018,160.31	—	324,209,600.00	1,220,663,466.91	—	356,978,743.33	1,935,869,970.55	1,577,642,210.24
36	Замфара	14	1,636,365,047.36	—	1,636,365,047.36	9,231,903.05	—	39,267,500.00	1,587,865,644.31	—	334,282,502.21	1,970,647,549.58	1,922,148,146.53
37	Сокуллин маргаантай сан		—	—	—	—	—	—	—	—	—	—	—
38	Онн Асабороллин маргаантай сан		—	—	—	—	—	—	—	—	—	—	—
	Нийтдүн (муж/ОНН)		61,600,236,771.09	27,366,503,715.26	88,966,740,486.35	2,058,356,069.97	864,796,612.04	3,118,353,065.00	82,925,234,739.34	—	15,845,617,409.84	104,812,357,896.19	98,770,852,149.18

Тэмдэглэл: Бусад хасалтунд, Үндэсний усны нөхөн сэргээлтийн төслүүд, Үндэсний хөдөө аж ахуйн технологийг дэмжих хөтөлбөр, Бордооны төлбөр, Мужийн усны нөөцийн төсөл, Мужийн Хөдөө аж ахуйн төсөл, Үндэсний Фадама төсөл.

Эх сурвалж: Холбооны Ерөнхий нягтлан бодогчийн газар.



БҮЛЭГ 11

ᠠ - ᠡ᠋᠋᠋᠋᠋ - ᠠᠢ ᠠᠢ ᠠᠢ ᠠᠢ ᠠᠢ

ОУИТБС-ын хэрэгжүүлэлтийн хүрээнд дараахи арга замуудын нэг буюу түүнээс дээшийг нэмснээр ОУИТБС-ын Нэмэлт хүрээ тодорхойлогдоно:

- Санхүүгийн нэгтгэн тулгалтаас илүү өргөн хүрээтэй аудитад шилжих
- Биет аудит хийх
- Олборлох үйлдвэрлэлийн голлох үйл явцуудыг шалгах
 - Тусгай зөвшөөрөл (лиценз)-ийн олголт
 - Портфелийн удирдлага (Сайдын удирдлага)
 - Орон нутгийн түвшинд хүргэх
- Салбарын зардлуудыг харьцуулан жишиж үзэх
- Орлогын хүрээнээс цааш хальж түүний хуваарилалтад шилжих

11.1 Санхүүгийн нэгтгэн тулгалтаас илүү өргөн хүрээтэй аудитад шилжих

ОУИТБС-д зөвхөн засгийн газар ба компаниудын бүртгэл тооцоог тулгаж үзэхийг шаарддаггүй. Түүнээс гадна нэг бол аудитын олон улсын стандартууд, эсхүл ООТБ-ээс зөвшөөрсөн стандартуудыг хангасан байхыг шаарддаг. Компаниуд ихэвчлэн үндэсний, олон тохиолдолд олон улсын түвшинд, түүнчлэн хүлээн авагч засгийн газрын орлогын болон зохицуулалтын байгууллагуудаар аудит хийлгэснээ нотлох болно. Мөн дахиж өөр аудит хийх нь илүүц, үнэтэй, цаг мөнгө үрсэн хэрэг гэж үздэг. Түүнчлэн газрын тосны үндэсний компаниуд хүртэл аль хэдийн хараат бус аудиторууд авч ажиллуулсан, гадны байгууллагаар болон засгийн газрын зохицуулагч байгууллагаар аудит хийлгэгчигхсэн гэж маргадаг.

Олонх тохиолдолд эдгээр аудитлагдсан бүртгэл тооцооны баттай байдалд эргэлзэх шалтгаан байхгүй бөгөөд нэгтгэн тулгалт хийхэд хангалттай байх болно. Үнэн хэрэгтээ, иж бүрэн аудит хийхэд мөнгө зарснаас мэдээлэл сурталчилгааг сайжруулах, эсхүл чадавхийг бэхжүүлэхэд мөнгө зарсан нь дээр байж болох юм.

Гэвч зарим улсад цаад тоо баримтад нь олон нийт эргэлзэх явдал гарах болно. Үндэсний бүртгэл тооцоонд аудит хийж болох боловч аудиторунд нь олон улсын хэмжээнд хүртэл баталгаа гаргах боломжгүй байж болно. Ийм тохиолдолд засгийн газрын болон компаний бүртгэл тооцоог зүгээр нэгтгэн тулгалтаас аудит хийсэн нь ухаалаг хэрэг байж болох юм. Татварыг зөв тооцож, төлж, засгийн газарт бүртгэгдсэн эсэхийг шалгахын тулд аудиторунд орлогын гол урсгалуудыг санамсаргүй сонголтоор түүвэрлэн шалгах болно. Олборлосон нөөц баялгийн тоо хэмжээг зөв тооцсоны үндсэн дээр нөөц ашигласны төлбөр төлсөн эсэхийг тогтоохын тулд нөөц ашигласны төлбөрийн тооцоог шалгах болно. Холбогдох хууль тогтоомжийг мөрдөж байгаа эсэх, тухайлбал бараа, түүхий эдийн үнэ өөрчлөгдвөл төлөх дүн нь өөрчлөгдөх шаардлагатай эсэх гэх мэтийг энэ аудитаар шалгах болно. Ийм үйл явц өртөг зардал өндөртэй байж болох боловч хууль тогтоомжийн тайлбарлалт, зохицуулалтын хэрэгжилт болон чадавхийн зөрүүтэй байдлыг илрүүлэх тал дээр гайхалтай үр дүн гаргаж чаддаг.

11.2 Мөнгөний үнэ цэнэ

Зарим улсад олборлосон нөөц баялгийнхаа санхүүгийн үнэ цэнийг дээд зэргээр олж авч байгаа эсэхээ тогтоохыг иргэний нийгэм болон засгийн газрын зүгээс хүсч байж болохын зэрэгцээ компаниуд нь шударгаар ажиллаж байгаагаар олон нийтэд батлан харуулахыг хүсч байж болно. Улс орнууд олон байдлаар баялгийнхаа үнэ цэнийг алддаг байж болно. Тэд татвар, эсхүл нөөц ашигласны төлбөрөө зөв тооцож чадаагүй байж болно. Тэд хөрөнгөө зах зээлийн үнээс нь доогуур үнээр борлуулдаг байж болно. Тэд хамтарсан үйлдвэрийн компаниудын зардлыг хянаж чадаагүй, улмаар татвар ногдох орлого нь багасдаг байж болно. Тэд үйлдвэрлэсэн нөөц баялгаа хөнгөлөлттэй үнээр борлуулах замаар дотооддоо хэрэглэж, улмаар бүтээгдэхүүн импортоор авах, эсхүл ядуустаа тэтгэмж олгоснаас бага орлого олдог байж болно. Эдгээр үйл явцыг хараат бусаар шалгаагүй, эсхүл засгийн газрын болон компаний бүртгэлд бичигдэж байгаа бодит гүйлгээнүүдийг шалгаж, аудит хийгээгүй тохиолдолд ОУИТБС-ын нэгтгэн тулгалтаар эдгээр сул талыг шийдвэрлэж чадахгүй. Гэвч боломжит эмзэг талуудыг шалгаж, засч залруулах арга хэмжээ авах, эсхүл ийм зүйл байхгүй гэдгийг нь нотлох үүднээс оролцогч талууд зөвшилцөлд хүрч болох юм.

Хайрцаг 11.1: ОУИТБС-ын дагуу хүлээн авч байгаа ашиг орлогын урсгалаа тайлагнах үүрэг (хүлээн авсан орлогынхоо зарцуулалтад үнэлэлт өгөх бус)

ОУИТБС нь зөвхөн засгийн газарт орж буй санхүүгийн урсгалд анхаарал хандуулдаг болохоос засгийн газар хүлээн авсан мөнгөө хэрхэн зарцуулж байгаад анхаарал тавьдаггүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Олборлох үйлдвэрлэлд зарцуулж буй хөрөнгийн хувьд ч гэсэн засгийн газрын хөрөнгө оруулалтын талаар тайлагнах шаардлага ОУИТБС-д байхгүй. Гэсэн хэдий ч, эдгээр нь тухайн улсын олборлох үйлдвэрлэлийн санхүүгийн дотоод ажиллагааг ойлгоход чухал гэж үзэж байгаа бол ООТБ-ийн зүгээс уг тайлагнах хүрээг өргөтгөж, хөрөнгө оруулалт болон бусад гүйлгээг хамруулах сонголт хийж болно. Жишээлбэл, Нигери Улс засгийн газраас хамтарсан үйлдвэрүүдэд оруулсан хөрөнгийн дүнг тайлагнасан байна.

11.3 Зардлын харьцуулалт хийх

Олон оронд тавигддаг нэг гол асуулт бол нөөц баялаг үйлдвэрлэлтийн зардал нь зохистой буюу олон улсын практикт нийцсэн эсэх тухай байдаг. 2002-2007 оны хугацаанд үйлдвэрлэлийн зардал огцом өсч байх үед компаниудын мэдүүлсэн зардлын хасалтууд үнэн зөв эсэх, тэдгээр нь үндэсний орлогод нөлөө үзүүлэх эсэхэд санаа зовсон дотоод улс төрийн асуудлууд олонтаа үүсч байв. Эдгээр зардлын үнэн зөв байдлыг баталгаажуулах нэг арга бол Мөнгөний үнэ цэнийн (МҮЦ) аудит⁶⁴ хийх явдал юм. МҮЦ аудит нь сонгосон төслүүдэд ажиллаж буй компаниудын капиталын ба үйл ажиллагааны зардлуудыг судалж, бусад орны төслүүдийнхтэй харьцуулахыг хараат бус аудитор буюу шинжээчээс шаарддаг. Эдгээр харьцуулалт нь ижил төстэй төслүүдэд ашиглаж байгаа түүхий эд, материалуудын ялгаатай байдал, засгийн газрын шийдвэр гаргалтын хурд ба тогтвортой байдлын ялгаа, аюулгүй байдлын эрсдэл, улс төрийн эрсдэл, хөдөлмөрийн зардлын ялгаа зэргийг тооцох ёстой.

11.4 Биет аудит хийх

Олборлох үйлдвэрлэлийн салбарт засгийн газарт орж байгаа орлогын хэмжээ нь үйлдвэрлэсэн газрын тос, байгалийн хий, ашигт малтмалын хэмжээтэй уялдаатай байх нь олонтаа байдаг. Мөн энэ хэмжээнээс хамаарч нөөц ашигласны төлбөрүүд төлөгддөг бөгөөд тухайн газрын тосыг үйлдвэрлэхэд гарсан зардлыг хассаны дараа үлдэх ашгаас татвар төлдөг. Гэвч эдгээр дүнгүүд үнэн зөв эсэхийг нотлохын тулд олборлосон баялгийн хэмжээг үнэн зөв тайлагнасан, компани бүрийн мэдүүлсэн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний мэдээлэл засгийн газрын тооцоонд ашиглаж буй тоотой тохирч байгаа гэдэгт иргэд итгэлтэй байх ёстой. Үүнийг биет аудитын аргаар тогтоож болох бөгөөд засгийн газрын болон компаниудын мэдээлэл тохирч байгаа эсэхийг хараат бус аудиторроор шалгуулж, хэрэв тохирохгүй байгаа бол шалтгааныг нь тогтоолгодог.

11.5 Голлох үйл явцуудыг шалгах

Дээр дурдсанчлан, авлигын үндсийг таслах шилдэг арга бол танай засгийн газрын олборлох үйлдвэрлэлийг удирдахад ашиглаж байгаа системүүд нь үнэ цэнийг дээд зэргээр нэмэгдүүлэх нөхцлийг бүрдүүлдэг байх явдал юм. Хэрэв үүнд эргэлзэж байгаа бол ОУИТБС нь голлох үйл явцуудад хараат бусаар шалгалт хийж, шинэчлэлээр хангах маш сайн үндэс суурь байж болох юм. Хэрэв шинэчлэлийн үр дүнд шударга, өрсөлдөөнт нөхцөл бүрдүүлж, сайд нарын дур зоргоор шийдвэрлэлтийг багасгах боломжтой бол оролцогч талууд энэ талаар зөвшилцөлд хүрч болох юм.

Шалгах гол үйл явцууд нь:

- Уул уурхай, газрын тос, байгалийн хийн ашиглалтын талбайг хэрхэн олгосон бэ (өөрөөр хэлбэл, хэнд, ямар үнээр, ямар техникийн болон санхүүгийн нөхцөлтэйгээр)?
- Тухайн улсын нөөц баялгийг хэрхэн зах зээлд борлуулж байна вэ (өөрөөр хэлбэл, хэнд, ямар санхүүгийн нөхцлөөр, ямар үнээр)?
- Хамтарсан үйлдвэрүүд дэх тухайн улсын эзэмшлийг хэрхэн удирддаг вэ (өөрөөр хэлбэл, тэд зардлын хяналт тавих, төслүүдийг сонгож авах зэргийг сайн хийдэг үү)?

- Тухайн улс үйлдвэрлэсэн нөөц баялгаа хэрхэн ашигладаг вэ (тухайлбал, дотоодын боловсруулах үйлдвэрүүдэд түүхий эд нийлүүлэх ажиллагаа ил тод явагддаг уу, аль эсхүл нефть бүтээгдэхүүний, эсхүл байгалийн хийн үнэ тогтоох систем нь үндэсний орлогод эерэгээр нөлөөлдөг үү, сөргөөр нөлөөлдөг үү)?
- Ажлын байр бий болгох, технологи шилжүүлэх систем нь тогтвортой юу, эсхүл авлигад өртөмтгий юу?

11.6 Орон нутгийн хуваарилалт ба зарцуулалт

Зарим улс орон ОУИТБС-ыг үндсэн зааврынх нь хүрээнээс цааш хөгжүүлж, газрын тос, байгалийн хий, уул уурхайн орлогыг орон нутгийн түвшинд хэрхэн хуваарилж, зарцуулж байгааг хамруулдаг болоод байна. Ингэснээр түүний үндсэн зарчмыг өргөтгөж, зөвхөн олборлох үйлдвэрлэлээс хэр их мөнгө гарч байгааг ойлгох биш, энэ баялгийг хаана, хэрхэн зарцуулж байгааг мэдэхэд чиглэгддэг.

Зөвхөн төв засгийн газарт орж байгаа бүх төлбөрийг биш, бүс нутаг, дүүрэг, орон нутгийн засгийн газруудад орж байгаа төлбөрүүдийг харуулахад ОУИТБС-ыг ашиглахыг оролдож, улмаар орон нутгийн хэмжээний тайлан гаргаж чадсан анхны улс бол Гана юм. Гана Улс “дүүргийн түвшний” өгөгдөл цуглуулах тайлангийн маягт бий болгож хэрэглэсэн нь олборлолтын орлогоос уул уурхайн бүс нутгийн иргэдэд зориулсан хөрөнгийн хүлээн авалт, ашиглалтыг харуулахыг зорьжээ. Гана Улс олон оролцогч талын ажлын хэсэгтээ Дүүргийн хурлын төлөөлөгчдийг оруулах онцгой алхам хийсэн нь ОУИТБС-ын мэдээлэл, үйл явцын өмчлөлийг анхан шатны түвшинд хүргэхэд тусалж байна. Мөн Гана Улс компаниудын хийсэн нийгмийн төлбөрүүдийг орон нутгийн болон үндэсний түвшинд тайлагнах ОУИТБС-ын маягтыг хэдийн нэвтрүүлээд байна.

Нигери Улсын Сангийн яам ОУИТБС-ыг хэрэгжүүлж эхлэх үеэс эхлэн Холбооны Засгийн газраас Мужуудад хуваарилж байгаа санхүүжилтыг үндэсний хэвлэл мэдээллийн хэрэгсэлүүдээр дамжуулан олон нийтэд мэдээлж байх журам нэвтрүүлжээ. Энэхүү олон нийтэд мэдээлэх үйл ажиллагаа нь НОУИТБС-ын схемийн нэг хэсэг яг биш боловч иргэд, иргэний нийгэм болон бусад талуудын зүгээс мужийн болон холбооны түвшний орлого, зарлагын удирдлагын талаар илүү утга учиртай асуултууд тавих боломж олгосон байна.



ХАВСРАЛТ А

Î - È Ò Á Ñ - ù í

Á à ò à è ã à à æ ó ó è à è ò ù í õ ç ñ í ý ã ò

ОУИТБС Олон улсын зөвлөх бүлгийн тайлан

5. Баталгаажуулалтын хүснэгт

ОУИТБС-ын Шалгуурууд - ОУИТБС-ын хэрэгжилт нь доорх шалгууруудад нийцсэн байх ёстой.

ОУИТБС-ын хэрэгжилэлт

Элсэн орох

Бэлтгэл

- 1. ХЭВЛЭН НИЙТЛЭЛТ:** Компаниудаас засгийн газарт төлж байгаа газрын тос, байгалийн хий, уул уурхайн холбогдолтой бүх материаллаг төлбөрүүд ("төлбөрүүд") болон газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниудаас засгийн газарт хүлээн авсан бүх материаллаг орлогуудын ("орлогууд") талаар өргөн олон нийтэд зориулж ил тод хүртээмжтэй, ойлгомжтой, цогц байдлаар дэлгэрэнгүй байдлаар тогтмол хэвлэн нийтэлж байх.
- 2. АУДИТ:** Хэрэв хөндлөнгийн хяналт байхгүй бол дээрх төлбөр болон орлогуудыг итгэмжлэгдсэн, хараат бус аудитаар аудитын олон улсын стандартууд хэрэглэн шалгуулдаг байх.
- 3. НЭГТГЭЛТ:** Төлбөр болон орлогыг итгэмжлэгдсэн, хараат бус захирагчаар аудитын олон улсын стандартууд хэрэглэн нэгтгэн тулгаж, хэрэв ямар нэг зөрүүтэй, зөрчилтэй байдал илэрсэн бол энэ талаархи тухайн захирагчийн дүгнэлтийг хэвлэн нийтэлдэг байх.
- 4. ХАМРАХ ХҮРЭЭ:** Энэ аргыг бүх компаниуд, түүний дотор төрийн өмчит үйлдвэрийн газруудад хамааруулан хэрэглэдэг байх.
- 5. ИРГЭНИЙ НИЙГЭМ:** Дээрх үйл явцыг зохион байгуулах, түүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд иргэний нийгэм идэвхтэй оролцож бөгөөд олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэхэд хувь нэмрээ оруулдаг байх.
- 6. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ:** Санаачилгыг хэрэгжүүлж буй хүлээн авагч засгийн газар, шаардлагатай тохиолдолд олон улсын санхүүгийн байгууллагуудын тусламжтайгаар, дээрх бүх үйл явцад зориулан санхүүгийн хувьд тогтвортой Үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах, энэхүү төлөвлөгөөндөө хэмжиж болохуйц зорилтууд, хэрэгжүүлэх хугацаа, гарч болзошгүй хүндрэл бэрхшээлийн үнэлгээ зэргийг тусгасан байх.

1. Засгийн газар ОУИТБС-ыг хэрэгжүүлэх хүсэл сонирхолтой байгаа талаараа олон нийтэд хандсан тодорхой мэдэгдэл хийсэн үү?

2. Засгийн газар ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд иргэний нийгмийнхэн болон компаниудтай хамтран ажиллах үүрэг амлалт авсан уу?

3. Засгийн газар ОУИТБС-ын хэрэгжилтийг хариуцан удирдаж хүнээ томилсон уу?

4. Хүрч болохуйц зорилтууд, хэрэгжүүлэх хугацаа, чадавхид (засгийн газар, хувийн хэвшил, иргэний нийгэм) гарч болзошгүй хүндрэл бэрхшээлийн үнэлгээ зэргийг агуулсан, зардлыг бүрэн тусгасан үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, нийтэд ил болгож мэдээлсэн үү?

Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгсэл (ҮҮХ)-ийг үзнэ үү.

5. Засгийн газраас ОУИТБС-ын хэрэгжилтийг хянах олон оролцогч талууд бүхий бүлэг байгуулсан уу?

ҮҮХ-г үзнэ үү.

6. Уг үйл явцад иргэний нийгмийнхэн оролцож байна уу?

ҮҮХ-г үзнэ үү.

7. Уг үйл явцад компаниуд оролцож байна уу?

ҮҮХ-г үзнэ үү.

8. Засгийн газар ОУИТБС-ын хэрэгжилтэд тулгарч буй аливаа саад тотгорыг арилгасан уу?

ҮҮХ-г үзнэ үү.

9. Тайлангийн маягтуудыг хэлэлцэн тохирсон уу?

ҮҮХ-г үзнэ үү.

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга

	Ил тод тайлагнах	Мэдээлэл түгээлт
<p>10. Тоо баримтуудыг цуглуулж нэгтгэх байгууллагад олон оролцогч талуудын бүлэг сэтгэл ханамжтай байна уу?</p> <p>ҮҮХ-г үзнэ үү. <input type="checkbox"/></p>	<p>14. Компаниудаас төлж байгаа газрын тос, байгалийн хий, уул уурхайн холбогдолтой бүх материаллаг төлбөрүүд ("төлбөрүүд")-ийг уг тоо баримтыг нэгтгэн тулгах гэрээтэй байгууллагад тайлагнаж, ОУИТБС-ын тайлан гаргасан уу? <input type="checkbox"/></p>	<p>18. ОУИТБС-ын тайланг: - нийтэд хүртээмжтэй - дэлгэрэнгүй, цогц байдлаар - ойлгомжтой байдлаар олон нийтийн хүртээл болгосон уу?</p> <p>ҮҮХ-г үзнэ үү. <input type="checkbox"/></p>
<p>11. Засгийн газраас бүх компаниудад тайлагнаж байх нөхцлийг бүрдүүлж өгсөн үү?</p> <p>ҮҮХ-г үзнэ үү. <input type="checkbox"/></p>	<p>15. Засгийн газарт хүлээн авсан газрын тос, байгалийн хий, уул уурхайн бүх материаллаг орлогуудын ("орлогууд")-ыг уг тоо баримтыг нэгтгэн тулгах гэрээтэй байгууллагад тайлагнаж, ОУИТБС-ын тайлан гаргасан уу? <input type="checkbox"/></p>	
<p>12. Компаниудын тайлан олон улсын стандартуудын дагуу аудитлагдсан тоо бүртгэлд тулгуурласан байх нөхцлийг засгийн газар хангаж өгсөн үү?</p> <p>ҮҮХ-г үзнэ үү. <input type="checkbox"/></p>	<p>16. Тоо баримтыг нэгтгэн тулгах гэрээтэй байгууллага үүргээ хангалттай биелүүлсэн гэдэгт олон оролцогч талуудын бүлэг сэтгэл ханамжтай байна уу? <input type="checkbox"/></p>	
<p>13. Засгийн газрын тайлангууд олон улсын стандартуудын дагуу аудитлагдсан тоо бүртгэлд тулгуурласан байх нөхцлийг засгийн газар бүрдүүлж өгсөн үү?</p> <p>ҮҮХ-г үзнэ үү. <input type="checkbox"/></p>	<p>17. ОУИТБС-ын тайланд зөрүүтэй байдлуудыг тодорхойлж, авбал зохих арга хэмжээний санал зөвлөмж гаргасан уу? <input type="checkbox"/></p>	
	<p>Газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниуд ОУИТБС-ыг хэрхэн дэмжиж байна вэ?</p> <p>ҮҮХ-г үзнэ үү. <input type="checkbox"/></p>	<p>Хэрэгжилтийн явцад авсан сургамжуудаас суралцах, зөрүүтэй байдлыг шийдвэрлэх, ОУИТБС-ыг цаашид тогтвортой хэрэгжүүлэх талаар ямар алхамууд хийгдээд байна вэ? ҮҮХ-г үзнэ үү. <input type="checkbox"/></p>



ХАВСРАЛТ Б

̄çççëýëòèéí çí ýëãýýí èé
õýðýãñëççä

6. Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгслүүд

Хүснэгтийн үзүүлэлт 4: Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгсэл

Үзүүлэлт: Хүрч болохуйц зорилтууд, хэрэгжүүлэх хугацаа, чадавхид (засгийн газар, хувийн хэвшил, иргэний нийгэм) тулгарах хүндрэл бэрхшээлийн үнэлгээ зэргийг агуулсан, зардлыг бүрэн тусгасан үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, нийтэд ил болгож мэдээлсэн үү?

Зорилго: Үйл ажиллагааны төлөвлөгөө бол тухайн улсын баталгаажуулалтын үйл явцын нэг үндэс суурь юм. ОҮИТБС-ын 6 дугаар шалгуурт гол оролцогч талуудтай хэлэлцэн тохирсны үндсэн дээр үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, олон нийтэд ил тод болгосон байхыг шаарддаг.

Нотлох баримт: Энэхүү үзүүлэлтээр үнэлгээ өгөхийн тулд Баталгаажуулагч тухайн үйл ажиллагааны төлөвлөгөөг гол оролцогч талуудтай хэлэлцэн тохирсон эсэхийг болон төлөвлөгөөнд дараахи зүйлсийг тусгасан эсэхийг шалгах болно:

- Хүрч болохуйц зорилтууд,
- Хэрэгжүүлэх хугацаа,
- Хэрэгжүүлэх чадавхид тулгарах хүндрэл бэрхшээлүүдийн үнэлгээ
- Засгийн газраас ОҮИТБС-ын олон оролцогч талт чанарыг хэрхэн хангах, ялангуяа иргэний нийгмийнхэнийг хэрхэн татан оролцуулах асуудал.
- Аливаа улс “Нэр дэвшигч” орны шатанд яваа тохиолдолд баталгаажуулалт хийлгэх цаг хугацааны хуваарь. Энэ нь тухайн улсын хэрэгцээ шаардлагыг тусгах бөгөөд дор хаяж хоёр жилд нэг удаа хийгдэх ёстой.
- Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тухайн засгийн газар баталгаажуулалтын зардлыг хэрхэн төлөхийг тодорхой заасан байна.

Баталгаажуулагч нь ОҮИТБС-ын хэрэгжилтэд гарч буй ахиц дэвшлийг эдгээр зорилтууд болон хэрэгжүүлэх хугацаатай харьцуулан үнэлэх шаардлагатай бөгөөд тухайн улсын чадавхид тулгарах хүндрэл бэрхшээлүүдийг арилгах арга хэмжээ авсан эсэхэд үнэлэлт өгнө.

Тухайн улсад хийгдэж буй баталгаажуулалтын үйл явцын нэг гол бүрдэл бол хэрэгжүүлэх хугацааг баримталж байгаа эсэх юм. Хэрвээ цаг хугацааг дагаж мөрдөхгүй байгаа бол Баталгаажуулагч (гол оролцогч талууд болон бусад этгээдүүдээс авсан нотлох баримтад тулгуурлан) уг хуваарийг ямар үндэслэлээр хойшлуулсан эсэхийг тодорхойлох шаардлагатай болно. Хэрвээ үндэслэлгүй байвал, Баталгаажуулагч тухайн улсыг Нэр дэвшигч орны жагсаалтаас хасах санал гаргах эсэхээ авч үзэх шаардлагатай.

Хүснэгтийн үзүүлэлт 5: Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгсэл

Үзүүлэлт: Засгийн газраас ОУИТБС-ын хэрэгжилтийг хянах олон оролцогч талын бүлэг байгуулсан уу?

Зорилго: ОУИТБС-ыг түүнд оролцогч холбогдох бүх талууд, түүний дотор хувийн хэвшил, иргэний нийгэм (иргэний нийгмийн бие даасан бүлгүүд, мөн хэвлэл мэдээлэл, парламентчид зэрэг бусад иргэний нийгмийнхэн орно), засгийн газрын холбогдох яамд зэргээс бүрдсэн (гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй) бүлэг удирдаж хянаж байх ёстой. Тус бүлэг нь тодорхой бөгөөд олон нийтийн чанартай Ажлын даалгавар (АД) гаргаж батлах ёстой. Эдгээр хийх АД-уудад дараахи зүйл орно. Үүнд: Тухайн улсын үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, шаардлагатай засвар өөрчлөлт хийх, компаниуд болон тухайн засгийн газраас нэгтгэн тулгахад зориулж ирүүлсэн тоо баримтууд нь олон улсын стандартад нийцүүлэн аудитлагдсан тоо баримтад тулгуурлаагүй тохиолдолд түүнд аудит хийх аудиторыг сонгох, тоо баримт цуглуулж нэгтгэх байгууллагыг сонгох болон Баталгаажуулалтын хүснэгтэд дурдсан бусад ажлууд орно.

Нотлох баримт: Энэ үзүүлэлтээр үнэлгээ өгөхийн тулд Баталгаажуулагч ямар нэг олон оролцогч талт бүлэг байгуулагдсан, түүнд нь зохих оролцогч талууд багтсан, ажлын даалгавар нь зорилгодоо тохирч байгаа эсэх тухай нотлох баримт олж авах хэрэгтэй болно.

Нотлох баримтад дараахи зүйлс орно:

- Оролцогч талуудын хийгдээд байгаа үнэлгээнүүд.
- Олон оролцогч талуудын бүлгийн гишүүнчлэлийн тухай мэдээлэл:
 - Үг бүлэгт оролцуулах урилга нь нээлттэй, ил тод байсан уу?
 - Оролцогч талуудын төлөөлөл бүрэн хангагдсан уу (энэ нь оролцогч талууд адил тэгш төлөөлөлтэй байх ёстой гэсэн үг биш)?
 - Оролцогч талууд өөрийн төлөөлөлөө хангалттай оруулсан гэж үзэж байна уу?
 - Оролцогч талууд тухайн бүлгийн нэг хэсэг болж ямарваа зохисгүй нөлөөлөл, эсхүл албадлагаас ангид ажиллаж (түүний дотор өөрсдийг сонгосон бүлэг ба бусад оролцогч талуудтай холбоотой ажиллах) чадна гэж үзэж байна уу?
 - Тус бүлгийн иргэний нийгмийг төлөөлсөн гишүүд нь үйл ажиллагааны хувьд болон бодлогын талаасаа төр засаг, хувийн хэвшлээс хараат бус байж чадах уу?
 - Бүлгийн гишүүд өөрчлөгдөх тохиолдолд хуучин байдлыг алдагдуулахгүйгээр ямар нэг байдлаар гишүүд нэмж оруулах албадлагын санал, оролдлого гарч байсан уу?
 - Бүлгийн гишүүд үүргээ гүйцэтгэх хангалттай чадавхитай юу?

- Ажлын даалгаварт ОУИТБС-ын талаар бүлгийн зүгээс үг хэлэх эрх олгодог уу? Ажлын даалгавруудад наад зах нь дараахь зүйлийг оруулсан байх ёстой: Улсын үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, шаардлагатай засвар өөрчлөлт хийх, компаниуд болон тухайн засгийн газраас нэгтгэн тулгахад зориулж илгээсэн тоо баримтууд нь олон улсын стандартад нийцүүлэн аудитлагдсан тоо баримтад тулгуурлаагүй тохиолдолд түүнд аудит хийх аудиторыг сонгох, тоо баримт цуглуулж нэгтгэн тулгах байгууллагыг сонгох болон Баталгаажуулалтын хүснэгтэд дурдсан бусад ажлууд орно.
- Бүлэгт засгийн газрын эрх бүхий албан тушаалтнуудын төлөөлөл орсон уу?

Хүснэгтийн үзүүлэлт 6: Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгсэл

Үзүүлэлт: Уг үйл явцад иргэний нийгмийнхэн оролцож байна уу?

Зорилго: Энэ үзүүлэлт нь 5 дугаар үзүүлэлтийг бататгаж байна. ОУИТБС-ын шалгуурт уг үйл явцын боловсруулалт, хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд оролцогчын хувьд иргэний нийгмийнхэн энэ ажилд идэвхтэй оролцох, олон нийтийн мэтгэлцээн өрнүүлэхэд хувь нэмрээ оруулахыг шаарддаг. Үүний тулд ОУИТБС-ын хэрэгжилтэд иргэний нийгэм идэвхтэй оролцох шаардлагатай болно. Үүнийг олон оролцогч талын бүлгээр дамжуулах, эсхүл олон оролцогч талын бүлэгт нэмэлт үүрэг болгох байдлаар гүйцэтгэж болно.

Нотлох баримт: Энэ үзүүлэлтээр үнэлгээ өгөхийн тулд Баталгаажуулагч тухайн засгийн газар болон шаардлагатай тохиолдолд олон оролцогч талын бүлгээс ОУИТБС-ын хэрэгжилтийн үйл явцад иргэний нийгмийнхнийг татан оролцуулахыг эрмэлзэж байгаа эсэх тухай нотлох баримт олох хэрэгтэй болно. Үүнд дараахи нотлох баримт орох ёстой:

- Олон оролцогч талуудын бүлгээс өргөн хүрээтэй иргэний нийгмийн бүлгүүдэд хандаж тухайн засгийн газар ОУИТБС-ыг хэрэгжүүлэх үүрэг амлалт авсан тухай болон үүнд иргэний нийгмийнхэн болон компаниудын гүйцэтгэх гол үүргийн талаар таниулан сурталчилж байгаа байдал, түүний дотор иргэний нийгмийн бүлэглэл, эвслүүдтэй (тухайлбал Төлснөө нийтэл эвслийн дотоодын салбар гэх мэт) харилцаж байгаа байдал (хэвлэл мэдээллийн хэрэгсэл, вэбсайт, албан бичгээр).
- Иргэний нийгмийн оролцоонд нөлөөлж буй чадавхийн асуудлыг хөндөж шийдвэрлэх талаар засгийн газар, иргэний нийгэм, эсхүл компаниудаас хэрэгжүүлж байгаа арга хэмжээ.
- ОУИТБС-д оролцож буй иргэний нийгмийн бүлгүүд үйл ажиллагааны хувьд ч, бодлогын талаасаа ч засгийн газар болон хувийн хэвшлээс хараат бус байх ёстой.
- ОУИТБС-д оролцож буй иргэний нийгмийн бүлгүүд ямар нэг зохисгүй дарамт шахалт, албадлагагүйгээр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлнэ.

Хүснэгтийн үзүүлэлт 7: Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгсэл

Үзүүлэлт: Уг үйл явцад компаниуд оролцож байна уу?

Зорилго: Энэ үзүүлэлт нь 5 дугаар үзүүлэлтийг бататгаж байна. ОУИТБС-ын шалгуурт компаниуд санаачилгын хэрэгжилтэд идэвхтэй оролцож, бүх компаниуд ОУИТБС-ын дагуу тайлагнахыг шаарддаг. Үүний тулд ОУИТБС-ын хэрэгжилтэд газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниуд идэвхтэй оролцох шаардлагатай болно. Үүнийг олон оролцогч талын бүлгээр дамжуулах, эсхүл олон оролцогч талын бүлэгт нэмэлт болох байдлаар гүйцэтгэж болно.

Нотлох баримт: Энэ үзүүлэлтээр үнэлгээ өгөхийн тулд Баталгаажуулагч тухайн засгийн газар болон шаардлагатай тохиолдолд олон оролцогч талын бүлгээс ОУИТБС-ын хэрэгжилтийн үйл явцад компаниудыг татан оролцуулахыг эрмэлзэж байгаа эсэх тухай нотлох баримт олох хэрэгтэй болно. Үүнд дараахи нотлох баримт орох ёстой:

- Олон оролцогч талын бүлгээс газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниудад хандаж тухайн засгийн газар ОУИТБС-ыг хэрэгжүүлэх үүрэг амлалт авсан тухай болон үүнд компаниудын гүйцэтгэх гол үүргийн талаар таниулан сурталчилж байгаа байдал, түүний дотор харилцааны хүрээ (хэвлэл мэдээллийн хэрэгсэл, вэбсайт, албан бичгээр).
- Компаниудад нөлөөлж буй чадавхийн асуудлыг хөндөж шийдвэрлэх талаар засгийн газар, иргэний нийгэм, эсхүл компаниудаас хэрэгжүүлж байгаа арга хэмжээ.

Хүснэгтийн үзүүлэлт 8: Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгсэл

Үзүүлэлт: Засгийн газар ОСИТБС-ын хэрэгжилтэд тулгарч байгаа аливаа саад тотгорыг арилгасан уу?

Зорилго: ОУИТБС-ын хэрэгжилтэд эрх зүй, зохицуулалтын болон бусад саад тотгор учирч байгаа бол тухайн засгийн газар тэдгээрийг арилгах шаардлагатай болно. Ийм нийтлэг саад тотгоруудын дотор засгийн газрын болон компаниудын гэрээн дэх нууцлалын заалтууд, засгийн газрын байгууллагуудын мөнгөн шилжүүлгийн зөрчилтэй байдал зэрэг асуудал орно.

Нотлох баримт: Энэ үзүүлэлтээр үнэлгээ өгөхийн тулд Баталгаажуулагч тухайн засгийн газар ямар нэг саад тотгорыг арилгасан эсэх тухай нотлох баримт олох хэрэгтэй болно. Үүнд дараахи болзошгүй саад тотгорыг урьдчилан үнэлэх идэвхтэй арга, эсхүл үүссэн саад тотгорыг тухай бүрт нь арилгах арга хэмжээ авах идэвхгүй арга байж болно. Энэ асуудлыг шийдвэрлэх тогтсон нэг арга гэж байхгүй, улс орнуудын хувьд хэрэгжилтэд нөлөөлж болох эрх зүйн янз бүрийн хүрээ, бусад гэрээнүүд байж болох бөгөөд энэ бүхэнд өөр өөр арга замаар хариу үйлдэл үзүүлэх шаардлагатай болно.

Баталгаажуулагчийн олохыг хүсэх нотлох баримтын төрлүүдэд дараахи зүйлс орно:

- Эрх зүйн хүрээний тойм
- Зохицуулалтын хүрээний тойм
- Эрх зүй, зохицуулалтын хүрээнд буй ОУИТБС-ын хэрэгжилтэд нөлөөлж болохуйц саад тотгоруудын үнэлгээ
- Ил тод байдал бий болгоход зориулж дэвшүүлсэн, батлан гаргасан эрх зүй, зохицуулалтын өөрчлөлтүүд
- Орлогоо ил тод тайлагнахыг зөвшөөрөх талаар засгийн газар болон компаниудын хооронд байгуулсан гэрээнүүдэд нууцлалын заалтуудаас татгалзсан байдал
- Ил тод байдлыг нэмэгдүүлэх талаар, тухайлбал компаниудтай тогтоосон шууд харилцаа
- Засгийн газар болон компаниудын хооронд хэлэлцэн тохирсон ил тод байдлын стандартууд, зөвшилцлийг зааж өгсөн Харилцан ойлголцолын санамж бичиг

Хүснэгтийн үзүүлэлт 9: Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгсэл

Үзүүлэлт: Тайлангийн маягтуудыг хэлэлцэн тохирсон уу?

Зорилго: Тайлангийн маягтууд бол мэдээллийг ил тодоор тайлагнаж, нэгтгэх, ОУИТБС-ын эцсийн тайланг гаргах үйл явцад гол үүрэг гүйцэтгэдэг. Энэхүү маягтуудад орлогын ямар урсгалуудыг засгийн газрын болон компаниудын тайлагналд оруулах ёстойг тодорхойлно. Уг маягтуудыг олон оролцогч талын бүлгээр хэлэлцэн батлах шаардлагатай болно.

ОУИТБС-ын шалгуурт “засгийн газарт төлж байгаа газрын тос, байгалийн хий, уул уурхайн холбогдолтой бүх материаллаг төлбөрүүд” ба “газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниудаас засгийн газарт хүлээн авсан бүх материаллаг орлогууд”-ыг хэвлэн нийтэлж байхыг шаарддаг. Иймээс ОУИТБС-ын маягтуудад эдгээр материаллаг төлбөрүүд ба орлогууд юунаас бүрдэх, “материаллаг” гэдэгт юу орохыг олон оролцогч талын бүлгээр хэлэлцэн тохирсны үндсэн дээр тодорхойлох шаардлагатай болно. Түүнчлэн олон оролцогч талын бүлгээс тайлагналд хамрагдах цаг хугацааны үеүдийг тодорхойлох зайлшгүй шаардлагатай байх болно. Аливаа орлогын урсгалыг орхигдуулах, эсхүл буруу тодорхойлсноор ОУИТБС-ын эцсийн тайланд материаллаг байдлаар нөлөө үзүүлэх чадамжтай бол түүнийг материаллаг гэж үзнэ.

Үүнд орлогын дараахи урсгалыг оруулах ёстой гэдгийг хүлээн зөвшөөрөх нь нийтлэг байдаг:

- Хүлээн авагч засгийн газраас олгосон үйлдвэрлэлийн эрхийн төлбөр.
- Төрийн өмчит үндэсний компаниудын үйлдвэрлэлийн эрхийн төлбөр.
- Ашгийн татварууд
- Нөөц ашигласны төлбөрүүд
- Ногдол ашгууд
- Урамшуулал буюу бонусууд (гэрээний, орд илрүүлсний, үйлдвэрлэлийн)
- Тусгай зөвшөөрлийн төлбөрүүд, түрээсийн төлбөрүүд, орох хураамжууд болон тусгай зөвшөөрөл болон хөнгөлөлттэй холбоотой бусад асуудлууд
- Газрын тосны ашиг
- Засгийн газарт орж буй, Олон оролцогч талын бүлгээр зөвшөөрөгдсөн бусад томоохон ашиг орлогууд

Нотлох баримт: Энэ үзүүлэлтээр үнэлгээ өгөхийн тулд Баталгаажуулагч олон оролцогч талын бүлэг уг маягтуудыг боловсруулах ажилд оролцож зөвлөсөн эсэх, олон нийтийн илүү өргөн хүрээг хамарсан санал шүүмжлэл явуулсан эсэх, маягтын эцсийн загварыг олон оролцогч талын бүлэг хүлээн зөвшөөрч батласан эсэх тухай нотлох баримт олох хэрэгтэй болно. Үүнд дараахи нотлох баримтуудыг оруулж болно:

- Олон оролцогч талын бүлэгт өгсөн маягтуудын төсөл
- Маягтын загварыг хэлэлцсэн тухай олон оролцогч талын бүлгийн хурлын тэмдэглэл
- Тайлангийн маягтуудын талаар олон оролцогч талын илүү өргөн хүрээнд (тухайлбал, компаниудад) харилцсан харилцаа
- Олон оролцогч талуудад холбогдох асуудлуудыг ойлгох боломж олгоход чиглэсэн зохицуулалтууд
- Тайлангийн маягтууд ба түүнд орсон орлогын бүхий л урсгалыг хүлээн зөвшөөрсөн талаар олон оролцогч талын бүлгээс гаргасан шийдвэр

Хүснэгтийн үзүүлэлт 10: Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгсэл

Үзүүлэлт: Тоо баримтуудыг цуглуулж нэгтгэх байгууллагад олон оролцогч талуудын бүлэг сэтгэл ханамжтай байна уу?

Зорилго: Компани ба засгийн газраас тайлагнасан тоо баримтуудыг хүлээн авч, тэдгээрийг нэгтгэх, улмаар ОУИТБС-ын эцсийн тайланг боловсруулан гаргах ямар нэг байгууллагыг томилох хэрэгтэй болно. Энэ байгууллагыг захиргаа, нэгтгэн тулгагч, эсхүл аудитор гэх мэт янз бүрээр нэрлэсэн байдаг. Энэ үүргийг гүйцэтгэж байгаа байгууллагыг оролцогч талуудын зүгээс найдвартай, итгэл хүлээхүйц, техникийн хувьд чадвартай байгууллага гэж үздэг байх нь амин чухал.

Нотлох баримт: Энэ үзүүлэлтээр үнэлгээ өгөхийн тулд Баталгаажуулагч тоо баримтыг нэгтгэн дүгнэхээр томилогдсон байгууллагад олон оролцогч талын бүлэг сэтгэл ханамжтай байгаа эсэх тухай нотлох баримт олох хэрэгтэй болно. Үүнд дараахи нотлох баримтууд орж болно:

- Олон оролцогч талын бүлгээс зөвшөөрөгдсөн Ажлын даалгаварууд
- Боломжит Баталгаажуулагчийг тогтоохын тулд ОУИТБС-ын Нарийн бичгийн газар болон Удирдах зөвлөлтэй ил тодоор харилцаж холбоо тогтоосон байдал
- Тухайн байгууллагын эцсийн сонголтыг олон оролцогч талын бүлэг зөвшөөрч баталсан байдал

Хүснэгтийн үзүүлэлт 11: Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгсэл

Үзүүлэлт: Засгийн газраас бүх компаниуд тайлагнадаг байх тэгш нөхцлийг бүрдүүлж өгсөн үү?

Зорилго: ОУИТБС-ын шалгуурт улсын (төрийн өмчит), хувийн, гадаад, дотоодын бүх компаниуд засгийн газарт төлж буй төлбөрөө зөвшөөрөгдсөн маягтуудын дагуу тайлагнаж, уг тайлагнасан тоо баримтыг нэгтгэн дүгнэхээр томилогдсон байгууллагад хүргүүлэхийг шаарддаг. Ийнхүү бүх компаниуд тайлагнах нөхцлийг хангах үүднээс засгийн газар бүхий л үндэслэлтэй алхамуудыг авч хэрэгжүүлэх шаардлагатай болно. Үүнд сайн дурын гэрээ, зохицуулалт, эсхүл хууль тогтоомж ашиглах явдал орно. Мөн яагаад зарим компаниудыг ойрын хугацаанд тайлагналтад хамруулж болохгүй тухай (хэдийгээр онцгой тохиолдол мэт боловч) учир шалтгаан байж болохыг энд үгүйсгээгүй. Энэ тохиолдолд дунд хугацаанд эдгээр компаниудыг тайлагналын үйл явцад хамруулах чиглэлд зохих алхамууд хийсэн гэдгийг, мөн эдгээр алхамууд нь бусад компаниудаар хүлээн зөвшөөрөгдөхүйц арга хэмжээ болохыг засгийн газар нотлон харуулах ёстой.

Нотлох баримт: Энэ үзүүлэлтээр үнэлгээ өгөхийн тулд Баталгаажуулагч тухайн засгийн газар дараахи зүйлийг хийсэн эсэх тухай нотлох баримтыг олох хэрэгтэй болно:

- Компаниуд ОУИТБС-ын шалгуурууд болон зөвшөөрөгдсөн тайлангийн маягтуудын дагуу заавал тайлагнадаг байх тухай хууль тогтоомж шинээр гаргасан, эсхүл нэмэлт, өөрчлөлт хийсэн байх.
- Компаниуд ОУИТБС-ын шалгуурууд болон зөвшөөрөгдсөн тайлангийн маягтуудын дагуу заавал тайлагнадаг байх тухай холбогдох зохицуулалтууд шинээр гаргасан, эсхүл нэмэлт, өөрчлөлт хийсэн байх.
- Бүх компаниуд ОУИТБС-ын шалгуурууд болон зөвшөөрөгдсөн тайлангийн маягтуудын дагуу заавал тайлагнадаг байх нөхцлийг хангахын тулд тэдэнтэй гэрээ хэлэлцээр (харилцан ойлголцолын санамж бичиг байгуулах, бүтээгдэхүүн хуваах гэрээний нууцлалын заалтаас татгалзах гэх мэт) хийсэн байх.
- Компаниуд оролцохгүй байгаа тохиолдолд эдгээр компаниуд (оролцогч талуудтай) тогтсон өдрөөс нэг хоногийн өмнө тайлагнадаг болгох үүднээс ерөнхийдөө (бусад оролцогч талуудаар) хүлээн зөвшөөрөгдсөн арга хэмжээг засгийн газраас авсан байх.

Хүснэгтийн үзүүлэлт 12: Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгсэл

Үзүүлэлт: Компаниудын тайлан олон улсын стандартуудын дагуу аудитлагдсан тоо бүртгэлд тулгуурласан байх нөхцлийг засгийн газар бүрдүүлж өгсөн үү?

Зорилго: ОУИТБС-ын шалгуурт компаниудын тайлагнасан бүх тоо баримтууд олон улсын стандартуудын дагуу аудитлагдсан тоо бүртгэлд тулгуурласан байхыг шаарддаг. Энэ нь ОУИТБС-ын хэрэгжилтийн нэг чухал бүрэлдэхүүн хэсэг юм.

Нотлох баримт: Энэ үзүүлэлтээр үнэлгээ өгөхийн тулд Баталгаажуулагч тухайн засгийн газраас компаниудын ирүүлж буй тоо баримтууд олон улсын стандартын дагуу аудитлагдсан байх нөхцлийг хангах алхамууд хийсэн тухай нотлох баримтыг олж авах хэрэгтэй болно. Эдгээрт дараахи нотлох баримтууд орж болно:

- Ирүүлж байгаа тоо баримтууд олон улсын стандартад тулгуурласан байхыг шаардсан хууль тогтоомж төрөөс гаргах.
- Төр засгаас одоо байгаа аудитын стандартуудыг олон улсын стандарт болгох, нэмэлт, өөрчлөлт оруулж, тэдгээрт нийцүүлж ажиллахыг компаниудаас шаардах.
- Засгийн газар бүх компаниудтай Харилцан ойлголцолын санамж бичиг байгуулж, улмаар компаниуд тоо баримтаа олон улсын стандартуудын дагуу гаргаж ирүүлдэг байхаар тохиролцох.
- Компаниуд олон улсын стандартуудын дагуу аудитлагдсан тоо баримт ирүүлж байх сайн дурын үүрэг хүлээх.
- Компаниуд олон улсын стандартуудын дагуу аудитлагдсан тоо баримт ирүүлэхгүй байгаа тохиолдолд тогтсон хугацааны дараа олон улсын стандартуудыг хангах талаар засгийн газар тухайн компанитай (түүний дотор төрийн өмчит үйлдвэрийн газартай) төлөвлөгөө гаргаж ажиллах.
- Нэгтгэлд ирүүлж байгаа тоо баримтууд стандартын дагуу аудитлагдаагүй тохиолдолд түүнийг шийдвэрлэхээр хэлэлцэн тохирсон арга замд олон оролцогч талын бүлэг сэтгэл ханамжтай байгаа эсэх.

Хүснэгтийн үзүүлэлт 13: Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгсэл

Үзүүлэлт: Засгийн газрын тайлангууд олон улсын стандартуудын дагуу аудитлагдсан тоо бүртгэлд тулгуурласан байх нөхцлийг засгийн газар бүрдүүлж өгсөн үү?

Зорилго: ОУИТБС-ын шалгуурт засгийн газрын тайлагнасан бүх тоо баримтууд олон улсын стандартуудын дагуу аудитлагдсан байхыг шаарддаг.

Нотлох баримт: Энэ үзүүлэлтээр үнэлгээ өгөхийн тулд Баталгаажуулагч нь засгийн газраас ирүүлж буй тоо баримтуудаа олон улсын стандартуудын дагуу аудитлагдсан байх нөхцлийг хангах алхамууд хийсэн эсэх тухай нотлох баримтыг олох хэрэгтэй болно. Үүнд дараахи нотлох баримтууд орж болох юм:

- Ирүүлж байгаа тоо баримтууд олон улсын стандартад нийцсэн байхыг шаардсан хууль тогтоомжийг төрөөс гаргах.
- Төр засгаас одоо мөрдөгдөж байгаа аудитын стандартуудыг олон улсын стандарт болгох, нэмэлт, өөрчлөлт оруулж, тэдгээрт нийцүүлэн ажиллах нөхцлийг бүрдүүлэх.
- Нэгтгэлд ирүүлж байгаа тоо баримтууд стандартын дагуу аудитлагдаагүй тохиолдолд түүнийг шийдвэрлэхээр хэлэлцэн тохирсон арга замд олон оролцогч талын бүлэг сэтгэл ханамжтай байгаа эсэх.

Хүснэгтийн үзүүлэлт 18: Үзүүлэлтийн үнэлгээний хэрэгсэл

Үзүүлэлт: ОУИТБС-ын тайланг

- нийтэд хүртээмжтэй
- дэлгэрэнгүй
- ойлгомжтой байдлаар олон нийтийн хүртээл болгосон уу?

Зорилго: Эцэстээ ОУИТБС-ын тайлан нийтийн хүртээл болж, түүнийг өргөнөөр түгээн дэлгэрүүлж, янз бүрийн оролцогч талууд нээлттэй хэлэлцдэг болох үед ОУИТБС бүрэн дүүрэн хэрэгжих юм. ОУИТБС-ын шалгуурт уг тайланг нийтэд хүртээмжтэй, дэлгэрэнгүй, ойлгомжтой байдлаар олон нийтийн хүртээл болгохыг шаарддаг.

Нотлох баримт: Энэ үзүүлэлтээр үнэлгээ өгөхийн тулд Баталгаажуулагч нь засгийн газар уг тайланг ОУИТБС-ын шалгууруудад нийцсэн байдлаар олон нийтийн хүртээл болгох нөхцлийг хангасан эсэх тухай нотлох баримтыг олох хэрэгтэй болно. Үүнд:

- Тайланг цаасан дээр хэвлэн гаргаж, иргэний нийгэм, компаниуд, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад оролцогч талуудын өргөн хүрээг хамруулан тараасан байх.
- Тайланг онлайн хэлбэрээр байрлуулж, вэб хуудасныхаа хаягийг гол оролцогч талуудад мэдээлж сурталчилах.
- Тайлан дэлгэрэнгүй байх, түүний дотор баталгаажуулалтын явцад цуглуулсан бүх мэдээлэл, санаачилгыг сайжруулах бүх санал зөвлөмжүүдийг багтаасан байх нөхцлийг хангах.
- Тайлан ойлгомжтой байх, түүний дотор тодорхой, хүртээлтэй хэлбэрээр, зохих хэлүүд дээр бичигдсэн байх нөхцлийг хангах.
- Тайлангийн тухай мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх үүднээс нийтэд сурталчилах үйл ажиллагааг (засгийн газар, иргэний нийгэм, компаниудын зүгээс) зохион явуулсан байх.



ХАВСРАЛТ В

Ã à í à Ó ë ñ û í ¯ é ë à æ è ë ë à ã à à í û
ò ° è ° â ë ° ã ° °



ХАВСРАЛТ Г

ÊàçàõñÒàí Óëñûí ¯éë
àæèëëàãààí û Ò°ë°âë°ã°°

Бүгд Найрамдах Казахстан Улсад Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх 2007-2009 оны ажлын төлөвлөгөө
(Казахстаны Засгийн газар болон Дэлхийн Банкны хооронд хооронд 2006 оны 12 дугаар сарын 1-нд байгуулсан ХОСБ-т тулгуурлав)

No	Зорилт	Гарц/Үр дүн/Хүлээлт		Санхүүжилтийн төлөвлөгөө (мянган КЗТ)			
		Богино хугацаа-2007	Дунд хугацаа 2008-2009	2007	2008	2009	Казахстаны Засгийн газрын санхүүжилт
1.	Нарийн бичгийн газар байгуулах (ХОСБ-ийн А алхам)	Гурван хүнтэй Нарийн бичгийн газрыг Эрчим хүч, эрдэс баялгийн нөөцийн яаманд төвтэй, Сангийн яамны оролцоотойгоор ЭХЭБЯ-ны дэд сайдаар даргалуулан байгуулав.		Шардлагагүй			
	Казахстан дахь ОУИТБС-ын ажлыг удирдан зохицуулж ОУИТБС-ын Үндэсний оролцогч талуудын зөвлөлд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй ОУИТБС-ын Нарийн бичгийн газар байгуулах.						
	Гүйцэтгэх хугацаа- 2006 оны 12 дугаар сар						
	Зорилго:						
	Казахстан дахь ОУИТБС-ын бүхий л ажиллагаа, дагалдах бүх арга хэмжээний гол төвлөрөх цэг болж ажиллах			Шардлагагүй			
	Шардагдах үйл ажиллагаанууд/ Орцууд-цагийн хуваарь						
1.1	Энэ хугацаанд Эрчим хүч, эрдэс баялгийн яамны дэргэд ОУИТБС-ын Нарийн бичгийн газрын үүрэг гүйцэтгэх орон тооны хэлтэс байгуулж, ОУИТБС-ын ажлын төлөвлөгөө, ажлын ачааллыг үр нөлөөтэй удирдахад зориулсан нэмэлт санхүүжилт олгох		ОУИТБС-ын өргөн хүрээтэй үйл явц жигд ажиллагатай болж, Нарийн бичгийн газрын удирдлага, зохицуулалтаар ажиллана	Шардлагагүй			
	Гүйцэтгэх хугацаа: 2007 оны 9 дүгээр сар						
1.2	ОУИТБС-ын хамрах хүрээ өргөжих тусам ОУИТБС-ын Нарийн бичгийн газрын ажлын агуулга, үүрэг, хариуцлага зэргийг (АД) дахин тодорхойлох		ОУИТБС-ын өргөн хүрээтэй үйл явц жигд ажиллагатай болж, Нарийн бичгийн газрын удирдлага, зохицуулалтаар ажиллана	Шардлагагүй			
	Гүйцэтгэх хугацаа: 2007-2008 он						

Компаниудыг бүрэн оролцуулах (ХОСБ-ын алхам Б.а)						
2.	ОУИТБС-д Казахстанд ажиллаж байгаа бүх олборлох үйлдвэрлэлийн (газрын тос, байгалийн хий, уул уурхайн) компаниудыг (ОУ компаниуд) бүрэн хамруулах Гүйцэтгэх хугацаа: 2007-2008 он	Казахстан дахь газрын тос, байгалийн хийн олборлолт, уул уурхайн компаниудыг Казахстан дахь Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгад хамруулах талаар гэрээ хэлэлцээр хийх	Шаардлагагүй			
	Зорилго: Казахстан дахь ОУИТБС-ын өргөн хүрээтэй үйл явц нь дэлхий дахины ОУИТБС-ын Шалгуур #1 (бүх төлбөрийг нийтлэх), Шалгуур #4 (компаниудыг татан оролцуулах) нийцсэн байх					
	Шаардагдах үйл ажиллагаанууд/ Орцууд-цагийн хуваарь					
2.1	ОУИТБС-ын хамрах хүрээнд Казахстанд байгаа олон улсын, дотоодын болон төрийн өмчийн ОУ компаниуд, тэдний үйлдвэрлэлийн салбаруудыг хамруулах (Засгийн газрын 2006 оны 12 сарын 4-ний 1166 дугаар тогтоолоор) Гүйцэтгэх хугацаа: 2007-2008 он		ОУ-н бүх компани ОУИТБС-д оролцож засгийн газарт төлсөн бүх төрлийн төлбөрөө тайлагнахыг бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрнө	Шаардлагагүй		
2.2	Газрын тос, байгалийн хийн болон Уул уурхайн салбаруудад аль алинд нь: ОУИТБС-ын үйл явцад шинээр оролцож буй ОУ, газрын тос, байгалийн хийн бүх компаниудтай уулзалт ярилцлага эхлүүлж, тэднийг ОУИТБС, түүнд гүйцэтгэх үүрэг, хүлээх хүлээлттэй нь танилцуулж, ТББ-уудын оролцооны дараагийн алхамуудын талаар хэлэлцэх Гүйцэтгэх хугацаа: 2007-2008 он	ОУ-н уул уухайн компаниуд, өөрсдийн хүлээх үүрэг, хариуцлага, ОУИТБС-д оролцосноор гарах зардал, үр ашгийг тодорхой ойлгож мэдэрдэг болох	Шаардлагагүй			

No	Зорилт	Гарц/Үр дүн/Үзүүлэлт		Санхүүжилтийн төлөвлөгөө (мянган КЗТ)			
		Богино хугацаа-2007	Дунд хугацаа 2008-2009	2007	2008	2009	Казахстаны Засгийн газрын санхүүжилт
2.3	ОУИТБС-д оролцогчдын тоог нэмэгдүүлэх үүднээс КЗГ ба газрын тос, байгалийн хийн компаниудын хооронд байгуулсан ХОСБ-ын талаар зөвшилцөж, өөрчлөлт оруулах Гүйцэтгэх хугацаа: 2007 оны сүүл-2008 оны 1 дүгээр улирал	ОУИТБС-ын удирдлага, шийдвэр гаргах ажиллагаанд ҮОТЗ-р дамжуулан (КЗГ ба ТББ-уудтай хамтран) оролцох, ҮОТЗ-ийн ажилд бүх компаний сегментийн төлөөллийг оруулж, тэдний идэвхтэй оролцоог хангах талаар ОУ-ийн бүх компанитай тохиролцох		Шаардлагагүй			
2.4	ОУ-ийн компаниудын гишүүнчлэл улам нэмэгдэхтэй холбогдуулан ҮОТЗ-ийн хэмжээ, бүрэлдэхүүнийг нэмэгдүүлэх журам, санал хураалтын дүрэм зэргийг хэлэлцэн тохирох - Дараагийн алхамуудыг No. 8-с үзэнэ үү. Гүйцэтгэх хугацаа- 2007-2008 он			Шаардлагагүй			
2.5	Маш жижиг компаниудыг тогтоох үүднээс ОУ-ийн компаниудад үйлдвэрлэлийн хэмжээ, орлогын дүнгээр нь "ангилал тогтоох" шаардлагатай эсэхийг авч хэлэлцэх. Гүйцэтгэх хугацаа: 2008 оны 1 дүгээр улирал	ОУ-н маш жижиг компаниудыг жил бүрийн ОУИТБС-ын мөчлөгөөс хасч болох эсэхийг шийдэж, шаардлагатай бол хасах шалгуур буюу дүнг тогтоох		Шаардлагагүй			
2.6	Чадавхийн боломжит хомсдолын үнэлгээ Хөрсөн доорх баялгийн ашиглалтын тухай БНКУ-ын хуулийн дагуу олборлох үйлдвэрлэл шинээр эрхэлж байгаа болон одоо байгаа бүх компани цаашид бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн гэрээ байгуулахаасаа өмнө ОУИТБС-ын ХОСБ-т гарын үсэг зурах үүрэгтэй. Харин ОУИТБС-ын сайн дурын онцлогоос үүдэн, хэдийн гэрээ байгуулчихсан буюу бүтээгдэхүүн хуваах гэрээнд гарын үсэг зурчихсан компаниуд гэрээнийхээ нууцлалын нөхцлийн дагуу ОУИТБС-ын ХОСБ-т гарын үсэг зурахгүй байх эрхтэй.	БНКУ-ын Засгийн газар ба Үндэсний оролцогч талуудын зөвлөлийн гишүүд ОУИТБС-д олборлолтын компаниудыг оролцуулахын ач холбогдлыг хүлээн зөвшөөрч, улмаар Газрын тос, байгалийн хий, уул уурхайн том, дунд хэмжээтэй компаниудыг 2007-2008 оны хугацаанд ОУИТБС-д хамруулах талаар дэд зэргийн хүчин чармайлт гаргах болно.					

ОУИТБС-ын тоо баримтуудын үнэн зөв байдал (ХОСБ-ын алхам Б.б)						
					Шаардлагагүй	
3.	<p>Казахстаны болон ОУ-ийн компаниудын ОУИТБС-ын тайланд орсон тоо баримтын үнэн зөв байдал ОУИТБС-ын Шалгуур #2-т (тоо баримт нь аудитлагдсан бүртгэл тооцоонд тулгуурласан байх) нийцсэн байх нөхцлийг бүрдүүлэх</p> <p>Зорилго:</p> <p>ОУ-н компаниуд ба засгийн газрын тайлагнасан тоо баримтын баттай байдал буюу иж бүрэн, үнэн зөв байдлыг нотлох нэмэлт баталгааг ОУИТБС-ын мэдээллийг хэрэглэгчдэд өгөх</p> <p>Шаардлагах үйл ажиллагаанууд/ Орцууд- цагийн хуваарь</p>					
3.1	<p>ОУ-ийн аж ахуйн нэгж, байгууллага бүрт байгаа аудитууд баталгаа (ө.х, тогтсон журмуудын мэдэгдэл) гаргаж, түүндээ тухайн байгууллагаас тайлагнасан ОУИТБС-ын тоо баримтууд нь компаниудын аудитлагдсан бүртгэл тооцоонд буюу аудитлагдсан нягтлан бодох бүртгэлийн бичилтүүдэд тулгуурласан гэдгийг гэрчлэхийг шаардсан зардлын хувьд үр нөлөөтэй механизм бий болгож хэрэгжүүлэх</p> <p>Гүйцэтгэх хугацаа: 2007 оны сүүл хүртэл</p>				Шаардлагагүй	
3.2	<p>Зөвхөн 2007 оны хувьд, 2008 оны 1 сарын 1-нээс өмнө (дээр дурдсан тогтоол хүчин төгөлдөр болоход) ОУИТБС-ын тоо баримт гаргаж өгөх компаниуд (1) компани одоо байгаа аудиторуудаас сайн дураар ийм гэрчилгээ авахыг дэмжих, эсхүл (2) тухайн тайлагнасан тоо баримт нь компаний одоогийн аудитлагдсан бүртгэл тооцооноос буюу аудитлагдсан нягтлан бодох бүртгэлийн бичилтүүдээс гаргаж авсан буюу түүнд нийцсэн гэдгийг тайлангийн маягт дээр тухайн компаний удирдах албан тушаалтан өөрөө гэрчлэхийг шаардах.</p> <p>Гүйцэтгэх хугацаа: 2007 оны сүүл хүртэл</p>				Шаардлагагүй	

No	Зорилт	Гарц/Үр дүн/Үзүүлэлт		Санхүүжилтийн төлөвлөгөө (мянган КЗТ)			
		Богино хугацаа-2007	Дунд хугацаа 2008-2009	2007	2008	2009	Казахстаны Засгийн газрын санхүүжилт
4.	ОУИТБС-ыг тогтвортой санхүүжилтээр хангах						
	Зорилго						
	Казахстан дахь ОУИТБС-ын үйл явцыг санхүүгийн хувьд тогтвортой, зардлын хувьд үр ашигтай болгох						
	Шаардагдах үйл ажиллагаанууд/ Орцууд- цагийн хуваарь						
4.1	Томилогдсон ажлын хэсэг (санхүүжилтээр хангахад шаардагдах зардлын шинжилгээ хийж, тайлагнах ажлын хэсэг) төсвийн шаардлагуудыг тогтоох Гүйцэтгэх хугацаа: 2007 оны 8 дугаар сар		КЗГ-аас ОУИТБС-ын урсгал зардлууд, түүний дотор тоо баримт нэгтгэх, тайлагнах зардлыг холбогдох яамны төсвийн зүйл анги болгож тодорхой зааж өгсөн.				
5.	Тулгалтын фирмийг томилох (ХОСБ-ын алхам Б.д)						
	ОУИТБС-ын хөтөлбөрийн дагуу тулгалтын ажлыг хийж тайлан гаргах үүрэгтэй зохих зөвлөх буюу аудитын фирмийг томилж удирдах						
	Зорилго:			13,000	13,000		26,000
	Компаниуд ба засгийн газраас гаргаж өгсөн тоо баримтыг нэгтгэж, тулган, тайлан гаргах фирмийг томилж ажиллуулах	Аудитын фирмийг өрсөлдөөнт шалгаруулалтын аргаар сонгох					
	Гүйцэтгэх хугацаа: 2007 оны 5-8-р сар						
	Шаардагдах үйл ажиллагаанууд/ Орцууд- цагийн хуваарь						

5.1	Эхний нэгтгэн тулгах, тайлагнах ажилд хамрагдах хугацаа (ө.х, зөвхөн 2005 оны өгөгдлийг) ба компаниудын тоог тодорхойлж, ҮОТЗ-тэй хамтран ажиллах АД боловсруулах								
5.2	Гүйцэтгэх хугацаа: 2007 оны 8 дугаар сар ОУИТБС-ын 2005 ба 2006 оны тайлангуудын хувьд, ОУИТБС-ын тоо баримтыг нэгтгэн тулгаж, аудит хийх олон улсын зөвлөх, аудитын, эсхүл мэргэжлийн фирмийг (эсхүл ийм фирм ба Казахстаны үндэсний фирмийн хамтарсан фирмийг) сонгон шалгаруулах ажиллагааг Засгийн газраас санхүүжүүлэн, үйл ажиллагааг эхлүүлэх	ОУИТБС-ын 2005 оны эхний тайланг гаргах							
5.3	Гүйцэтгэх хугацаа: 2007 оны 8 дугаар сар ОУИТБС-ын 2006, 2007 оны тайлангуудын хувьд, тулгалт хийх фирмийн санхүүжилтийг 2008 онд гаргахаар Засгийн газар төлөвлөж байна		ОУИТБС-ын дараагийн тайлангууд						
5.4	Гүйцэтгэх хугацаа: 2007 оны 6 дугаар сар ОУИТБС-ын тулгалтын ажлын хувьд сонгогдсон фирмтэй тулгалтын гэрээ байгуулж ажиллах явдлыг ҮОТЗ-ийн мэргэжлийн ажлын хэсгийн оролцоотойгоор засгийн газраас удирдан зохион байгуулна								
5.5	Гүйцэтгэх хугацаа: 2007-2009 он ҮОТЗ нь ОУИТБС-ын тайлангаас олж мэдсэн зүйлсийнхээ мөрөөр дагалдах арга хэмжээ авч дараагийн алхамуудыг Засгийн газартай тохиролцоно. Гүйцэтгэх хугацаа: 2007 оныг дуустал			ОУИТБС болон салбарын бусад шинэчлэл, ил тод байдлын асуудлуудаар урт хугацааны дагалдах арга хэмжээ авах					
5.6	ОУИТБС-ын 2005 оны тайланг ОУИТБС-ын шалгуур үзүүлэлтүүдийн дагуу хэвлэн нийтлэх Гүйцэтгэх хугацаа: 2007 оныг дуустал								

№	Зорилт	Гарц/Үр дүн/Үзүүлэлт		Санхүүжилтийн төлөвлөгөө (мянган КЗТ)			Казахстаны Засгийн газрын санхүүжилт
		Богино хугацаа-2007	Дунд хугацаа 2008-2009	2007	2008	2009	
6.	ОУИТБС-ын олон нийттэй харилцах ажиллагаа (ХОСБ-ийн алхам Б.е) ОУИТБС-ын тоо баримтын тайлагналттай холбогдуулан Казахстан даяар ОУИТБС-ыг сурталчлан хэлэлцүүлэх үүднээс үндэсний ба бүс нутгийн хэмжээний цуврал сургалт семинаруудыг зохион байгуулж, эхний семинарыг 2007 оны 9 дүгээр сарын сүүлээр эхлүүлэх Гүйцэтгэх хугацаа: 2007-2008 он						
	Зорилго:						
	Казахстан дахь ОУИТБС-ын үйл явцыг ОУИТБС-ын Шалгуур #1 (ОУИТБС-ын тайлангуудыг нийтэд хүртээмжтэй, ойлгомжтой байдлаар нийтлэх) ба Шалгуур #5 (ОУИТБС-ын яриа хэлэлцүүлэгт иргэний нийгмийн татан оролцуулах)-д нийцүүлэн явуулах						
	Шаардагдах үйл ажиллагаанууд/Орцууд- цагийн хуваарь						
6.1	ОУИТБС-ын мэдээллийг олон нийтэд өргөн хүрээтэй хүргэх мэдээлэл сурталчилгааны стратеги боловсруулах Гүйцэтгэх хугацаа: 2007 оныг дуусгал	Бичиг үсэг тайлагдалтын түвшин багатай, хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр мэдээлэл авах боломж муутай газруудад хүрч ажиллах	ОУ-ийн салбар ба санхүүгийн урсгалуудын тухай олон нийтийн ойлголтод хэмжиж болохуйц сайжралт гаргах				
6.2	Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, олон нийт, иргэний нийгэм, үзэл бодлоор тэргүүлэгчдэд зориулсан мэдээлэл сурталчилгаа, олон нийтийн харилцааны ажлууд эхлүүлж, ОУИТБС-ын үндэсний цуврал бага хурлууд зохион байгуулах						
6.3	Гүйцэтгэх хугацаа: 2007-2008 он Вэбсайтын үндэс суурь, агуулгыг шинэчлэн мэдээлэл авахад хялбар дөхөм болгож холбоосоор хангах асуудлыг авч үзэх Гүйцэтгэх хугацаа: 2007 оны 8 дугаар сар						

6.4	ОУИТБС-ын мэдээллийг нийт иргэд авсан байх нөхцлийг бүрдүүлэх үүднээс ОУИТБС-ын мэдээллийн эмхтгэл гаргах Гүйцэтгэх хугацаа: 2007-2009 он	ОУИТБС-ын тайлангаар олж мэдсэн зүйлсийг www.eiti.kz вэбсайтад энгийн, хүртээмжтэй байдлаар байрлуулах						
6.5	www.eiti.kz вэбсайтыг ажиллуулах Гүйцэтгэх хугацаа: 2007-2009 он		437.5					—
7.0	Иргэний нийгмийн бусад хамтын ажиллагаа (ХОСБ-н Б.ё) Төрийн бус байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллах замаар ОУИТБС-ыг хэрэгжүүлэх бусад арга хэмжээг тодорхойлох Зорилго: Казахстан улс үндэсний хэмжээний өргөн хүрээтэй хамтын ажиллагаа, олон нийтийн харилцааны аргаар дамжуулан ОУИТБС-ыг хэрэгжүүлэх тэргүүн туршлагын дээд түвшинд хүрэхэд нь туслах Шардагдах үйл ажиллагаанууд/Орцуул- цагийн хуваарь							
7.1	Уул уурхайн ил тод байдал, орон нутгийн түвшний нийгмийн асуудлуудыг онцгойлон авч үзсэн сургалт, семинарууд зохион байгуулахад анхаарах Гүйцэтгэх хугацаа: 2007-2008 он	Уул уурхайн салбарыг тусгайлан сонирхдог ТББ-уудтай илүү өргөн хүрээнд хамтран ажиллах						

№	Зорилт	Гарц/Үр дүн/Үзүүлэлт		Санхүүжилтийн төлөвлөгөө (мянган КЗТ)			
		Ботино хугацаа-2007	Дунд хугацаа 2008-2009	2007	2008	2009	Казахстаны Засгийн газрын санхүүжилт
8.	ҮОТЗ-ийн удирдлагыг тодотгох						
	ОУИТБС-д оролцогч компаниудын тоо нэмэгдэх тусам ҮОТЗ-ийн удирдлагад болон засгийн газар, компаниуд, ТББ-уудын хооронд байгуулсан ХОСБ-т өөрчлөлт оруулах шаардлагыг хэлэлцэн шийдвэрлэх						
	Зорилго:						
	Казахстан Улс үндэсний хэмжээний өргөн хүрээтэй хамтын ажиллагаа, олон нийтийн харилцааны аргаар дамжуулан ОУИТБС-ыг хэрэгжүүлэх тэргүүн туршлагын дээд түвшинд хүрэхэд нь туслах						
9.	Шаардагдах үйл ажиллагаанууд/Орцууд- цагийн хуваарь						
	ҮОТЗ-ийн ажлын хэсгүүдийн үр ашигтай байдлыг (1) үйл ажиллагааны төлөвлөгөө ба олж мэдсэн зүйлс, (2) тоо баримт тулгалт ба салбарын асуудлууд (3) мэдээлэл сурталчилгаа, олон нийтийн харилцаа зэрэг чиглэлээр дээшлүүлэх талаар авч хэлэлцэх						
	Гүйцэтгэх хугацаа: 2007 оны 4 дүгээр сар						
	2007 оны 4 дүгээр сарын 20-нд болсон ҮОТЗ-ийн хурлын 8 дугаар тэмдэглэлийн дагуу дараахи ажлын хэсгүүд байгуулагдсан: 1) ОУИТБС-ыг дэлгэрүүлэх ажлын хэсэг 2) Нэмэлт өөрчлөлтүүд боловсруулах ажлын хэсэг 3) ОУИТБС-ын тайлан бэлтгэх ажлын хэсэг 4) Ажлын төлөвлөгөөний санхүүжилтийн ажлын хэсэг						
9.	ОУИТБС-ын Баталгаажуулалт						
	2008 онд ОУИТБС-ын Баталгаажуулалтын ажиллагааг гүйцэтгэх Баталгаажуулалтын компанийг томилох				8,750	—	8,750
	Гүйцэтгэх хугацаа: 2008 он						
	Зорилго:						
9.	Казахстан дахь ОУИТБС-ын үйл явцыг ОУИТБС-ын Олон улсын удирдах зөвлөлийн шаардлагад нийцүүлж, ОУИТБС-ыг Дагаж мөрдөгч орон болох						
	Шаардагдах үйл ажиллагаанууд/Орцууд- цагийн хуваарь						

9.1	Баталгаажуулалтын санхүүжилтийг шийдвэрлүүлэх хүсэлтийг Улсын төсвийн хороонд гаргах Гүйцэтгэх хугацаа: 2007 оны 6 дугаар сар												
9.2	ОУИТБС-ын Олон улсын удирдах зөвлөлөөс санал болгосон нэр дэвшигч компаниудын дунд тендер шалгаруулалт явуулах замаар баталгаажуулалтын компанийг сонгох Гүйцэтгэх хугацаа: 2007 оны I-II улирал												
9.3	ОУИТБС-ын баталгаажуулалтын ажиллагаанд орох Гүйцэтгэх хугацаа: 2007 оны I-II улирал												
	НИЙТ ДҮН (мянган КЗ тэнгэгээр)					13,438					21,751		34,751
	НИЙТ ДҮН (Ам.доллараар, 1ТКТ/АМ\$)					107,5					174		278



нд, газрын тосон зардлын хэмжээ эхэндээ өндөр байснаа яваандаа буюу зарим онцгой үйл явдлын улмаас (тухайлбал, дор дурдсанчлан илүүдэл газрын тосон зардал анх үүсэхэд) буурч болно.

Үйлдвэрлэл эхлэх үед, эсхүл эхлэхээс өмнө зардал өндөр байгаа үед газрын тосон зардлаасаа илүү их нөхөгдөх зардал гарч байж болох юм. Энэ тохиолдолд нөхөгдөөгүй зардлыг жил жилд хойшлуулан, газрын тосон зардлаараа нөхөгдөх хүртэл тооцдог. Газрын тосон зардлыг хойшлуулан тооцох нь хөнгөлөлтийн гэрээтэй үед капиталын зардалд элэгдэл хорогдол тооцдогтой адилхан үр нөлөөтэй байдаг. Жишээлбэл, 20,000\$-н зардал нөхөх ёстой боловч дөнгөж 500 баррель газрын тосон зардал байгаа бол ($500 \text{ брл} \times 20\$/\text{брл} = 10,000\text{\$}$), үлдэж байгаа 10,000\$-н нөхөгдөөгүй зардлыг хангалттай хэмжээний газрын тосон зардалтай болтлоо хойшлуулан тооцно гэсэн үг. Зарим БХГ-нд зардлыг хойшлуулан нөхөх болвол тухайн нөхөгдөөгүй зардалд инфляцийн болон мөнгөний цаг хугацааны үнэ цэнийг тооцож тодорхой хувиар нэмэгдүүлдэг.

Аяндаа үйлдвэрлэсэн газрын тосон зардлын дүн гарсан зардлынхаа хэмжээнээс давах үе ирнэ. Энэ үед бэлэн байгаа газрын тосон зардал ба гарсан бодит зардлыг нөхөхөд шаардагдах газрын тосон зардал (нэмэгдэх хувийг тооцоод) хоёрын зөрүүг илүүдэл газрын тосон зардал гэж нэрлэдэг. Зарим БХГ-нд илүүдэл газрын тосон зардлыг газрын тосон ашигтай (дор үзнэ үү) адилтгаж үздэг бол, бусад БХГ-нд өөрөөр ханддаг. Зарим БХГ-нд (Египет, Сирийн гэх мэт) илүүдэл газрын тосон зардлыг бүхэлд нь засгийн газарт шилжүүлдэг байна. Ийм нөхцөл байдалд гэрээлэгчид хожоо гарахгүй учраас энэ зохицуулалт нь гэрээлэгч зардлаа хэмнэхийг хөхиүлэн дэмждэггүй. Бусад БХГ-нд бол илүүдэл газрын тосон зардлыг газрын тосон ашигтай адил хандаж хуваадаг боловч хуваах хувь хэмжээ нь өөр байдаг.

Зардал нөхөх талаасаа бол үйл ажиллагааны болон капиталын зардлуудад ерөнхийдөө адил ханддаг бөгөөд байгаа газрын тосон зардлаасаа үйл ажиллагааны зардлуудыг эхэлж нөхдөг байна. Мөн зарим БХГ-нд капиталын зардлуудыг газрын тосон зардлаар нөхөхийн өмнө санхүүгийн элэгдэл хорогдол тооцдог байна

ХАВСРАЛТ E

ÀÕÃ-í èé äàãóó ãàçðûí òî ñî í àøãèéã òî î öî î ëî õ í ü

Газрын тосон зардлыг хуваарилсны дараа хуваарилагдаагүй үлдэж байгаа газрын тосны хэмжээгээр газрын тосон ашгийг тухайн засгийн газар ба бизнес эрхлэгчийн хооронд хуваарилдаг. БХГ-ний дагуу газрын тосон ашиг хуваарилах ажиллагаа нь хөнгөлөлтийн гэрээний дагуу ногдуулах нефть бүтээгдэхүүний татвартай тодорхой хэмжээгээр ижил төстэй явагддаг.

АНУ гэх мэт зарим оронд БХГ-нүүдийг татвараас чөлөөлөгдсөнд тооцдоггүй бөгөөд гэрээлэгч газрын тосон ашгийнхаа тодорхой хувиар татвар төлдөг. Энэ нь давхар татвар ногдуулахад хүргэж болдог. Иймээс гэрээлэгчийн хувьд үйлдвэрээ эдийн засгийн хувьд амьдрах чадвартай байлгахын тулд гэрээлэгчид ногдох газрын тосон ашгийнхаа хувийг нэмэгдүүлж, түүнээсээ татвар төлөх боломжтой. Жишээлбэл, анхнаасаа газрын тосон ашгийн 30 хувь нь гэрээлэгчид, 70 хувь нь засгийн газарт хуваарилагдахаар заасан бөгөөд газрын тос үйлдвэрлэж байгаа орны аж ахуйн нэгжийн орлогын татвар 50 байсан бол гэрээлэгчид ногдох ашгийг 60 хувь болгож нэмэгдүүлээд, түүнээсээ 50 хувийн татвар төлж болно. Энэ нь мөн л гэрээлэгчид үлдэх татварын дараахь газрын тосон ашгийг 30 хувь хэвээр болгож байна. Аливаа БХГ-нд заавал тусгах шаардлагагүй боловч бүтээгдэхүүн хуваах гэрээнд ордог параметруудийн нэг нь татвар байх нь олонтаа тохиолддог.

Ихэнх орон тодорхой шалгуурт хүрсний дараа гэрээлэгчид ногдох эзэмших газрын тосон ашгийн хувийг бууруулах замаар газрын тосны компаний ашигт ажиллагаанд дээд хязгаар тогтоох тохиролцоо хийх дуртай байдаг. Эдгээр дээд хязгаар нь тухайн төслийн ашигт ажиллагаа (хөрөнгийн дотоод үр өгөөж буюу IRR-р дамжуулан), орлого олох чадвар, гэрээлэгчийн нийт шагналын нийлбэр дүн ба зардлын нийлбэр дүнгийн харьцаа, өдрийн үйлдвэрлэлийн хувиар

тооцсон тухайн төслийн хэмжээ, үйлдвэрлэсэн газрын тосны нийт хэмжээ зэргээс хамааралтай байж болно. Гэрээлэгчид ногдох газрын тосны хувь хэмжээ газрын тосны үнийг дагаж өөрчлөгдөх өөр нэг боломж байдаг бөгөөд Ангол Улсын зарим гэрээнд ийм жишээ байдаг. Зарим гэрээнд иймэрхүү ялгавартай тооцогддог дээд хязгаар гурав хүртэл байж болох бөгөөд үүний нэг нь гэрээлэгчид хамгийн бага хэмжээний газрын тосон ашиг олгохоор хийгдсэн байж болно (тухайлбал, Казахстанд).

Дээр дурдсан шалгууруудын зарим нь тухайн үйлдвэрийн ашигт ажиллагаатай огт холбоогүй байдаг. Ийм нөхцөл нь өгөгдсөн төсөл өөрийн хөрөнгө оруулалтын өгөөжийг бодитойгоор өгөөгүй байхад газрын тосны компанийг шийтгэх эрсдэл бий болгодог. Мөн эдгээр нөхцлүүдийг БХГ-нд оруулсан тохиолдолд тухайн улс бусад компаниудын сонирхлыг татах нь багасаж, яваандаа хөгжил удаашрахад хүргэж болох талтай.

ХАВСРАЛТ Ө

А᠋᠋᠋-í èé äàáóó ãàç᠋᠋í òî ñî í ýçýì øèè õóâèéá òî î öî î ëî õ í ü

БХГ-ний дагуу төслөөс гаргасан зардал, олсон ашгийг тооцохын тулд газрын тосон зардал ба газрын тосон ашгийг хэрэглэж байгаа бол тухайн компанийн газрын тосон эзэмшил хувийн хэмжээ газрын тосон ашгийн хувь дээр газрын тосон ашгийн хувийг нэмсэнтэй тэнцүү байна.

Жишээ болгож, гэрээлэгчийн газрын тосон зардлын хэмжээ 40%, газрын тосон ашгийн хэмжээ 30% гэж үзвэл түүний газрын тосон эзэмшил хувь нь:

$$\begin{aligned}
 & (\text{Газрын тосны нийт үйлдвэрлэл } \times \text{ Газрын тосны үнэ}) \times \text{Газрын тосон зардлын } 40\% = \text{Гэрээлэгчийн газрын тосон зардал (40\%)} \\
 & + \\
 & \text{Хуваарилагдаагүй үлдсэн газрын тос (60\%)} \times \text{Газрын тосон ашгийн } 30\% = \\
 & \text{Гэрээлэгчийн газрын тосон ашиг (18\%)} \\
 & = \text{Гэрээлэгчийн нийт газрын тосон эзэмшил (58\%)} \\
 & = \text{Засгийн газрын нийт газрын тосон эзэмшил (42\%)}
 \end{aligned}$$

Засгийн газар ба гэрээлэгчийн хоорондох эдгээр хуваарилалтууд нь тухайн БХГ-ний хугацаанд өөрчлөгдөж болох бөгөөд улмаар тал бүрт ногдох газрын тосон эзэмшлийн хувь өөрчлөгдөх болно. Жишээлбэл, яваандаа капиталын томоохон зардлууд газрын тосон зардлаар нөхөгдөж, тодорхой цэгээс эхлэн илүүдэл газрын тосон зардал гарах боломжтой болно. Мөн үйлдвэрлэсэн газрын тосны үнийн өөрчлөлтүүд ч засгийн газар ба гэрээлэгчийн хоорондох газрын тосны бодит хуваарилалтад нөлөө үзүүлж болно.

Тухайлбал, газрын тосон зардлаа (40%) бүрэн ашигласан өмнөх жишээг ашиглан, газрын тосны үнэ нэг баррель нь 20\$ байснаа 40\$ болж өслөө гэж

үзье. Түүнчлэн, 1,000 баррель газрын тос үйлдвэрлэсэн, 8000\$-н зардлыг газрын тосон зардлаар нөхөж болохоор батлагдсан гэж үзье. Үнэ өссөнөөр тус төслийн нийт орлого 40,000\$ болж, үүнээс 16,000\$ (40%) нь зардал нөхөхөд бэлэн болно. Хэрэв газрын тосон зардлын хуваарилалт ёсоор 8,000\$-г нөхөх юм бол илүүдэл газрын тосон зардалд 8,000\$ үлдэх бөгөөд энэ нь БХГ-ний тусгай нөхцлийн дагуу хуваарилагдахад бэлэн болох юм. Энэ жишээнд илүүдэл газрын тосон зардалд газрын тосон ашигтай адил хандана гэж үзье. Тэгвэл гэрээлэгчийн нийт газрын тосон эзэмшил нь газрын тосон зардлын 20% дээр нэмэх нь газрын тосон ашгийн $(80\% \times 30\%) = 24\%$ буюу нийтдээ 44% болно. Энэ нь газрын тосны үнэ одоогийн үнийн тал хувь буюу нэг баррель нь 20\$ байх үеийн 58%-н нийт газрын тосон эзэмшлээс эрс ялгаатай байна. Газрын тосны үнэ буурах үед гэрээлэгчийн газрын тосон эзэмшил хувь өсөх хамаарал нь бэлэн байгаа газрын тосон зардлыг бүрэн ашиглагдаагүй үед л хүчинтэй байх юм.

Энэ бүхнээс үзэхэд, эдгээр жишээ нь бас нэг чухал санааг илэрхийлж байна. Газрын тосны үнэ нэмэгдэх үед засгийн газар БХГ-ний дагуу газрын тосон ашгийнхаа үнийн дүнгээр төдийгүй газрын тосон ашгийн илүү их хувийг авах замаар үнийн өсөлтийн үр шимийг нь хүртэж байна. Энэ нөлөөний улмаас БХГ нь газрын тосны үнийн хэлбэлзлийг үл харгалзан орлогыг тогтворжуулах арга хэрэгсэл болдог бөгөөд гэнэтийн ашгийн татвар гэх мэт нэмэлт татвар ногдуулахгүйгээр орлого бүрдүүлэх боломж олгодог байна.

ХАВСРАЛТ Ж

Çàñãèéí ààçàð áà õóáâèéí êî ì ï àí èéí òçí øëýë

Засгийн газар хөнгөлөлтийн, эсхүл БХГ-нд түншлэгчээр оролцож байгаа үед онцгой асуудлууд үүсдэг. Эдгээрээс гурван гол асуудал нь:

1. Засгийн газар өөрийн эзэмшил хувийг төлж чадах уу?
2. Засгийн газрын гүйцэтгэх үүрэг нь тухайн хамтарсан компанийн хувьд ашиг сонирхлын зөрчил үүсгэх үү?
3. Хамтарсан компанийн аудитлагдсан тоо бүртгэл нь ОУИТБС-ын зорилгод хангалттай нийцэх үү?

Хамтарсан үйлдвэр гэж юу вэ?

Нэг буюу түүнээс дээш тооны хувийн компани түншилж ажилладаг төслийг хамтарсан үйлдвэр гэх бөгөөд үүнд гол төлөв газрын тосны үндэсний компани түншлэгчээр оролцдог. Хамтарсан үйлдвэрийн түншлэгч нарын хоорондын харилцааг ихэвчлэн хамтын ажиллагааны гэрээ (ХАГ)-гээр зохицуулдаг. Ийм түншлэл нь аливаа хөнгөлөлтийн, бүтээгдэхүүн хуваах, ашгийн түвшний, эсхүл техникийн үйлчилгээний гэрээнд байж болдог.

Зарим хамтарсан үйлдвэрийн жишээнүүд:

- Нигери Улсад ашгийн түвшний гэрээний дагуу ажилладаг НГТҮК (Нигерийн ГТҮК, 55%), Шелл (30%), Элф (10%), АГИП (5%) компаниудын хамтарсан үйлдвэр байдаг.

- Их Британид хөнгөлөлтийн гэрээний дагуу байгуулагдсан Шелл, Эссо (Экскон) компаниудын тус бүр 50%-н эзэмшилтэй хамтарсан үйлдвэр байдаг.
- Казахстанд Хойд Каспийн тэнгисийн БХГ-ний дагуу Агип, Экскон, Шелл, Тотал компаниудын тус бүрийн 18,52 %-н эзэмшил, КазМунайГаз (Казахийн засгийн газрыг төлөөлсөн), Инпекс компаниудын тус бүрийн 8,52 хувь, КонокоФиллипс компаний 9,28%-н эзэмшилтэй хамтарсан үйлдвэр ажиллаж байна.

Засгийн газар өөрийн эзэмшил хувиа төлж чадах уу? Үүрэх гэрээ ашиглах нь

Засгийн газар, эсхүл түүний ГТҮК хамтарсан үйлдвэрийн түншлэгчээр оролцож байгаа бөгөөд хамтарсан үйлдвэрт шаардагдах капиталын, эсхүл үйл ажиллагааны зардлын өөрт ногдох хувийг төлөх хөрөнгө байхгүй зарим тохиолдолд хайгуулын шатны, эсхүл бүр үнэлгээний шатны бүхий л зардлыг төрийн бус талын компаниуд дааж, улмаар энэ зардлаа тухайн ГТҮК-ний үйлдвэрлэлийн орлогоос хүртэх хувиас хүүтэй буюу хүүгүйгээр нөхөж авдаг байж болно. Энэ зохицуулалтыг үүрэх гэрээ гэж нэрлэдэг. Харин ашиглалтын зардлууд хамаагүй их байдаг учраас тухайн компаниуд төслийн энэ шатанд ГТҮК-ийг үүрэх магадлал багатай байдаг боловч заримдаа ингэх тохиолдол гардаг. Ерөнхийдөө, ГТҮК хөгжлийн ашиглалтын зардлуудаа гаргаж чадахгүй бол гаднаас санхүүжилтын эх үүсвэр олж авах шаардлагатай болно. Тэр ч бүү хэл, ашиглалтын зардлын үлдэх хувийг төлөхөд нэмэр болгож хамтарсан үйлдвэр эзэмшил хувийнхаа нэг хэсгийг зарж борлуулж болно. Ийм тохиолдолд Казахстаны Хойд Каспийн тэнгисийн хамтарсан үйлдвэрт гарсан юм. Эсрэг тохиолдолд, засгийн газар өөрийн эзэмшил хувийнхаа хөрөнгийг оруулж чадахгүй байх нь тухайн улсын нөөц баялаг ашиглалтыг удаашруулж болно. Нигери гэх мэт төсөв санхүүгийн хэрэгцээ шаардлагаасаа болж хамтарсан үйлдвэр дэх капиталын зардлын хувиа санхүүжүүлэхэд хүндрэлтэй байж ирсэн улс орнууд өнөөдөр БХГ-нд шилжээд байгаа нь бүхий л капиталын зардал ба эрсдлийг хувийн компаниудад шилжүүлдэг байна.

Шигтгээ Ж.1: ГТҮК хамтарсан үйлдвэрийн түншлэгч болох нь

Засгийн газар өөрийн хувиа цаг тухайд нь оруулсан эсэхэд гол асуудал оршино.

ГТҮК хамтарсан үйлдвэрт түншлэгчээр оролцох нь зөрчил үүсгэх үү?

Улсын оролцоо нь аливаа хамтарсан үйлдвэрийн эдийн засагт ихээхэн ашиггүй нөлөө үзүүлж болох бөгөөд энэ асуудлыг гэрээндээ зөв зохистой шийдвэрлэж өгөх хэрэгтэй. ГТҮК хамтарсан үйлдвэрт түншлэгчээр оролцох үед зөрчил гарах нь олонтаа байдаг. Жишээлбэл, засгийн газар дотоодоос аль болох олон ажилтан ажиллуулах, ажлын гэрээнүүдийг дотоодын компаниудад олгохыг хүсэхийн зэрэгцээ хамтарсан үйлдвэрийн түншлэгчийн хувьд хамтарсан үйлдвэрийг аль болох хурдан, хамгийн бага зардлаар ажиллуулахыг хүсч болох талтай. Эдгээр зорилгууд нь өөр хоорондоо зөрчилдөж болно.

Мөн ГТҮК нь хамтарсан үйлдвэрийн түншлэгчийн хувьд капиталын болон үйл ажиллагааны зардлын өөрт ногдох хувийг оруулах үүрэгтэй бөгөөд төслөөс олж буй газрын тос буюу мөнгөнөөс хувь хүртэх эрхтэй байна. Гэхдээ, дээр дурдсанчлан ГТҮК өөрт ногдох хөрөнгөө цаг тухайд нь оруулж чадахгүй бол энэ асуудлыг шийдвэрлэхэд цаг хугацаа алдаж, ашиглалтын хугацааг хойшлуулж болох юм.

Хамтарсан үйлдвэрийн аудитлагдсан бүртгэл тооцоонууд ОУИТБС-ын зорилгод хангалттай нийцэх үү?

Хамтарсан үйлдвэрийн түншлэгч нар уг үйл ажиллагааг эрхлэгчийг томилж, тэр нь хамтарсан үйлдвэрийг удирдан бусад түншлэгч нарынхаа өмнө хариуцлага хүлээж ажиллах болно. Үйл ажиллагаа хариуцан эрхлэгчийн үүрэг бол хувь эзэмшигчдийн нэрийн өмнөөс үйлдвэрийг ажиллуулах, үйл ажиллагааны зардлыг даах хэмжээний бэлэн мөнгө татан авах, газрын тосон зардал ба ашгийг хамтарсан үйлдвэрийн түншлэгч нарт болон засгийн газарт хуваарилах явдал юм. Аливаа татвар, нөөц ашигласны төлбөр төлөх нь хувь эзэмшигч түншлэгч бүрийн хүлээх үүрэг хариуцлага байх болно.

Хамтарсан үйлдвэрийн зохицуулалтын дагуу түншлэгч нарын зүгээс үйл ажиллагаа эрхлэгчийн бүртгэл тооцоонд аудит хийж, оруулсан мөнгө нь хамтран ажиллах гэрээний дагуу зөв зохистой зарцуулагдаж байгаа эсэхийг хянах явдал хэвшмэл байдаг. Үйл ажиллагаа эрхлэгч түүхий эд материалаа зардлын хувьд үр ашигтай байдлаар олж авч, хамтарсан үйлдвэрийн нэрийн өмнөөс хангалттай үнэ цэнэ бий болгож чадаж байгаа эсэхийг түншлэгч талууд сонирхох болно.

ОУИТБС-д холбогдолтой байдал. Хэрэв хамтарсан үйлдвэрт өргөн хүрээтэй аудит хийгдэж байгаа бол ОУИТБС-ын аудитын хамрах хүрээг багасгах буюу ОУИТБС-ын нэгтгэн тулгалтад аудитлагдсан тоо бүртгэл ашиглах үндэслэлтэй байж болно. Иймээс тухайн аудит нийтлэгдсэн эсэх, аудиторүүд нь хараат бус байсан эсэх, уг аудитад олон улсын стандартуудыг ашигласан эсэх талаар асуух хэрэгтэй.



ХАВСРАЛТ 3

Çàñãèéí ààçàðò ì ðî õ áýëýí ì °í ã°í èé óðñãàèëûí áóñàä ò°ðë¿¿ä

Засгийн газарт орж байгаа “ашиг орлого” гэж шууд ангилахад хэцүү бусад төрлийн бэлэн мөнгөний урсгалууд бизнес эрхлэгчдээс засгийн газарт ордог байж болно. Тухайлбал, засгийн газар газрын тос, байгалийн хийн салбарт томоохон үйлдвэр барьж байгуулах ажлыг санхүүжүүлэх зорилгоор мөнгө зээлдүүлсэн тохиолдлыг авч үзье. Засгийн газар шингэрүүлсэн байгалийн хийн үйлдвэрийн эзэмшил хувийг санхүүжүүлсэн ийм тохиолдол Нигерид гарсан юм. Үйлдвэрийн бэлэн мөнгөний урсгал эерэг болж эхэлмэгц зээлийг буцааж төлж эхэлсэн байна. Харин ийнхүү засгийн газарт эргүүлэн төлж байгаа зээлийн төлбөрийг засгийн газарт орж буй ашиг орлогын урсгал гэж үзэх эсэх нь асуудал болж байна.

Энэ бол хариулахад хялбар асуулт биш. Яагаад гэвэл засгийн газар зээлдүүлсэн мөнгөө буцаан авч байгаа учраас техникийн хувьд “ашиг орлого” гэж үзэж болохгүй. Нөгөө талаас, ОУИТБС-ын цаад зорилго бол засгийн газар ба олборлох үйлдвэрлэл дэх түүний бизнесийн түншийн хооронд хийгдэж байгаа санхүүгийн гүйлгээтэй холбоотой зохих ёсны хариуцлагатай байдал хангагдах нөхцлийг бүрдүүлэх явдал юм. Энэ үүднээсээ, засгийн газраас тухайн төслийг удирдаж буй бизнесийн талд олгосон зээлийн эргэн төлөлтийг ОУИТБС-ын хүрээнд тайлагнахыг шаардах нь зүйтэй юм. Хэдийгээр энэ нь засгийн газарт орж буй ашиг орлогын үндсэн урсгалтай холбоогүй боловч яг ийм нөхцөл байдалд Нигери Улс зээлийн эргэн төлөлтийн дүнг нийтлэхээр шийдсэн байна.

ОУИТБС-д тавигдах шаардлагыг зээлийн нөхцөл байдалтай холбож өргөтгөхийн тулд засгийн газар зээлийнхээ хүүг тооцож авсан эсэх талаар заавал тайлагнадаг болгоход анхаарах хэрэгтэй. Энэ тохиолдолд анх олгосон зээлд төлсөн болон хүлээн авсан хүүгийн төлбөрийг ашиг орлогод тооцох үндэслэлтэй байна. Ийм учраас төлсөн ба хүлээн авсан хүүгийн төлбөрийг тайлагнах ёстой. Үүний дараа

үүсэх илүү ярвигтай асуудал бол ийнхүү засгийн газарт төлсөн ба хүлээн авсан хүүнд зохих бүртгэл тооцоо хэрэглэх явдал юм. Тухайн хүүгийн орлогыг олсон үед нь бүртгэх үү, эсхүл төлсөн үед нь бүртгэх үү гэдэг асуудал үүснэ. Хэрэв бэлэн мөнгөнд суурилсан нягтлан бодох бүртгэл хэрэглэдэг бол хүүгийн орлого олсон өдрөөс илүү хүү төлөгдсөн өдөр чухал байх нь мэдээж. Харин засгийн газарт үндсэн зээл ба хүүгийн төлбөрийг нийлүүлэн төлсөн⁶⁵ бол уг төлбөрийг задлах шаардлагатай, Учир нь хүүгийн төлбөр бол тайлагнавал зохих ашиг орлогын урсгал бөгөөд харин зээлийн үндсэн төлбөр нь засгийн газарт орсон ашиг орлогод тооцогдохгүйгээр тайлагнагдах төлбөр байна.

Хавсралт И

Ì î í ã î ë Ó ë ñ û í ò î î á ç ð ò ã ý è è é í
ì à ÿ ã ò û í ç à ã â à ð ó ó ä

Үндэсний Статистикийн хорооны дарга, Сангийн сайдын
2008 оны 42/116 дугаар хамтарсан тушаалаар батлав.

ОУИТБС Маягт No-1

**Олборлох үйлдвэрлэл эрхэлж байгаа аж ахуйн нэгжийн /охин компани/
борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, улсын болон орон нутгийн
төсөвт төлсөн албан татвар, төлбөр болон бусад зардлын 200.. оны ТАЙЛАН**

Регистрийн дугаар										1. Олборлох үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуйн нэгжүүд дараа оны 3 дугаар сарын 30-ны дотор гаргаж нийтэд мэдээлж, Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар (АМГТХЭГ)-т маягтаар, нийтэд мэдээлсэн тайлангийн хамт ирүүлнэ.
Нэр Код										2. АМГТХЭГ нь 4 дүгээр сарын 20-ны дотор Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга хариуцсан ажлын албанд ирүүлнэ.
Аймаг, нийслэл										3. ОУИТБС-ын ажлын алба нь 4 дүгээр сарын 25-ны дотор Үндэсний Статистикийн хороонд ирүүлнэ.
Аж ахуйн нэгж, байгууллагын нэр										
Аж ахуйн нэгж, байгууллагын төрөл										

Хамрах хүрээ 1. Ашиг орлогын урсгал				
Үзүүлэлт	Мөрийн дугаар	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Үнийн дүн \мян.төг\
1. Бүтээгдэхүүний борлуулалт, үйлдвэрлэлт				
1.1. Бүтээгдэхүүний үйлдвэрлэлт				
ТЗ No Бүтээгдэхүүн		тонн		
ТЗ No Бүтээгдэхүүн		тонн		
ТЗ No Бүтээгдэхүүн		тонн		
ТЗ No Бүтээгдэхүүн		тонн		
Нийт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн		мян.төг	-	
1.2. Бүтээгдэхүүний борлуулалт				
ТЗ No Бүтээгдэхүүн	1.2.1	тонн		
ТЗ No Бүтээгдэхүүн	1.2.2	тонн		
ТЗ No Бүтээгдэхүүн	1.2.3	тонн		
ТЗ No Бүтээгдэхүүн	1.2.4	тонн		
Нийт борлуулсан бүтээгдэхүүн	1.2.5	мян.төг	-	
1.3. Бүтээгдэхүүн хуваах гэрээ бүхий компаний борлуулсан бүтээгдэхүүн	1.3	тонн		
2. Аж ахуйн нэгжээс улсын болон орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр болон бусад зардлууд				
2.1. Төлсөн татварууд		Хэмжих нэгж	Татвар, төлбөр, зардлын хэмжээ	
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	2.1.1	мян.төг		
Гаалийн албан татвар	2.1.2	мян.төг		
Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн татвар	2.1.3	мян.төг		
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	2.1.4	мян.төг		
Онцгой албан татвар (шатах тослох материал имдортолсон бол)	2.1.5	мян.төг		
Автобензин, дизелийн түлшний албан татвар	2.1.6	мян.төг		
Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар	2.1.7	мян.төг		
Бусад (тодорхойлно уу	2.1.8	мян.төг		
Бусад (тодорхойлно уу	2.1.9	мян.төг		
2.2 Төлбөр				
Ашигт малтмал нөөц ашигласны төлбөр	2.2.1	мян.төг		
Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	2.2.2	мян.төг		
Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	2.2.3	мян.төг		

Газрын төлбөр	2.2.4	мян.төг	
Ус ашигласны төлбөр	2.2.5	мян.төг	
Ойгоос мод, түлээ бэлтгэсний төлбөр	2.2.6	мян.төг	
Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	2.2.7	мян.төг	
Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	2.2.8	мян.төг	
Бусад (тодорхойлно уу	2.2.9	мян.төг	
Бусад (тодорхойлно уу	2.2.10	мян.төг	
2.3 Хураамж, үйлчилгээний хөлс			
Зохих хууль тогтоомжийн дагуу төв, орон нутгийн төрийн захиргааны байгууллагад төлсөн улсын тэмдэгтийн хураамж, бусад хураамж	2.3.1	мян.төг	
Зохих хууль тогтоомжийн дагуу төв, орон нутгийн төрийн захиргааны байгууллагад төлсөн үйлчилгээний хөлс	2.3.2	мян.төг	
Гаалийн үйлчилгээний хураамж	2.3.3	мян.төг	
2.4 Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг			
Төрийн өмчийн ногдол ашиг	2.4.1	мян.төг	
Орон нутгийн өмчийн ногдол ашиг	2.4.2	мян.төг	
2.5 Хүлээн авагч Засгийн газарт төлсөн бусад төлбөрүүд			
Бүтээгдэхүүн хуваах гэрээ бүхий аж ахуйн нэгжийн Засгийн газарт ногдох бүтээгдэхүүний оронд төлсөн төлбөр	2.5.1	мян.төг	
Бусад (тодорхойлно уу	2.5.2	мян.төг	
2.6 Төрийн байгууллага, олон нийтэд үзүүлсэн дэмжлэг			
Аж ахуйн нэгжээс яам, агентлагт үзүүлсэн мөнгөн дэмжлэг	2.6.1	мян.төг	
Аж ахуйн нэгжээс аймагт үзүүлсэн мөнгөн дэмжлэг	2.6.2	мян.төг	
Аж ахуйн нэгжээс суманд үзүүлсэн мөнгөн дэмжлэг	2.6.3	мян.төг	
Аж ахуйн нэгжээс олон нийттэй харилцах харилцаа, орон нутгийн тогтвортой хөгжилд зарцуулсан хөрөнгө	2.6.4	мян.төг	
Бусад (тодорхойлно уу	2.6.5	мян.төг	
2.7 Байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардал			
Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд төвлөрүүлсэн байдал	2.7.1	мян.төг	
Байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулсан зардал	2.7.2	мян.төг	
Хамрах хүрээ 2. Ашиг орлогын урсгал (сайн дурын тайлан)			
Гэрээ, тодорхой нөхцлөөр хөнгөлсөн, чөлөөлсөн татварын дүн	3.1	мян.төг	
Хөрөнгө оруулалтын зардал	3.2	мян.төг	
Ажиллагсдын сургалт, хөгжилд зориулсан зардал	3.3	мян.төг	
Геологи, хайгуулын зардал	3.4	мян.төг	
Гамшгаас хамгаалахад зориулсан зардал \Гамшгаас хамгаалах тухай хууль 27 дугаар зүйл	3.5	мян.төг	

Дор дурдсанаас бусад тохиолдолд тайлангийн заавар ёсоор Тайлангийн маягтыг үнэн зөв гаргаснаа бид хариуцахаа мэдэгдэж байна:

-
-

Тайлан гаргасан:

.....

Гүйцэтгэх захирал

ТАМГА

Ерөнхий нягтлан бодогч

200... оны дугаар сарын -ны өдөр

Тайлангийн тоон үзүүлэлт нь аж ахуйн нэгжийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлангийн тоотой тохирсон байна.

ОУИТБС МАЯГТ-1-ийг гаргах заавар

1. Нийтлэг зүйл

- 1.1. Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын ажлын алба нь Засгийн газар, уул уурхайн компаниуд, иргэний нийгмийн гурван талт тэгш оролцооны үндсэн дээр хэрэгжүүлж буй энэхүү санаачлагын өдөр дутмын зохицуулалтыг хангах чиг үүрэгтэй ба Ерөнхий сайдын ажлын албаны дэргэд ажилладаг байгууллага юм.
- 1.2. Албан татвар, төлбөр, хураамж, үйлчилгээний хөлс, аливаа дэмжлэгийг гаргахдаа давхардуулахгүй, орхигдуулахгүй байхын хамт аудитын байгууллагаар хянан баталгаажсан санхүүгийн тайлангийн тоон үзүүлэлттэй тохирсон байх хэрэгтэй. Учир нь энэхүү санаачлагын тайлан нь Сангийн яамнаас гаргах Засгийн газрын тайлантай хэрхэн уялдсан талаар олон улсын аудитын стандартын дагуу аудит /Монгол улсын Нэгдсэн тайланг/ хийлгэх, санаачлагын баталгаажуулалт хийх зэрэг үйл ажиллагаанд үндсэн баримт бичиг болж хэрэглэгдэх болно.
- 1.3. Ашиг орлогын урсгал гэдэгт олборлох үйлдвэрлэлээс Засгийн газрын хүлээн авч буй эдийн засгийн үр өгөөжийн эх үүсвэр юм. Эдийн засгийн шууд бус өгөөж болох барилга, дэд бүтэц, орон нутгийн хүмүүсийг ажлаар хангах зэргийг уг тайлангийн ашиг орлогын урсгалд тусгахгүй.
- 1.4. Аж ахуйн нэгж хэрвээ олборлох үйлдвэрлэлээс өөр төрлийн үйлдвэрлэл, борлуулалт хийдэг бол энэхүү тайланг гаргахдаа олборлох үйлдвэрлэлийн үйлдвэрлэлт, борлуулалтыг бүтээгдэхүүн нэг бүрээр, тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа үйлдвэрлэлээс төлсөн албан татвар, төлбөр, шимтгэл, үйлчилгээний хөлс, дэмжлэгийг тусгайлан салгаж гаргана. Энэ тайлан бусад салбарын үйлдвэрлэлт, борлуулалттай холилдовол тайлангийн ач холбогдол алдагдана.
- 1.5. Энэхүү тайланг аж ахуйн нэгжийн удирдлага санхүүгийн тайланд аудит хийлгэсний дараа үнэн зөв гаргаж нийтэд мэдээлнэ. Энэ тайланд орох тоо, баримт нь аж ахуйн нэгжийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлангийн тоон үзүүлэлттэй тохирсон байна.

2. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалт

- 2.1. Тайлангийн ОУИТБС Маягт-1-ийн 1-д заасан “Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалт” гэсэн хэсгийг олборлох үйлдвэрлэлийн салбарт тусгай зөвшөөрөл эзэмшин үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж бүр гаргана.
- 2.2. Маягтын 1.1 ”Бүтээгдэхүүний үйлдвэрлэлт” гэсэн хэсгийн бүтээгдэхүүний нэр төрлийг гаргахдаа тухайн аж ахуйн нэгж өөрийн эзэмшиж байгаа тусгай зөвшөөрлийн дугаар /Маягтад ТЗ№.. гэж тэмдэглэсэн/-ыг тавьж тусгай зөвшөөрлийн дагуу үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний нэрийг бичиж тайланг гаргана. Тухайлбал, “алт”, “зэс”, “нүүрс” гэж төрөл бүрээр нь ялган бичиж, “тоо хэмжээ” гэсэн мөрөнд тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэсэн тоо хэмжээг, “үнийн дүн” гэсэн мөрөнд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний үнийн дүнг тус тус бичнэ. Хэд хэдэн тусгай зөвшөөрөл эзэмшиж хэд хэдэн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн аж ахуйн нэгж хүснэгтийн мөрийг нэмж нэр төрөл бүрээр энэ үзүүлэлтийг гаргана. Тусгай зөвшөөрлийн дугаарыг тавьж байгаа нь зарим аж ахуйн нэгж хэд хэдэн

аймагт ижил болон өөр өөр төрлийн ашигт малтмалын олборлолт эрхэлж байгаа тул тухайн аймаг, суманд мэдээлэхэд ач холбогдолтой гэж үзсэн болно. Бүтээгдэхүүний /алт/ үйлдвэрлэлт, тоо хэмжээг "Цэвэршүүлсэн" дүнгээр бичнэ.

- 2.3. Маягтын 1.2 "Бүтээгдэхүүний борлуулалт" гэсэн хэсгийн "Бүтээгдэхүүний нэр төрөл" гэсэн хэсгийг тухайн аж ахуйн нэгж нь тусгай зөвшөөрөл /Маягтад ТЗ№ гэж бичсэн/ тус бүрээр тухайн жилд борлуулсан бүтээгдэхүүнээ нэр төрөл нэг бүрээр бичнэ. Тухайлбал, "алт", "зэс", "нүүрс" гэж төрөл бүрээр нь ялган бичиж, "хэмжих нэгж" гэсэн босоо мөрөнд тухайн борлуулсан бүтээгдэхүүний хэмжих нэгжийг "тонн" гэж, "тоо хэмжээ" гэсэн босоо мөрөнд тухай бүтээгдэхүүний борлуулсан хэмжээг тоогоор, "үнийн дүн" гэсэн босоо мөрөнд борлуулсан бүтээгдэхүүний үнийн дүнг бичнэ. Хэд хэдэн тусгай зөвшөөрөл эзэмшиж хэд хэдэн бүтээгдэхүүн борлуулсан аж ахуйн нэгж хүснэгтийн мөрийг нэмж бүтээгдэхүүний нэр төрөл бүрээр энэ үзүүлэлтийг гаргана. Хэд хэдэн бүтээгдэхүүн борлуулсан аж ахуйн нэгж хүснэгтийн мөрийг нэмж нэр төрөл бүрээр энэ үзүүлэлтийг гаргана.
- 2.4. Маягтын 1.3 "Бүтээгдэхүүн хуваах гэрээ бүхий компанийн бүтээгдэхүүнийн нэр төрөл" гэсэн мөрөнд Бүтээгдэхүүн хуваах гэрээтэй аж ахуйн нэгжийн борлуулсан бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг бичнэ. Тухайлбал, газрын тос гэж бичээд "тоо хэмжээ" гэсэн босоо мөрөнд борлуулсан бүтээгдэхүүний нийт хэмжээг бичиж, "үнийн дүн" гэсэн босоо мөрөнд бүтээгдэхүүний үнийн дүнг бичнэ.

3. Аж ахуйн нэгжээс улсын болон орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр болон бусад зардлууд

- 3.1. ОУИТБС Маягт- 1-ийн 2.1 "Төлсөн татварууд" гэсэн хэсгийг гаргахдаа тухайн жилд улс болон орон нутагт төлсөн албан татвар, төлбөр болон бусад зардал нэг бүрээр гаргах бөгөөд "татвар, төлбөр, зардлын хэмжээ" гэсэн босоо мөрөнд төлсөн татвар, төлбөр, зардал тус бүрийн дүнг тоогоор бичнэ. /Нягтлан бодохын мөнгөн суурьтай үнэлгээгээр бичнэ/ Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (Мөр 2.1.1)-т жилийн орлогод ногдуулсан татвараас гадна ногдол ашгийн орлого, эрхийн шимтгэлийн орлого, үл хөдлөх борлуулсны орлого, хүүгийн орлого, эрх борлуулсны орлого, гадаадын аж ахуйн нэгжийн төлөөлөгчийн газар өөрт ногдох ашгаасаа гадаадад шилжүүлсэн ашиг, Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн Монгол Улсад бүртгүүлэн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжээс авсан ногдол ашгийн орлого, Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн зээлийн хүүгийн болон батлан даалт гаргасны төлбөр, Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн эрхийн шимтгэлийн орлого, санхүүгийн түрээсийн хүүгийн орлого, удирдлагын зардалд төлсөн төлбөр, түрээсийн төлбөр, биет болон биет бус хөрөнгө ашиглуулсны орлого, Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн Монгол Улсын нутаг дэвсгэр дээр борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний орлого зэрэгт ногдуулсан татварыг оруулан тооцож бичнэ. Орлогын албан татварыг бусад татвараар суутгал хийгдсэн бол аль татвар болохыг тусад нь тэмдэглэл нэмж оруулна. Гаалийн албан татвар (Мөр 2.1.2)-т зөвхөн гаалийн татварыг дангаар оруулна. Хэрэв аж ахуйн нэгж нь шатах тослох материал импортолсон, автобензин, дизель түлшний албан татвар төлсөн бол 2.1.5 болон 2.1.6 мөрөнд салгаж бичнэ. Хэрвээ татварын байгууллагад татвар хоорондын суутган хийсэн бол түүний талаарх тайлбарыг тайланд хавсаргана. Энэ тайланд нэмэгдсэн өртгийн

албан татвар, хувь хүний албан татварыг оруулахгүй. Эдгээр татварыг олон улсын хэмжээгээр энэ тайланд оруулахгүй байгаа бөгөөд энэ нь хэрэглээний татвар гэдэгтэй, аудит хийхэд хүндрэл гардагтай холбоотой болохыг анхаарна уу. Хэрвээ маягтад заагаагүй өөр төрлийн татварыг холбогдох хууль тогтоомжийн дагуу төлсөн бол "Бусад (тодорхойлно уу)" гэсэн 2.1.8 болон 2.1.9 мөрөнд татварын нэр, тоо хэмжээг бичнэ.

- 3.2. Маягтын 2.2 "Төлбөр" гэсэн хэсгийг гаргахдаа тухайн жилд улс болон орон нутагт төлсөн төлбөр нэг бүрээр гаргах бөгөөд "Татвар, төлбөрийн хэмжээ" гэсэн босоо мөрөнд улсын болон орон нутгийн төсөвт төлсөн тухайн төлбөрийн дүнг төлбөр бүрийн нэр төрлөөр тоогоор бичнэ. Хэрвээ маягтад заагаагүй өөр төрлийн төлбөрийг холбогдох хууль тогтоомжийн дагуу төлсөн бол "Бусад (тодорхойлно уу)" гэсэн 2.2.9 болон 2.2.10 мөрөнд төлбөрийн нэр, тоо хэмжээг бичнэ.
- 3.3. Маягтын 2.3 "Хураамж, үйлчилгээний хөлс" гэсэн хэсэгт зохих хууль тогтоомжийн дагуу аж ахуйн нэгжээс төв, орон нутгийн төрийн захиргааны байгууллагад тухайн жилд төлсөн тээврийн болон өөрөө явагч хэрэгслийг бүртгэх, жолоодох зөвшөөрөл олгоход хураах хураамж, аж ахуйн нэгж, байгууллагыг бүртгэхэд хураах хураамж, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулахад зөвшөөрөл олгоход хураах хураамж, тусгай зөвшөөрөл шаардагдах үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад зөвшөөрөл олгоход хураах хураамж, үл хөдлөх хөрөнгийг бүртгэхэд хураах хураамж зэрэг улсын тэмдэгтийн хураамж болон тусгай зөвшөөрөл авах, шилжүүлэх, барьцаалах, сунгуулах, талбайг буцаан хүлээлгэн өгөх, хилийн маргааныг шийдвэрлэх, үрэгдүүлсэн тусгай зөвшөөрлийг нөхөн олгох зэрэг үед өргөдлийг хянан үзэх үйл ажиллагааны үйлчилгээний хөлсний дүнг бичих бөгөөд "Татвар, төлбөр, зардлын хэмжээ" гэсэн босоо мөрөнд тухайн жилд төлсөн хураамж, үйлчилгээний хөлсний нэгдсэн дүнг тус тусын мөрөнд тоогоор бичнэ. "Гаалийн үйлчилгээний хураамж" гэсэн 2.3.3 мөрөнд экспорт, импортын үед гаалийн бүрдүүлэлт хийсэн үйлчилгээний хураамжийг оруулна.
- 3.4. Маягтын 2.4 "Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг" гэсэн хэсэгт төрийн өмчийн оролцоотой болон төрийн өмчит аж ахуйн нэгжээс тухайн жилд төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашгийг төлсөн тухайгаа бичих бөгөөд "Татвар, төлбөрийн хэмжээ" гэсэн босоо мөрөнд төлсөн ногдол ашгийн дүнг тухайн хүснэгтийн 2.4.1 болон 2.4.2 мөрөнд тоогоор бичнэ. Энэ хэсэг нь төрийн болон орон нутгийн өмчийн оролцоогүй, төрийн байгууллагатай ногдол ашиг өгөх гэрээ хийгээгүй аж ахуйн нэгжид хамаарахгүй.
- 3.5. Маягтын 2.5 "Хүлээн авагч Засгийн газарт төлсөн бусад төлбөрүүд" гэсэн хэсэгт тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Засгийн газартай байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээгээр ногдох бүтээгдэхүүний оронд төлсөн төлбөрийг, мөн бусад гэрээгээр төлсөн төлбөрийг төлсөн бол бичиж тайлагнана. Тайлангийн "Татвар, төлбөр, зардлын хэмжээ" гэсэн босоо мөрөнд төлбөрийн дүнг тоогоор бичнэ. Хэрвээ төлбөр нь өөр өөр төрөлтэй байсан бол төлбөр бүрийн нэр, хэмжээ, дүнг тус тусад бичиж тайланд хавсаргана.
- 3.6. Маягтын 2.6 "Төрийн байгууллага, олон нийтэд үзүүлсэн дэмжлэг" гэсэн хэсгийг гаргахдаа тухайн аж ахуйн нэгжээс яам, агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүрэгт үзүүлсэн дэмжлэг, аж ахуйн нэгжээс олон нийттэй харилцах харилцаа, орон нутгийн тогтвортой хөгжилд зарцуулсан хөрөнгийг тооцож тайлагнана. Хэрвээ биет тусламж үзүүлсэн бол мөнгөн дүнд шилжүүлж

бичнэ. "Аж ахуйн нэгжээс яам, агентлагт үзүүлсэн мөнгөн дэмжлэг" гэсэн 2.6.1 мөрөнд тухайн жилийн хугацаанд яам, төрийн байгууллагуудад өгсөн хандив, дэмжлэгийн хэмжээг бичнэ. "Аж ахуйн нэгжээс аймагт үзүүлсэн мөнгөн дэмжлэг" гэсэн 2.6.2 мөрөнд тайлангийн хугацаанд харъяа болон үйл ажиллагаа явуулж байгаа аймагтаа өгсөн хандив дэмжлэгийн хэмжээг бичнэ. "Аж ахуйн нэгжээс суманд үзүүлсэн мөнгөн дэмжлэг" гэсэн 2.6.3 мөрөнд тайлангийн хугацаанд харъяа болон үйл ажиллагаа явуулж байгаа сумандаа өгсөн хандив дэмжлэгийн хэмжээг бичнэ. "Аж ахуйн нэгжээс олон нийттэй харилцах харилцаа, орон нутгийн тогтвортой хөгжилд зарцуулсан хөрөнгийг" гэсэн 2.6.4 мөрөнд тайлангийн хугацаанд аж ахуйн нэгжээс олон нийттэй харилцах харилцаа болон орон нутгийн тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн дагуу сан байгуулан хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хөрөнгийн зарцуулалтын хэмжээг бичнэ. Тайлангийн энэ үзүүлэлтийг тусламж үзүүлсэн, тусламж, дэмжлэг авсан аль аль тал гаргана. Тусламж үзүүлсэн огноо, ямар байгууллагад, тусламж дэмжлэгийн агуулга, үнийн дүнг жагсаалтаар гарган, энэхүү Тайланд хавсаргана. Хэрвээ биет материалын тусламж, эсхүл үйлчилгээ үзүүлсэн бол түүний нэрийг бичиж хавсралтад мөнгөн дүнд шилжүүлэн бичнэ. Энэ хэсэг нь өнөөгийн байдлаар ямар нэгэн тайланд тусгагддаггүй, аж ахуйн нэгжийг тухайн нутаг дэвсгэрт оршдог сум, аймаг тусламж, өглөг гуйж, айлгаж авдаг явдлыг ил тод болгох зорилготой болно.

- 3.7 Маягтын 2.7 "Байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардал" хэсгийн 2.7.1 үзүүлэлтийг гаргахдаа аж ахуйн нэгжээс "Ашигт малтмалын тухай" Монгол улсын хуулийн 39.1.9-д заасны дагуу байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас нээсэн тусгай дансанд байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг байршуулсан дүнг бичнэ. "Байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардал" гэсэн 2.7.2 дугаар мөрөнд тухайн жилд байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан нийт зардлын мөнгөн дүнг тавина.

4. Хамрах хүрээ 2. Ашиг орлогын урсгал /Сайн дурын тайлан/

- 4.1 Маягтын "Хамрах хүрээ 2 Ашиг орлогын урсгал" гэсэн хэсэгт байгаа тухайн аж ахуйн нэгж тусгай гэрээ, тодорхой нөхцлөөр хөнгөлүүлсэн, чөлөөлсөн татварын дүн, хөрөнгө оруулалтын дүн, ажиллагсдын сургалт, хөгжилд зарцуулсан зардал, геологи, хайгуулын зардал, аж ахуйн нэгжээс гамшгаас хамгаалахад зарцуулсан зардал зэргийг аж ахуйн нэгж сайн дураар тайлагнана. Гэхдээ үүнийг гаргах нь аж ахуйн нэгжээс ажиллагсдын хөгжил, аж ахуйн нэгжийн ирээдүй, байгаль хамгаалах зэрэг эдийн засаг, нийгмийн ач холбогдолтой болно. Нөгөө талаар тайлангийн энэ хэсэг нь аж ахуйн нэгжээс оршин байгаа иргэд, иргэний нийгмийн байгууллагад мэдээлэл өгөх, компанийн нэр хүндийг дээшлүүлэх, орон нутаг, иргэний нийгэмтэй хамтран ажиллахад ач холбогдолтой үзүүлэлт болно.

5. Бусад

- 5.1. Маягтын "баталгаажуулалт" хэсгийн тайлангийн үнэн зөвийг хариуцах албан тушаалтны албан тушаалын нэр, өөрийн нэр, гарын үсэг, огноо зэргийг бичсэн байна.

Үндэсний Статистикийн хорооны дарга, Сангийн сайдын
2008 оны 42/116 дугаар хамтарсан тушаалаар батлав.

ОҮИТБС Маягт No-2

**Олборлох үйлдвэрлэл эрхэлж байгаа аж ахуйн нэгжээс улсын болон орон нутгийн төсөвт хүлээн авсан
албан татвар, төлбөр болон бусад зардлын 200.. оны ТАЙЛАН**

Регистрийн дугаар										1.Төрийн захиргааны бүх шатны байгууллага болон татварын албад дараа оны 3 дугаар сарын 30-ны дотор олборлох үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуйн нэгж тус бүрээр гаргаж ҮТЕГ-т маягтаар ирүүлнэ.
Нэр										2.ҮТЕГ нь мэдээллийг нэгтгэж 4 дүгээр сарын 15-ны дотор Сангийн яаманд хүргүүлнэ.
Код										3.Сангийн яам нь мэдээллийг аж ахуйн нэгж бүрээр хянаж Засгийн газрын тайлан болгож баталгаажуулж 4 дүгээр сарын 30-ны дотор Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга ажлын албанд ирүүлнэ.
Аймаг, нийслэл										
Аж ахуйн нэгж, байгууллагын нэр										
Аж ахуйн нэгж, байгууллагын төрөл										

Хамрах хүрээ 1. Ашиг орлогын урсгал		
Үзүүлэлт	Мөрийн дугаар	Татвар, төлбөр, зардлын хэмжээ, мян.төг
1. Аж ахуйн нэгжээс улсын болон орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр		
1.1 Төлсөн татварууд		
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	1.1.1	
Гаалийн албан татвар	1.1.2	
Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн татвар	1.1.3	
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	1.1.4	
Онцгой албан татвар (шатах тослох материал импортолсон бол)	1.1.5	
Автобензин, дизелийн түлшний албан татвар	1.1.6	
Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар	1.1.7	
Бусад (тодорхойлно уу)	1.1.8	
Бусад (тодорхойлно уу)	1.1.9	
1.2 Төлбөр		
Ашигт малтмал нөөц ашигласны төлбөр	1.2.1	
Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	1.2.2	
Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	1.2.3	
Газрын төлбөр	1.2.4	
Ус ашигласны төлбөр	1.2.5	
Ойгоос мод, түлээ бэлтгэсний төлбөр	1.2.6	
Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	1.2.7	
Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	1.2.8	
Бусад (тодорхойлно уу)	1.2.9	
Бусад (тодорхойлно уу)	1.2.10	

1.3 Хураамж, үйлчилгээний хөлс		
Зохих хууль тогтоомжийн дагуу төв, орон нутгийн төрийн захиргааны байгууллагад төлсөн улсын тэмдэгтийн хураамж, бусад хураамж	1.3.1	
Зохих хууль тогтоомжийн дагуу төв, орон нутгийн төрийн захиргааны байгууллагад төлсөн үйлчилгээний хөлс	1.3.2	
Гаалийн үйлчилгээний хураамж	1.3.3	
1.4 Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг		
Төрийн өмчийн ногдол ашиг	1.4.1	
Орон нутгийн өмчийн ногдол ашиг	1.4.2	
1.5 Хүлээн авагч Засгийн газарт төлсөн бусад төлбөрүүд		
Бүтээгдэхүүн хуваах гэрээ бүхий аж ахуйн нэгжийн Засгийн газарт ногдох бүтээгдэхүүний оронд төлсөн төлбөр	1.5.1	
Бусад (тодорхойлно уу)	1.5.2	
